

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

## СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

---



### ТОЙМ АГУУЛГА

- ◇ Эдийн засгийн бодлого
- ◇ Нийгмийн бодлого
- ◇ Эрх зүй, төрийн байгуулал, гадаад бодлого

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

“Судалгааны эмхэтгэл” (XXI боть)-ийг  
Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Хянасан: Р.Хатанбаатар

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Т.Цэнд-Аюуш



## ГАРЧИГ

### I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 1.1 Төвлөрлийг сааруулах, шинээр хөгжлийн төв байгуулах талаарх гадаадын зарим орны туршлага**  
(Харьцуулсан судалгаа)..... 8-27
- Г. Алтан-Оч (PhD), Г. Билгээ, Д.Жигваагүнсэл,  
Р. Нургүл, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа*
- 1.2 Хөрөнгийн зах зээл болон шударга бус өрсөлдөөний салбар дахь зөрчил, гэмт хэргийн шинжтэй асуудлыг эрүүгийн хуулиар зохицуулдаг эсэх талаарх гадаадын зарим орны туршлага** (Харьцуулсан судалгаа)..... 28-41
- Г.Алтан-Оч (PhD), Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа*
- 1.3 Дэлхийн улс орнуудын ногдол ашгийн суутгалын татварын хувь хэмжээ** (Мэдээлэл, лавлагаа)..... 42-50
- Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа*

### II БҮЛЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО

- 2.1 Хүүхэд асран хамгаалах эцэг, эхийн хариуцлагын тухай Монгол Улсын болон гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт, туршлага**  
(Харьцуулсан судалгаа)..... 52-63
- Б.Ариунжаргал, Р.Нургүл, Д.Жигваагүнсэл,  
Ө.Мөнхтунгалаг, А.Пагма*
- 2.2 Тэтгэврийн зээлийн талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт**  
(Мэдээлэл, лавлагаа)..... 64-67
- Ө.Мөнхтунгалаг, Д.Жигваагүнсэл, А.Пагма*

### III. БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, ГАДААД БОДЛОГО

- 3.1 Холбооны улсуудын парламентын танхимын тоо**  
(Мэдээлэл, лавлагаа)..... 70-71
- Б.Ариунжаргал, Г.Билгээ*
- 3.2 Парламентын засаглалтай зарим орны Парламентын гишүүнээр сонгогдох насны доод хязгаар**  
(Харьцуулсан судалгаа)..... 72-73

*Г.Билгээ*

<b>3.3 Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох, засгийн газрын гишүүдийг томилох тухай гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт</b> (Харьцуулсан судалгаа).....	74-78
<i>Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч (PhD), Б.Ариунжаргал, Г.Билгээ, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл, Ч.Онончимэг, Д.Халиун, А.Пагма, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа</i>	
<b>3.4 Төрийн тэргүүнээр сонгогдсон тохиолдолд улс төрийн намын гишүүнчлэлээс татгалздаг болон түдгэлзүүлдэг эсэх талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт</b> (Харьцуулсан судалгаа).....	79-82
<i>Р.Хатанбаатар, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Ө.Мөнхтунгалаг, Ч.Онончимэг, А.Пагма, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа</i>	
<b>3.5 Үндсэн хуулийн шүүх ба Прокурорын байгууллагын харьяаллын талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт</b> (Харьцуулсан судалгаа).....	83-87
<i>Б.Ариунжаргал, Р.Нургүл, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Ч.Онончимэг, Г.Чулуун, А.Пагма, Ц.Элбэгзаяа</i>	
<b>3.6 Бүгд Найрамдах Солонгос улс, Бүгд Найрамдах Турк улс, Бүгд Найрамдах Кыргызстан улсын шүүгчийн эрх зүйн байдлын талаарх эрх зүйн зохицуулалт</b> (Харьцуулсан судалгаа).....	88-101
<i>Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа</i>	
<b>3.7 Шүүхийн ерөнхий зөвлөлийн талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт</b> (Харьцуулсан судалгаа).....	102-109
<i>И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг</i>	
<b>3.8 Болгар улсын сонгуулийн систем, 2009 оны сонгууль болон Европын парламентын сонгуулийн талаарх товч мэдээлэл</b> (Мэдээлэл, лавлагаа).....	110-111
<i>Д.Жигваагүнсэл</i>	
<b>3.9 Дээд шүүхийн хуулийн тайлбар хийх бүрэн эрхийн талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт</b> (Мэдээлэл, лавлагаа).....	112-118
<i>Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч (PhD), Б.Ариунжаргал, А.Пагма,</i>	

<b>3.10 БНМАУ-ын Ардын Их Хуралтай холбогдох лавлагаа</b> (Мэдээлэл, лавлагаа).....	119-122
---	---------

*А.Пагма, Д.Жигваагүнсэл*

<b>3.11 Орон нутгийн сонгууль явуулах хугацааны талаарх гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт</b> (Мэдээлэл, лавлагаа).....	123-133
--	---------

*Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч (PhD),  
Б.Ариунжаргал, И.Жаргалзаяабямба,  
Ч.Онончимэг, Ө.Мөнхтунгалаг,  
Д.Халиун, Ц.Элбэгзаяа*

<b>3.12 Дэлхийн улс орнуудын парламентын бүрэн эрхийн хугацаа</b> (Мэдээлэл, лавлагаа).....	134
---	-----

*Г.Алтан-Оч (PhD), Б.Ариунжаргал,  
И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл,  
Ө.Мөнхтунгалаг, О.Нарантуяа, Ч.Онончимэг,  
А.Пагма, Д.Халиун, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа*

<b>3.13 Дэлхийн улс орнуудад 2015 оны 3-6 дугаар сарын хооронд явагдсан парламентын болон ерөнхийлөгчийн сонгуулийн талаарх лавлагаа</b> (Мэдээлэл, лавлагаа).....	135-141
--	---------

*Р.Хатанбаатар, А.Пагма, Д.Халиун*

<b>3.14 Дэлхийн 25 орны 1945 оноос хойших засаглалын хэлбэр, төрийн тэргүүний сонгуулийн тогтолцоо, төрийн тэргүүнээр ажилласан хүмүүсийн лавлагаа</b> (Мэдээлэл, лавлагаа).....	142-151
--	---------

*Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч (PhD),  
Б.Ариунжаргал, И.Жаргалзаяабямба,  
Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг,  
О.Нарантуяа, Ч.Онончимэг, А.Пагма,  
Д.Халиун, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа*

<b>3.15 Израиль улсын Үндсэн хууль дахь Засгийн газрыг байгуулахтай холбогдсон заалтууд</b> (Албан бус орчуулга).....	152-154
---	---------

*Р.Хатанбаатар*

<b>3.16 Монгол улсад төрийн захиргааны албаны удирдлагыг хэрхэн сонгож, томилж байсан талаарх лавлагаа</b> (Мэдээлэл, лавлагаа).....	155-158
--	---------

*А.Пагма*

<b>3.17 Дэлхийн 25 орны Ерөнхийлөгч /төрийн тэргүүн/-ийг огцруулах үндэслэлийг үндсэн хуулиар зохицуулсан эсэх (Мэдээлэл, лавлагаа).....</b>	<b>159-164</b>
--	----------------

*Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч (PhD),  
Б.Ариунжаргал, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл,  
Ө.Мөнхтунгалаг, О.Нарантуяа, Ч.Онончимэг,  
А.Пагма, Д.Халиун, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа*

<b>3.18 Дэлхийн улс орнуудын засаглалын хэлбэр: ангилал, шинж чанар (Мэдээлэл, лавлагаа).....</b>	<b>165-168</b>
---	----------------

*Р.Хатанбаатар, А.Пагма*

<b>3.19 Монгол улстай засаглалын хэлбэрийн хувьд ижил төстэй гадаадын орны мэдээлэл (Мэдээлэл, лавлагаа).....</b>	<b>169-237</b>
---	----------------

*Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг, Д.Халиун*

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

# 1

## БҮЛЭГ

---

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ, ШИНЭЭР ХӨГЖЛИЙН ТӨВ  
БАЙГУУЛАХ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

*Г. Алтан-Оч (PhD), Г. Билгээ, Д.Жигваагүнсэл,  
Р. Нургул, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа*

**АГУУЛГА**

Судалгааны ерөнхий тойм, онолын үндэслэл  
Судалгааны үр дүн, дүгнэлт  
ОХУ-ын Санкт-петербург хот  
БНХАУ-ын Шанхай хот  
БНСУ-ын Пусан хот  
Бүгд Найрамдах Казахстан улс  
Канадын Торонто хот  
Ашигласан материалын жагсаалт

**СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ТОЙМ, ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ**

Төвлөрлийг сааруулах гэдэг нь улс төр, захиргаа, төсвийн талаар шийдвэр гаргах эрх мэдлийг төв Засгийн газраас орон нутгийн засаг захиргаа, байгууллагад шилжүүлэх үйл явц юм. Энэхүү нэр томъёо нь эрх мэдлийг дээрээс доош нь шилжүүлэх гэсэн ойлголтыг илэрхийлдэг.

Төвлөрлийг сааруулах үйл явц нь дараах үндсэн 2 хэлбэртэй байдаг. Үүнд:

- төрийн захиргааны албаны тогтолцооны хүрээнд чиг үүрэг, хариуцлагыг шилжүүлэх (deconcentration)
- улс төрийн тогтолцооны хүрээнд шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцлагыг шилжүүлэх (devolution)

***Захиргааны чиг үүрэг, хариуцлагыг шилжүүлэх замаар төвлөрлийг сааруулах нь***

Энэ нь төрийн захиргааны албадын чиг үүрэг, хариуцлагыг үндэсний түвшнээс орон нутгийн түвшин рүү, мөн төрийн захиргааны төв байгууллагуудаас тэдгээрийн орон нутаг дахь салбар руу шилжүүлэх үйл явц бөгөөд үүнийг захиргааны төвлөрлийг сааруулах ч гэж нэрлэдэг. Энэ тохиолдолд шийдвэр гаргах эрх мэдэл орон нутгийн иргэдийн өмнө хариуцлага хүлээдэг төлөөллийн байгууллагад бус харин төрийн захиргааны төв байгууллагаас томилогддог, түүнд ажлаа тайлагнадаг албан тушаалтанд шилждэг гэдгийг тэмдэглэх хэрэгтэй юм. Иймд төвлөрлийг сааруулах энэ хэлбэр нь олон нийтийн оролцоог хөхиүлэн дэмжих гэхээсээ илүү захиргааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой байдаг.

Төрийн захиргааны онол боловсруулагчид орон нутгийн салбаруудад чиг үүрэг, хариуцлагыг шилжүүлэх нь үр ашгийг дээшлүүлэх, яамдын ажлын ачааллыг багасгах, тэднийг өдөр тутмын захиргааны ажлаас чөлөөлж, анхаарлыг нь бодлогын асуудалд төвлөрүүлэх гэх мэт зөвхөн менежментийн хэмжигдэхүүнүүдэд үндэслэсэн улс төрийн бус шийдвэр хэмээн үнэмшүүлэхийг оролддог ч энэ нь үнэн хэрэгтээ дээд зэргийн улс төрийн шийдвэр байх тохиолдол байдаг.

*Нэгдүгээрт*, төв засгийн газар энэ шийдвэрийг гаргахдаа орон нутгийн засаг захиргааны эрх мэдлийг өргөтгөхөөсөө илүү төрийн эрх баригчдын улс төрийн сонирхлыг хамгийн түрүүнд харгалзан үздэг.



*Хоёрдугаарт*, орон нутгийн салбар дахь албан хаагчид гол төлөв Засгийн газрын буюу улс төрийн тогтвортой байдлыг хангах, улс төрийн сөрөг хүчний үйл ажиллагаанд саад учруулах, орон нутгийн засаг захиргаадаар төв засгийн газрын бодлогын хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн түвшний албан хаагчид улс төрийн хувьд үнэнч байгаа эсэхэд хяналт тавих зэрэг үүрэг гүйцэтгэдэг.

Төрийн захиргааны төв байгууллагуудын орон нутаг дахь салбарыг хэрхэн зохион байгуулах буюу захиргааны төвлөрлийг хэрхэн сааруулах тухай асуудал улс орон бүрт өөр өөр байх боловч Смидт дараах нийтлэг 3 хувилбарыг авч үзсэн байна. Үүнд:

Орон нутаг дахь салбарын тогтолцооны загвар-Төрийн захиргааны төв байгууллагын орон нутаг дахь төлөөлөл нь боловсрол, эрүүл мэнд, үйлдвэр, хөдөө аж ахуй зэрэг төрийн үйлчилгээ, аж ахуйн тодорхой салбарын асуудлыг эрхэлдэг. Энэ тохиолдолд төв Засгийн газрыг төлөөлөн захирагч гэж байдаггүй бөгөөд салбарын чанартай зохицуулалт хийх, мэргэжлийн удирдлагаар хангах, үйлчилгээний нийтлэг стандарт мөрдүүлэх зэрэг чиг үүргийг холбогдох яамд нь хэрэгжүүлдэг.

Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч-Муж, дүүргийн засаг дарга зэрэг төв Засгийн газрыг бүрэн эрхтэй төлөөлөн захирагчдын гарт ихээхэн эрх мэдэл төвлөрдөг. Эдгээр албан тушаалтан тухайн нутаг дэвсгэр дээрээ төрийн бүх чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг хүлээж, бусад төрийн албан хаагчид, орон нутгийн засаг захиргааны албан тушаалтнуудаас дээгүүр эрх мэдэл эдэлдэг. Энэ нь орон нутгийн өөрөө удирдах ёсыг ихээхэн хязгаарласан хувилбар юм.

Засгийн газрын төлөөлөгч-Төлөөлөгч нь гол төлөв зохицуулалтын чиг үүрэгтэй байдаг. Орон нутгийн засаг захиргааны болон мэргэжлийн албан тушаалтнуудад зөвлөмж өгөхөөс биш дагаж мөрдөх тушаал, шийдвэр гаргадаггүй.

Их Британи, АНУ зэрэг хөгжингүй орнууд захиргааны төвлөрлийг сааруулах орон нутаг дахь салбарын тогтолцооны загварыг авч хэрэглэсэн бол хөгжиж буй орнуудын ихэнх нь бүрэн эрхт төлөөлөн захирагч бүхий тогтолцооны загварыг авч хэрэглэсэн байна. Загварын сонголтод тухайн орны түүхэн нөхцөл байдал тодорхой хэмжээгээр нөлөөлөх боловч төв Засгийн газрууд улс төрийн төвлөрлийг сааруулахаасаа илүү захиргааны төвлөрлийг сааруулахыг илүүд үздэг ерөнхий хандлага ажиглагдаж байна.

### ***Улс төрийн эрх мэдэл, хариуцлагыг шилжүүлэх замаар төвлөрлийг сааруулах нь***

Төвлөрлийг сааруулах энэ хэлбэр нь орон нутгийн ардчиллыг бэхжүүлэх, үр ашгийг дээшлүүлэх зорилтын аль алиныг агуулдаг учраас сонгодог хэлбэрт тооцогддог. Энэ нь орон нутгийн засаг захиргаадад эрх мэдэл, хариуцлагыг цогц байдлаар шилжүүлэх үйл явц бөгөөд захиргааны болон санхүүгийн, мөн улс төрийн эрх мэдлийг хамардаг гэж ойлгох нь зүйтэй юм.

Эрх мэдэл, хариуцлага цогц байдлаар шилжсэн орон нутгийн засгийн газрын шинжийг:

- үндсэн хуулийн дагуу тухайн нутаг дэвсгэрийнхээ хүрээнд эрх барих чиг үүргийг хэрэгжүүлж, орон нутгийн чухал чухал үйлчилгээний талаар хариуцлага хүлээдэг;
- санхүү, төсвийн хувьд бие даасан байдалтай, орлогоо өөрөө бүрдүүлэх эрх мэдэлтэй байх;
- орон нутгийн иргэдийн ардчилсан сонгуулиар томилогддог, орон нутгийнхаа хөгжлийн бодлогыг тодорхойлж, дотооддоо мөрдөх дүрэм гаргаж хэрэгжүүлдэг;
- төрийн захиргааны төв байгууллагуудын албан тушаалтнууд зөвхөн зөвлөгөө өгөх, мэргэжлийн хяналт хийх үүрэгтэй болохоос биш орон нутгийн бүрэн эрхэд хамаарах асуудалд оролцдоггүй хэмээн тодорхойлжээ.

Гэхдээ ийм сонгодог хэлбэрийн орон нутгийн засгийн газрыг бий болгох, бэхжүүлэх асуудал урт удаан хугацааны үйл явц юм. Эхний ээлжинд орон нутагт үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг төв засгийн газрын бодлогын дагуу төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж, дараа нь эдгээр үйлчилгээг төв засгийн газрын заавар, чиглэлийн дагуу үзүүлэх чиг үүргийг орон нутгийн удирдлагад шилжүүлж, эцэст нь орон нутгийн засаг захиргаадад чадавх бий болохын хэрээр тэдэнд үйлчилгээний зарим салбарт илүү их хариуцлага хүлээлгэж, өөрөө засаглах эрх олгож болох юм.

Төвлөрлийг сааруулах үйл явц нь харьцангуй бие даасан засаг захиргааг бий болгох, орон нутгийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх тухай асуудал юм. Гэхдээ энэ тодорхойлолт тэр бүр улс орнуудад тохирохгүй байх явдал бий. Жишээлбэл, Энэтхэгт холбооны засгийн газар нь мужийн засаг захиргаадаа бодвол харьцангуй их эрх мэдэл эдэлдэг. Хятад улс нь төрийн эрх мэдлийн ихээхэн төвлөрөлтэй гэгддэг боловч бодит байдал дээрээ орон нутгийн засаг захиргаад нь өөрөө засаглах ихээхэн эрх эдэлдэг бөгөөд үүнийг “хятад маягийн төвлөрлийг сааруулах үйл явц” гэж тодорхойлдог.

Эрх мэдлийг цогц байдлаар шилжүүлэх аргаар төвлөрлийг сааруулах нь хамгийн хүчтэй хэлбэрт тооцогддог бөгөөд гол төлөв төрийн захиргааны байгууллагуудын түвшинд төвлөрлийг сааруулах үйл явцтай хамт хэрэгждэг.

Ардчилал хөгжсөн ихэнх оронд зарим асуудлыг өөрөө шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллагууд, орон нутгийн асуудлаа өөрөө шийдвэрлэх бүрэн эрх бүхий орон нутгийн засаг захиргаад, бүсийн түвшинд яамны эрх мэдлийг хэрэгжүүлдэг салбар нэгжүүд гэх мэт олон хэлбэр байдаг. Эндээс засгийн газар нь ардчилсан шинэтгэлд баримжаалсан төвлөрлийг сааруулах өөрчлөлт шинэчлэлтийг хэрэгжүүлэхдээ төрөл бүрийн хэлбэрийг хослуулан ашиглах боломжтой болохыг харж болно.

### ***Төвлөрлийг сааруулж, эрх мэдэл шилжүүлэх нэгж***

Төв Засгийн газраас доош засаг захиргааны хэд хэдэн нэгж байдаг учраас төвлөрлийг сааруулж, эрх мэдэл шилжүүлэх нэгж тэдгээрийн чухам аль нь байхыг тодорхойлох явдал чухал ач холбогдолтой. Ихэнх улс оронд гол төлөв төв Засгийн газар, муж, орон нутгийн засаг захиргаа гэсэн засгийн газрын гурван түвшин байдаг.

Уганда улсад дүүрэг, каунти, дэд каунти, тосгоны зөвлөл гэсэн засаг захиргааны нэгжүүд байдаг бөгөөд төвлөрлийг сааруулж, эрх мэдэл шилжүүлсэн нэгж нь дүүрэг юм. Энэтхэгт ийм нэгж нь муж улсын засаг захиргаа байсан бол Хятад, Орос улсад бүсийн түвшинд байдаг. Ийнхүү дээрх улсуудад төвлөрлийг сааруулж, эрх мэдлийг шилжүүлсэн нэгж нь дундаж хэмжээний газар нутагтай улс орнуудтай дүйцэхүйц том хэмжээтэй байна.

Гэвч төвлөрлийг жинхэнэ ёсоор сааруулъя гэвэл эрх мэдлийг үүнээс доош түвшинд шилжүүлэх шаардлагатай юм.

Орос улсад бүсүүд нь харьцангуй том газар нутагтайгаас үүдэн төв засгийн газраас бүсүүдэд чиг үүрэг шилжүүлснээр бүсээс доош түвшинд буюу ялангуяа хот, дүүргийн захиргаадад төвлөрөл саарсны ач тус мэдрэгдэж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Хэрэв ихэнх эх үүсвэр, чиг үүрэг бүсийн засаг захиргаадад төвлөрч, түүнээс доошхи түвшинд эрх мэдэл шилжихгүй бол төвлөрсөн нэг улсын оронд жижиг хэмжээний олон төвлөрсөн нэгж үүсч бий болох эрсдэлтэй юм.

Ингээд дээрх онолын үндэслэл болон Орос, Хятад, Өмнөд Солонгос, Казахстан, Канад улсуудад нийслэлээс гадна эдийн засгийн идэвхтэй бүс буюу хөгжлийн бусад төвүүдийг хэрхэн байгуулж, төвлөрлийг сааруулан улс орныхоо эдийн засаг, нийгмийг хөгжүүлсэн туршлагыг судалсаны үндсэн дээр уг судалгааны захиалгатай холбогдуулан доорх дүгнэлтийг гаргаж болохоор байна.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

- Эдийн засгийн идэвхтэй бүс нутгийн хэмжээг нэмэгдүүлэн эдийн засгийг хурдацтай тэлэх буюу хөгжлийн хоёроос доошгүй төв байгуулах замаар төвлөрлийг сааруулах үйл явц нь эдийн засгийн хөшүүрэг гэхээсээ илүүтэй улс төрийн шийдвэр, төрийн бодлогын үр дүн юм байна.
- Шинээр байгуулах хөгжлийн төвийг засаг захиргааны төв хот гэхээс бизнесийн хот буюу аж үйлдвэр, эдийн засгийн төв болгосон нь илүү оновчтой байгаа нь ихэнх улсуудын туршлагаас харагдаж байна (зөвхөн ОХУ-ын Санкт-Петербург хамаарахгүй). Энэ талаар хамгийн сайн туршлага гэвэл, Казахстан улсад байгуулсан олон тооны эдийн засгийн тусгай бүсүүдийг нэрлэж болно.
- Хөгжлийн шинэ төв байгуулахад хамгийн чухалд тооцогдох хүчин зүйл бол дэд бүтэц, нэн ялангуяа далайн буюу усан замын тээврийн ложистик, сүлжээ юм байна. Түүнээс биш хөгжлийн шинэ, хуучин төвийн хоорондох зай чухал ач холбогдолгүй юм. Манай орны хувьд авч үзвэл, зам тээврийн дэд бүтэц буюу төмөр замын ложистик хамгийн чухал ач холбогдолтой хүчин зүйл юм. Иймээс хөгжлийн шинэ төвөөр Дархан, Сайншанд (усан хангамж, эрчим хүчний дэд бүтцийн асуудлыг шийдэж чадвал) хотыг сонгох нь илүү оновчтой харагдаж байна.
- Хөрөнгө оруулалтын шингээх чадварт хамгийн сайн нөлөө үзүүлдэг чухал хүчин зүйл бол санхүүгийн зах зээлийн хөгжил байдаг<sup>1</sup>. Санхүүгийн зах зээл нь банк санхүүгийн байгууллага, хөрөнгийн биржийн хөгжлийн түвшингээр тодорхойлогдоно. Тэгвэл Сингапур улсын жишгээр олон улсын санхүүгийн төв болгохоор Пусан хотыг хөгжүүлсэн Өмнөд Солонгосын туршлагыг хамгийн сайн жишээгээр нэрлэж болохоор байна.

### 1. ОХУ-ЫН САНКТ-ПЕТЕРБУРГ ХОТ

Ленинград мужийн төв болох Санкт-Петербург хот нь 5 сая орчим хүн амтай, 1 439 км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй бөгөөд Москва хотын дараа орох ОХУ-ын хоёр дахь том хот юм. Санкт-Петербург нь Холбооны хотын статустай хот юм.

Тус хот нь Цагаан тэнгис, Днепр мөрөн, Ижил мөрөн хүртэл усан зам татагдсан байдаг тул Каспийн тэнгис, Урал, Ижил мөрнөөс Балтын тэнгист гарах гарц болдог бөгөөд улсдаа томоохонд тооцогдох боомт хотоос гадна төмөр зам, агаарын замын чухал зангилаа болж хөгжсөн.

Анх Санкт-Петербург хотыг I Петр хаан Умардын дайны үед усан онгоц үйлдвэрлэх зорилготой усан цэргийн бааз байгуулж (1703 он) байсан. Дараа нь Оросын эзэн хаант улсын нийслэл болсноор (1712 он) энд тансаг хэрэглээний үйлдвэрүүд байгуулагдахын зэрэгцээ шинжлэх ухаан, боловсролын салбар идэвхтэй хөгжиж, архитектурын шилдэг бүтээлүүд бий болж эхэлсэн.

ХХ зууны эхээр Санкт-Петербург хотод тэргүүлэх чиглэлийн үйлдвэрүүд байгуулагдсанаар тус улсын нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 30 хувийг үйлдвэрлэж, тэнд 250 мянга гаруй хүн ажиллаж байжээ.

<sup>1</sup>Г.Алтан-Оч, Ц.Элбэгзаяа “Хөрөнгө оруулалтын шингээх чадвар, түүнд нөлөөлөх хүчин зүйлс” СТ-13/425, УИХТГ-ын Судалгаа, шинжилгээний хэлтэс, 2013 он

Зөвлөлт Орос улсын үед нийслэлийг Москва руу шилжүүлсний (1918 он) дараа Санкт-Петербург хотод аж үйлдвэрийн салбар улам эрчимтэй хөгжиж, боловсрол, шинжлэх ухаан, соёлын болон зэвсэгт хүчинд гүйцэтгэх үндсэн үүрэг нь хадгалагдсан хэвээр байв.

Санкт-Петербургийн эдийн засаг, нийгмийг 2030 он хүртэл хөгжүүлэх стратеги “Санкт-Петербург-2030 стратеги”<sup>1</sup>-д дурьдсанаар тус хотын гүйцэтгэх үүрэг хэд хэдэн удаа хувьсан өөрчлөгдөж байсан бөгөөд өөрчлөлтийг дараах хүснэгтэд харуулав.

**Санкт-Петербург хотын гүйцэтгэх үүргийн өөрчлөлт**

/Хүснэгт 1/

<b>Санкт-Петербург (1703-1917)</b>	<b>Ленинград</b>	<b>Санкт-Петербург 2013</b>	<b>Санкт-Петербург 2030</b>
<ul style="list-style-type: none"> <li>Оросын эзэн хаант улсын нийслэл</li> <li>Хилийн хамгаалалтын штаб</li> <li>Усан цэргийн флот</li> <li>“Европ руу харах цонх”</li> <li>Олон улсын худалдааны төв</li> <li>Аж үйлдвэрийн төв</li> <li>Соёл, шинжлэх ухаан, боловсролын төв</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хил хамгаалалтын штаб</li> <li>Усан цэргийн флот</li> <li>Оюуны төв</li> <li>Үйлдвэрлэлийн судалгаа, инженерчлэл, барилга, хот төлөвлөлтийн төв</li> <li>Зэвсэгт хүчний үйлдвэрлэл, судалгааны төв</li> <li>Боловсролын төв</li> <li>Арктик судлалын төв</li> <li>Далайд гарах гарц</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Дэлхийн түүх-соёлын төв</li> <li>Боловсрол, шинжлэх ухаан, инновацийн төв</li> <li>Нийслэлийн зэрэглэлтэй хот</li> <li>Аж үйлдвэрийн төв</li> <li>Ажил хэрэг, аялал жуулчлалын төв</li> <li>Тээвэр, дамжин өнгөрөх, худалдааны төв</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тохилог амьдрах хот</li> <li>Дэлхийн түүх-соёлын төв</li> <li>Боловсрол, шинжлэх ухаан, инновацийн төв</li> <li>Нийслэлийн зэрэглэлтэй хот</li> <li>Өндөр технологит үйлдвэрлэлийн төв</li> <li>Бүтээлч аж үйлдвэрлэлийн төв</li> <li>Ажил хэрэг, удирдлага, аялал жуулчлалын төв</li> <li>Балтын тэнгис орчмын тэргүүлэх хот</li> <li>Тээвэр-логистик, худалдааны төв</li> <li>Арктик судлал, инновацийн хөгжлийн төв</li> </ul>

Санкт-Петербург хотын үндсэн үүргүүдийн нэг бол “тав тухтай амьдрах хот” хэмээн тодорхойлсон байна. Ийнхүү үүнд анхаарал хандуулснаа тус хотын засаг захиргаа дараах байдлаар тодорхойлж байна. “Хэдийгээр энэ нь мэдээжийн асуудал боловч бодлогын баримт бичгүүдэд түүнийг тэргүүлэх, эсвэл тодорхойлох хэмжээнд тэр бүр авч үздэггүй. Орчин үед үүнд онцгой анхаарсан хотууд нь хүний төлөөх өрсөлдөөнд тэргүүлж байна. Амжилттай хөгжиж байгаа хотууд руу авьяаслаг, бүтээлч, овсгоотой хүмүүс тэмүүлж, тав тухтай, эрх чөлөөтэй, сэтгэл хангалуун амьдрахыг хүсэж байна. Үүний тулд хотын тогтвортой хөгжлийг хангах, өөрийн гэсэн өвөрмөц дүр төрхийг бий болгох, таарсан хэмжээтэй зай талбайг зохион байгуулах, орчин үеийн дэд бүтцийг дэмжих ёстой.” хэмээн Санкт-Петербург-2030 стратегид дурьдсан байна. Санкт-Петербург нь энэ үүргээ гүйцэтгэхийн тулд дэлхийн хүн амыг соронз мэт татдаг Москва, Лондон, Парис, Бостон болон бусад томоохон хотуудтай өрсөлдөж байна.

Хэдийгээр Санкт-Петербург хотын цаг агаар таагүй байдаг ч 2013 онд тус хотод байнга оршин суудаг хүний тоо 5 сая болж өссөн бөгөөд 2030 онд энэ үзүүлэлт 870 мянгаар нэмэгдэх урьдчилсан тооцоо гарсан байна. Одоогийн байдлаар хүн амын тоогоороо Холбооны улсад 4-рт жагсаж байна.

**Санкт-Петербург хотын хүн амын үзүүлэлт, урьдчилсан тооцоо**

/Хүснэгт 2/

Үзүүлэлт	Тайлан				Урьдчилсан тооцоо		
	2010	2011	2012	2013	2020	2025	2030
Байнга оршин суугч, мян.хүн	4,866.0	4,926.3	4,990.6	5,080.0	5,541.0	5,728.0	5,870.0
Дундаж наслалт	72.1	73.1	73.4	73.6	76.9	77.5	78.0

Хүн амын тогтвортой өсөлтөд нөлөөлж байгаа олон хүчин зүйлсийн нэг нь иргэдийн орлого бөгөөд эндэхийн иргэдийн сарын дундаж орлого 2005 онд 12.3 мянган рубль байсан бол 2012 онд 27.8 мянган рубль болж хоёр дахин нэмэгдсэн, харин өндөр насны тэтгэврийн хэмжээ 2.9 мянган рублиас 10.6 мянган рубль болж бараг 4 дахин нэмэгдсэн байна.

Хотын ирээдүйд гүйцэтгэх дараагийн үүргийг нийслэлийн зэрэглэлтэй хот байх хэмээн тодорхойлсон. Санкт-Петербург хотод дэлхийн тэргүүлэгч орны тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалтууд явагддаг бөгөөд жил бүр Петербургийн олон улсын эдийн засгийн форум, Усан цэргийн олон улсын үзэсгэлэн, Петербургийн олон улсын инновацийн форум зохион байгуулагддаг.

Мөн Санкт-Петербург хотод Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн орнуудын парламентын ассамблей, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх (2008 оны V сараас), “Конгрессын ордон” төрийн арга хэмжээний цогцолбор, Б.Н.Ельцины нэрэмжит Ерөнхийлөгчийн номын сан, Усан цэргийн жанжин штаб, ОХУ-ын Зэвсэгт хүчний баруун бүсийн штаб, Ленинград мужийн засаг захиргааны байгууллагууд болон бусад олон улсын, холбооны улсын байгууллагууд байрлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Санкт-Петербург бол түүх дурсгал, соёлын өв ихтэй бөгөөд ОХУ болон дэлхийн аялал жуулчлалын төв юм. Энд ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгэгдсэн олон түүх дурсгал болон соёлын цогцолборууд байдаг. 2005 онд ирсэн жуулчдын тоо 3.7 сая (үүнээс 1.8 сая нь гадаадын иргэн) байсан бол 2012 онд 6 сая (үүнээс 2.9 сая гадаадын иргэн) болж өссөн байна. Аялал жуулчлалын салбарын гол ажиллах хүчин болсон зочид буудал, зоогийн газарт ажиллагсдын тоо 2005 онд 61.6 мянга байсан бол 2012 онд 62.5 мянган хүн болсон байна.

Санкт-Петербург хотын төсвийн дийлэнхийг бүрдүүлдэг аж үйлдвэрийн салбар нь үетэйгээ нийцэн байнга шинэчилэгдэж ирсэн. Хамгийн сүүлд Зөвлөлт улс задрах үеэр орчин үеийн шинэ үйлдвэрүүд байгуулагдан уг салбар хөгжлийн шинэ шатанд гарч ирсэн. Тухайлбал, Ленинград мужийн автомашин угсралт болон автомашины эд ангийн үйлдвэрүүдтэй хамтран ажилласнаас хойш өнөөдөр тус хотод автомашины иж бүрэн үйлдвэртэй болсон.

**Санкт-Петербург хотын үйлдвэрлэлийн хэмжээ, урьдчилсан тооцоо**

/Хүснэгт 3/

Үзүүлэлт	Тайлан				Урьдчилсан тооцоо		
	2010	2011	2012	2013	2020	2025	2030
Үйлдвэрлэлийн хэмжээ, тэр.руб.	1,448.5	1,891.1	2,222.1	2,313.4	4,550.0	7,250.0	11,120.0

Мөн олон улсын тэргүүлэх Microsoft, EMC, Oracle, Intel, Яндекс, Google, Hewlett-Packard, Motorola Mobility, EPAM, LGSoftLab, Siemens, T-Systems зэрэг компаниуд эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдээ байгуулаад байна.

Тус хот нь жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлж байгаа туршлагаараа ОХУ-д тэргүүлж байна. 2012 оны байдлаар, 100 мянган хүнд ногдох жижиг үйлдвэрийн тоогоороо 1-д, жижиг үйлдвэрүүдэд ажиллаж байгаа боловсон хүчний тоогоороо 3-т тус тус жагссан байна. Тодруулбал, 211.3 мянган жижиг үйлдвэрт нийт 692.4 мянган хүн ажиллаж байсан нь нийт ажиллагсадын 30.7%-ийг эзэлж байна. Жижиг үйлдвэрүүдийн хөрөнгийн эргэлт 2011 онд 1,365.1 тэр.рубль байсан бол 2012 онд 1,431.1 тэр.рубль болж өссөн байна. Сүүлийн жилүүдэд жижиг үйлдвэрүүдээс Санкт-Петербург хотын татварын нийт орлогын оруулж буй хувь нэмэгдэж 3%-д хүрсэн байна.

Эдийн засгийн хөгжлийн өөр нэг эх үүсвэр болсон хөрөнгө оруулалтын салбарыг “Эксперт РА” агентлагаас дүгнэн 2013 оны 12-р сард 1А зэрэглэлийг олгосон байна. Энэ нь Санкт-Петербург хотод хөрөнгө оруулалт хийхэд хамгийн өндөр боломжтой, хамгийн бага эрсдэлтэй гэж үзсэн байна.

ОХУ-ын Статистикийн албаны мэдээллээр Санкт-Петербург хот болон Ленинград мужийн үндсэн хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтын 2013 оны хэмжээ 2012 оныхтой харьцуулбал 0.3%-иар өссөн байна. Байгууллагуудын үндсэн хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалт 276.2 тэр.рубль болсоноос 47% нь хөрөнгө оруулагчдын өөрсдийн хөрөнгөөс, 53% нь татан оролцуулсан хөрөнгөөс (үүнээс 27% нь төсвийн хөрөнгө оруулалт) бүрдсэн байна.

2013 онд Санкт-Петербург хотын тэргүүлэгч гадаадын хөрөнгө оруулагчдад дараах 5 улс багтсан байна. Үүнд: Люксембург (3.2 тэр.ам.\$), Герман (1.25 тэр.ам.\$), Ирланд (1.24 тэр.ам.\$), Казахстан (1.2 тэр.ам.\$), Өмнөд Солонгос (813 сая ам.\$) орсон байна.

**Санкт-Петербург хотын хөрөнгө оруулалтын хэмжээ, урьдчилсан тооцоо**

/Хүснэгт 4/

Үзүүлэлт	Тайлан				Урьдчилсан тооцоо		
	2010	2011	2012	2013	2020	2025	2030
Үндсэн хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ, тэр.руб.	401.5	360.4	351.9	366.9	982.7	1,750.0	3,000.0
Гадаадын хөрөнгө оруулалт, тэр.ам.дол.	5.2	6.1	10.8	13.4	15.2	15.5	17.0
Үүнээс шууд хөрөнгө оруулалт, тэр.ам.дол.	0.5	1.1	0.9	1.4	3.9	4.3	5.4

Зөвлөлт Холбоот Улс задарсны дараа Санкт-Петербург хотын усан боомт нь ОХУ-ын үндсэн усан боомт болж, тээвэр-транзитын төв болон эрчимтэй хөгжих болсон. Учир нь энэ усан боомт Европын холбооны улсуудтай холбогдох хамгийн дөт зам юм. Ийнхүү шинэ боломж гарч ирснээр Санкт-Петербург хотын усан боомтоор улсын хэмжээний ачааг тээвэрлэлтийн экспортын 10%, импортын 50%-ийг зөөвөрлөх болсон.

Үүний зэрэгцээ дамжин өнгөрөх үйл ажиллагаа томоохон үүрэг гүйцэтгэж байсан. Гэхдээ цаашид ачаа тээвэрлэлтийг хотоор дамжин өнгөрүүлэх нь үр ашиггүй, гагцхүү орон нутгийн тээврийн сүлжээнд томоохон ачаалал өгч байгаа аж. Тийм учраас энэ үүргийг Ленинград муж руу шилжүүлж байгаа.

Санкт-Петербург-2030 стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л төрлийн эх үүсвэрүүдийг баримт бичигт тусгасан байна. Ингэхдээ санхүүгийн эх үүсвэрээс гадна хөдөлмөрийн зах зээл, газрын харилцаа, үйлдвэрлэлийн нөөц зэргийг хамруулсан бөгөөд эх үүсвэрүүдийн урьдчилсан тооцоог дараах хүснэгтэд оруулсан.



## Стратегийг хэрэгжүүлэх эх үүсвэрүүд

/Хүснэгт 5/

Үзүүлэлтүүд	2012 он	2020 он	2030 он
<b>Хөдөлмөрийн зах зээл</b>			
Ажилтай хүний тоо, мян.хүн	2,530.4	2,966.9	3,174.2
Үүнээс дээд боловсролтой хүний эзлэх хувь	44.7	47.0	50.0
Бүтээмж өндөртэй ажлын байр, мян.нэгж	102.7	280.0	400.0
<b>Газар нутгийн нөөц</b>			
Нийт талбай, мян.км <sup>2</sup>	1.4	1.4	1.4
Үүнээс орон сууц, барилга байгууламжтай талбайн эзлэх хувь	30.6 <sup>1</sup>	30.9	30.9
Хүн амын нягтрал, мян.хүн/км <sup>2</sup>	3.4	3.9	4.2
<b>Хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэр</b>			
Үндсэн хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ, тэр.руб.	351.9	982.7	3,000.0
1 оршин суугчид ногдох үндсэн хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ, мян.руб.	70.5	178.0	511.1
Гадаадын хөрөнгө оруулалт, тэр.ам.дол.	10.8	15.2	17.0
Үүнээс шууд хөрөнгө оруулалт, тэр.ам.дол.	0.9	3.9	5.4
Хүн амын мөнгөн орлого, тэр.руб.	1,640.9	3,199.4	6,691.8
Хотын нэгдсэн төсвийн орлого, тэр.руб.	379.9	648.3	1,401.4
Хотын нэгдсэн төсвийн зарлага, тэр.руб.	382.3	630.9	1,401.4
<b>Үйлдвэрлэлийн нөөц</b>			
Цахилгаан хангамжийн хүчин чадал, Мвт	12,104.0	15,904.0	21,356.0
Дулаан хангамжийн хүчин чадал, Гкал/цаг	26,081.2	29,238.2	31,003.2
Усан хангамжийн хүчин чадал, мян.м <sup>3</sup> /хоног	3,028.0	2,799.0	2,251.0
Цэвэршүүлэх системийн хүчин чадал, мян.м <sup>3</sup> /хоног	2,327.0	2,444.5	2,758.0

<sup>1</sup> 2011 оны байдлаар

## 2. БНХАУ-ЫН ШАНХАЙ ХОТ

Шанхай нь БНХАУ-ын төв засгийн газрын шууд харьяанд байдаг 4 хотын нэг бөгөөд хамгийн том аж үйлдвэр, худалдааны хот юм. Шанхай хот нь Хятадын зүүн нутгийн тэнгисийн эргийн мөрний цутгаланд оршсон газар зүйн таатай нөхцөлтэй бөгөөд нийт метрополи газар нутаг нь 20 гаруй сая хүнтэйгээрээ дэлхийн хамгийн том хотын бүсүүдийн нэг болдог.

Шанхай хот нь анх загасны аж ахуй, даавууны үйлдвэрлэл явуулдаг тосгон байсан боловч XIX зуунаас байр суурьтай болж, 1842 онд англичууд орон нутгийн оршин суугчдын эсэргүүцэлтэй тулгарсан хэдий ч Шанхайг эзэлсэн бөгөөд “Нанкийн” гэрээний дагуу хотыг гадаад улс орнуудтай худалдаа хийхийг зөвшөөрснөөр зүүн, барууны хоорондох худалдаа арилжааны төв, гадаад худалдаа наймааны нээлттэй боомт болгон зарлажээ.

Нанкийн гэрээ байгуулагдсаны дараахан 1843 оны «Нэмэлт тогтоол» болон Хятад-Америкийн, 1844 оны «Васяний гэрээ»-ний дагуу англичууд, дараагаар нь францчууд Шанхайд газар нутгийн эрхтэй болж, 1850 оны сүүлчээр Америкчууд концессийн дагуу мөн газартай болж америкчуудын оршин суурьших эхлэлийг тавьсан. Шанхайд гадаадынхан орж ирснээр гадаад худалдаа наймаа болон урлаг соёлын хувьд хурдан хөгжиж Хятадын гол хотуудын нэг нь болов.

Солонгосыг хянах 1894-1895 оны Япон-Хятадын дайн нь Симоносекийн гэрээнд гарын үсэг зурснаар төгсөж, үүний дараагаар Шанхай дахь гадаад гүрнүүдийн тоог Япон улс нэмэгдүүлсэн бөгөөд Япончууд Шанхайд өөрсдийн анхны үйлдвэрийг барьж, энэхүү жишгийг даган бусад улс орнууд ч үйлдвэрээ барьснаар Шанхайн үйлдвэрлэлийн эхлэлийг тавьсан байна.

Шанхай нь аажмаар Алс дорнодын санхүүгийн төв болж байв. 1927 онд Шанхай онцгой хотын статустай болж, 1930 оны 5 сард төв засгийн удирдлагатай хотын тоонд оржээ. 1937 онд Японы арми Шанхайг эзэлж, 1945 он хүртэл эзлэн түрэмгийлэгч япончуудын гарт байжээ.

1949 оны 5-р сарын 27-нд Гоминданы цэргүүд Шанхай хотыг коммунистуудад өгч гадаадын ихэнх фирм, оффисууд Хонг-Конг уруу шилжин нүүж, гадаадын хөрөнгө оруулалт бүрэн зогсож, эдийн засаг нь маш хурдацтайгаар буурсан.

1950, 1960 онуудад аж үйлдвэрийн чухал төв болж Хятадын коммунист намын зүүний хүчний суурь нь болжээ. Соёлын хувьсгалын үед ч үйлдвэрлэлийн төвшин нь өндөр байж нийгмийн тогтвортой байдлыг хадгалж чаджээ. Удаан хугацааны туршид Шанхай нь бусад Хятадын муж болон хотуудтай харьцуулахад хамгийн ихээр татварын орлогыг бүрдүүлсэн байна.

Хятадын хувьд гадаад худалдааг нээлттэй хөгжүүлэх бодлогыг 1979 оноос эхлэн Гуанжоу болон Шэньжэнь хотуудаас эхэлсэн бөгөөд 1984 онд Шанхай хотыг нээлттэй хөгжүүлэх шийдвэрийг Төрийн зөвлөлөөс гаргасан байна.

Шанхай хот нь 1991 оноос эхлэн өөрчлөн байгуулах зөвшөөрлийг авч, эдийн засгийн шинэчлэл хийж, хотын гадаад худалдааны нээлттэй бүсээр Пүдун дүүргийг тодруулан худалдаа, эдийн засгийн уян хатан, хөнгөлөлттэй бодлого хэрэгжүүлж эхэлсэн байна.

1992 оноос эхлэн Шанхай хотын дарга байсан Цзян Цзэмин тэргүүтэй Төв засгийн газар нь Шанхай хотыг Ази номхон далайн бүсийн эдийн засгийн төвүүдийн нэг болгох мөн түүнчлэн Шанхайгаар дамжуулан гадаадын хөрөнгө оруулалтыг Хятад уруу оруулах зорилгоор Шанхай хотын татварын хэмжээг бууруулах үе шаттай бодлого явуулж эхэлсэн бөгөөд Шанхай хотын эдийн засаг Хятадын бусад мужуудаас хамгийн хурдацтай өсөж, эдийн засгийн өсөлт нь жилд 9-15% өсөлттэй байж 2005 он гэхэд дэлхийн хамгийн том боомт болсон байна.

Одоогоор Пүдун дүүрэгт дэлхийн 85 орны бүс нутгаас хөрөнгө оруулалт оруулж, гадаадын нийт 48 банк үйл ажиллагаагаа явуулж байна. Пүдун нь гадаадын хөрөнгө оруулалтаараа Хонгконг, АНУ, Японы дараа орж байгаа, одоо дэлхийн 160 гаруй улс, бүс нутагтай худалдаа арилжаа хийж байгаа Хятадын томоохон худалдааны төв болсон байна.

### 3. БНСУ-ЫН ПУСАН ХОТ

Пусан хот нь 4 сая орчим хүн амтай, Солонгосын хойгийн зүүн өмнөд үзүүрт оршдог Солонгосын хоёр дахь том хот юм. Хотын нутаг дэвсгэр нь 769.8 км<sup>2</sup> ба энэ нь нийт Солонгосын хойгийн газар нутгийн 0.8%-ийг эзэлдэг. Пусан бол өндөр уул, ус мөрөн ба далай тэнгисийн төгс зохицол болсон газрын нэг юм. Газарзүйн хувьд энд бас тэнгисийн эргийн газрууд, наранд шарлагын газрууд, үзэсгэлэнт хадан цохио, явган аяллаар явахад тохиромжтой содон сайхан уулс, хотын энд тэндгүй оргилох халуун рашаануудтай. Дөрвөн улиралтай, хэт халуун биш, хэт хүйтэн биш таатай сайхан уур амьсгалтай.



***Пусаныг Зүүн хойд Азийн бүс нутгийн санхүүгийн төв болгон хөгжүүлэх зорилт***

Өмнөд Солонгос улс бол нийслэл Сөүл хотдоо хэт их төвлөрсөн санхүүгийн тогтолцоотой орон юм. Санхүүгийн тогтолцооны хэт алслагдмал бүтэц нь аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн нийлүүлэлтэд нөлөөлж, улмаар бүс нутгийн харилцан адилгүй тэгш бус хөгжлийн суурь болдог байна.

Тиймээс, Пусан хотыг 1970 оноос Солонгос улсын хөгжлийн (үйлчилгээ, бизнес, санхүүгийн) хоёр дахь төв болгон хөгжүүлэх зорилт тавьжээ. Пусан хотыг бүс нутгийн цаашлаад Олон улсын санхүүгийн төв болгон хөгжүүлэх болсон нь нэг талаас улс орны бүс нутгийн хөгжлийг тэнцвэртэй болгох, нөгөө талаас бүс нутаг дахь аж ахуйн нэгжүүд болон хөрш орнуудын үйлчлүүлэгчдэд тусгай санхүүгийн үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэх боломжийг бүрэлдүүлэх улс үндэснийхээ зорилгыг ханган биелүүлэхэд чиглэжээ.

Пусан хотыг сонгох болсон шалтгаан нь тус хот хүн ам ихтэй (Сөүлийн дараа ордог), бөс даавуу, гутлын үйлдвэрлэл сайн хөгжсөн, газарзүйн байршлын хувьд далай тэнгисээр хүрээлэгдсэн боомт газар бөгөөд ачаа тээвэр, аялал жуулчлал хөгжүүлэх таатай нөхцөлтэй, байгалийн үзэсгэлэн бүрдсэн, уур амьсгал тохиромжтой эртний түүхт хот учраас Өмнөд Солонгос улсын үйлчилгээ, бизнес, санхүүгийн төв болгон хөгжүүлэх зорилт тавьж ажилласан байна.

1990-ээд оны үед Пусаны эдийн засаг гутал, бөс даавуун бүтээгдэхүүн тэргүүтний экспорт огцом буурснаас үүдэн уналтад орсон юм. Гэхдээ 1999 оноос эхлэн Пусан нь ирээдүйд өсч эдийн засгийг үндсээр нь эргүүлэн босгох боломж ихтэй арван стратегийн аж үйлдвэрлэлийг онцгойлон хөгжүүлжээ. Мөн аж ахуйн нэгжүүдээ хэвийн үйл ажиллагаатай байлгахын тулд урьд байсан аж үйлдвэрийн хэрэгслүүдийг өргөжүүлэх оролдлогыг хийсээр ирсэн байдаг.

Дэлхий дахины бизнесийн орчин ба технологийн өөрчлөлтийг харгалзан үзэж Пусан нь өөрийн гол хөгжлийн аж үйлдвэрийн стратегийг 2004 ба 2009 онуудад хоёр удаа дахин төлөвлөж, 2014 онд дөрөв дэх дахин төлөвлөлтийг бас хийсэн юм. Энэхүү дахин төлөвлөлтөөр Пусан хот нь таван гол түлхүүр аж үйлдвэрлэл дээр онцгойлон анхаарахаар төлөвлөсөн байдаг.

Энэ нь боомт хотыг Номхон далайн бүс нутгийн арилжааны тээвэр зууч, мэдээлэл, санхүү, аялал жуулчлалын гол томоохон төв болгож хөгжүүлэх өргөн цар хүрээтэй зорилтын нэгэн хэсэг байв. Эдгээр их хүчин чармайлтын үр дүнд энэ хот нь Зүүн хойд Азийн тэнгисийн нийслэл, дэлхийн томоохон боомтуудын нэг болж чаджээ.

***Пусаны стратегийн таван шинэ аж үйлдвэр (2014 он):***

- Тэнгисийн аж үйлдвэр
- Техник хэрэгслийн эд анги ба материал
- Бүтээлч соёлын аж үйлдвэр
- Био-эрүүл мэндийн аж үйлдвэр
- Мэдлэг, дэд бүтцийн үйлчилгээний аж үйлдвэр

## Үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын үе шат

/Хүснэгт 1/

Стратегийн аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын I шат (1999-2003)		Стратегийн аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын II шат (2004-2008)		Стратегийн аж үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын III шат (2009-2013)	
Ирээдүйтэй аж үйлдвэрүүд	Тэнгисийн замын тээвэр зууч	Гол стратегийн аж үйлдвэрүүд	Тэнгисийн замын тээвэр зууч	Гол стратегийн аж үйлдвэрүүд	Тэнгис (Тэнгисийн тээвэр зууч+Тэнгисийн Био+Загасан бүтээгдэхүүн)
	Аялал жуулчлал		Эд анги ба материалууд		Эд анги ба материалууд
	Софтвэйр		Аялал жуулчлал ба конвенц		Аялал жуулчлал ба конвенц
	Санхүү		Төрөл бүрийн мэдээллийн хэрэгсэл ба Мэдээллийн технологи		Төрөл бүрийн мэдээллийн хэрэгсэл ба Мэдээллийн технологи
	Төрөл бүрийн мэдээллийн хэрэгсэл	Орон нутгийн стратегийн аж үйлдвэрлэлүүд	Санхүүгийн үйлчилгээ (Худалдааны хэтийн төлөв)	Ирээдүйн стратегийн аж үйлдвэрүүд	Санхүүгийн үйлчилгээ
Бүтцийн өргөтгөлийн аж үйлдвэрүүд	Авто машины эд ангиуд		Тэнгисийн Био		Ахмадын таатай орчин бүрдүүлэх
	Усан онгоц барих материалууд		Мөнгө		Анагаах ухааны
	Гутал		Гутал		Хөвөн даавуу ба загварын
	Хөвөн даавуу ба загвар		Тэнгисийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл		Загвар дизайны
	Загасны махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл		Хөвөн даавуу ба загвар		Ногоон энерги

## Эдийн засгийн гол үзүүлэлтүүд

/Хүснэгт 2/

	Эдийн засгийн идэвхтэй хүн ам (1,000 хүнээр)	GRDP (US \$m)	Бага ба дунд бизнесийн үйл ажиллагааны дундаж (%)	Экспорт (US \$m)	Импорт (US \$m)	Контейнер агуулах, зөөх хэмжээ (TEU m)
Пусан	1,693	62,128	71.9	13,560	13,770	17.046
Улсын	25,501	1,241,582	71.1	548,076	519,582	22.55
Хувь	6.6%	5.5%		2.5%	2.7%	75.6
Он	2012	2011	2012	2012	2012	2012

Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнесийн таатай орчныг сайжруулах зорилгоор 2002 онд Эдийн засгийн чөлөөт бүс байгуулсан зэрэг алхмуудыг авч хэрэгжүүлсэн байна. Тэрхүү бүс нутаг нь усан онгоцны тээврийн санхүүжилт, боомтын санхүүжилт ба ирээдүйн зах зээлийн зэрэг бүс нутгийн бизнесийн мөнгө санхүүжилтийн асар их эрэлт хэрэгцээний боломжууд байдаг. Бас Солонгосын зүүн өмнөд бүс нутаг ба Зүүн хойд Азийн Олон Улсын Санхүүгийн Төвийн үүргийг гүйцэтгэх байршлын давуу тал бий.

Тиймээс 2005 онд Өмнөд Солонгосын Засгийн газар бүс нутгийн хөгжлийг тэнцвэртэй болгох үүднээс Солонгосын Биржийн төв байрыг (KRX) Пусан руу шилжүүлэн нүүлгэсэн юм. Пусанд санхүүгийн ажил үйлчилгээний төвлөрлийг бий болгох цаашдын хөгжлийг бодит хэрэг болгох нь төлөвлөсөн дүүрэгт төрийн санхүүгийн байгууллагуудыг шилжүүлэн байрлуулах нь чухал гэж үзжээ.

Пусан хотын байршил нь Похан-аас Квангян хүртэлх Зүүн өмнөд аж үйлдвэрийн бүслүүрийн төв болж байдаг. Үүнийг нийтээрээ Донгнам бүс нутаг гэж нэрлэнэ. 2003 оны байдлаар Зүүн өмнөд Донгнам бүс нутаг ДНБ-ний (GRDP) 27.4% бүтээж байхад Сөүл болон Кюнти муж зэргийг багтаасан Нийслэлийн бүс нутаг нь ДНБ-ний 43.4%-ийг бүтээж байжээ. Тэгэхээр ийнхүү Донгнам бүс нутаг нийт ДНБ-ний чамгүй хувийг оруулж чадаж байгаа нь Пусан хотод санхүүгийн төв болох боломж чадавх байгааг харуулж байсан юм. Гэтэл энэ бүс нутгийн санхүүгийн гүйлгээний нийт хэмжээ 18% байгаа нь өөрийн ДНБ-д оруулдаг хувь хэмжээнээс (27.4%) хавьгүй бага үзүүлэлттэй байгаа юм. Харин Нийслэлийн бүс нутгийн энэ үзүүлэлт нь 54% байсан нь банк санхүүгийн зах зээл үнэхээр нийслэлийн бүс нутагтаа бодсоноос ч илүү их төвлөрснийг харуулж байгаа үзүүлэлт юм.

1997 оны Азийн санхүүгийн хямралаас хойш дотогш чиглэсэн хөрөнгө мөнгөний чухал ач холбогдол бүхий урсгалын үр дүнд Зүүн Азийн бүс нутгийн санхүүгийн өсөлт хурдацтай болсон. Мөн Хятадын эдийн засгийн асар том бөгөөд хүчтэй өсөлт нь Зүүн Азийн эдийн засгийг ихээхэн батжуулж өгсөн. Ингэснээр Зүүн Азийн улс орнуудын дундах Санхүүгийн төвийн хөгжил ба өрсөлдөөн мэдэгдэхүйц өрнөсөн.

Пусан бол өнө эртний түүхт боомт хот бөгөөд далайн эрэг дагуух наран шарлагын газрууд, үзэсгэлэнт уулс, Накдонг мөрөн тэргүүтэн байгалийн сайхан цогцолсон газар тул Солонгосын дайнаас хойш энд зочлох гадаадын жуулчдын тоо жил ирэх тутам өссөөр ирсэн ба, 2002 онд 2 саяд хүрч байжээ. Мөн Пусаны Олон Улсын Кино Наадам нь дэлхийд 5-д ордог төдийгүй чухамхүү Венецийн Кино Фестивалийн адил хэдийнээ дэлхийн зэрэглэлийн кино фестивалийн нэг болж хөгжжээ.

“Fortune” сэтгүүлээс (Fortune magazine) 1998 онд Пусаныг бүхэл Ази дахь бизнесийн хамгийн таатай 10 газрын нэгээр сонгосон байдаг байна. 2000 оны 12-р сард Хонгконгийн “Азийн долоо хоног” (Asia week) сэтгүүлээс Пусаныг Ази дахь амьдрахад хамгийн таатай 10 газрын нэгээр сонгон нэрлэсэн байдаг. “Дэлхийн Хоёрдугаар Лотте” (“the Second Lotte World”) гэж нэрлэгддэг 465 метр өндөр барилга нь Пусаныг төлөөлөх нэгэн зүйл онцгой нэрийн хуудас ба энэ мэт өөрчлөлт хөгжилт нь бизнес ба аялал жуулчлалыг нэмэгдүүлэх хэрэгсэл болж иржээ.

### ***Пусаныг бүс нутгийн санхүүгийн төв болгох үндсэн чиглэлүүд***

2003 онд зохион байгуулагдсан Сөүлийн Санхүүгийн форумаас Солонгос улс нь үл хөдлөх хөрөнгө цуглуулах, үл хөдлөх хөрөнгө хуваарилах, үл хөдлөх хөрөнгө худалдаалах ба зах зээл бүрэлдүүлэх чиглэлд илүүтэй анхаарсан Олон улсын санхүүгийн төв хөгжүүлэх шаардлагатай гэж үзжээ.

Пусан нь 1970-аад оноос хойш өөрийн бүс нутгийн хөгжлийн стратегийг өөрчлөн боловсруулж, Солонгосын эдийн засгийн зүүн өмнөд бүс нутгийн төв менежментийн үүргийг гүйцэтгэж иржээ. Пусан нь олон удаа Азийн урлагийн их наадам, Пусаны олон улсын кино наадам гэх зэрэг олон улсын хэмжээний арга хэмжээ, баяр наадмыг зохион байгуулсан байдаг.

Пусан нь Зүүн хойд Азийн гол төв боомт болох зорилгоор шинэ боомтыг барих гэх зэргээр дэд бүтцээ тэлэн хөгжүүлж 21-р зууны Зүүн хойд Азийн худалдаа болон ханган нийлүүлэгч

төв болохоор шамдаж байна. Үүний зэрэгцээ Пусан нь авто машин, мэдээлэл, харилцаа холбоо, био аж үйлдвэрлэлийн зэрэг өндөр технологийн аж үйлдвэрүүдийг маш идэвхтэй хөгжүүлж байгаа юм. Мөн дээр дурдсанчлан, Солонгосын зүүн өмнөд бүсийн болон Зүүн хойд Азийн санхүүгийн төв болгох үүднээс Солонгосын биржийг Пусанд шилжүүлэн байгуулсан билээ.

Хэдийгээр эдгээрийн олонхыг нь эхлүүлчихсэн боловч Пусан нь өнөөг хүртэл хийж бүтээснээсээ илүү их үндсэн өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай байгаа юм.

Пусан нь 4 сая орчим хүн амтай Сингапуртай хэмжээний хувьд бараг адил. Бас дээр дурдсанчлан Пусанд Олон улсын санхүүгийн төв (ОУСТ) болох боломж чадавх их бий гэж олон улсын эдийн засагчид тодорхойлсон байна. Тиймээс, Сингапур, Люксембург, Дублин ба Хонконг-д авч хэрэгжүүлсэн стратеги бодлогууд нь Пусаны хувьд маш чухал жишээ загвар болдог.

2009 онд Өмнөд Солонгосын Засгийн газраас Сөүл болон Пусаныг санхүүгийн төвүүд гэж албан ёсоор зарласан байна. Пусан нь усан тээврийн санхүүгээр мэргэжсэн санхүүгийн төв болох төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байгаа. Ингэснээр Солонгосын санхүүгийн аж үйлдвэрлэлийн хөгжлийг тэнцвэржүүлнэ гэж үзэж байгаа юм.

Аль нэгэн хот ОУСТ болоход байгууллагууд, хүн ам ба зах зээл чухал шаардлагатай. Үүнд багагүй тооны санхүүгийн болон бусад худалдаа арилжааны байгууллагуудтай, санхүүгийн салбар болон маш уян хатан санхүүгийн зах зээлийн орчинд ажиллах мэргэжилтний нөөц хангалттай байх шаардлагатай. Энэ чиглэлээр Солонгосын санхүүгийн зах зээл ба үл хөдлөх хөрөнгийн менежментийг Хонконг болон Сингапурын туршлагаар хөгжүүлж болох олон шинж ажиглагддаг гэж судлаачид үздэг байна.

Хөрөнгө оруулагчдын итгэлийг олсон үед л санхүүгийн зах зээл үнэ цэнэтэй болно. Хөрөнгө оруулагчдын энэхүү итгэл нь зах зээлийн дүрэм журам нь илт тод, тодорхой бөгөөд шударга байж төрдөг.

**Үүнд хамгийн гол нь санхүүгийн үйл ажиллагааны бүх талыг зохицуулсан олон тооны хууль журамтай байхад биш харин байнгын тогтмол үйл ажиллагаа, ил тод дүрэм журамтай, зах зээлийн буруу үйл үйлдлийн шийтгэл нь шударга бөгөөд зөв учир шалтгаантай байх явдал байдаг байна.**

ОУ-ын санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд бас нэгэн чухал нөхцөл бол улс төр ба нийгмийн тогтвортой байдал юм. Ийм тогтвортой байдлыг бүрэлдүүлэхэд улс төрийн хүрээнийхний авилгыг арилгах, улс төрийн шийдвэрүүд нь ил тод байх, хөдөлмөр болон менежментийн хоорондох хамтын ажиллагаанд хөдөлмөрийн маргааныг бууруулах зэрэг нь их чухал. ОУ-ын санхүүгийн төвийг байгуулахад эдийн засгийн өсөлт их чухал хөрс болно.

Мөн тухайн бүс нутагт гадаадын хөрөнгө ба хүний нөөцийн урсгалыг оруулах шаардлагатай. Хүн амын орлогын болон корпорацийн татвар гэхчлэн татварын систем нь гадаадын үндсэн болон хүний хөрөнгөнд таатай байх шаардлагатай. Санхүүгийн дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, улмаар олон улсын түвшний маш идэвхтэй сүлжээ болох, санхүүгийн зах зээлээ давшингуй болгох, амьжиргааны түвшнийг сайжруулах зэрэг ажлууд нь ОУ-ын санхүүгийн төв болох тухайд маш чухал байдаг байна.

**Пусанд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын таатай орчныг бүрдүүлэх эдийн засгийн хөшүүрэг арга хэмжээнүүд**

/Хүснэгт 3/

<b>Пусаны Хөрөнгө оруулалтыг татах сан</b>	Дүн хэмжээ	-180 сая ам. доллар
	Зорилтот үйл ажиллагаа	-Гол томоохон аж үйлдвэрийн конгломерат, гадаадын хөрөнгө оруулалт, өргөн цар хүрээтэй хөрөнгө оруулалт
	Хэрэглээ	-Урт хугацааны ба үнийн түрээс -Бэлэн мөнгөний тэтгэмж ба бага хүүтэй зээл
<b>Бэлэн мөнгөний тэтгэмж</b>	Албан хаагчдыг сургах тэтгэмж	-Дүн хэмжээ: 20 эсхүл түүнээс дээш тоогоор шинэ ажилтан ажилд авах үед ажилтан бүрд сард KRW500,000 хүртэл -Хязгаар: KRW200 сая -Хугацаа: 6 сар хүртэл
	Зөвлөгөөний тусламж	-Дүн хэмжээ: 30% хүртэлх зөвлөгөө авах төлбөр (санхүү, хуулийн, г.м.) -Хязгаар: KRW20 сая -Хугацаа: 6 сар хүртэл
<b>Газар худалдан авалтын/эсхүл Түрээсийн төлбөрийн тэтгэмж</b>	Худалдан авалт	-Худалдан авалтын үнийн дүнгийн 30% хүртэлх тусламж тэтгэмж
	Түрээсийн төлбөрөөс чөлөөлөх	-1 сая ам доллар буюу түүнээс дээш хэмжээний өндөр технологийн бизнесийн хөрөнгө оруулалт: 100% -Чөлөөт Худалдааны бүсэд оршдог бизнес: 100% -5 сая ам. доллар эсхүл түүнээс дээш үйлдвэрлэлийн бизнесийн хөрөнгө оруулалт: 50-70%
	Тусламж тэтгэлэг	-Гадаад хөрөнгө оруулалтын эдийн засгийн зэрэг үр нөлөөнөөс шалтгаалан түрээсийн тэтгэмж өгөх боломжтой
<b>Татвараас чөлөөлөх/Хөнгөлөх</b>	Корпорацийн татвар/ орлогын татвар	-Эхний 3 жил: 100%, Удаах 2 жилд: 50%
	Орон нутгийн татвар (Эзэмшин авалтын татвар, Бүртгэлийн татвар, Эд хөрөнгийн татвар)	-Эзэмшин авах/Бүртгэлийн татвар: 100% -Эд хөрөнгийн татвар: Эхний 7 жилд: 100%, удаах 3 жилд: 50%
	Тариф	-Чөлөөт Худалдааны Бүс: Татваргүй -Чөлөөт Худалдааны Бүс: капитал бараанд 3 жилийн турш татвараас чөлөөлөх

#### 4. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

Казахстан улс тусгаар тогтносны дараа улс төрийн болон зах зээлийн шинэ нөхцөлд улс орноо хөгжүүлэх түүхэн цаг үетэй тулгарсан бөгөөд эдийн засгаа эрчимтэй хөгжүүлэх арга хэмжээний нэг нь эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулсан явдал юм.

Улмаар өрсөлдөх чадвар өндөр, үр ашигтай үйлдвэрүүдийг эрчимтэй хөгжүүлэх, эдийн засаг болон бусад салбаруудад хөрөнгө оруулалт хийх, шинэ техник технологи нэвтрүүлэх, иргэдийг ажлын байраар хангах зорилгоор эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулжээ.

Казахстанд 1991-1992 онуудад бүс нутгийн онцлог, давуу байдалд түшиглэн эдийн засгийн тусгай бүсүүд хөгжиж эхэлсэн байна. Үүнд:

- 1991 онд Жезказганд Жайрем-Атасу;
- 1992 онд Мангыстау эдийн засгийн тусгай бүс;
- 1992 онд Талдыкорганд Алатау, Жаркент;
- 1992 онд Талдыкорганвнеш сервис;
- 1992 онд Зүүн Казахстаны эдийн засгийн тусгай бүс;
- 1994 онд Алматыд Атакент чөлөөт худалдааны бүс;
- 1996-1999 онуудад Костанайд Лисаковск;
- 1996-1999 онуудад Кызылорда эдийн засгийн тусгай бүс;
- 1996-1999 онуудад Акмола эдийн засгийн тусгай бүс (1999 оноос Астана, 2001 оноос Астана-шинэ хот гэж нэрлэх болсон) орно.

Эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулахын тулд эхлээд холбогдох хууль тогтоомжуудыг боловсруулсан байна. 1990 онд Эдийн засгийн тусгай бүсийн тухай анхны хууль батлагдсан бөгөөд үүнд эдийн засгийн тусгай бүс гэх ойлголтыг тодорхойлсон. 1994 онд Эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг зохицуулах журмын тухай Ерөнхийлөгчийн зарлиг, 1996, 1999, 2007, 2011 онуудад Эдийн засгийн тусгай бүсийн тухай хуулийг<sup>2</sup> тус тус гаргасан.

Эдийн засгийн тусгай бүсүүд нь эдгээр хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хуулийн дагуу Ерөнхийлөгч тусгай бүс байгуулах эрх олгодог. Тус улсын хуулиар эдийн засгийн тусгай бүс байгуулж үйл ажиллагаа явуулах хугацаа нь 25 жилээс хэтрэхгүй.

Анхны эдийн засгийн тусгай бүс нь 1991 онд байгуулагдсан Жайрем Атасу чөлөөт эдийн засгийн бүс юм. Түүний дараа Атырау, Зүүн Казахстан, Караганды, Мангыстау зэрэг чөлөөт эдийн засгийн бүсүүд байгуулагдсан.

Эдгээр бүсүүдийн зарим нь амжилтад хүрээгүй, эдийн засгийн үр ашгаа өгөөгүй бол зарим нь амжилттай болж, сайн үр дүнд хүрчээ.

Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхийн тулд 1997 оноос Алматы, Көкшетау, Караганды, Кызылорда зэрэг 4 газар хөгжлийн стратеги төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлж эхэлсэн.

Жайрем-Атасу нь газрын баялагтай уул уурхайн бүс тул уг бүсийн хөгжилд ихээхэн анхаарал хандуулсан байна. Үүний үр дүнд Жайрем нь төмрийн хүдэр олборлолт, марганец боловсруулалтаараа улсад тэргүүлэх болсон. Улмаар марганецын хүдэр өнгөлөх, баяжуулах үйлдвэр, цайр болон хар тугалга үйлдвэрлэх металлургийн үйлдвэрүүдийг байгуулсан нь уул уурхайн үйлдвэрлэл улам сайн хөгжих алхам болжээ.

Ийнхүү эдийн засгийн тусгай бүсүүд үр ашгаа өгч улс орны хөгжилд сайнаар нөлөөлсөн хэдий ч зарим бүсүүдийн хувьд муу үр дагаварт хүрсэн байна. Зарим бүсэд хэрэгжүүлсэн эдийн засаг, үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээ нь шударга бус өрсөлдөөн хөгжих болон бусад шалтгааны улмаас үйлдвэрлэлийн өсөлт үр ашиггүй эдийн засаг саарахад хүрсэн тул тэдгээр бүсүүдийн тусгай эрхийг хүчингүй болгож хаахад хүрчээ. Тухайлбал, Атырау, Зүүн Казахстан, Караганды, Мангыстауд байсан эдийн засгийн чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг зогсоосон байна. Зогсоох болсон гол шалтгаан нь бүсийн эдийн засгийн хүчин чадлыг урьдчилан тооцоолоогүй явдал юм. Түүнээс гадна, орон нутгийн удирдлагыг чөлөөт бүсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, татвар болон төсөв мөнгийг зарцуулах эрх мэдлээр хангаагүй байдал нөлөөлсөн байна. Үр ашигтай байж чадаагүй

<sup>2</sup>Закон о специальных экономических зонах в Республике Казахстан <http://adilet.zan.kz/kaz/docs/Z1100000469>

тул ихэнх эдийн засгийн тусгай бүсүүдийн үйл ажиллагааг 1999 онд Ерөнхийлөгчийн зарлигаар зогсоосон.

2000 он хүртэл идэвхтэй үйл ажиллагаа явуулж ирсэн бүс нь Астана-шинэ хот юм. Астанад эдийн засгийн тусгай бүсийг байгуулснаар тус хотын хөгжилд, ялангуяа барилга хот байгуулалтад чухал хувь нэмэр оруулсан. Бүсийн эдийн засгийн үйл ажиллагаанаас олсон ашгийн 60 хувь хотын санд хуримтлагддаг бөгөөд энэ нь Астана хотыг байгуулж, бүтээн байгуулалтын ажлыг санхүүжүүлэх гол эх үүсвэрийн нэг байв. Астана хотыг байгуулахад 2 тэрбум гаруй долларын хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд түүний 70%-ийг дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлжээ.

Хэдийгээр 1991-2000 онуудад байгуулагдсан эдийн засгийн тусгай бүсүүд нь үр дүн муутай болсон ч 2001 оноос шинэ бүсүүдийг байгуулж эхэлсэн.

2000 оны дунд үеэс дээд технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд Караганды болон Астанад үйлдвэрлэлийн бүсүүдийг байгуулах ажлыг эхлүүлсэн.

Казахстанд 2001-2012 онуудад дараах эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулжээ. Үүнд:

- 2001 онд Астанад Астана-шинэ хот;
- 2003 онд Алатауд Мэдээллийн технологийн парк;
- 2005 онд “Онтүстик”-Өмнөд бүс нутгийн эдийн засгийн тусгай бүс;
- 2006 онд Актау тэнгисийн боомт;
- 2008 онд “Бурабай”;
- 2011 онд Карагандыд “Сарыарка”;
- 2011 онд Алматыд “Хоргос-Шыгыс какпасы”;
- 2011 онд Павлодар—Зүүн хойд бүс нутгийн эдийн засгийн тусгай бүс;
- 2012 онд “Тараз” химийн парк тус тус байгуулагджээ.

Эдийн засгийн тусгай бүс нь хөрөнгө оруулагчдад татвараас чөлөөлөгдөх, татварын хөнгөлөлт эдлэх, газрын татвараас чөлөөлөгдөх зэрэг давуу байдлыг олгож байна.

2006 оноос Актау тэнгисийн боомтыг хөгжүүлж, үйл ажиллагааг нь өргөжүүлэх бодлого баримталсан бөгөөд үүний үр дүнд газрын тосны экспорт 2 дахин өсч, жилдээ 11-ээс 23 сая тонн хүртэл нэмэгдсэн байна.

“Арселор Металл” компани уг боомтод зориулалтын хоолойнуудыг барьсан нь газрын тосны үйлдвэрлэл өсөхөд чухал хувь нэмэр оруулжээ.

Алатау дахь Мэдээллийн технологийн парк нь үндэсний хэмжээний томоохон төслүүдийн нэг бөгөөд Төв Азид дээд технологи бүхий үйлдвэрлэлийн анхдагч юм. Уг төсөл эхэлснээс хойш 5.3 тэрбум ам. долларын хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд 1,100 гаруй хүнийг ажлын байраар хангасан. Энэхүү төсөлд 63 байгууллага хамрагдан мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

“Онтүстик” эдийн засгийн тусгай бүсэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд “Хлопкопром-Целлюза” целлюз болон хөвөнгийн түүхий эдийн үйлдвэр, “Оху Textile” нэхмэл утасны үйлдвэр, “АГФ Групп” оёдлын үйлдвэр, “Kagaz Shahary SEZ” цаасны үйлдвэрүүд нээгдэж үйл ажиллагаа явуулж байна.

Павлодар эдийн засгийн тусгай бүсэд аж үйлдвэрийн болон газрын тосны химийн үйлдвэрүүдийг байгуулсан.

Ийнхүү эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулснаар хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлсэн бөгөөд богино хугацаанд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж чадсан.



Казахстанд 1991-2000 онуудад 140 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийгдсэн бол 2012 оны байдлаар 160 тэрбум доллар хүртэл өссөн байна. Нидерланд, АНУ, Хятад, Япон, Их Британи зэрэг улсууд гол хөрөнгө оруулагчид юм.

Эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулах нь эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэн, ард иргэдийг ажлын байраар хангаж, амьжиргааг дээшлүүлэх чухал алхам болсон. Энэ ажлыг эхлүүлсэнээр эдийн засгийн тусгай бүстэй холбоотой хууль тогтоомжуудыг гаргаж, найдвартай бөгөөд үр ашигтай хөрөнгө оруулагчдыг татан, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлж чадсан.

1990-ээд оны эхээр эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулах төсөл хөтөлбөрүүдийг дөнгөж хэрэгжүүлж байсан үед мэдлэг, туршлага дутсанаас тэдгээр бүсүүдийн ирээдүй бүрхэг, үр ашиггүй байдалд орж байсан ч алдаа дутагдлаасаа суралцаж үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлсний үр дүнд амжилтад хүрч, чамгүй туршлага хуримтлуулсан юм.

Түүнээс гадна дараах давуу талуудыг бий болгожээ. Үүнд:

- Дотоодын болон гадаадын байгууллагуудад хөнгөлөлт үзүүлж, бизнесийн таатай орчин бүрдүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлсэн;
- Дэд бүтцийн хөгжил сайжирсан;
- Төрөл бүрийн үйлдвэрийн салбарууд нэмэгдэж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн;
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн;
- Шинэ ажлын байрууд бий болж, иргэдийг ажлаар хангах боломж нэмэгдсэн;
- Барилгын салбарын хөгжилд ахиц гарсан.

Нэг үгээр хэлбэл, эдийн засгийн тусгай бүсүүдийг байгуулсан нь тус улсын эдийн засгийг тогтворжуулах, улмаар эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан. Цаашид ч эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжүүлэх бодлого барьж байна.

## 5. КАНАДЫН ТОРОНТО ХОТ

Онтарио мужийн нийслэл Торонто хот нь Канадын санхүү, аж үйлдвэрлэл, соёлын хамгийн том хот юм. Тус хотын улбаа бүр мөстлөгийн үеэс эхлэлтэй боловч 1793 онд Британийн колоничлогчид Йорк хотыг байгуулсан үеэс хотын түүхийн эхлэл тавигдсан гэж үздэг байна. Торонтогийн нутаг дэвсгэр дээгүүр “Simcoe”, “Huron” гэх 2 том нуурын ус урсан өнгөрдөг нь загас агнуурын аж ахуй хөгжих болон амьдрах таатай орчинг бүрдүүлж өгсөн гэж үздэг. Канад орон дэлхийн хамгийн өндөр хөгжилтэй баян орнуудын нэг болсон нь тус улсын байгалийн баялаг, эдийн засгийн олон тулгуурт бодлоготой холбоотой гэж үздэг. Мөн бусад орон, тэр дундаа АНУ-тай хийх худалдаа, эдийн засгийн харилцаа нь тус орны хөгжилд ихээхэн түлхэц үзүүлжээ. Дашрамд дурдахад, Канад болон АНУ-ын хооронд орших хилийн зурвас, орчин үед дэлхий дээр оршиж байгаа хил хязгааруудаас хамгийн урт нь юм.

1951 оноос Торонто нь улс төр, эдийн засаг, нийгэм соёлын хувьд бүхэлдээ өөрчлөгдөж эхэлсэн гэж үздэг. 1951 оны байдлаар Торонто нь одоогийн засаг захиргаа, газар нутгийн хэмжээнээс 8 дахин бага, одоогийн ихэнх бүс нь тухайн үед хөдөөгийн бүсэд тооцогдож байсан байна. Тухайн үед хүн амын 73 хувийг Британичууд эзэлдэг, мөн хүн амын 69 хувь нь Канадад төрсөн хүмүүс эзэлж байсан баримт байдаг. Бусад үндэстэн ястны бүрдүүлж байгаа 27 хувь нь XX зууны эхээр хүн амын 8 хувийг эзэлж байв. Энэхүү үзүүлэлт өссөн буюу хүн амын дунд олон үндэстэн ястны эзлэх хувь үлэмж нэмэгдсэн нь 1951 оноос Торонтод шилжин ирэх цагаачдын урсгалыг хурдасгасан гэж үздэг байна. Тэд Торонтог зорин ирэх дүрвэгсэд, цагаач, эдийн засгийн цагаачдыг дэмжин, харилцан туслалцсан явдал нь одоогийн Торонтогийн хөгжилд хүрэх, бүтээн байгуулалтыг бий болгох чухал



хүчин зүйл болсон байна. 2001 оны байдлаар Торонтогийн оршин суугчдын 50-иас илүү хувь нь Канадад төрж өсөөгүй хүмүүс байжээ.

1950 оноос Канадын цагаачлалын хуулиар Герман, Италийн, 1960 оноос гуравдагч орнуудын цагаачдыг хүлээн зөвшөөрсөн нь хүн амын тоо, түүний бүтцэд эзлэх цагаачдын тоо, бүрэлдэхүүнийг ихэд өөрчилсөн байна. 1970 он гэхэд цагаачдын дийлэнх хувийг Европоос бусад газраас ирсэн цагаачид бүрдүүлэх болсон байна. 1720 онд анх Франц худалдаачид Торонтод ирж 1759 он гэхэд цагаачид арилжаа наймаа эрхлэх болж, худалдаа арилжааны гол төв цэг болсон.

Цагаачдын урсгалтай холбогдон ялгаварлан гадуурхах, мөлжлөг, ажил хөдөлмөрийн тэгш бус байдал зэрэг олон асуудлуудыг шийдвэрлэх үүднээс мужийн захиргаанаас олон арга хэмжээг дэс дараалан авч хэрэгжүүлсэн байдаг. Ажил олголтын тэгш байдлын тухай хуулийг 1954 онд баталж, сургууль, нийгмийн байгууллагууд компанит ажлуудыг идэвхтэй өрнүүлэх болсон.

Торонто хотын хамгийн гол ололтын нэг бол яах аргагүй олон үндэстний соёлын үнэт чанарыг зориуд хэвээр хадгалан авч үлдсэн орон нутгийн удирдлагын бодлого бөгөөд “Хотын өнгө төрхийг илтгэх гол хүчин зүйлийг бид олон төрлийн үндэстний онцлог” хэмээн үзэж байна гэж төлөвлөгөөнийхөө зорилт болгон тавьсан байдаг.

Төрийн алба өсөж буй олон соёл үндэстний энэхүү орчинг хэвээр нь хадгалах, 1970-аад оноос олон соёлт нийгмийн талаарх бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн байна. Нийгэмд үйлчлэгч сайн санааны олон байгууллагууд байгуулагдаж энэ асуудалд анхаарлаа хандуулж эхэлсний нэг жишээ нь 1956 онд байгуулагдсан Нэгдсэн зам хэмээх сайн санаа тусламж үйлчилгээний аян юм. 1787 онд Англичууд Торонтогийн 1000м2 газар нутгийг өөрийн мэдэлд авсан бөгөөд үүний дараа Торонто хотыг Йорк хэмээх нэрээр сольсон бөгөөд Йорк хотыг Канадын шинэ нийслэл болгохоор төлөвлөж байжээ. Мөн Йорк хотыг засаг захиргааны хот болгохоор төлөвлөж Парламентын байшинг барьж эхэлсэн байна.

1813 оны дайны үеэр Йорк хотод их хэмжээний хохирол учирч парламентын ордноо хүртэл шатаалгаж байсан бол дайны дараа 1834 онд Йорк хотыг буцаан “Торонто” хэмээн нэрлэсэн байдаг. Энэ хугацаанд Английн колонийн бодлогыг эсэргүүцсэн эсэргүүцэл хэд хэдэн удаа гарч байсан боловч төдийлөн амжилт олоогүй байна. XIX зууны үед Торонто хот цагаачлалын томоохон хот болон хувирсан байна. Торонто хот 1849-1852, 1856-1858 онуудад Канад улсын нийслэл байсан түүхтэй. 1867 оноос Торонто хот нь албан ёсоор Онтарио мужийн төв болсон. Ерөнхийдөө Торонто хотыг 11 000 жилийн түүхтэй хот гэж үздэг.

XIX зуунд Торонто хотод хот дамжсан төмөр зам баригдаж түүнийг даган их хэмжээний цагаачид орж ирэн аж үйлдвэр эрчимтэй хөгжиж эхэлсэн байна. Төмөр зам болон далайн боомтууд нь Хойд Америкийг дэлхийтэй холбох гүүр болж өгсөний зэрэгцээ төмөр зам болон далайн боомтуудыг өргөжүүлэн хөгжүүлсэн нь тус улсын нүүрсний экспорт импортод сайнаар нөлөөлж чадсан гэж дүгнэдэг байна.

Цагаачлалын үеийн дийлэнх хэсгийг дэлхийн II дайнаар дүрвэгсэд, мөн Унгар, Голланд, Вьетнамын хямралаас шалтгаалан дүрвэгсэд эзэлж байсан боловч өдрөөс өдөрт өсөн дэвжиж буй Торонтод шинэ боломж сайхан амьдралыг хайн ирсэн Канадын олон олон иргэдийн шилжих хөдөлгөөн урсгалыг дурдах хэрэгтэй юм. Канадад ерөнхийдөө барууны дэглэм, коммунист үзэл суртлаас дүрвэгч, дээрх орнуудын цагаачдыг хүлээн авах бодлогын улмаас Торонтод цагаачдын хүрээнд харьцангуй уламжлалт улс төрийн соёл тогтсон байна.

Энэ үед хүн амын өсөлт болон цагаачлалаас үүдэлтэй өсөлттэй холбогдон Торонтогийн ойр орчим газруудыг хотжуулах үйл явц чухлаар тавигдаж эхэлсэн. Иргэд хотынхоо ойролцоо байшин барьж ихээр суурьшиж эхэлсэн. 1940-1953 оны хооронд хүн амын өсөлт Торонтогийн тогтоосон хязгаараас хоёр зуун мянгаас хол давсан байна. Тухайлбал, 1946 оны байдлаар үйлдвэрлэл эрхлэгчдийн 90% Торонто хотод байрлаж байсан бол 1954 он гэхэд энэ тоо 77% хүртэл буурч хотын гадна хуучин хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж байсан газруудад тэлж суурьшиж эхэлсэн байна. Үүнтэй зэрэгцэн зам харилцааны асуудал дээр ч шинэчлэл хийгдэж, ахиц дэвшил гарч эхэлсэн байна. Тухайлбал, 401 дүгээр хурдны замыг бүрэн ашиглалтад орохоос олон жилийн өмнө иргэдэд зорчих зөвшөөрлийг олгосон байна.

1952 онд дайны дараах төрөлтийн огцом өсөлтөөс шалтгаалан төрөх газруудын тоог нэмэгдүүлэхээс эхлээд орон сууцжуулах ажил, шинэ бүтээн байгуулалт шаардагдаж, хотын зах руу бүтээн байгуулалтын ажлуудыг хийж эхэлсэн байна. Эхэндээ Торонтогийн зэргэлдээх жижиг хотоор төсөөлөгдөж байсан тэр бүтээн байгуулалт дайны дараах анхны томоохон бүтээн байгуулалт болсон төдийгүй, иргэдийн хүсэл тэмүүлэл, эрэлт хэрэгцээ зэргээс улбаалан хөгжиж, одоогийн Торонтогийн гол цөм хэсэгт тэрхүү бүтээн байгуулалтыг хийх болсон байна.

1953 оны 4 дүгээр сард Онтарио мужаас хосолмол бүтцийг буюу Торонто болон түүнийг тойрон орших 12 нутгийн захиргаа нэгдэн Метрополитан Торонто хотыг бий болгосон. Өөрөөр хэлбэл, Метрополитан Торонто болон Торонто гэсэн 2 хотын захиргааг бий болгож, Метрополитан Торонто нь бүс нутгийн асуудал болон орон нутгийн асуудалд үйлчлэх хуучин шүүх эрх мэдлийн үйлчлэх харъяа нутаг дэвсгэрийн асуудлаа хариуцаж, Торонтогийн засаг захиргаа нь 8 жижиг тосгон болон 3 хотын зах орчмын нутаг дэвсгэрийг хариуцан ажиллахаар болжээ. 1966 оны байдлаар тус мужид 13 хот харьяалагдаж байсан байна. 1998 онд мужаас дээрх системийг хүчингүй болгож, Торонто хотын захиргаанд нутаг дэвсгэрийг бүхэлд нь хариуцуулсан байна.

Дээрх зохион байгуулалтыг хийснээр цаг хугацаа болон цахилгаан, усны систем, нийтийн тээврийг хамтран удирдах болсон нь бүс нутагт ихээхэн хэмжээний ашиг болон хэмнэлтийг авчирсан бол 1998 онд бүс нутгийн засаг захиргаанаас тус холбоог эсэргүүцэн задалж одоогийн Торонтог бий болгожээ.

Төвлөрлөөс үүдэн 1953 оноос шинээр зам тавих ажил эрчимжиж төсвийн ихэнх хувийг зарцуулсан байна. Нийтийн тээвэр, метроны шинэ шугамуудыг мөн ашиглалтад оруулж эхэлсэн байна. Мөн дээрх шалтгаанаар 1960 онд хотын захиргаа болон бизнес арилжааны дүүргүүдийг шинэ дүүрэгт нүүлгэн төвлөрүүлсэн байна. 1950-аад он гэхэд Торонто нь мөнгө санхүүгийн зах зээл бизнесийн салбарууд ялангуяа даатгалын зах зээлийн хувьд тухайн үед Канадын хамгийн том төвлөрсөн хот байсан Монреалиас давж эхэлсэн байна.

1860 онд Торонто хотын “Gooderham and Worts whisky”-ний үйлдвэр нь дэлхийн хамгийн том архины үйлдвэр болж өргөжсөн байдаг. 1891 онд анхны нийтийн тээвэр төмөр замын компанийн тусламжтайгаар ашиглалтад орж 1921 онд олон нийтэд хувьцааг тарааж өгснөөр өнөөдөр Торонто хотын нийтийн тээврийн ашиглалт Хойд Америк тивдээ 3 дугаарт бичигдэж байна.

1904 онд Торонто хотын төв галд шатан тухайн үедээ 10 сая ам. долларын хохирол учирч байсан ч хотын дахин сэргээн босголтыг асар түргэн хугацаанд хийсэн байна. 1934 онд Торонтогийн хөрөнгийн бирж Канад улсад хамгийн томд тооцогдох болсон. Канад орон дэлхийн хамгийн өндөр хөгжилтэй баян орнуудын нэг болсон нь тус улсын байгалийн баялаг, эдийн засгийн олон тулгуурт бодлоготой холбоотой гэж үздэг. Мөн бусад орон, тэр дундаа АНУ-тай хийх худалдаа, эдийн засгийн харилцаа нь тус орны хөгжилд ихээхэн түлхэц үзүүлжээ. Дашрамд дурдахад, Канад болон АНУ-ын хооронд орших хилийн зурвас, орчин үед дэлхий дээр оршиж байгаа хил хязгааруудаас хамгийн урт нь юм.

Дэлхийн II дайны дараагаас Торонто хотод дэлхийн өнцөг булан бүрээс цагаачид ирэх болсон нь хямд ажиллах хүчийг бий болгож байсан төдийгүй хотын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан гэж үздэг. Мөн “Quebec” мужийн бослогоос хамааран томоохон орон нутгийн болон бүс дамжсан корпорациуд өөрсдийн оффисыг Торонто хот руу нүүлгэн шилжүүлсэн байна. 1965 он гэхэд үндэсний тэргүүлэгч компаниуд Торонтод төвлөрч 1976 онд Канадын хамгийн том, алдартай хотоор тооцогдож эхэлсэн байна. Үүний шалтгааныг компаниуд Квебек мужийн салан тусгаарлалттай холбогдох маргаанаас үүдэн Монреалиас нүүж Торонтод шилжин ирсэнээр тайлбарладаг байна.

Мөн хотын хөгжилд нөлөөлсөн чухал хүчин зүйл бол хот төлөвлөлтийн ухаалаг зарчим, бодлоготой нь холбоотой гэж үздэг байна. Хотын төвд хүн амын нягтаршилтай уялдуулан амьдралын хэв маягт тааруулж судалгаан дээр тулгуурлан барилга байшин барьдаг бөгөөд ингэснээр хүмүүс өдөр тутам автомашины зайлшгүй хэрэгцээгүйгээр амьдрах боломж олгожээ.

Бас нэгэн нөлөөлж байгаа хүчин зүйл бол төмөр зам болон хурдны замуудын систем юм. Дэлхийн хоёрдугаар дайны дараа АНУ-ын Батлан хамгаалах яамнаас санхүүжүүлэн хот дотор түргэн хугацаанд цэргүүдийг оруулж ирэх зорилгоор ийм хурдны замуудыг барьж эхэлсэн түүхтэй.

Торонто хотын хөгжил дэвшилд өөрийн газар нутгийн давуу тал ихээхэн үүрэг гүйцэтгэсэн гэж үздэг. Учир нь Торонто хот нь өөрийн төмөр зам болон далайн гарцуудаар дэлхийг хойд америктай холбох гүүр болж өгсөн. Үүнийг дагаад цагаачид олноор орж ирэн энэ нь хямд ажиллах хүчнийг бүрдүүлж өгсөн гэж үздэг. Мөн Торонто хотод бүс нутгийн болон үндэстэн дамнасан корпорациудын төв оффисууд байрлаж байсан нь эдийн засгийн хувьд ихээхэн ашигтай байсан. Улмаар Торонто хотын хөрөнгийн биржийн үйл ажиллагаа өргөжиж, Канадаа хамгийн томд тооцогдох болсон байна.

Ер нь Канад улсын туршлагаас харахад, хөгжлөө зөвхөн нэг газар төвлөрүүлдэггүй бөгөөд муж болгоныг өөрийн онцлог, чиглэл чиглэлийн дагуу хөгжүүлэхээс гадна бизнес санхүүгийн төв гээд нэг хот байхад, засаг захиргааны төв нь өөр хотод байх жишээтэй. Тухайлбал, Монреаль нь бизнес санхүүгийн төв байхад, засаг захиргааны төв нь Квебек хот байх жишээтэй.

\*\*\*

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Постановление Правительство Санкт-Петербурга от 13 мая 2014 года N 355 “О Стратегии экономического и социального развития Санкт-Петербурга на период до 2030 года”
2. Шанхай хотын түүх <http://ucoz.com/news/2011-05-19-56>
3. The Official Website of Busan Metropolitan City <http://english.busan.go.kr>
4. Казахстан-2050 стратеги <http://strategy2050.kz>
5. Қазақстандағы арнайы экономикалық аймақтар <http://e-history.kz/kz/books/library/view/583>
6. Қазақстанда 9 арнайы экономикалық аймақ жұмыс істейді <http://inform.kz/kaz/article/2436112>
7. The History of Toronto <http://www1.toronto.ca/wps/portal/contentonly?vgnextoid=ac418d577e312410VgnVCM10000071d60f89RCRD>

**ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БОЛОН ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙ САЛБАР  
ДАХЬ ЗӨРЧИЛ, ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ АСУУДЛЫГ ЭРҮҮГИЙН ХУУЛИАР  
ЗОХИЦУУЛДАГ ЭСЭХ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

*Г.Алтан-Оч (PhD), Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа*

**НЭГ. ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Ихэнх орнуудад хуулиар хориглосон шударга бус өрсөлдөөний дараах нийтлэг 3 хэлбэр байна.

1/ Үнэ тогтоох явдал /price fixing/ Өрсөлдөгч компаниудын хоорондох үнийг өсгөх, тогтоох эсвэл тодорхой түвшинд хадгалах талаар тохиролцдог.

2/ Тендерийн гажуудал /bid rigging/ Төрийн байгууллага худалдан авах тендерийг зориудаар будлиулж, эхнээс нь тендерт ялагчийг тодорхойлж өрсөлдөөн байхгүй болгох замаар үнийг өсгөх явдал юм. Тендерийн гажуудал хэд хэдэн төрөлтэй байж болно.

*Тухайлбал:*

- Аль нэг тохиролцсон компанийг ялуулахын тулд өрсөлдөгч компаниуд тендерт оролцох саналаа татан авдаг.
- Хорших санал өгөх буюу эхнээсээ тендерт ялах ямар ч бололцоогүй хэт өндөр үнэтэй саналыг өгч, тохиролцсон компанид тендерийг ялах боломжийг олгож, өрсөлдсөн дүр харуулдаг.
- Дэд гэрээний арга буюу бага үнэтэй өрсөлдөгч компани тендерт оролцохгүй боловч эргээд түүний шанд тендерт ялсан илүү өндөр үнэтэй компаниас захиалгыг тендерийн дэд гэрээний байдлаар авч, ашгаа хуваана.

3/ Зах зээлийг хуваах явдал /market division/ Компаниуд хоорондоо тохиролцсоны үндсэн дээр зах зээлийг газар зүйн байрлалаар, барааны төрлөөр, эсвэл худалдан авагчийн төрлөөр хуваахыг хэлнэ. Үүнээс гадна шударга бус өрсөлдөөний өөр төрлийн хэлбэрүүд ч байж болох ба дээр дурдсан хэлбэрүүд түгээмэл бөгөөд сөрөг нөлөө ихтэй.

Хэдийгээр ихэнх орнуудад, ялангуяа эрх зүйн хувьд өндөр хөгжилтэй орнуудад шударга өрсөлдөөний талаар хууль баталсан байдаг ч тэдгээр нь харилцан адилгүй байдаг. Гэсэн хэдий ч эдгээр орнуудад шударга өрсөлдөөний талаар дараах зохицуулалт хийж, шударга өрсөлдөөнд харш гурван төрлийн үйл ажиллагааг хориглосон байдаг.

1/ Хөндлөнгөөр болон босоо шугамын түвшинд үгсэж хуйвалдахын эсрэг буюу картелийн эсрэг үйл ажиллагаа<sup>3</sup>

2/ Давамгай байдалтай аж ахуйн нэгж эрх мэдлээ урвуулан ашиглахын эсрэг эрх зүйн зохицуулалт хийж, давамгай байдалтай аж ахуйн нэгж нь бусад өрсөлдөгч, мөн хэрэглэгчдэд сөрөг үр нөлөө авчирч болзошгүй байдаг тул хуулиар давамгай байдалтай аж ахуйн нэгжийн зарим үйл ажиллагааг хориглосон байдаг,

3/ Өрсөлдөгч нь өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулах байдлыг хориглосон байдаг.

Олон улсын хамтын ажиллагааны түвшинд шударга бус өрсөлдөөний эсрэг холбогдох гэрээ, конвенцид нэгдэн орох, ялангуяа /International Competition Network/ Олон улсын өрсөлдөөний санаачилгад нэгдэн орох, улмаар өрсөлдөөний чиглэлээрх дотоодын хууль тогтоомжоо тус стандартад нийцүүлэн өөрчлөх нь үр дүнтэй алхам болно гэж үзэж байна.

<sup>3</sup>хэвтээ (horizontal) буюу нэг салбарын үйлдвэрлэгч, худалдагч, компаниуд хоорондоо эвсэхийг хэлдэг, мөн босоо (vertical) буюу өөр өөр салбар хоорондын хүмүүс хоорондоо эвсэхийг хэлнэ.

Ингэснээр өрсөлдөөнийг хянан зохицуулах газрын хараат бус, бие даасан, асуудал шийдэхүйц эрх мэдэл бүхий эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх. Тухайлбал: Япон, Франц, Солонгос, Тайван зэрэг улсад өрсөлдөөний байгууллагаас гаргасан дүгнэлт, торгууль, шийтгэл нь гарсан даруйдаа хэрэгжих механизмтай, гаргасан шийдвэр нь шүүхийн харьяаллын хувьд зөвхөн хяналтын шатны шүүхээр хянуулдаг зэрэг асуудалтай адилтгах хэрэгтэй.

### **1.1 Шударга бус өрсөлдөөний хэргийг эрүүгийн хуулиар зохицуулдаггүй зарим орны туршлага**

#### **• ЛИТВА УЛС**

Литва Улсад шударга бус өрсөлдөөнтэй холбоотой асуудлыг 1999 онд батлагдсан Өрсөлдөөний тухай хууль болон бусад хуулиар<sup>4</sup> зохицуулна. Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч байгууллага нь үндэсний өрсөлдөөний газар болох Өрсөлдөөний зөвлөл /Competition Council/ байна. Өрсөлдөөний зөвлөл нь дарга болон 4 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийг Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилно. Өрсөлдөөний зөвлөлийн гүйцэтгэх ажлыг тамгын газар нь гүйцэтгэнэ.

Чөлөөт өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагаа явуулахыг хориглосон дүрэм журмын зөрчлийг захиргааны, эсхүл иргэний хэрэг үүсэн хянан шийдвэрлэнэ. Өрсөлдөөний зөвлөл нь өрсөлдөөний бодлогыг улс орны хэмжээнд хэрэгжүүлэх, хэрэг хянан шалгах болон захиргааны шийтгэл ногдуулах эрх, үүрэгтэй байна. Өрсөлдөөний зөвлөл нь өрсөлдөөний тухай хуулийн 23 болон 40 дүгээр зүйлд заасан өрсөлдөөний дүрмийг зөрчсөн зөрчилд хариуцлага ногдуулна.

Бизнесийн үйл ажиллагаа явуулахад ялгаварлан гадуурхсан, давамгайл байдал олгосон, мөн холбогдох зах зээлд үйл ажиллагаа явуулахад өрсөлдөөний ялгавартай нөхцөл бүрдүүлэх шийдвэр гаргасан Литва Улсын төрийн захиргааны байгууллагуудад хариуцлага ногдуулдаг.

Хэргийг Вильнюсийн бүс нутгийн захиргааны шүүхээр шийдвэрлэх бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар, иргэний хэрэг үүсгэсэн тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар тус тус зохицуулна.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>4</sup>Applicable Legislation

1. The 23 March 1999 Law No. VIII-1099 of the Republic of Lithuania "On Competition";
2. The 18 June 2000 Law No. VIII-1871 of the Republic of Lithuania "On Advertisement";
3. The 27 April 2000 Resolution No. 45 of the Competition Council of the Republic of Lithuania "On Approval of the Procedure for Submission and Examination of Notification on Concentration and of Calculation of Aggregate Turnover";
4. Block exemption for vertical agreements, approved by the 27 December 1999 Resolution No. 38 of the Competition Council;
5. Block exemption for certain categories of agreements among carriers in specific transport sectors, approved by the 18 January 2001 Resolution No. 11 of the Competition Council;
6. Block exemption for certain categories of agreements among users of land plots of agricultural purpose, approved by the 27 December 2001 Resolution No. 157 of the Competition Council.

**Түр зуурын арга хэмжээ:**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 144-1 дүгээр заалтад заасны дагуу түр зуурын арга хэмжээ авч болохоор заасан байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 145 дугаар зүйлд түр зуурын арга хэмжээг нарийвчлан заасан бөгөөд Литвийн шүүхийн практикт шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд шаардагдах түр зуурын арга хэмжээг тухайн хэргээс хамааран тогтоодог байна.

Өрсөлдөөний тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу Литвийн Өрсөлдөөний Зөвлөл нь нотлох баримт бүхий Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн зөрчил нь төр, аж ахуйн нэгжид ноцтой хохирол учруулахаас урьдчилан сэргийлж Өрсөлдөөний зөвлөлийн шийдвэрийг гүйцэтгэхэд шаардагдах түр зуурын арга хэмжээ авч болохоор заасан байна. Өрсөлдөөний зөвлөлийн түр зуурын арга хэмжээнд:

1. Аж ахуйн нэгжид хууль бус үйл ажиллагааг таслан зогсоохыг шаардлага хүргүүлэх;
2. Холбогдох шүүхийн зөвшөөрөлтэйгөөр, тухайн зохих арга хэмжээ авахгүй бол тухайн ААН-ийн явуулж буй үйл ажиллагаа нь бусдад их хэмжээний хохирол учруулах бол зохих арга хэмжээ авахыг шаардах эрхтэй байна.

Өрсөлдөөний тухай хуулийн 26-4 дүгээр заалтад заасны дагуу Өрсөлдөөний зөвлөл нь түр зуурын арга хэмжээний шийдвэр гаргахаасаа өмнө Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн гэж сэжиглэгдэж буй ААН-д тайлбар хийх тодорхой хугацаа, боломж олгоно.

Өрсөлдөөний тухай хуулийн 6 дугаар бүлэгт Өрсөлдөөний тухай хуулийг зөрчигчид хүлээлгэх захиргааны хариуцлагын тухай зохицуулсан байна.

**Өрсөлдөөний зөвлөлийн шийдвэр:**

Өрсөлдөөний тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу Өрсөлдөөний зөвлөл нь дараах шийдвэр гаргана:

1. Хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, зөрчлийн улмаас үүссэн үр дагаврыг арилгуулах, түүнчлэн гэрээ байгуулах, хүчингүйд тооцох болон өөрчлөлт оруулах зэргийг шаардах болон тухайн шаардлагыг биелүүлэх нөхцөл болон хугацааг тогтоох;
2. ААН, эсхүл удирдлага нь Өрсөлдөөний зөвлөлд урьдчилан мэдүүлээгүй, эсхүл зөвшөөрөл авалгүйгээр зах зээлд давамгай байдал бий болгосон, эсхүл давамгай байдлаа бэхжүүлсэн төвлөрлийн үйл ажиллагаа явуулсан, эсхүл тухай зах зээлд дахь өрсөлдөөнийг ноцтой хязгаарлах үйл ажиллагаа явуулсан тохиолдолд өмнөх байдалд нь байгууллагыг, хөрөнгө, хувьцаа, эсхүл тэдгээрийн тодорхой хэсгийг нь худалдах, байгууллагын бүтцийг өөрчлөх, гэрээг хүчингүй болгох, эсхүл өөрчлөлт оруулах, зэрэг өмнөх хэлбэрт нь эргүүлэх оруулахыг шаардах болон тухайн шаардлагыг биелүүлэх нөхцөл болон хугацааг тогтоох;
3. Торгууль ногдуулах зэрэг эрхтэй байна.

**• ХЯТАД УЛС**

БНХАУ-ын “Шударга бус өрсөлдөөний эсрэг” хууль нь зах зээлийн эдийн засгийн эрүүл хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлэх, шударга өрсөлдөөнийг хамгаалах, идэвхжүүлэх, шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэх, зах зээлд оролцогч болон хэрэглэгчдийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах зэрэгт үйлчилнэ.

БНХАУ-ын Шударга бус өрсөлдөөний эсрэг хуулиар зах зээлд оролцогчийн бизнесийн нууц, нэр хүндийг хамгаалах талаар болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах талаар нарийвчлан зохицуулсан байхаас гадна хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хянан шалгалт явуулах үе шатуудыг нарийвчлан заасан байна.



/Шударга бус өрсөлдөөний эсрэг хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Хүснэгт 1-ээс үзнэ үү/

Хүснэгт 1.

1	Хяналт шалгалт хийх эрх бүхий албан тушаалтан 16-р зүйл	Орон нутгийн болон түүнээс дээших шатны хянан шалгах эрх бүхий албан тушаалтан
2	Хариуцлагын хэлбэр 20-р зүйл	<ul style="list-style-type: none"> <li>• Хохирлыг барагдуулан нөхөн төлбөр өгөх</li> <li>• Хууль бусаар олсон орлогыг хураан авах</li> <li>• Үйл ажиллагаа эрхлэх лицензийг хүчингүй болгох</li> <li>• Харин хянан шалгах эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн албан үүргээ урвуулан ашиглах, эрх хэмжээг хэтрүүлсэн зэрэг тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</li> </ul>
3	Хохирлыг тооцох хэлбэр 21-р зүйл	<ul style="list-style-type: none"> <li>• Хохирсон этгээдийн хохирлыг тооцоолоход хэцүү үед хохирлын нийт хэмжээ нь тухайн зөрчилтэй үйл ажиллагааны үед зөрчлийн хугацааны туршид олсон ашиг орлого байх болно.</li> <li>• Хууль ёсны эрх ашиг сонирхлыг нь зөрчсөн шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаанд тооцогдох зөрчил гаргасан этгээд нь хохирсон этгээдийн улирлын бүх зардлыг төлнө.</li> <li>• Зах зээлд оролцогч этгээд зөвшөөрөлгүйгээр хуурамч бараа бүтээгдэхүүн, баглаа боодол, чимэглэлийг хэрэглэх, эдгээр нь олонд танил бүтээгдэхүүнтэй андуурах, худалдан авагчид хохирохоор үйлдэл хийсэн хянан шалгалт хийх эрх бүхий албан тушаалтан буруутай үйл ажиллагааг таслан зогсоох, хууль бус орлогыг хураан авч улсын орлого болгох, торгууль оногдуулна. Нөхцөл байдлаас хамааруулан хууль бус орлогын дүнгээс 2 ба 3 дахин их байх мөнгөн торгууль ногдуулна. Нөхцөл байдал илүү хурц бол бизнесийн үйл ажиллагаа эрхлэх лицензийг хүчингүй болгоно.</li> </ul>
4	Эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэх тохиолдол	<p>4.1 Монополь байдалтай аж ахуйн нэгжийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шударгаар өрсөлдөж буй бусад зах зээлд оролцогчдыг гаргах зорилгоор тэдний бараа бүтээгдэхүүний борлуулалтад хязгаарлалт тавьсан монополь байдалд зах зээлд оролцогч этгээд болон олон нийтэд ашигтай компани үйлдвэрийн газар нь дүүргүүдэд хуваагдах мужийн болон хотын шатны хянан шалгалт хийх эрх бүхий албан тушаалтан хуулийн дагуу хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, нөхцөл байдлаас хамаарч 50.000 юаниас их ба 200.000 юаниас бага байх мөнгөн торгууль ногдуулна.</li> </ul> <p>4.2 Давамгайл байдалтай аж ахуй нэгжийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хуулийн дагуу зах зээлд оролцогч этгээд нь давуу талаа ашиглан бараа бүтээгдэхүүндээ хэт өндөр үнэ тогтоож, түүнийгээ худалдан авагчид тулгасан тохиолдолд хянан шалгалт хийх эрх бүхий албан тушаалтан хууль бус орлогыг хураан авч улсын орлого болгох ба нөхцөл байдлаас хамааруулан тус орлогоос 2 ба 3 дахин их байх мөнгөн торгууль ногдуулна.</li> <li>• Зах зээлд оролцогч нь давуу талаа ашиглан хэт өндөр үнэ тогтоож, өндөр үнэтэй бараа бүтээгдэхүүнээ худалдан авагчид тулгасан тохиолдолд хянан шалгах эрх бүхий албан тушаалтан хууль бус орлогыг хураан улсын орлого болгох, нөхцөл байдалд тохируулан хууль бус орлогыг 2 ба 3 дахин илүү мөнгөн торгууль ногдуулна.</li> </ul>

		<p>4.3 Бараа бүтээгдэхүүний талаар олон нийтийг төөрөгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>Зах зээлд оролцогч этгээд нь бусдын бараа бүтээгдэхүүний талаар олон нийтийг төөрөгдүүлэх худал мэдээлэл өгсөн зар сурталчилгаа явуулсан тохиолдолд холбогдох хянан шалгах эрх бүхий албан тушаалтан уг хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, үүссэн үр дагаврыг арилгах, мөн нөхцөл байдлаас хамааран 10.000 юаниас их ба 200.000 юаниас бага байх мөнгөн торгууль ногдуулна.</li> </ul> <p>4.4 Бизнесийн нууцад халдах</p> <ul style="list-style-type: none"> <li>Хуулийг зөрчин хэн нэгний бизнесийн нууцад халдсан тохиолдолд холбогдох хянан шалгах эрх бүхий албан тушаалтан хууль бус үйл ажиллагааг зогсоох, нөхцөл байдлаас хамааруулан 10.000 юаниас их ба 200.000 юаниас бага байх мөнгөн торгууль ногдуулна.</li> </ul> <p>4.5 Бараа бүтээгдэхүүний урамшуулал</p> <ul style="list-style-type: none"> <li>Хуульд зөрчиж урамшуулал үзүүлсэн зах зээлд оролцогч этгээдийг холбогдох хянан шалгах эрх бүхий албан тушаалтан хууль бус үйл ажиллагааг зогсоох, нөхцөл байдлаас хамааруулан 10.000 юаниас их ба 100.000 юаниас бага байх мөнгөн торгууль ногдуулна.</li> </ul> <p>4.6 Тендер</p> <ul style="list-style-type: none"> <li>Тендерт оролцогч нь тендерийн үнийг хүчээр буулгах ба өсгөх зорилгоор хэн нэгэнтэй хуйвалдаж тендерт оролцсон, эсвэл тендерт оролцогч шударгаар өрсөлдөж буй өрсөлдөгчөө гаргах зорилгоор тендер зарлагчтай хамтран ажилласан тохиолдолд буруутай этгээдийн тендерийн материалыг хүчингүй болгоно. Мөн хянан шалгах эрх бүхий албан тушаалтан нөхцөл байдлаас хамааруулан 10.000 юаниас их ба 200.000 юаниас бага байх мөнгөн торгууль ногдуулна.</li> </ul>
5	Шүүхэд хандах тохиолдолд	<ul style="list-style-type: none"> <li>Зах зээлд оролцогчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг шударга бус өрсөлдөөний үйл ажиллагаагаар хохироосон тохиолдолд шүүхэд хандах эрхтэй.</li> <li>Зах зээлд оролцогч этгээд нь хуурамч болон муу чанарын бараа бүтээгдэхүүн борлуулсан энэ нь гэмт хэргийн шинжтэй тохиолдолд түүнд хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</li> <li>Зах зээлд оролцогч этгээд нь бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авахтай холбоотой мөнгө, бэлэг болон бусад зүйл ашиглан хахууль өгсөн тохиолдолд түүнд хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</li> <li>Шударга бус өрсөлдөөний үйл ажиллагааг хянан шалгах эрх бүхий улсын байгууллагын ажилтан эрх мэдлээ хэтрүүлэх, өөрийн үүргээ үл хайхарсан гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн тохиолдолд хуулийн дагуу түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжгүй бол түүнд сахилгын шийтгэл ногдуулна.</li> <li>Шударга бус өрсөлдөөний үйл ажиллагааг хянан шалгах эрх бүхий улсын байгууллагын ажилтан гишүүн хууль зөрчсөн этгээдийг мэдсэн авч арга хэмжээ авалгүй нуун дарагдуулсан, хуулиас гадуур өөрийн эрх ашгийн үүднээс гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн тохиолдолд хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</li> </ul>



6	Хянан шалгах эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд давж заалдах	<ul style="list-style-type: none"> <li>Гэм буруутай этгээд хянан шалгах эрх бүхий албан тушаалтны гаргасан шийтгэл ногдуулах шийдвэрийг зөвшөөрөхгүй бол шийтгэл ногдуулах шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 15 өдрийн дотор дараагийн шатны эрх мэдэл бүхий албан тушаалтанд дахин хянуулахаар хандаж болно, гэм буруутай этгээд нь дараагийн шатны эрх мэдэл бүхий албан тушаалтны шийдвэрийг зөвшөөрөхгүй бол шийдвэр хүлээн авсан өдрөөс хойш 15 өдрийн дотор БНХАУ-ын шүүхэд хандаж болно.</li> <li>БНХАУ-ын шүүхийн шийдвэрийг уг этгээд шууд дагаж мөрдөнө.</li> </ul>
---	--	---

## • ГЕРМАН УЛС

Германы Эрүүгийн хууль<sup>5</sup> нь материаллаг эрүүгийн эрхзүйн харилцааг зохицуулдаг цөм хууль бөгөөд эрүүгийн процессийг “Эрүүгийн процессийн журам” (манайхаар бол “эрүүгийн байцаан шийтгэх хууль”) нэртэй өөр хуулиар зохицуулдаг. Эрүүгийн хуулийг сүүлийн 140 жилийн туршид мөрдүүлэн хэрэглэж байгаа бөгөөд энэ хугацаанд 200 гаруй өөрчлөлт оржээ.

1945 оноос хойш эрхзүйн болон гэмт хэргийн өөрчлөлт, нийгмийн үнэлэмж, шинжлэх ухаан, техникийн дэвшлээс улбаатай мэдэгдэх болсон гэмт хэргүүдийг тодорхойлж, шинэчлэгдэж ирсэн. Иймэрхүү “шинэ” гэмт хэргүүдийг дурдъя гэвэл: терроризмын бүлэглэлд гишүүнээр элсэх, компьютерийн луйвар, мөнгө угаах, нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх зэргийг нэрлэж болно.

Эрүүгийн хуулинд бүх гэмт хэрэг тухайлбал, эдийн засгийн чиглэлийн гэмт хэргүүд багтаагүй байдаг. Зарим төрлийн гэмт хэргийг “эрүүгийн салбар эрхзүй”<sup>6</sup> хэмээн нэрийдэх хуулиудаар тусгайлан зохицуулдаг. Тухайлбал, эдийн засгийн гэмт хэрэг, түүний дотор өрсөлдөөний гэмт хэрэг болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль<sup>7</sup>, мөн 1954 оны Эдийн засгийн эрүүгийн тухай хууль<sup>8</sup> бий.

### **Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль:**

Анх 1894 онд батлагдсан Барааны тэмдгийг хамгаалах тухай хууль батлагдсанаар өрсөлдөөний эрхзүйн үндэс суурь тавигдсан гэж үздэг. Энэ хуулийн хамгаалалт хангалтгүй байсан учир улмаар 1896 онд Шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх тухай хуулийг баталж байжээ.

Уг хуулийг Европын Холбооны 2005 оны “Шударга бус бизнесийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим”-д тусгагдсан заалтуудыг оруулан 2008 онд нилээн шинэчилсэн.

Уг хуулинд 30 шахам гэмт хэргийг тодорхойлсон байдаг. Тухайлбал:

- Бодит бусаар нөлөөлөх
- Бизнесийн туршлага дутмаг байдал буюу хүчинд автагдах байдлыг ашиглах, айлган сүрдүүлэх сурталчилгаа
- Сугалаат хонжвороор борлуулалтыг тэтгэх

<sup>5</sup>Германы Эрүүгийн хууль-Strafgesetzbuch (Deutschland) [https://de.wikipedia.org/wiki/Strafgesetzbuch\\_%28Deutschland%29](https://de.wikipedia.org/wiki/Strafgesetzbuch_%28Deutschland%29)

<sup>6</sup>Nebenstrafrecht

<sup>7</sup>Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль-Gesetz gegen den unlauteren Wettbewerb [https://de.wikipedia.org/wiki/Gesetz\\_gegen\\_den\\_unlauteren\\_Wettbewerb](https://de.wikipedia.org/wiki/Gesetz_gegen_den_unlauteren_Wettbewerb)

<sup>8</sup>Эдийн засгийн эрүүгийн тухай хууль-Wirtschaftsstrafgesetz 1954 [https://de.wikipedia.org/wiki/Wirtschaftsstrafgesetz\\_1954](https://de.wikipedia.org/wiki/Wirtschaftsstrafgesetz_1954)

- Өнгөлөн далдалсан сурталчилгаа (гэтэх сурталчилгаа гэж нэрлэдэг)
- Өрсөлдөгчийг доош хийх (гүтгэлэг гэж нэрлэдэг)
- Өрсөлдөөний эрхзүйн нэмэлт хамгаалалт
- Хууль зөрчих
- Төөрөгдүүлсэн сурталчилгаа
- Харьцуулсан сурталчилгаа
- Тэвчишгүй дарамт (хүсээгүй телефон сурталчилгаа, хүсээгүй хэвлэлийн хуудас болон спам-цахим шуудан г.м.)

Мөн тусгайлан салбар эрхзүйгээр зохицуулдаг зарим гэмт хэргүүд байна. Үүнд:

- Худал мэдээллээр төөрөгдүүлэх;
- Цасан бөмблөгийн систем;
- Нууц задруулах (ятгах болон гуйхыг хамруулна);
- Төсөл загварыг буруугаар ашиглах.

Шударга бус өрсөлдөөний хуулийн эрүүгийн эрхзүйн зохицуулалт нь зарим талаар иргэний эрхзүйн хэм хэмжээнээс ондоо буюу нэмэж хамгаалах зорилготой байдаг. Иймээс хэрэглэгчийн өмч хөрөнгийг хамгаалах тухай заалтууд нь эрүүгийн хуулийн залилангийн гэмт хэрэг бөгөөд хөрөнгийн эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт хамаардаг.

Өрсөлдөөнийг хязгаарлахын эсрэг хуулийн<sup>9</sup> 20 дугаар зүйлд зааснаар тодорхой нөхцөлд барааг тэнцэх үнээр<sup>10</sup> борлуулахыг хориглодог.

Шударга бус өрсөлдөөнтэй холбоотой хэргийг Мужийн шүүх харъяалдаг бөгөөд хэрэв нэхэмжлэлийн үнэлгээ 600 еврогоос дээш бол Мужийн дээд шүүх, эсвэл Холбооны дээд шүүхэд давж заалдаж болно.

Мужийн дээд шүүх зөвшөөрвөл, эсвэл хохирлын хэмжээ 20 000 еврогоос дээш бол ялагдсан тал Холбооны дээд шүүхэд давж заалдах эрхтэй.

Өрсөлдөөнтэй холбоотой маргааныг шийдвэрлэх шүүхийн процессоос илүү хямд өртөгтэй алтернатив арга бол эвлэрлийн алба юм. Эвлэрлийн алба нь Худалдаа, Аж үйлдвэрийн танхимын дэргэд ажилладаг бөгөөд өрсөлдөөний эрхзүй дэх иргэний эрхзүйн маргааныг шийдвэрлэхийг хариуцдаг. Ингэхдээ талууд аман хэлцлийн дүнд ихэвчлэн тохиролцоонд хүрдэг бөгөөд энэ нь тусгай гэрчилгээнд бичгэн харьцуулалт хэлбэрээр буудаг. Энэхүү гэрчилгээнд зөрчил дахин давтагдвал гэрээний үүрэг зөрчсөн шийтгэл ногдуулахаар тусгасан байдаг. Хэрэв талууд тохиролцоонд хүрэхгүй бол шүүхээр маргаанаа таслуулахаас өөр аргагүй болдог.

Өрсөлдөөний эрхзүйг нийгэм-улстөрийн талаас нь харвал нилээн асуудалтай тулгардаг. Энэ талыг баримтлагчдын үзэж байгаагаар, Шударга бус өрсөлдөөний эсрэг хуулийг өрсөлдөөний зорилгоор буруугаар ашиглах боломжтой гэдэг. Санхүүгийн хувьд хүчтэй компаниуд хэдийгээр шүүхэд ялалт байгуулах магадлал багатай ч гэсэн бусдын эсрэг гомдол гаргаж болно. Ингэснээр нөгөө тал нь санхүүгийн хувьд маш хүчтэй дарамтанд орсоны улмаас бууж өгөхөд хүрдэг.

Нөгөөтэйгүүр, эдийн засагчдийн зүгээс Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль нь өөрөө өөрийгөө зохицуулах чадвартай зах зээлийн процесст хөндлөнгөөс орж, урт хугацаанд саад бэрхшээл учруулж байна хэмээн шүүмжилдэг. Тэдний үзэж байгаагаар, Их Британи,

<sup>9</sup>Өрсөлдөөнийг хязгаарлахын эсрэг хууль-Gesetz gegen Wettbewerbsbeschränkungen [https://de.wikipedia.org/wiki/Gesetz\\_gegen\\_Wettbewerbsbeschr%C3%A4nkungen](https://de.wikipedia.org/wiki/Gesetz_gegen_Wettbewerbsbeschr%C3%A4nkungen)

<sup>10</sup>Einstandspreis

Австрали г.м. жишиг хэргийн<sup>11</sup> эрхзүйтэй улсуудад маш бага өргөн болон гүний зохицуулалт бүхий ерөнхий хуультай мөртлөө болоод байдаг сайн туршлагатай.

### **Эдийн засгийн эрүүгийн тухай хууль:**

1954 онд батлагдсан уг хууль нь төрөл бүрийн зах зээл дэх зөрчил, гэмт хэргийг тодорхойлсон германы эрүүгийн салбар хууль бөгөөд бүтэн нэр нь “Эдийн засгийн эрүүгийн эрхзүйг цаашид улам хялбаршуулах тухай хууль” юм. Энэ хууль нь 1949 онд батлагдсан “Эдийн засгийн эрүүгийн хууль”-ийн оронд шинээр гарч ирсэн хууль.

Хууль гарах үндсэн санаа, сэдэл нь дайны дараах нийгэм-эдийн засгийн үе тул өнөөдөр ач холбогдол нь эрс буурсан. Тус хуулийн дагуу 2008 онд зөвхөн нэг хүнд ял оногдуулсан бол 2007 онд огт шийтгэгдээгүй ажээ.

Хуулийн агуулга нь:

- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг. Эдийн засгийн аюулгүй байдлын тухай хууль (АБТХ), Зам тээврийн АБТХ, Хүнсний АБТХ, Усны АБТХ зэрэгт тусгагдсан ард түмний хангамжийн дэд бүтцийн эсрэг гэмт хэргүүд юуны өмнө багтана.
- Үнэ зохиохын эсрэг гэмт хэрэг. Энд 1954 батлагдсан Үнэ илэрхийлэх журмын зөрчлүүд бас хамаарна.
- Түрээсийн мөнгө хүүлэхээс хамгаалах. Энд ямар тохиолдолд түрээсийн төлбөр хэт өндөр болохыг тодорхойлсон.
- Нэмүү орлого болон зөвшөөрөгдсөн ба хууль бус өндөр үнийн зөрүүний дүнтэй холбоотой хөрөнгийн элэгдэл, мөн хөрөнгө хурааж авах.

## **1.2 Шударга бус өрсөлдөөний хэргийг эрүүгийн хууль тогтоомжоор зохицуулсан орнуудын туршлага**

### **• ЭСТОНИ УЛС**

Шударга бус өрсөлдөөнтэй холбоотой гэмт хэргийг Эстони улс Эрүүгийн хуулийн<sup>12</sup> VII бүлэг, 399-402 дугаар зүйлд тусгайлан зохицуулсан бөгөөд Давамгайл байдлтай этгээд, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хувьд хуулиар тогтоосон хэм хэмжээг зөрчих, чөлөөт өрсөлдөөнд хохирол учруулахуйц гэрээ хэлцэл байгуулах, чухал агууламж бүхий барилга байгууламжийг хянах хяналтын үүргээ биелүүлэхэд саад болох зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцсон болно.

Тус улсын эрүүгийн хуулийн өрсөлдөөнтэй холбоотой гэмт хэргийн хувьд дараах онцлогтой байна.

- Өрсөлдөөнтэй холбоотой гэмт хэргийн хувьд хуулиар хүлээлгэх санкц нь мөнгөн шийтгэл ногдуулах эсхүл хорих ял шийтгэдэг. Мөнгөн шийтгэл */pecuniary punishment/* гэдэг ойлголтын хувьд Эрүүгийн хуулийн 44-р зүйлд мөнгөөр зарж борлуулж болохуйц бараа, газрыг ойлгоно гэсэн байна.
- Энэ төрлийн гэмт хэргийг иргэн эсхүл хуулийн этгээд үйлдсэн эсэхийг харгалзан иргэнд хорих ялаар, хуулийн этгээдэд мөнгөн шийтгэл, албадан татан буулгах ял шийтгэлийг ногдуулна.
- Ус, дулаан, цахилгаан, байгалийн хийн үйлчилгээг үзүүлдэг аж ахуйн нэгжийн хувьд төрөөс баталсан үнэ тарифыг өөрчлөх, эсхүл үнэ тарифаа эрх бүхий байгууллагаар батлуулаагүй үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцдог.

<sup>11</sup>Common Law

<sup>12</sup><http://www.legislationline.org/documents/section/criminal-codes>

- Шударга өрсөлдөөн хянан зохицуулагчдыг тодорхой шалтгаантай болон шалтгаангүйгээр сүлжээ, дэд бүтэц болон чухал байгууламж руу нэвтрэхийг үл зөвшөөрөх, мөн үүнтэй холбоотой хууль зөрчсөн аливаа үйлдлийг эрүүгийн хуулийн холбогдох зүйлээр шийтгэдэг.
- Зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар аливаа бүтээгдэхүүний орц, агууламжийг баяжуулсан, түүнчлэн хориглосон агууламжийг хүчээр хийсэн эсхүл бүтээгдэхүүний зөвшөөрөгдсөн орцыг өөрчилсөн тохиолдолд гэмт хэрэгт тооцдог байна.

399-р зүйл: Давамгай байдлаа урвуулан ашиглах

1/ Хэрэв, давамгай байдалтай этгээд бусад этгээдтэй эсхүл харилцан хамаарал бүхий этгээдтэй хамтран зах зээл дээр өөрийн давамгай байдлыг урвуулан ашиглаж, шударга бус худалдааны нөхцөлийг бүрдүүлэх, эсвэл худалдан авагчдад хохирол учруулахуйц үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүн, техникийн хөгжил, хөрөнгө оруулалтыг хязгаарлаж байгаа тохиолдолд мөнгөн шийтгэл эсхүл 3 хүртэлх жилийн хорих ял шийтгэнэ.

2/ Ус, дулаан, цахилгаан, байгалийн хийн үйлчилгээг борлуулагч нь төрөөс тогтоосон үнэ тарифыг зөрчсөн эсхүл үнэ тарифыг тогтоогоогүй, батлуулаагүй болон бусад шалтгаанаар зах зээл дээрх давамгай байдлаа урвуулан ашиглаж хууль бус үйлчилгээ үзүүлсэн бол мөнгөн шийтгэлээр шийтгэнэ.

400-р зүйл: Чөлөөт өрсөлдөөнд хохирол учруулах гэрээ, шийдвэр, хамтарсан үйл ажиллагаа

1.Чөлөөт өрсөлдөөнийг хянан зохицуулагчид нь хувийн ашиг сонирхлын үүднээс чөлөөт өрсөлдөөний үйл ажиллагааг саатуулах, нөлөөлөх аливаа нэгэн гэрээ, шийдвэр, тохиролцоо хийсэн бол мөнгөн шийтгэл ногдуулах болон нэг жил хүртэл хугацаанд хорих ял оногдуулна.

2.Чөлөөт өрсөлдөөнд оролцогч талуудын хооронд үйлдсэн зөвшилцөл, шийдвэр, хамтарсан үйл ажиллагаан нь хэрэглэгчийн худалдан авалтад доорх байдлаар нөлөөлсөн бол:

- а)Гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөө үнийг шууд болон шууд бусаар өсгөх ба худалдан авах үйл ажиллагааны нэр томьёонд өөрчлөлт оруулсан бол,
- б)Үйлдвэрлэл, үйлчилгээ, барааны зах зээл, техникийн хөгжил болон хөрөнгө оруулалтад хязгаарлалт хийсэн бол,
- с) Гуравдагч этгээдийн барааны зах зээлд орох боломжийг хязгаарлах эсхүл гуравдагч этгээдийг зах зээлээс хасах оролдлого хийсэн бол мөнгөн шийтгэл ногдуулах буюу 1-3 жил хорих ял онооно.

1. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт үйлдлийг хуулийн этгээд үйлдэгдсэн бол барааны эргэлтийн хөрөнгийн 5 хувьтай тэнцэх мөнгөн дүнгээр торгоно.
2. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйлдлийг хуулийн этгээд үйлдэгдсэн бол нийт бараа эргэлтийн 5-10 хувьтай тэнцэх мөнгөн дүнгээр торгоно.

401-р зүйл: Зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар бүтээгдэхүүний агууламжийг баяжуулсан болон бүтээгдэхүүний хууль бус агууламж нь өрсөлдөөнд хохирол учруулах

1.Зөвшөөрөлгүйгээр хууль бусаар бүтээгдэхүүний агууламжийг баяжуулсан, түүнчлэн хориглосон агууламжийг хүчээр хийсэн эсхүл бүтээгдэхүүний зөвшөөрөгдсөн орцыг өөрчилсөн бол гэмт этгээдийг мөнгөн шийтгэл ногдуулах болон 3 хүртэл жилээр хорих ялаар шийтгэнэ.

2.Тус хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол санхүүгийн шийтгэл буюу торгох ялаар шийтгэнэ.

402- зүйл: Чухал ач холбогдол бүхий барилга, байгууламжийг хянах хяналтын үүргээ биелүүлэхэд саад учруулах

1.Шударга өрсөлдөөн хянан зохицуулагчдыг тодорхой шалтгаантай болон шалтгаангүйгээр сүлжээ, дэд бүтэц болон чухал байгууламж руу нэвтрэхийг үл зөвшөөрөх, мөн үүнтэй холбоотой хууль зөрчсөн аливаа үйлдэл өдөөсөн этгээдийг мөнгөн шийтгэл болон 3 хүртэлх жилээр хорих ял онооно.

2.Дээрх үйлдлийг хуулийн этгээд үйлдэгдсэн бол мөн адил шийтгэлийг оногдуулна.

• **ЛАТВИ УЛС**

Латви Улсын хувьд эдийн засгийн гэмт хэргүүдийг Эрүүгийн хуулийнхаа<sup>13</sup> 19 дүгээр бүлгээр зохицуулж өгсөн бөгөөд эрүүгийн хуульд шударга бус өрсөлдөөнтэй холбоо бүхий дараах 2 заалтыг тусгасан байна.

211-р зүйл. Хууль бусаар өрсөлдөх болон хэрэглэгчийг төөрөлдүүлэх.

Хэрэглэгчийг төөрөлдүүлэх болон хууль бус өрсөлдөөний үйл ажиллагаа явуулсан зөрчлийг нэг жилийн хугацаанд дахин гаргасан бол тухайн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёроос таван жилийн хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 8 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй хэмжээгээр торгох буюу 2 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

212-р зүйл. Өрсөлдөөний асуудал эрхэлсэн байгууллагаас тавьсан шаардлагыг зөрчих.

Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас тогтоосон журмыг зөрчсөн үйлдлийг нэг жилийн хугацаанд дахин гаргасан эсхүл тус үйлдлийн улмаас төр болон иргэнд их хэмжээний хохирол учирсан бол тухайн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёроос таван жилийн хугацаагаар хасах буюу хасахгүйгээр 2 жил хүртэлх хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлах эсхүл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй хэмжээгээр торгох буюу 2 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

**ХОЁР: ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЛААРХ  
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

• **ЭСТОНИ УЛС**

Үнэт цаасны зах зээлтэй холбоотой гэмт хэргийг Эстони улс Эрүүгийн хуулийн<sup>14</sup> VI бүлэг, 333, 397-398.1 дугаар зүйлд тусгайлан зохицуулсан бөгөөд Үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгслийг хуурамчаар үйлдэх, хууль бус хөрөнгө оруулалт, үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээ мэдээллийг ашиглан зах зээлийг тогтворгүй болгох зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцсон болно. Энэ төрлийн гэмт хэргийн санкц нь иргэн хуулийн этгээд нэгэн адил мөнгөн шийтгэл ногдуулах ба үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгслийг хуурамчаар үйлдэх гэмт хэргийн хувьд хүндрүүлэх нөхцөлийг хуульчилсан байна.

333-р зүйл. Үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгслийг хуурамчаар үйлдэх

1/ Банкны карт болон бусад төлбөрийн цахим хэрэгсэл, үнэт цаас хуурамчаар үйлдэх, хуурамч гэдгийг нь мэдсээр байж ашигласан тохиолдолд мөнгөн шийтгэл ногдуулах буюу 3 жил хүртэлх хорих ялаар шийтгэнэ.

<sup>13</sup>Criminal Law of the Republic of Latvia (2000, amended 2013) (English version), <http://www.legislationline.org/documents/section/criminal-codes>,

<sup>14</sup><http://www.legislationline.org/documents/section/criminal-codes>

2/ Иргэн 2 буюу түүнээс дээш удаа давтан эсхүл их хэмжээгээр үйлдсэн бол 1-6 жилийн хорих ял шийтгэнэ. Хэрэв хуулийн этгээд нь 2 буюу түүнээс дээш давтан үйлдсэн бол мөнгөн шийтгэл, их хэмжээгээр үйлдсэн бол албадан татан буулгана.

397-р зүйл. Хууль бүс хөрөнгө оруулалт

1/ “Хөрөнгө оруулалтын тухай” хуульд заасан хязгаарлалт зөрчсөн бол мөнгөн шийтгэл ногдуулна. Энэхүү гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол мөнгөн шийтгэл ногдуулна.

398-р зүйлд Дотоод мэдээллийг урвуулан ашиглах

1/ Шууд буюу шууд бусаар өөрийн нэрийн өмнөөс худалдаж авсан, шилжүүлсэн, эсхүл гуравдагч этгээдэд зөвлөгөө өгсөн, худалдаж авахаар нөлөөлсөн, эсхүл дериватив санхүүгийн хэрэгслээр дамжуулан нийтэд түгээгүй дотоод мэдээллийг тараасан бол мөнгөн шийтгэл буюу 3 жилийн хорих хүртэл ял шийтгэнэ. Хэрэв энэхүү гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол мөнгөн шийтгэл ногдуулна.

398.1-р зүйлд Зах зээлийг урвуулан ашиглах

1/ Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд хувь эзэмшдэг, үнэт цаас гаргагчтай ажил мэргэжил, албан үүргийн дагуу гүйлгээ хийдэг эсхүл төөрөгдүүлэх зорилгоор гүйлгээ хийхдээ үнэт цаас, хуулиар арилжихыг зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслээр дамжуулан үнэт цаасны зах зээлд буруу ташаа мэдээлэл хүргэх, тараах, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх зэрэгт хувь хүнд мөнгөн шийтгэл ногдуулах эсхүл 3 жилийн хорих ял шийтгэнэ.

2/ Хуулийн этгээд энэхүү гэмт хэргийг үйлдсэн бол мөнгөн шийтгэл ногдуулна.

• **ЛАТВИ УЛС**

Үнэт цаасны зах зээлтэй холбоотой гэмт хэргийг Латви улсын Эрүүгийн хуулийн XIX бүлгийн 192, 193, 194, 200 дугаар зүйлээр зохицуулсан бөгөөд мөнгөн тэмдэгт, төлбөр тооцооны хэрэгслийг хуурамчаар бэлтгэх, ашиглах, санхүү, төлбөр тооцооны хэрэгслийг хууль бусаар ашиглах, санхүүгийн хэрэгслийг хууль бусаар гаргах, санхүүгийн хэрэгслийн зах зээлийн дотоод мэдээ мэдээлэл, арилжааны зах зээлийн нууцыг хууль бусаар олж авах, тараах зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байна.

192. Мөнгөн тэмдэгт, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах

1/ Тус улсын мөнгөн тэмдэгт, төлбөр тооцооны хэрэгсэл болон гадаад улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулах зорилгоор тус улсын нутаг дэвсгэрт хуурамчаар үйлдвэрлэсэн эсхүл гүйлгээнд оруулсан бол эд хөрөнгө хураах буюу хураахгүйгээр гурваас арван жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулна.

2/ Тус үйлдлийг давтан, их хэмжээгээр, эсхүл зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол эд хөрөнгө хурааж, таваас арван таван жил хүртэлх хугацаагаар хорих ял онооно.

193. Санхүү, төлбөр тооцооны хэрэгслийг хууль бусаар ашиглах

Санхүүгийн хэрэгслийн зах зээлийн нийтэд түгээгүй дотоод мэдээллийн үндсэн дээр өөрийн буюу бусдын нэрээр санхүүгийн хэрэгслийг олж авсан, санхүүгийн хэрэгслийн зах зээлд залилан мэхлэх үйл ажиллагаа явуулсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр 10 жил хүртэлх хугацаагаар хорих, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэлх хэмжээгээр торгох ял шийтгэнэ.

194. Санхүүгийн хэрэгслийг хууль бусаар гаргах

1/ Санхүүгийн хэрэгслийн олон нийтэд хамааралтай мэдээллийг зориуд буруугаар өгсөн, санхүүгийн хэрэгслийг хуульд заасан бүртгэл, зөвшөөрөлгүйгээр гүйлгээнд оруулсан,



бусдын санхүүгийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр гүйлгээнд оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэлх хэмжээгээр торгох, эсхүл 5 жил хүртэлх хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, хорих ял шийтгэнэ.

200. Санхүүгийн хэрэгслийн зах зээлийн дотоод мэдээ мэдээлэл, арилжааны зах зээлийн нууц мэдээллийг хууль бусаар олж авах, тараах

1/ Санхүүгийн хэрэгслийн зах зээлийн нийтэд түгээгүй дотоод мэдээллийг хууль бусаар тараасан, худалдааны нууцлал бүхий эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн болон бусад мэдээллийг хууль бусаар олж авсан, ашигласан, бусдад тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэлх хэмжээгээр торгох, эсхүл 8 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2/ Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийг хулгайлсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэлх хэмжээгээр торгох, эсхүл 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

• **ЛИТВА УЛС**

Литва улсын Эрүүгийн хууль<sup>15</sup>-д үнэт цаасны зах зээлтэй холбоотой гэмт хэргийг зохицуулсан байдал:

**32-р бүлэг. Санхүүгийн зах зээлийн хэрэг, зөрчил болон гэмт хэрэг**

218 дугаар зүйл. Үнэт цаасны үнэд хууль бусаар нөлөөлөх

1/ Үнэт цаасны зах зээлийн үнийг зохиомлоор өсгөх, бууруулах зорилгоор үнэт цаас гаргагч, эсхүл үнэт цаасны талаар худал, эсхүл бүрэн бус мэдээлэл тарааж, их хэмжээний хохирол учруулсан этгээдийг эрх чөлөөг нь хязгаарлах, эсхүл торгууль, эсхүл 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2/ Дээрх зөрчил, гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд хариуцлага ногдуулна.

213 дугаар зүйл. Мөнгөн тэмдэгт, үнэт цаас хуурамчаар бэлтгэх, хадгалах болон ашиглах

1/ Литва, эсхүл бусад орны гүйлгээнд байгаа, эсхүл албан ёсоор батлагдсан боловч гүйлгээнд гаргаагүй мөнгөн тэмдэгт, эсхүл үнэт цаасыг хуурамчаар үйлдсэн этгээд, Литв эсхүл бусад орны гүйлгээнд байгаа, эсхүл албан ёсоор батлагдсан боловч гүйлгээнд гаргаагүй хуурамч мөнгөн тэмдэгт, эсхүл үнэт цаасыг хадгалж, ашигласан, эсхүл мөнгөн тэмдэгт болон үнэт цаасыг хуурамчаар үйлдэх тоног төхөөрөмж, програм хангамж, эсхүл тусгай материал үйлдвэрлэж, худалдан авсан, хадгалсан, эсхүл ашигласан этгээдийг торгууль, эсхүл эрх чөлөөг нь хязгаарлах, баривчлах, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2/ Литва, эсхүл бусад орны гүйлгээнд байгаа, эсхүл албан ёсоор батлагдсан боловч гүйлгээнд гаргаагүй мөнгөн тэмдэгт эсхүл үнэт цаасыг их хэмжээгээр, эсхүл өндөр дүнтэйгээр хуурамчаар үйлдсэн, худалдан авсан, хадгалсан, эсхүл ашигласан этгээдийг 3-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3/ Литва, эсхүл бусад орны гүйлгээнд байгаа мөнгөн тэмдэгт, эсхүл үнэт цаасыг жинхэнэ гэж авсан боловч хуурамч мөнгөн тэмдэгт, үнэт цаас гэж мэдсэний дараагаар бага хэмжээгээр арилжаалсан бол торгууль, эсхүл эрх чөлөөг нь хязгаарлах, баривчлах эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

<sup>15</sup>Литва Улсын Эрүүгийн хууль, 2000 [http://www3.lrs.lt/pls/inter3/dokpaieska.showdoc\\_l?p\\_id=366707](http://www3.lrs.lt/pls/inter3/dokpaieska.showdoc_l?p_id=366707)

4/ Мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх эрх бүхий этгээд нь тогтоосон журам, нөхцөлийг зөрчиж, Литва эсхүл бусад орны гүйлгээнд байгаа, эсхүл албан ёсоор батлагдсан боловч гүйлгээнд гараагүй мөнгөн тэмдэгтийг үйлдсэн, эсхүл мэдсээр байж тогтоосон журам, нөхцөлийг зөрчиж үйлдсэн мөнгөн тэмдэгтийг хадгалсан, худалдан авсан, эсхүл ашигласан этгээдийг тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах, эсхүл тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эсхүл торгууль, эсхүл баривчлах, эсхүл 4 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5/ Дээрх зөрчил, гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд хариуцлага ногдуулна.

217 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох

1/ Үнэт цаас болон үнэт цаас гаргахтай холбоотой нийтийн хүртээл болоогүй дотоод мэдээлэлд нэвтрэх эрх бүхий этгээд нь тус үнэт цаас гаргагчийн үнэт цаасны арилжаанд шууд, эсхүл гуравдагч этгээдээр дамжуулан, оролцож байгаа, эсхүл тухайн мэдээллээ гуравдагч талд дамжуулсан, эсхүл гуравдагч талд ямарваа нэгэн зөвлөмж өгч их хэмжээний хохирол учруулсан тохиолдолд эрх чөлөөг нь хязгаарлах, эсхүл торгууль, эсхүл 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2/ Дээрх зөрчил, гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд хариуцлага ногдуулдаг байна.

• **ЕВРОПЫН ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАЛТ**

Европын Комиссоос 2014 онд Зах зээлийг урвуулан ашиглах тухай тогтоол 596/2014 болон Зах зээлийг урвуулан ашигласанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай удирдамж 2014/57/EU-ийг<sup>16</sup> тус тус баталсан бөгөөд 2016 оны 7 дугаар сараар дагаж мөрдөхөөр заасан байна. Ингэснээр 2003 онд батлагдсан Зах зээлийг урвуулан ашиглах тухай удирдамжийг хүчингүй болгож, хөрөнгө оруулагчдыг хамгаалах болон зах зээлийг урвуулан ашиглахтай холбогдох гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг шинэчилж, чангатгаж өгсөн байна. Шинэ зохицуулалтууд нь санхүүгийн зах зээлийн хөгжлийг даган шинээр үүсэж буй харилцааг зохицуулах<sup>17</sup>, зохицуулагч байгууллагуудын хянан шалгах болон захиргааны шийтгэл ногдуулах эрх мэдлийг бэхжүүлэх болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхэд саад болох захиргааны хүнд суртлыг арилгах зэрэгт чиглэгдсэн байна.

Зах зээлийг урвуулан ашигласанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай удирдамж нь Европын Холбооны бүх гишүүн орнуудад дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцох болон зах зээлийн үнэд хууль бусаар нөлөөлөхөд дээд тал нь 4 жил хүртэлх хугацаагаар эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тогтоосон бөгөөд зах зээлийг урвуулан ашиглах ноцтой гэмт хэрэг үйлдсэн бол 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Дэлхий нийтэд санхүүгийн зах зээл дахь хяналтын асуудал нь 2007-2008 оны эдийн засгийн хямралын үеэр анхаарлын төвд орсон бөгөөд энэ асуудлаар олон улсын байгууллагууд нэлээдгүй судалгаа тооцоо хийсэн байдаг. 2009 онд ОУВС-аас гаргасан судалгаанд<sup>18</sup> Үнэт цаасны комиссын олон улсын байгууллагаас гаргасан үнэлгээнд үндэслэн 80 гаруй орны санхүүгийн зохицуулагч байгууллагуудын эрх, үүрэг, тэдгээрийн ногдуулах хариуцлагын төрөл зэргийг судалж үзсэн байна. Тус судалгаанд үнэт цаасны зах зээлд олон төрлийн

<sup>16</sup>Regulation No 596/2014 on market abuse (Market Abuse Regulation) and Directive 2014/57/EU on criminal sanctions for market abuse (Market Abuse Directive) <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:32014L0057>, <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:32014R0596>

<sup>17</sup>over the counter (OTC) trading and new technology such as high frequency trading (HFT), strengthens the fight against market abuse across commodity and related derivative markets, explicitly bans the manipulation of benchmarks (such as LIBOR)

<sup>18</sup>The Challenge of Enforcement in Securities Markets: Mission Impossible? IMF <http://www.imf.org/external/pubs/ft/wp/2009/wp09168.pdf>



хяналт, хариуцлагын арга хэрэгслийн ач холбогдлыг тусгасан бөгөөд зарим орны хувьд зөвхөн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь практик дээр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдгийг онцолжээ.

Үнэт цаасны зохицуулагч байгууллагууд нь хянан шалгах эрх үүрэг нь хязгаарлагдмал байдгаас хэргийг хууль сахиулах байгууллагад шилжүүлэхээс өөр аргагүй байдаг. Харин тэдгээр нь чиг үүргийн хувьд өргөн байдаг бөгөөд ихэнхдээ эдийн засгийн томоохон гэмт хэрэгт голлон анхаарлаа хандуулдаг гадна эдийн засгийн гэмт хэргийг хянан шалгах зохих мэргэжлийн чадвар дутмаг байдаг. Иймд зохицуулагч байгууллагад зохих хянан шалгах эрхийг өргөн хүрээтэй олгох нь үр дүнтэй гэж үзжээ. Үүнээс гадна зарим орнуудын хувьд ногдуулах захиргааны шийтгэл нь хэт нарийн хүрээтэй байгаа нь зөрчлийг бууруулахад төдийлөн нөлөөлдөггүй гэж тогтоожээ. Жишээ нь: Испанид зохицуулагч байгууллага нь зөвхөн жижиг зөрчилд мөнгөн торгууль ногдуулдаг бол томоохон зөрчлүүдийн хувьд Эдийн засгийн яам нь ногдуулдаг байна. Мөн зарим тохиолдолд, мөнгөн торгуулийн хэмжээ нь зөрчилтэйгөө харьцуулахад харьцангуй байдаг байна. Жишээ нь: Финлянд улсад үнэт цаасны зохицуулагч байгууллага нь зөрчлөөсөө үл хамааран дээд тал нь 100 еврогийн торгууль ногдуулдаг.

Судалгаанд эдийн засгийн гэмт хэргийг бууруулахад захиргааны хариуцлагаас гадна эрүүгийн хариуцлага ихээхэн хувь нэмэртэйг онцолжээ. Эрүүгийн хариуцлагыг ихэнхдээ удаа дараа давтагдсан, эсхүл их хэмжээний мөнгөтэй холбоотой болон олон тооны хөрөнгө оруулагч, эсхүл улс орныг хамарсан зэрэг онц ноцтой гэмт хэрэгт шийтгэж байна.

Эрүүгийн хариуцлагад хорих ял, гэмт хэрэгтнийг шилжүүлэх болон албадан гаргах зэрэг багтаж байна. Судлаачид ихэнх орнуудын эрүүгийн хянан шалгах эрх бүхий байгууллагууд нь эдийн засгийн гэмт хэрэгт төдийлөн анхаарал хандуулдаггүйг онцолсон. Жишээ нь: Канадын хувьд эдийн засгийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага шийтгэх эрх зүйн зохицуулалттай хэдий ч төдийлөн ногдуулаад байдаггүй нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хянан шалгах ажиллагааг хэрэгжүүлдэг зохицуулагч байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллагын ажлын үр дүнгээс үл хамааран хууль хэрэгжүүлэх, хяналт тавих механизм сул гэж дүгнэгддэг байна.

Мөн зохицуулагч болон прокурорын байгууллагуудын нөөц бололцоо, чадавх чадамжийн хувьд хязгаарлагдмал, тэдгээрийн хамтын ажиллагаа, уялдаа холбоо тааруу байдаг нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна гэж дүгнэжээ.

\* \* \*

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <http://www.legislationline.org/documents/section/criminal-codes>
- Criminal Law of the Republic of Latvia (2000, amended 2013) (English version)
- [http://www3.lrs.lt/pls/inter3/dokpaieska.showdoc\\_l?p\\_id=366707](http://www3.lrs.lt/pls/inter3/dokpaieska.showdoc_l?p_id=366707)
- [http://kt.gov.it/en/index.php?show=contacts&con\\_meniu=compet](http://kt.gov.it/en/index.php?show=contacts&con_meniu=compet)
- <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:32014L0057>
- <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:32014R0596>
- The Challenge of Enforcement in Securities Markets: Mission Impossible? IMF <http://www.imf.org/external/pubs/ft/wp/2009/wp09168.pdf>

## ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН НОГДОЛ АШГИЙН СУУТГАЛЫН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа

**ДНБ-ийн хэмжээ болон Нэг хүнд ногдох ДНБ-ийн хэмжээгээр тэргүүлэгч  
улсуудын ашиг орлогын татварын хувь хэмжээ**

Хүснэгт 1

№	Улс	Ногдол ашиг	Хүүнээс	Роялти	Тайлбар
<i>ДНБ-ийн хэмжээгээр тэргүүлэгч улсууд:</i>					
1	АНУ	30%	0%-30%	30%	
2	БНХАУ	10%	10%	10%	
3	Япон	20%	15%-20%	20%	
4	Герман	25%	0%	15%	
5	Франц	30%-75%	0%-75%	33.3%-75%	Давхар татварын гэрээгүй орнуудын компаниудын хувьд 75% хүртэл байж болно.  Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
6	Их Британи	0%	20%	20%	Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
7	Бразил	0%	15%-25%	15%-25%	
8	Итали	1.375%-26%	12.5%-26%	30%	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь нийт төлбөрийн 75% байх ба үүний ашигтай хувь хэмжээ нь 22.5% байна. Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
9	ОХУ	15%	20%	20%	
10	Энэтхэг	0%	5%-20%	25%	
11	Канад	25%	0%-25%	0%-25%	
12	Австрали	0%-30%	10%	30%	
13	Испани	20%	0%-20%	20%-24%	2015.01.01-ний өдрөөс ногдол ашиг болон хүүний татварын хэмжээ 21%-аас 20%, Нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 24.75%-аас 24% болж буурсан. Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
14	Өмнөд Солонгос	20%	14%-20%	20%	

15	Мексик	10%	4.9%- 10%-15%- 21%-35%- 40%	25%-35%- 40%	
<i>Нэг хүнд ногдох ДНБ-ийн хэмжээгээр тэргүүлэгч улсууд:</i>					
16	Катар	0%	7%	5%	
17	Люксембург	0%-15%	0%	0%	ААН-ийн тусгай төлбөрт албан татвар ногдуулдаг, гэхдээ гэрээтэй улсад албан татвараас чөлөөлнө.
18	Сингапур	0%	0%-15%	0%-10%	
19	Бруней	0%	15%	10%	
20	Кувейт	0%-15%	0%	0%	
21	Норвеги	0%-25%	0%	0%	
22	Арабын НЭУ	0%-5%-10%	0%	0%	
23	Турк	15%	0%-10%	20%	
24	Швейцарь	35%	0%-35%	0%	Швейцарийн ЕХ-той байгуулсан гэрээний дагуу ЕХ-ны үндсэн компани, охин/салбар компаниуд ижил арга хэмжээ авах тохиолдолд хэрэглэнэ.
25	Саудын Араб	5%	5%	15%	

**Нийт 162 улсын ногдол ашгийн суутгалын татварын ангилсан байдал**

Хүснэгт 2.

- *Ногдол ашгийн суутгалын шатлал бүхий татвартай нийт 51 улс*

№	Улс	Ногдол ашиг	Тайлбар
1	Австрали	0%-30%	
2	Аргентин	10%-35%	
3	Араб	0%-5%-10%	
4	Барбадос	0%-15%-25%	
5	Бельги	15%-25%	2014.10.01-нээс эхлэн татан буугдалтын ногдол ашиг 10%-аас 25% болж нэмэгдсэн. Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
6	Бенин	7%-10%-15%	
7	Босни Герцеговин	0%-5%	Серби нь ногдол ашгийн суутгалын татвар ногдуулахгүй.
8	Болгар	0%-5%	Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
9	Венесуэл	0%-34%	15%-34%-ийг Нийт ашгийн 95%-д нь ногдуулна.
10	Гамби	0%-15%	
11	Габон	10%-20%	
12	Гвиней	10%-15%	

13	Дани	0%-15%-27%	Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
14	Египет	5%-10%	
15	Замби	0%-15%	
16	Зимбабве	10%-15%	
17	Исланд	0%-18%	
18	Ирланд	0%-20%	Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
19	Итали	1.375%-26%	Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
20	Израиль	4%-15%-20%-25%-30%	
21	Кени	5%-10%	
22	Колумб	0%-33%	
23	Коста-Рика	5%-15%	
24	Кувейт	0%-15%	
25	Лесото	0%-25%	
26	Литва	0%-15%	Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
27	Люксембург	0%-15%	Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
28	Мозамбик	10%-20%	
29	Нидерланд	0%-15%	Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
30	Никарагуа	15%-17%	
31	Намиби	10%-20%	
32	Норвеги	0%-25%	
33	Папуа Шинэ Гвиней	0%-10%-17%	
34	Пакистан	10%-15%	
35	Панам	5%-10%-20%	Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
36	Перу	4.1%-6.8%	2015.01.01-нээс эхлэн ногдол ашгийн татвар 4.1% болж нэмэгдсэн.
37	Португал	0%-25%-35%	Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
38	Румын	0%-16%	
39	Соломоны арлууд	0%-30%	
40	Сальвадор	5%-25%	
41	Серби	20%-25%	
42	Свазиланд	12.5%-15%	
43	Танзани	5%-10%	
44	Тринадад Тобаго	5%-10%	

45	Франц	30%-75%	Давхар татварын гэрээгүй орнуудын компаниудын хувьд 75% хүртэл байж болно.  Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
46	Филлипин	15%-30%	
47	Фижи	0%-15%	
48	Чех	15%-35%	Төлбөрийн хэмжээ 35% болж нэмэгдсэн. Европын холбооны компаниудын тусгай төлбөрийг ЕХ-ны удирдамжийн дагуу чөлөөлж болно.
49	Шинэ Зеланд	0%-15%-30%	
50	Швед	0%-30%	
51	Эквадор	0%-13%	

- *Ногдол ашгийн суутгалын татвар 0% хэмжээтэй нийт 40 улс*

№	Улс	Ногдол ашиг
1	Андорра	0%
2	Арабын Нэгдсэн Эмират	0%
3	Багамын арлууд	0%
4	Бахрейн	0%
5	Бримудын арлууд	0%
6	Бразил	0%
7	Бруней	0%
8	Виржины арлууд	0%
9	Вануату	0%
10	Вьетнам	0%
11	Гибралтар	0%
12	Ирак	0%
13	Их Британи	0%
14	Йордан	0%
15	Конго	0%
16	Кипр	0%
17	Косово	0%
18	Катар	0%
19	Латва	0%
20	Ливи	0%
21	Лихтенштейн	0%
22	Макао	0%
23	Мадагаскар	0%
24	Малайз	0%
25	Мальдив	0%
26	Мальт	0%
27	Мавритани	0%

28	Монако	0%
29	Мьянмар	0%
30	Науру	0%
31	Оман	0%
32	Палау	0%
33	Сингапур	0%
34	Словак	0%
35	Сент-Люсия	0%
36	Сири	0%
37	Унгар	0%
38	Хонг Конг	0%
39	Энэтхэг	0%
40	Эстони	0%

• Ногдол ашгийн суутгалын татвар 1%-10% хэмжээтэй нийт 8 улс

№	Улс	Ногдол ашиг хувь хэмжээ
1	Гүрж	5.0%
2	Гватемал	5.0%
3	Саудын Араб	5.0%
4	Тунис	5.0%
5	Урагвай	7.0%
6	Ботсвана	7.5%
7	Гана	8.0%
8	Монтенегро	9.0%

• Ногдол ашгийн суутгалын татвар 10%-15% хэмжээтэй нийт 26 улс

№	Улс	Ногдол ашиг хувь хэмжээ
1	Ангол	10.0%
2	Азербайжан	10.0%
3	БНХАУ	10.0%
4	Доминикан	10.0%
5	Этиопи	10.0%
6	Грек	10.0%
7	Кыргызстан	10.0%
8	Ливан	10.0%
9	Македон	10.0%
10	Малави	10.0%
11	Мавритани	10.0%
12	Мексик	10.0%
13	Нигер	10.0%
14	Палестины нутаг дэвсгэрүүд	10.0%
15	Сенегал	10.0%

16	Сьерра-Леоне	10.0%
17	Өмнөд Судан	10.0%
18	Шри-Ланка	10.0%
19	Китс ба нэйвс	10.0%
20	Тайланд	10.0%
21	Узбекистан	10.0%
22	Йемен	10.0%
23	Беларус	12.0%
24	Хорват	12.0%
25	Буркина фасо	12.5%
26	Камбож	14.0%

- Ногдол ашгийн суутгалын татвар 15%-25% хэмжээтэй нийт 28 улс

№	Улс	Ногдол ашиг хувь хэмжээ
1	Бурунди	15.0%
2	Албани	15.0%
3	Алжир	15.0%
4	Доминика	15.0%
5	Күүкийн арлууд	15.0%
6	Гренада	15.0%
7	Марокко	15.0%
8	ОХУ	15.0%
9	Руанда	15.0%
10	Словени	15.0%
11	Өмнөд африк	15.0%
12	Турк	15.0%
13	Туркменистан	15.0%
14	Уганда	15.0%
15	Украйн	15.0%
16	Парагвай	15.0%
17	Камерун	16.5%
18	Польш	19.0%
19	Чад	20.0%
20	Конго	20.0%
21	Финлянд	20.0%
22	Афганистан	20.0%
23	Бангладеш	20.0%
24	Япон	20.0%
25	Солонгос	20.0%
26	Тайвань	20.0%
27	Испани	20.0%
28	Монгол	20.0%



• Ногдол ашгийн суутгалын татвар 25%-30% хэмжээтэй 6 улс

№	Улс	Ногдол ашиг хувь хэмжээ
1	Антигуа ба Барбуда	25.0%
2	Экваторын Гвиней	25.0%
3	Австри	25.0%
4	Канад	25.0%
5	Герман	25.0%
6	АНУ	30.0%

• Ногдол ашгийн суутгалын татвар 30%-аас дээш хэмжээтэй 3 улс

№	Улс	Ногдол ашиг хувь хэмжээ
1	Ямайка	33.33%
2	Швейцар	35.0%
3	Чили	35.0%

Ногдол ашгийн суутгалын татварыг Европын улсуудад оршин суугч болон оршин суугч бус этгээдэд ногдуулах хувь хэмжээ

Хүснэгт 3

№	Улсууд	Ногдол ашиг		Хүүнээс авах	
		Оршин суугч	Оршин суугч бус	Оршин суугч	Оршин суугч бус
1	Андорра	0.00%	10.00%	0.00%	10.00%
2	Ангол	0.00%	0.00%	0.00%	0.00%
3	Австри	25.00%	25.00%	25.00%	0.00%
4	Бельги	25.00%	25.00%	15.00%	15.00%
5	Бермудын арлууд	0.00%	0.00%	0.00%	0.00%
6	Виржины арлууд	-	-	-	-
7	Болгар	-	-	-	-
8	Кайманы арлууд	0.00%	0.00%	0.00%	0.00%
9	Хорват	-	-	-	-
10	сигасао	0.00%	0.00%	0.00%	0.00%
11	Кипр	0.00%	0.00%	0.00%	0.00%
12	Чех	-	-	-	-
13	Дани	27.00%	27.00%	0.00%	0.00%
14	Эстони	-	-	-	-
15	Финлянд	-	-	-	-
16	Франц	21.00%	30.00%	24.00%	0.00%
17	Герман	26.00%	26.00%	26.00%	0.00%
18	Гибралтар	0.00%	0.00%	0.00%	0.00%

19	Грек	-	-	-	-
20	Guernsey норманд	20.00%	0.00%	0.00%	0.00%
21	Унгар	16.00%	16.00%	16.00%	16.00%
22	Исланд	-	-	-	-
23	Ирланд	-	-	-	-
24	Isle of man	-	-	-	-
25	Итали	20.00%	20.00%	20.00%	0.00%
26	Жерси	20.00%	0.00%	0.00%	0.00%
27	Латви	10.00%	10.00%	10.00%	10.00%
28	Лихтенштейн	0.00%	0.00%	0.00%	0.00%
29	Литва	-	-	-	-
30	Люксембург	0.00%	15.00%	10.00%	0.00%
31	Македон	-	-	-	-
32	Мальт	15.00%	0.00%	15.00%	0.00%
33	Монако	0.00%	0.00%	0.00%	0.00%
34	Монтенегро	-	-	-	-
35	Нидерланд	15.00%	15.00%	0.00%	0.00%
36	Норвеги	0.00%	25.00%	0.00%	0.00%
37	Польш	-	-	-	-
38	Португал	-	-	-	-
39	Румын	-	-	-	-
40	Сан-Марино	0.00%	0.00%	11.00%	11.00%
41	Серби	-	-	-	-
42	Словак	-	-	-	-
43	Словен	-	-	-	-
44	Испани	21.00%	21.00%	21.00%	0.00
45	Швед	30.00%	30.00%	30.00%	0.00%
46	Швейцарь	35.00%	35.00%	35.00%	35.00%
47	Турк	-	-	-	-
48	Турк болон Кайкосын арлууд	-	-	-	-
49	Их Британи	0.00%	0.00%	20.00%	0.00%

\* \* \*

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <http://www2.deloitte.com/content/dam/Deloitte/global/Documents/Tax/dttl-tax-withholding-tax-rates-2015.pdf>
- [https://www.nyse.com/publicdocs/nyse/indices/us\\_index\\_group\\_tax\\_withholding\\_table.pdf](https://www.nyse.com/publicdocs/nyse/indices/us_index_group_tax_withholding_table.pdf)
- <http://dx.doi.org/10.1787/5k3wh96w246k-en>
- <https://dits.deloitte.com/>
- [https://www.nyse.com/publicdocs/nyse/indices/us\\_index\\_group\\_tax\\_withholding\\_table.pdf](https://www.nyse.com/publicdocs/nyse/indices/us_index_group_tax_withholding_table.pdf)
- <https://thebanks.eu/compare-countries-by-withholding-tax>
- <http://data.worldbank.org/indicator/EN.ATM.METH.AG.ZS/countries>

# 2

## БҮЛЭГ

---

НИЙГМИЙН БОДЛОГО

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**ХҮҮХЭД АСРАН ХАМГААЛАХ ЭЦЭГ, ЭХИЙН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ  
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА**

*А.Пагма, Б.Ариунжаргал, Р.Нургүл,  
Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаа*

## **1. МОНГОЛ УЛС**

Хүүхдийн асран хамгаалагчийн хариуцлагын тухай асуудлыг дараах хууль эрх зүйн актуудаар зохицуулсан байна. Үүнд:

- Үндсэн хууль (1992),
- Гэр бүлийн тухай (1999),
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай (1999),
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай (2011),
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (2014),
- Эрүүгийн хууль (2002),
- Хүүхдийн эрхийн тухай конвенц (1990).

### **Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол хөтөлбөрүүд:**

- Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Улсын Их Хурлын 2008 оны №12 тоот тогтоолд (*Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлогын хүрээнд “гэр бүл бат бэх байх, үр хүүхэд аюулгүй орчинд эрүүл өсөж хөгжих”*);
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих хөтөлбөр (2008-2012), Засгийн газрын 2006 оны №283 тоот тогтоолд (*хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагч болон хүүхдийн төлөө ажил, үйлчилгээ эрхэлдэг ажилтны чадавхыг бэхжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдыг нөхөн сэргээх эмчилгээний арга барилд сургах сургалт, сурталчилгааг өргөжүүлэх*);
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөр (2007-2015), Засгийн газрын 2006 оны №282 тоот тогтоолд (*шинээр гэр бүл бологсдод зориулан гэр бүлийн үүрэг, хариуцлага болон жендерийн харилцааны чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах*) (7.2.4);
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр (2008-2014), Засгийн газрын 2011 оны 303 тоот тогтоол;
- Монгол Улсын Үндсэн хуулинд “хүүхэд төрүүлэх, асрах эрхтэй” (16.5) гэж заасан бол хүлээх үүргийн талаар “үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн” (17.2) гэж заажээ.

Гэр бүлийн тухай хуулинд эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ. (26-р зүйл) Үүнд:

- хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх;
- хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх;
- хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох;
- хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах;
- эцэг, эх нь хүүхдийн эрүүл мэнд, сэтгэхүй, ёс суртахууны хүмүүжилд хохирол учруулах, хүүхдэдээ хэрцгий хандах, эцэг, эх байх эрхээ зүй бусаар ашиглахыг хориглоно.

Эцэг, эх гэрлэлтээ цуцлуулсан ч үүрэг нь хэвээр үлдэнэ. Эцэг, эх үүргээ хэрэгжүүлэх журмыг тусгайлан тохиролцоогүй бол түүнийг шүүх тогтоодог. Хүүхдийн эцэг, эх нь эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан нь үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болдоггүй.

Эцэг, эх байх эрхийг дараах тохиолдолд хасдаг. Үүнд:

Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан /хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр/, хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүний эцэг, эх байх эрхийг шүүх хасаж болно. (30.1)

Гэр бүлийн тухай хуулиар зохицуулсан нэгэн чухал харилцаа бол хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх харилцаа байдаг. **Хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх** асуудал нь өөрөө онцгой тохиолдлуудад хэрэглэгддэг байна.

Дараах хүүхдийг асран хамгаалалтад авдаг. Гэр бүлийн хуулийн (63-р зүйлд)

Үүнд:

- Бага насны (14 нас хүрээгүй) бүтэн өнчин хүүхэд,
- Эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байр эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний бага насны хүүхэд,
- Эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний бага насны хүүхэд,

Дараах хүүхдийг харгалзан дэмждэг. Тус хуулийн (64-р зүйл)

Үүнд:

- Насанд хүрээгүй (14-18 хүртэлх насны) бүтэн өнчин хүүхэд,
- Эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний насанд хүрээгүй хүүхэд,
- Эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа буюу хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний насанд хүрээгүй хүүхэд,

14 хүртэлх насны хүүхдэд асран хамгаалагч, 14-18 насны хүүхдэд харгалзан дэмжигчийг томилдог. Бусдаар асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа хүүхэд асран хамгаалагч, харгалзан дэмжигчийнхээ гэр бүлд амьдрах, сурч боловсрох нөхцөлөөр хангуулах, эсэн мэнд амьдрах, орон сууцандаа амьдрах эрхээ хэвээр хадгалах зэрэг хуулиар олгогдсон эрхийг эдэлнэ.

Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг дараах журмаар тогтоодог:

- Эд хөрөнгийн зохих бололцоотой төрөл, садан буюу төрөл, садан бус хүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг нь үндэслэн сум, дүүргийн Засаг дарга асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоох,
- Хэрэв асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдоогүй бол хүүхдийг нас, эрүүл мэндийн байдлыг нь харгалзан хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх,

Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоохдоо тодорхой шалгуурыг үндэслэл болгоно. Хэрэв эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан болон хасуулсан, өөрөө бусдын асрамжинд байгаа, мансууруулах бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэдэг, хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн, үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн бол эдгээр хүмүүст хүүхдийг асран хамгаалуулах, харгалзан дэмжүүлэхээр өгөхийг хориглодог.

Хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа этгээд нь хүүхдийг хоол хүнс, орон сууцаар хангах, асран сувилах, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, тухайн хүүхдийн мөнгөн хөрөнгө, үнэт зүйл, үнэт цаас, бусад баримт бичгийг банкинд хадгалуулах, эд хөрөнгийг нь хүүхдэд зориулан зарцуулах, өөрийн үүргийн талаар сум, дүүргийн Засаг даргад жил бүр тайлан өгөх зэрэг үүрэгтэй байдаг.

Харин хүүхдийг эцэг, эхэд нь буцаасан, хүүхдийг үрчлүүлсэн, эсхүл хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлсэн, хүүхэд насанд хүрсэн зэрэг тохиолдолд тухайн хүүхдийн өмнө хүлээсэн асран хамгаалах, харгалзан дэмжих үүрэг дуусгавар болно.

Хэрэв асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь эрхээ урвуулан ашигласан, үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас хүүхдийг хараа хяналтгүй, эсхүл шаардлагатай тусламж үзүүлээгүй орхисон бол шүүх асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэрийг хүчингүй болгож, шинээр асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг шинээр тогтоох асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэдэг.

Эрүүгийн хуулинд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээлгэх хариуцлагын талаар дараах заалтууд байна. Үүнд:

- эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуулиар хүлээсэн асран хамгаалах үүргээ шунахай зорилгоор урвуулан ашигласан, асран хамгаалж байгаа хүнээ хараа хяналтгүй байлгасан, шаардлагатай тусламж үзүүлэлгүй орхисон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. (118.1)
- эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэх талаар гарсан шүүхийн шийдвэр биелүүлэхээс ноцтой зайлсхийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. (120.1)
- хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ (121.1) гэж тус тус заасан байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулинд “эх, эцэг хүүхэддээ нийгмийн үүрэг, хариуцлага, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хамтын эрх тэгш оролцоо болон жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголт, хүнийг хүйсийн шинжээр үл ялгаварлах үзэл, зан үйлийг өөрсдийн үлгэр дууриал, гэр бүлийн хүмүүжлээр олгох үүрэгтэй” гэж заасан байна. (14.4)

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь дараах үүргийг хүлээдэг байна. (12-р зүйл)

Үүнд:

- хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах амьдрах эрүүл саруул, аюулгүй орчин бүрдүүлэх, нэн шаардлагатай хоол хүнс, орон байр, хувцас, тоглоом, бусад шаардлагатай зүйлээр хангах,
- хүүхдэд удам угсаагаа мэдүүлж, төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг эзэмшүүлэх;
- хүүхдэд эх орон, ард түмэн, эцэг эх, ах дүү, төрөл садан, бусад хүнийг хайрлан хүндэтгэх үзэл, үнэнч шударга, тэвчээр хатуужилтай зан чанар, харилцааны соёл төлөвшүүлэх;
- хүүхдийг архидах, мансуурахад донтох, садар самуунд автах, хүчирхийлэл, гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд өртөхөөс сэргийлэх, хамгаалах;



- хүүхдийн эрүүл мэнд, ёс суртахуун, амь насанд нь аюул учруулах хөдөлмөр эрхлүүлэхгүй байх;
- хүүхдийг сурган хүмүүжүүлэх, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хамт олон, хүүхдэд боловсрол эзэмших боломж нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийн дэмжлэг туслалцааг авч, хамтран ажиллах;
- хүүхдийг эрүүл мэндийн болон хууль тогтоомжид заасан бусад даатгал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах;
- хүүхдийн нэр төр, эрүүл мэнд, хувийн нууцыг хамгаалах, үзэл бодлыг хүндэтгэх, саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжийг бүрдүүлэх;
- хүүхдэд журамт үүргээ биелүүлэхэд нь туслах;
- хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн улмаас учруулсан хохирлыг хууль тогтоомжид заасан журмын дагуу арилгах;

Эцэг, эх тусдаа амьдрах болсон, гэрлэлтээ цуцлуулсан нь үүргээс чөлөөлөх үндэслэл болдоггүй байна.

Хүүхдийн эрхийн конвенцийн 19-р зүйлд *“оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон эгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна”* гэж заасан байна.

Хүүхдийн бие махбодид учруулж буй хүчирхийллийн хэлбэрүүдээс хамгийн их тохиолдсон хүчирхийллүүдийг хэн үйлддэгийг тодруулахад насанд хүрсэн хүмүүс тэр дундаас багш, эцэг эх, асран хамгаалагч нар дээрх хүчирхийллийн хэлбэрүүдийг хүүхдийн бие махбодид үзүүлдэг байна.<sup>19</sup>

## 2. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ GERMAN УЛС

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуулийн 1 дэх хэсгийн 6 дугаар зүйлд гэрлэлт, гэр бүл төрийн хамгаалалтад байна хэмээн хуульчилсан байна. “Гэр бүл” гэсэн ойлголт нь эцэг, эх тэдний хүүхдүүдийн хоорондын харилцааг хамрах ба дээрх заалт нь энэ институтийн Үндсэн хуулийн баталгаа, тус улсын нийтийн болон хувийн эрх зүйд тусгалаа олж уг суурь үнэт зүйлийн илэрхийлэл болдог ажээ.

Үндсэн хуулийн 2 дахь хэсгийн 6 дугаар зүйлийн дагуу хүүхдийг халамжлан хүмүүжүүлэх нь эцэг эхийн зүй ёсны эрх, тэргүүн зэргийн үүрэг байдаг.

Гэр бүлийн хууль, тогтоомжийн гол эх сурвалж нь Германы Иргэний хуулийн дөрвөн бүлэг бүхий 4 дүгээр ном болдог ба эхний гурван бүлэг нь “Иргэний гэрлэлт”, “Гэр бүлийн харилцаа”, “Асран хамгаалах” гэсэн харилцааг тус тус зохицуулна<sup>20</sup>.

Нийгмийн хамгааллын тухай хуулийн 8 дугаар ном болох “Хүүхэд, залуучуудын тухай” хууль нь онцгой ач холбогдолтой бөгөөд энэ хуулийн дагуу хөдөө тосгон, 60 000 доошгүй хүн амтай хотод өргөн эрх мэдэл бүхий хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн байгууллага ажилладаг.

<sup>19</sup>Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа-2014., НХГБХГ, ММСЖ ХХК.

<sup>20</sup>German Civil Code BGB. Book 4 Family Law, Division 2 Relationship, Title 5 Parental custody. [www.gesetze-im-internet.de/englisch\\_bgb/](http://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/)

Иргэний хуульд “эцэг, эхийн халамж хамгаалал” нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих, улам бүр өсөн нэмэгдэж буй хүүхдийн бие даах гэсэн чадварыг харгалзах зарчимд тулгуурлахыг хуульчилсан байна. Тус хуулийн 4 дүгээр номын 2 дахь хэсгийн 5.1626 дахь зүйлд эцэг, эх насанд хүрээгүй хүүхдээ асран хамгаалах эрх, үүрэгтэй болохыг зааж, эцэг, эхийн асран хамгаалал нь хүүхдээ асран хамгаалахын зэрэгцээ түүний хөрөнгийг мөн харж хамгаалахыг хэлнэ хэмээн тодорхойлжээ<sup>21</sup>.

Эцэг, эх нь хууль ёсны хүүхдээ хамтран асран хамгаалах ба боловсрол олгох болон бусад хүүхдийн амьдралын чухал асуудлаар санал зөрөлдсөн тохиолдолд Гэр бүлийн шүүхэд хандах эрхтэй. Тус шүүх нь эцэг, эхийн өмнөөс шийдвэр гаргахгүй боловч эцэг, эхийн хэнийх нь санал шийдвэрлэх үүрэгтэй болохыг тодорхойлж өгдөг.

Эцэг, эх нь хүүхдийн хөрөнгийг харж хамгаалах үүрэгтэй болохын хувьд хүүхдийн хөрөнгөөс олсон орлогыг зөвхөн хүүхдийн хэрэгцээнд л зарцуулах боломжтой. Хүүхдийн нэрийн өмнөөс хийгдэх онцгой чухал худалдаа, наймааг Гэр бүлийн шүүхийн зөвшөөрөлтэй хийнэ.

Иргэний хуулийн 4 дүгээр номын 2 дахь хэсгийн 5.1626 дахь зүйлд хүүхдийн хувийн ба өмчийн эрх зөрчигдөн, хүүхэд бие бялдар сэтгэл, санаа, сэтгэцийн хувьд аюултай байдалд орвол Гэр бүлийн шүүх хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах бүх шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй. Эцсийн арга хэмжээ нь эцэг, эх байх эрхийг нь хэсэгчлэн болон бүрэн хасах шийдвэр юм. Эцэг, эх асран хамгаалах эрхээ хэтрүүлсэн, хүүхдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хариуцлагатай эцэг, эх байх чадваргүй тохиолдолд эцэг, эх байх эрхийг нь хасна.

Гэхдээ ХБНГУ-ын Үндсэн хуулийн дагуу эцэг, эх байх эрх нь чухал үндсэн эрхүүдийн нэг учраас эцэг, эх байх эрхийг хасах асуудалд өндөр босго, шалгуур тавьдаг. Хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллага хүүхдийг гэр бүлээс нь салган авч өөр гэр бүл, хүмүүс, байгууллагад асран, хүмүүжүүлэхээр шилжүүлэхийн өмнө хүүхдийн сайн сайхны төлөө ямар арга хэмжээ авсан, цаашид ямар арга хэмжээ авах гэж байгаа талаар нухацтай судлан үздэг. Үүний дараа эцэг, эхийн эрхийг хязгаарлах талаар ямар нэг шийдвэр гаргадаг байна.

Тус улсын хууль тогтоомж нь 16 нас хүрээгүй хүүхдийг хараа хяналтгүй орхихыг хориглодог ба үүнийг зөрчсөн тохиолдолд тухайлбал, эцэг, эхийг 10-15 минут хүүхдээ хараа хяналтгүй үлдээсэн бол торгох хуультай. Германы эрүүгийн хуулийн Асран хамгаалах, хүмүүжүүлэх үүргээ зөрчих гэсэн 171 дүгээр зүйлд *“Арван зургаан нас хүрээгүй этгээдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх үүргээ зөрчин түүний бие бялдар, сэтгэцийн хөгжилд хор учруулах, улмаар түүнийг гэмт хэрэг үйлдэх, биеэ үнэлэхэд хүргэсэн хүнийг гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу мөнгөн торгууль ногдуулна”*<sup>22</sup> гэж заажээ.

Холбооны Бүгд Найрамдах Герман улсад хүүхдийн эрхийг хамгаалах асуудалд онцгой анхаарал хандуулдаг бөгөөд төрийн болон иргэдийн үүсгэл санаачилгын олон тооны байгууллагууд энэ чиглэлд үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, Хүүхэд, залуучуудын газар, өдрөөр ажилладаг Урьдчилан сэргийлэх-эмчилгээний газар ба Асрамжийн газар, Эмэгтэйчүүдийн асрамжийн газар, Хүүхэд хамгаалах төв гэх мэт болно.

*Жишээ нь, Хүүхэд хамгаалах төвүүд нь хүчирхийллийн (биеийн, сэтгэцийн, бэлгийн г.м.) асуудалтай гэр бүлд тусламж үзүүлэх зорилготой тусгай албад юм. Тэд “Хүүхэд хамгаалах орчин үеийн ажил” нэрийн дор үйл ажиллагаагаа явуулдаг ба нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч, социологич зэрэг 5-10 ажилтан нэг баг болон ажилладаг.*

<sup>21</sup>Мөн тэнд

<sup>22</sup>Уголовный кодекс Германии, § 171, <http://constitutions.ru/?p=5854>

Төвийн ажилтнууд үр нөлөөтэй тусламж үзүүлэхийн тулд хүчирхийллийн шалтгааныг мэдэх шаардлагатай гэсэн үзэл баримтлалын үүднээс хүүхдэд хүч хэрэглэх нь зөвхөн гэр бүлийн зөрчлийн илэрхийлэл бус, нийгмийн үйл явц, түүний хүндрэл, асуудал нь гэр бүлийн харилцаанд нөлөөлж байгаа хэрэг гэсэн ойлголтоор хүчирхийллийг цогц байдлаар нь авч үздэг байна.

Германы Кельн хот ба Хойд Рейн Вестфали холбооны мужийн жишээн дээр зарим тоо баримтыг авч үзье. Хуулийн дагуу орон нутгийн хүүхэд хамгаалах байгууллага буюу Jugendamt (CPB) болон цагдаагийн газарт хүүхдийн эрхийн зөрчлийн талаар эцэг, эх, хүүхэд өөрөө ба бусад гурав дахь тал мэдээлж болно.

Үнэхээр хүүхдээ хүмүүжүүлж “дийлэхгүй” буюу өөрсдөө муу хүмүүжүүлэгч болохоо хүлээн зөвшөөрсөн хүмүүс (архичид, хар тамхичид, сэтгэцийн өөрчлөлттэй) тусламж хүсэх нь олонтаа байдаг. Нөхцөл байдлыг зохицуулах арга нь зөвлөгөө өгөх, тусламж үзүүлэхээс эхлээд хүүхдийг гэр бүлээс нь авах хүртэл маш олон янз байна.

2013 онд Кельн хотод төрөл төрөгсөд, хөршүүд, багш нар, цагдаагийн газраас хүүхдэд аюул заналхийлж байгаа талаар 11.780 удаа хотын тусгай алба (Gefahrdungsmeldungs-Sofort-Dienst)-руу мэдээлсэн байна. Үүнээс 3480 тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэн, 2716 хүүхдийг халамжинд авсан ба эдгээрээс 2412 хүүхдийг шүүхийн шийдвэр гарахаас өмнө гэр бүлээс нь авч асрамжийн газар шилжүүлсэн<sup>23</sup>.

Хойд Рейн Вестфали холбооны мужид мөн 2013 онд 12.259 хүүхэд халамжийн байгууллагын ивээлд орсон ба тэдний 40.1 хувь нь 14-өөс доош насны хүүхэд, 48 хувь нь эмэгтэй хүүхдүүд байсан байна<sup>24</sup>.

Хүүхдийг эцэг, эхээс нь авч асрамжийн байгууллагад шилжүүлэх шалтгаан нь эцэг, эхчүүд хүүхдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй, эцэг, эхийн хоорондын харилцааны асуудал, тус улсад хүүхэд ганцаараа орж ирэх (дүрвэгсэд) зэрэг янз бүрийн шалтгаантай байжээ.

### 3. НОРВЕГИ УЛС

Норвеги улсад Хүүхдийн асран хамгаалагчийн буюу эцэг, эхийн хариуцлагын тухай асуудлыг 1981 оны Хүүхдийн тухай хууль<sup>25</sup> /The Children act/, 1927 оны Асран хамгаалагчийн тухай хууль<sup>26</sup> /Guardianship act/-уудад тус тус тусгасан байна. Хүүхдийн асран хамгаалагчийн үүрэг хариуцлагын тухай бие даасан хуультай ч энд зөвхөн хүүхдийн өмнөөс хуулийн байгууллагад хүлээх хариуцлага буюу хүүхдийн гаргасан зүй бус үйлдлийн төлөө хүлээх эцэг эхийн үүрэг хариуцлагын талаар зохицуулсан байна.

Харин Хүүхдийн тухай хуулийн 5-р бүлэгт эцэг, эхийн үүрэг хариуцлагын тухай заасан бөгөөд “хүүхдийн асран хамгаалагч” гэдгийг түүний эцэг эх болон хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн түүний ойр дотнын хүн гэж тодорхойлсон байдаг бол “хүүхдийн асран хамгаалал” гэсэн ойлголтод хүүхдийг асран хамгаалах үүрэг ба тэдний төлөө шийдвэр гаргах эрх аль аль нь багтсан байна. Гэхдээ энэ хуульд хүүхдийн эд хөрөнгөтэй холбоотой асуудал болон хууль зүйн төлөөллийн эрх үүрэг багтаагүй.

<sup>23</sup>О защите прав ребенка в Германии. <http://pora-valit.livejournal.com/2830106.html>

<sup>24</sup>Мөн тэнд.

<sup>25</sup>The Children Act No. 7 of 8 April 1981. [www.regjeringen.no/en/dokumenter/the-children-act/id448389/](http://www.regjeringen.no/en/dokumenter/the-children-act/id448389/)

<sup>26</sup>Parental Responsibilities Norway.

**Эцэг, эхийн үүрэг хариуцлага**

Норвегийн Хүүхдийн тухай хуулийн 30-р зүйлд зааснаар хүүхдийн асран хамгаалагч нь юун түрүүнд түүний эцэг байх ба тэдгээр нь хүүхдээ 18 нас хүртэл түүний өмнө дараах үндсэн үүрэг хариуцлагыг хүлээдэг. Үүнд:

- Хайр, халамж, асаргаагаар хангах
- Зөв зохистой арга хэлбэрээр өсгөн бойжуулах, тэжээн тэтгэх
- Сурган боловсруулах, боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх
- Эрүүл мэндийн үүрэг хариуцлага
- Орон байраар хангах, /хаана амьдрах тухайд/
- Удирдан чиглүүлэх,
- Тэдний өмнөөс шийдвэр гаргах үүрэгтэй.

Ингэхдээ аливаа шийдвэрийг хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн гаргах ёстой гэдгийг мөн хуульд тунхагласан байдаг байна.

Асран хамгаална гэдэг нь эцэг, эхийн үүрэг хариуцлагыг аяндаа дагалдах зүйл мөн бөгөөд эцэг, эх нь салсан ч хүүхдээ асран хамгаалах үүрэг хариуцлага нь хэвээр байна. Харин Гэр бүлийн тухай хуулиар эцэг, эх нь хууль ёсоор салсан бол хүүхэд асран хамгаалах төлөвлөгөө гарган түүний дагуу эрх үүргийг харилцан зөвшилцөн үргэлжлүүлэн биелүүлэх үүрэгтэй. Энэ нь хүүхэд эцэг, эхийнхээ хэнтэй нь хамт амьдрахаас үл шалтгаалан заавал биелүүлэх үүрэг хариуцлагад тооцогдоно. Норвегид эцэг, эх хүүхдийн өмнө хүлээсэн үүргээ заавал биелүүлэх ёстой.

1927 оны Норвегийн асран хамгаалагчийн тухай хуульд зааснаар эцэг, эх нь хүүхдийн санхүүгийн асуудлыг мөн шийдвэрлэнэ.

Хүүхдийн тухай хуулийн 30.2-р зүйлд эцэг, эхчүүд хүүхдээ сонирхол, чадвар, боломжийн дагуу боловсрол эзэмшихийг ханган баталгаажуулах үүрэгтэй бөгөөд 15 болон түүнээс дээш насны хүүхэд өөрийнхөө боловсролын тухайд эцэг, эхийн зөвшөөрөлгүйгээр шийдвэр гаргаж болно гэж заасан байна.

Мөн 18-аас доош насны хүнийг хууль эрх зүйн хувьд төлөөлөх хүн нь түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч байна.

Эд хөрөнгийн захиран зарцуулалтын асуудлыг 1927 оны Асран хамгаалагчийн тухай хуулийн 3-р зүйлд заасан этгээдүүд эрхлэн явуулах ба тэдгээр нь эцэг, эх буюу асран хамгаалагч байна. Гэхдээ 15 болон түүнээс дээш насны хүүхэд өөрийн хөдөлмөрлөж олсон орлого, авсан бэлэг, хуульд өөрөөр заагаагүй бол, өвлүүлэгч өв залгамжлалыг тухайн хүүхэд бүрэн захиран зарцуулах ёстой гэж заасан бол захиран зарцуулах эрхтэй байна.

Хүүхдийн тухай хуулийн 31-р зүйлд зааснаар хүүхэд насанд хүрмэгц /18/ хүүхдийн өмнөөс шийдвэр гаргах эрх дуусгавар болно. Мөн 18 нас хүрээгүй л бол тэрээр гэрлэсэн байсан ч эцэг, эхийн үүрэг хариуцлага хэвээр үргэлжилнэ.

Энэ хуулийн жишээ хууль /Case law/ нь мөн Эцэг, эхийн үүрэг хариуцлагын тухай хуулийн чухал нэгэн хэсэг болдог.

**Эцэг, эхийн хариуцлагад ногдуулах шийтгэл**

Норвегид эцэг эхийн хариуцлагад ногдуулах шийтгэл гэж журамласан зүйлгүй. Харин хэрэг шийдвэрлэсэн жишээ хуулиуд нь /Case law/ хуулийн нэгэн хэсэг болдог.

Эцэг, эх өөрсдийн үүрэг хариуцлагыг ямар ч тохиолдолд ханган биелүүлж явахыг эрхэмлэнэ. Тэр бүү хэл эцэг, эх гэр бүлээ цуцлуулсан нь хүртэл тэдний эцэг, эхийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болдоггүй. Тэд тэрхүү үүрэг хариуцлагаа үргэлжлүүлэн биелүүлэх ерөнхий журамтай. Гэхдээ аль нэгийнх нь эцэг эсхүл эхийн хариуцлагыг цуцлах тохиолдол бий. Энэ нь практик амьдрал дээр зөвхөн гэр бүл цуцлуулсны дараа хөндөгддөг. Хоёр тал харилцан зөвшөөрсөн эсхүл шүүхийн шийдвэрт үндэслэн эцэг, эх байх хариуцлагыг цуцална.

1981 оны Норвегийн Хүүхдийн тухай хуулийн 48-р зүйлд зааснаар бол дээрх асуудлыг хүүхдийн хүсэл сонирхолд хамгийн сайн нийцэхээр зохицуулна гэжээ. Шүүхийн практикаас үзэхэд, хүүхэдтэйгээ цуг амьдардаг эцэг эсхүл эхийн үүрэг хариуцлагыг хэрвээ энэ хариуцлагаас таагүй нөхцөл үүсэхээр байгаа тохиолдолд цуцалдаг байна. *Жишээлэхэд*, түүний ерөнхий зан байдал нь хүүхдэд хор хөнөөлтэй (*дорд үзэн шоовдорлодог, хүчирхийлдэг, бэлгийн дарамт үзүүлдэг зэрэгт сэжиглэгдсэн*) гэж үзэх үндэстэй бол эцэг эсхүл эхийн хариуцлагыг цуцална. Зарим тохиолдолд эцэг, эхийн хоорондын харилцаа нь цаашид хүүхдийнхээ тухайд хамтрах ямар ч аргагүй болтлоо муудсан зэрэг нь аль нэгийнх нь эцэг, эхийн хариуцлагыг цуцлахаас өөр аргагүй болгодог тал байдаг байна. Ийнхүү эцэг, эхийн хариуцлагыг цуцлах талаар гагцхүү эцэг, эхийн аль нэг нь нөгөөгийнхөө тухайд шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Хэрвээ дээр дурдсанчлан хүүхэдтэйгээ зүй бус харилцсан нь баттай бөгөөд ноцтой бол түүнийг Ерөнхий Иргэний Шийтгэлийн Хууль<sup>27</sup> ба Эрүүгийн хуулийн<sup>28</sup> дагуу шийдвэрлэнэ. Тухайлбал, Ерөнхий Иргэний Шийтгэлийн хуулийн “*Бэлгийн хүчирхийллийн хэрэг*” гэх 19-р бүлэг, “Гэр бүлийн харилцааны хэргүүд” гэх 20-р зүйл, “Хүний эрх чөлөөний эсрэг хэрэг” гэх 21-р бүлэг зэргээр журамлаж байна.

Ерөнхий Иргэний Шийтгэлийн хуулийн 20-р бүлгийн 219-р хэсэгт:

- А) Урьдын эсхүл одоогийн хань ижил,
- Б) Урьдын эсхүл одоогийн хань ижлийн удамд шууд хамаарах садан төрөлд,
- В) Өөрийн удамд шууд хамаарах хүнд,
- Г) Өөрийн гэр бүл дэх гишүүнд,
- Д) Өөрийн асран хамгаалалд буй хэнийг ч сүрдүүлэх, албадах, эрх чөлөөнд нь халдах, хүчирхийлэх эсхүл бусад ямарваа бүдүүлэг эсхүл олон удаагийн дорд үзэх зэргээр авирласан хэнийг боловч гурван жилээс илүүгүй хугацаагаар хорьж шийтгэнэ.

Хэрвээ дорд үзэх үйлдэл нь бүдүүлэг эсхүл хохирогч нь нас барсан эсхүл бие, эрүүл мэндийн хувьд ноцтой гэмтэж хохирсон бол гэмт этгээдийг 6 жилээс илүүгүй хугацаагаар хорьж шийтгэнэ. Энэхүү хэргийг үйлдэхэд тусалсан, оролцсон этгээдэд адил шийтгэлийг ногдуулна гэхчлэн заасан байна.

Бусад бэлгийн хүчирхийлэл, эрх чөлөөний эсрэг зэрэг хэргүүдийг заахдаа хэрвээ 14 наснаас бага, заримдаа 16 наснаас бага насны хүүхдүүдийг хохироосон бол гэж онцлон заасан нь эцэг, эхийг оролцуулаад бүгдэд хамааралтай гэсэн үг юм.

<sup>27</sup>General Civil Penal Code. [www.un.org/depts/los/legislationandtreaties/pdf/nor\\_penal\\_code.pdf](http://www.un.org/depts/los/legislationandtreaties/pdf/nor_penal_code.pdf)

<sup>28</sup>Criminal code. [www.loc.gov/law/help/norway-criminal-law\\_new.php](http://www.loc.gov/law/help/norway-criminal-law_new.php)

#### 4. ИХ БРИТАНИ УЛС

Их Британид асран хамгаалагчийн хариуцлагыг эцэг, эхийн хариуцлага (**parental responsibility**) гэсэн ойлголтын хүрээнд авч үздэг. Эцэг, эхийн хариуцлагын талаарх ойлголтыг Хүүхдийн тухай /1989 оны/ <sup>29</sup> хуульд тодорхойлсон байна. Уг хариуцлага нь хүүхдийн төрсөн эцэг, эхээс гадна хуулийн дагуу эрх үүрэг хүлээсэн бусад хүн, байгууллагад бас хамаатай.

##### Эцэг, эхийн хариуцлага<sup>30</sup>

Хуульд тодорхойлсноор, хуулийн дагуу хүүхдийн эцэг, эхэд хүүхэд болон түүний өмч хөрөнгөд хамааралтай олгогдсон эрх, үүрэг, эрх мэдэл, хариуцлага, бүрэн эрхийг эцэг, эхийн хариуцлага гэж ойлгоно.

Эцэг, эхийн хариуцлага нь хүүхэд төрөнгүүт хэрэгжиж эхэлдэг бөгөөд бүх эхчүүд, ихэнх эцгүүд хуулийн дагуу эцэг эхийн хариуцлагыг хүлээдэг.

Эцэг, эхийн гол үүрэг хүүхдийг амьдрах орон байраар хангах болон асран хамгаалах явдал юм. Түүнээс гадна эцэг эх нь дараах үүрэг хариуцлагатай байна. Үүнд:

1. хүүхэд хүмүүжүүлэх;
2. хүүхдэд боловсрол сонгох, боловсрол эзэмшүүлэх;
3. хүүхдийн эрүүл мэндэд анхаарал тавих;
4. хүүхдэд нэр өгөх, нэр өөрчлөхийг зөвшөөрөх;
5. хүүхдийн өмч хөрөнгийг хамгаалах зэрэг болно.

Эцэг, эх нь хүүхэдтэй хамт амьдардаггүй, байнгын харилцаа холбоогүй байдаг ч түүний өсөлт хөгжил болон сайн сайхан амьдрахад туслах ёстой.

Эцэг, эх нь хүүхдийнхээ өмнө эцэг, эхийн хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран хүүхдэд санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлнэ.

Эцэг эхийн хариуцлагыг дараах хүмүүс хүлээдэг.<sup>31</sup> Үүнд:

1. Эх нь хүүхдээ төрүүлсэн цагаасаа эхлэн эцэг эхийн хариуцлагыг хүлээнэ.
2. Эцэг нь хүүхэд төрөхөөс өмнө, эсвэл төрсний дараа хүүхдийнхээ эхтэй гэрлэсэн бол эцэг эхийн хариуцлагыг хүлээнэ. Хэрэв хүүхдийнхээ эхтэй гэрлээгүй бол дараах тохиолдолд уг хариуцлагыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- хүүхдийн төрсний гэрчилгээнд эцгээр бүртгүүлсэн бол (2003 оны 12-р сарын 1-нээс мөрдөж байна);
- Хүүхдийнхээ эхтэй гэрээ байгуулсны үндсэн дээр эцэг нь уг хариуцлагыг хүлээх;
- Шүүхийн шийдвэрээр эцэг нь уг хариуцлагыг хүлээх зэрэг болно.

3. Тухайн хүүхдийг шүүхийн зөвшөөрлөөр гэртээ авч, хамт амьдрахаар болсон хүн;
4. Хүүхдийг хуулийн дагуу үрчилж авсан хүн;
5. Хүүхдийг шүүхийн шийдвэрийн дагуу орон нутгийн эрүүл мэнд, халамжийн байгууллагын асаргаанд шилжүүлсэн бол уг байгууллага эцэг эхийн хариуцлагыг хүлээнэ.
6. Хуулийн дагуу томилогдсон асран хамгаалагч;

<sup>29</sup>Children Act 1989. [www.legislation.gov.uk/ukpga/1989/41/content](http://www.legislation.gov.uk/ukpga/1989/41/content)

<sup>30</sup>Parental rights and responsibilities. [www.gov.uk/parental-rights-responsibilities/what-is-parental-responsibility](http://www.gov.uk/parental-rights-responsibilities/what-is-parental-responsibility)

<sup>31</sup>Мөн тэнд

7. Аюултай, эрсдэлтэй нөхцөлд орсон хүүхдийг шүүхийн шийдвэрээр хамгаалалтад авсан байгууллага, эсвэл хувь хүн түр хугацаанд эцэг эхийн хариуцлагыг хүлээдэг.

Хүүхдийн төрсөн эхээс бусад асран хамгаалах үүрэг бүхий хүн, байгууллага, мөн хүүхдийнхээ эхтэй гэрлээгүй тохиолдолд төрсөн эцэг ч гэсэн эцэг эхийн хариуцлагыг зөвхөн хуулийн дагуу шүүхийн шийдвэрээр хэрэгжүүлнэ.

### **Хүүхдийг асран хамгаалах, тэдний аюулгүй байдлыг хангах<sup>32</sup>**

Их Британид насанд хүрээгүй хүүхдийг санхүүгийн боломжгүй байдлаас зовж зүдрэх, өлсөх, гэрт болон гадаа гудамжинд хүчирхийлэлд өртөх, эцэг эхийн хариуцлагагүй байдлаас хордох, гэмтэж бэртэх зэргээр аюулд осолд орохоос урьдчилан сэргийлэхэд ихээхэн анхаардаг. Энэ нь эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг төдийгүй үүний төлөө хүүхэд хамгаалах үүрэг бүхий тусгай төрийн байгууллага хүртэл ажилладаг байна. Ялангуяа, насанд хүрээгүй хүүхдийг хараа хяналтгүй ганцааранг нь үлдээхгүй байхад онцгой анхаарал хандуулдаг. Их Британид 14 нас хүрээгүй хүүхдийг хараа хяналтгүй орхиж болохгүй бөгөөд үүнийг эрүүгийн хэрэгт тооцдог. Хэрэв насанд хүрээгүй хүүхдийг хараа хяналтгүй орхивол холбогдох байгууллагаас эцэг эхийг хариуцлагад татна. Түүнчлэн, Их Британид нийгэм хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллагууд хүүхдийн эрх ашгийг хамгаалах, ялангуяа насанд хүрээгүй хүүхдийг хараа хяналтгүй үлдэхээс сэргийлэхэд ихээхэн анхаарал хандуулж байна.

Хүүхдийн төлөө ажилладаг байгууллагуудаас хүүхдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах үүднээс чухал шаардлагатай зөвлөмжүүдийг байнга гаргадаг бөгөөд үүнийг эцэг эхчүүд, асран хамгаалагч нар дагаж мөрдөх ёстой. Өөрөөр хэлбэл, энэ нь эцэг эхийн үүрэг хариуцлагын нэг хэсэг юм. Зөвлөмжүүдээс заримыг дурьдвал:

- Хордохоос сэргийлж, цэвэрлэгээний болон ахуйн хэрэглээний бодис, химийн бодис, эм тариа, хорт бодисыг хүүхдийн гар хүрэхгүй газар тавих;
- Хүүхдийг түлэгдэхээс сэргийлж шатамхай бодис, галт тогооны өрөөнөөс аль болох хол байлгах;
- Үер усны аюулаас хамгаалах;
- Галын аюулаас хамгаалах, галын аюул болон гал түймэрийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах талаар хүүхдэд сайтар тайлбарлаж ойлгуулах;
- Гэрийн шат, гэрийн гадаа хашаа цэцэрлэг болон бусад газарт унаж, ойчих, улмаар бэртэл авахаас сэргийлэх;
- Гэрт болон бусад газар хараа хяналтгүй ганцааранг нь үлдээхгүй байх зэрэг болно.

Их Британид эцэг эхийн үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч нарт нэн тустай үйлчилгээний нэг бол Family Information Service буюу гэр бүлд мэдээлэл өгөх үйлчилгээ юм. Эндээс эцэг эх, асран хамгаалагч нь хүүхэд асрах, хүүхдийн боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал гэх мэт хүүхэдтэй холбоо бүхий бүх төрлийн мэдээлэл, зарим дэмжлэг, тусламжийг үнэ төлбөргүй авах боломжтой.

### **5. ИРЛАНД УЛС**

Хүүхдийн асран хамгааллын асуудлыг нийгмийн үйлчилгээний тухай хууль, гэр бүлийн болон эцэг эхийн эрх, үүргийг тогтоосон хуулийн бүрэлдэхүүнд багтаасан байна.

<sup>32</sup><http://webarchive.nationalarchives.gov.uk>



Ирланд улс хүүхдийн асран хамгаалагчийн хариуцлагын тухай асуудлыг зохицуулсан бие даасан хуульгүй боловч 1991 оны Хүүхдийн асаргааны тухай /Child care act<sup>33</sup>, хуулиар 0-18 хүртэлх настай хүүхдийн асран хамгаалал, гэр бүлд туслалцаа үзүүлэх асуудлыг дэмжих чиг үүрэг бүхий байгууллагууд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асран хүмүүжүүлэгчдийн хооронд үүсэх харилцааг зохицуулжээ.

### Эцэг, эхийн үүрэг, хариуцлага

Гэр бүлд эцэг, эх нь хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч байж хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, амьдрах эрүүл саруул орчинг бүрдүүлэх, нэн шаардлагатай хоол хүнс, орон байр, бусад зүйлсээр хангах, эрүүл чийрэг өсгөн бойжуулах, суурь боловсрол эзэмшүүлэх үүрэгтэй.

Хэрэв хүүхдийн асран хамгаалагч хуулиар хүлээсэн эрх үүргээ хүндэтгэн үзэх шалтгаанаар биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэр бүлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудад хуулийн дагуу хандах эрхтэй.

*Хүүхдийн асаргааны тухай хуулийн 2.3-т* тухайн хангалттай халамж, хамгаалалт асаргаа авч чадахгүй байгаа хүүхдүүдэд Эрүүл мэндийн хуульд зааснаар *хүүхдийн эрүүл мэндийн зөвлөл* нь дараах төрлийн асран хамгааллын дэмжих үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

- Хараа хяналтгүй орон гэргүй хүүхдүүдэд зориулсан үйлчилгээ,
- Хүүхдийн үрчлэлт болон эцэг, эх асран хамгаалагчийн эрхийг сэргээх,
- Хүүхдийн асран хамгааллын талаар зөвлөх үйлчилгээ,
- Хүүхдийн асран хамгааллын сайн дурын байгууллага, иргэдэд туслалцаа үзүүлэх,
- Хүүхдийн халамж, гэр бүлийг дэмжих үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон аливаа асуудлаар судалгаа, тайлан гаргах,
- Гамшиг ослын үед дэмжлэг туслалцаа үзүүлэх.

*Хүүхдийн асаргааны тухай хуулийн 4.1 -т* Хүүхдийн асран хамгааллын асуудлаар хүүхдийн эрүүл мэндийн зөвлөл нь захирамж гаргах, эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй асуудлаар дүгнэлт гаргах, шүүхэд өргөдөл гаргах эрхтэй. Эрх нь зөрчигдсөн хүүхдийг хамгаалалтад авч эцэг, эх, асран хамгаалагчаас тусгаарлана. Шүүхээс хүүхдийн хууль ёсны асран хамгаалагчийг тогтоож, мэдэгдэл хүргүүлэх бөгөөд асран хамгаалагч харгалзан дэмжигч хуульд заасан хугацаанд хүүхдээ асран хамгаалалтандаа аваагүй буюу шаардлага биелүүлээгүй тохиолдолд 6 сар хүртэлх хугацаагаар хорих буюу 500 фунт стерлингийн торгууль ногдуулна.

Ирландад хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар иргэн бүр Хүүхэд, гэр бүлийн байгууллагад утсаар болон бичгээр, биечлэн мэдээлэх үүрэгтэй. Эдгээр мэдээллийн дагуу *Хүүхэд, гэр бүлийн агентлаг* хүүхдийн хүчирхийллийн бүх тайланг үнэлэх, дүгнэх эрхтэй. *Хүүхэд асаргааны тухай хуулиар* эцэг, эх, асран хамгаалагч хүүхдийг үл тоомсорлох, сэтгэл санааны дарамт, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд оруулах, хүүхэдтэй зүй бусаар харьцах, зодох, гэртээ ганцааранг нь үлдээсэн бол нэн даруй арга хэмжээ авна.

Хүүхдийн асаргааны тухай анхан шатны үнэлгээг нийгмийн ажилтан хийх бөгөөд асаргааны талаар ямар нэгэн асуудал байгаа эсэхийг шалгахын тулд нийгмийн эрүүл мэндийн сувилагч, хэл, ярианы эмч, орон нутгийн нийгмийн халамжийн ажилтан, нярайн асаргааны сувилагч, гэр бүлийг дэмжих ажилтан, сэтгэл зүйч, бүсийн эрүүл мэндийн ажилтан зэрэг хүмүүс үнэлгээ гаргах эрхтэй байна.

<sup>33</sup>Child vsre Act, 1991. [www.irishstatutebook.ie/1991/en/act/pub/0017/](http://www.irishstatutebook.ie/1991/en/act/pub/0017/)



Эрүүгийн хууль (хүүхэд, эмзэг бүлгийн талаарх гэмт хэргийн талаар мэдээллийг нуун дарагдуулах) 2012. Criminal Justice (Withholding of Information on Offences against Children and Vulnerable Persons) Act 2012<sup>34</sup>-аар хүүхэд, эмзэг бүлгийн хүмүүсийн эсрэг тодорхой заасан гэмт хэрэгт холбоотой мэдээллийг нуун дарагдуулсан бол хуулийн дагуу гэм буруутайд тооцогдоно.

\*\*\*

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Үндсэн хууль /1992/,
- Гэр бүлийн тухай /1999/,
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай /1999/,
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай /2011/,
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /2014/,
- Эрүүгийн хууль /2002/,
- Хүүхдийн эрхийн тухай конвенц /1990/,
- Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого УИХ-2008 №12
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих хөтөлбөр (2008-2012) ЗГ-2006 №283,
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хөтөлбөр (2007-2015) ЗГ-2006 №282,
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвшиггүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр (2008-2014) ЗГ-2011 №303.
- Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа-2014, НХГБХГ, ММСЖ ХХК.

#### Гадаад хэлээр

- Основной закон Федеративной Республики Германии. [www.rfhwb.de/Pravo/](http://www.rfhwb.de/Pravo/)
- German Civil Code BGB. Book 4 Family Law, Division 2 Relationship, Title 5 Parental custody. [www.gesetze-im-internet.de/englisch\\_bgb/](http://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/)
- Уголовный кодекс Германии, § 171. <http://constitutions.ru/?p=5854>
- О защите прав ребенка в Германии. <http://pora-valit.livejournal.com/2830106.html>
- Children Act No. 7 of 8 April 1981. [www.regjeringen.no/en/dokumenter/the-children-act/id448389/](http://www.regjeringen.no/en/dokumenter/the-children-act/id448389/)
- [ceflonline.net/wp-content/uploads/Norway-Parental-Responsibilities.pdf](http://ceflonline.net/wp-content/uploads/Norway-Parental-Responsibilities.pdf)
- General Civil Penal Code.
- [www.un.org/depts/los/legislationandtreaties/pdf/nor\\_penal\\_code.pdf](http://www.un.org/depts/los/legislationandtreaties/pdf/nor_penal_code.pdf)
- [www.loc.gov/law/help/norway-criminal-law\\_new.php](http://www.loc.gov/law/help/norway-criminal-law_new.php) -Criminal code
- Parental rights and responsibilities. [www.gov.uk/parental-rights-responsibilities/](http://www.gov.uk/parental-rights-responsibilities/)
- Children Act 1989. [www.legislation.gov.uk/ukpga/1989/41/contents](http://www.legislation.gov.uk/ukpga/1989/41/contents)
- <http://webarchive.nationalarchives.gov.uk>
- [www.teescpp.org.uk/children-and-young-persons-act-1933](http://www.teescpp.org.uk/children-and-young-persons-act-1933)
- Child vsre Act, 1991. [www.irishstatutebook.ie/1991/en/act/pub/0017/](http://www.irishstatutebook.ie/1991/en/act/pub/0017/)

<sup>34</sup>Criminal Justice (Withholding of Information on Offences against Children and Vulnerable Persons) Act 2012. [www.irishstatutebook.ie/2012/en/act/pub/0024/](http://www.irishstatutebook.ie/2012/en/act/pub/0024/)

## ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА

*А.Пагма, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг,*

Судалгааны хүрээнд Америк, Европ, Азийн нэлээд хэдэн орны өндөр насны тэтгэвэр авагчдад хэрхэн зээл олгодог асуудлыг судалж үзэхэд өндөр насны улсаас олгодог суурь тэтгэврийг барьцаалан зээл олгохыг зохицуулсан “Тэтгэврийн зээлийн тухай” хуультай улс орон байхгүй байна.

Харин өндөр насны тэтгэвэрт гарсан хүмүүст банк ба бусад санхүүгийн байгууллагаас олгох зээлийн харилцаа нь банкны зээлийн талаарх эрх зүйн хэм хэмжээг зохицуулдаг гол эрх зүйн актууд, тухайн банкны зээлийн журмаар зохицуулагддаг байна.

Энэтхэг, Австрали зэрэг оронд өндөр насны тэтгэвэр авагчдад зайлшгүй шаардлагатай эмчилгээний төлбөр, гэр бүлийн хэрэгцээнд зориулан тодорхой хугацаагаар, тодорхой хэмжээний зээлийг хүүгүй олгодог ба Австралид Засгийн газраас нь тэтгэврийн насны зээл хүссэн иргэдэд зориулан дээрх хүүгүй зээлийг олгодог “Засгийн газрын тэтгэвэр авагчдад зориулсан дэмжлэг” нэртэй хөтөлбөрийг хэрэгжүүлдэг юм байна.

Их Британид 2002 онд Улсын тэтгэврийн кредитийн тухай хууль /State Pension Credit Act 2002/ батлан улсын нэмэлт тэтгэврийг амьжиргааны түвшнээс доогуур орлоготой, 65-аас дээш насны өндөр настнуудад улсын тэтгэвэр дээр нь нэмэлт тэтгэлэг байдлаар олгодог байна.

Доор зарим улс орны тэтгэврийн зээлийн эрх зүйн зохицуулалтыг товч авч үзлээ.

### 1. ИХ БРИТАНИ УЛС<sup>35</sup>

Их Британи Улсад тэтгэврийг барьцаалсан зээлийн тухай хууль байхгүй бөгөөд харин өндөр настнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг дараах хууль, журмаар зохицуулж байна. Үүнд:

- Улсын тэтгэврийн кредитийн тухай хууль /State Pension Credit Act 2002/,
- Улсын тэтгэврийн кредитийн журам /State Pension Credit Regulations 2002 (SI 2002 No. 1792)/,
- Тэтгэврийн тухай хууль /Pensions act/ гэх мэт.

Улсын тэтгэврийн кредитийн тухай хууль /State Pension Credit Act 2002/-иар өндөр настны эрүүл мэндийн үйлчилгээнд тусламж үзүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд тусламж үзүүлэх зорилгоор олгож буй санхүүгийн дэмжлэг бүхий нэмэлт тэтгэврийн харилцааг зохицуулж байна.

Уг хуульд зааснаар дээрх зорилгоор олгож буй улсын нэмэлт тэтгэврийг амьжиргааны түвшнээс доогуур орлоготой, 65-аас дээш насны өндөр настнуудад улсын тэтгэвэр дээр нь нэмэлт тэтгэлэг байдлаар олгодог.

Харин хувийн тэтгэврийн хуримтлалын сангаас ирээдүйн тэтгэврээ урьдчилан зээлэх үйлчилгээ байдаг. Өөрөөр хэлбэл тэтгэврийн насанд хүрээгүй ч гэсэн өөрийн тэтгэврийн хуримтлалаа барьцаалан урьдчилан зээл авч болдог байна.

<sup>35</sup>About Pension Credit 2014. [https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment\\_data/file/382513/pc10s.pdf](https://www.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/382513/pc10s.pdf)

## 2. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС<sup>36</sup>

Тус улсад “Тэтгэвэр барьцаалсан зээлийн тухай” хууль үйлчилдэггүй байна. Энэтхэг улсад зээл хүссэн тэтгэврийн насны иргэдэд Иргэний хууль болон банкны үйл ажиллагааг зохицуулсан бусад хууль тогтоомжуудаар зээл авах харилцааг хуульчилсан. Зээл хүссэн тэтгэврийн насны иргэдэд тухайн банкны зээлийн журмаар зээл олгодог байна.

*Тухайлбал*, Энэтхэгийн төрийн банк нь тэтгэврийн сангаас 76 хүртэлх настай тэтгэвэр авагчдад 18 сарын хугацаагаар 25 мянган хүртэлх рупигийн зээлийг хүүгүйгээр олгодог байна. Харин банк зээл олгосон банкны үйлчилгээний шимтгэлд зээлийн үнийн дүнгийн 0.51 хувийн шимтгэл тооцож авна. Зээл хүссэн тэтгэврийн насны иргэн 25 мянган рупигээс дээш хэмжээний зээл авахыг хүссэн тохиолдолд тэрээр гэр бүлийнхээ гишүүдтэй хамтран зээл авах бололцоотой. Банк тухайн иргэний гэр бүлийнх нь гишүүдийн орлогын 33 хувиас хэтрүүлэхгүйгээр зээл олгох эрх зүйн зохицуулалттай болно.

## 3. АВСТРАЛИ<sup>37</sup>

Австралид “Тэтгэвэр барьцаалсан зээлийн тухай” тусгайлсан хуулийн зохицуулалтгүй болно. Банкны зээлийн тухайд ч “Тэтгэвэр барьцаалсан зээл” гэж тусгайлсан зээлийн төрөлгүй юм. Тэтгэвэр авагчид нь зээл авахыг хүссэн иргэдийн нэгэн адил хэрэглээний богино хугацааны зээлийн сонголт хийж үйлчилгээ авах эрхтэй байдаг байна.

Засгийн газраас нь тэтгэврийн насны зээл хүссэн иргэдэд зориулан **“Засгийн газрын тэтгэвэр авагчдад зориулсан дэмжлэг”** нэртэй хөтөлбөр хэрэгжүүлдэг. Тус хөтөлбөр нь бага орлоготой тэтгэвэр авагчдад болон бусад тэтгэврийн насны хүмүүст санхүүгийн дэмжлэг шаардлагатай үед тэдний нийгмийн асуудлыг шийдэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Хөтөлбөрийн хүрээнд тэтгэвэр авагчдад дараах 2 төрлийн богино хугацааны зээлийг арилжааны банкаар дамжуулан олгодог байна.

Үүнд:

- 16 хоногоос 1 жил хүртэлх хугацаагаар 100-2000 хүртэлх ам.доллар, хүүгүй зээлдүүлнэ,
- Зээл хүссэн тэтгэврийн насны бага орлоготой иргэдэд зайлшгүй шаардлагатай эмчилгээний төлбөр, өрхийн хэрэгцээний нэн шаардлагатай эд зүйл худалдан авах, автомашины засвар үйлчилгээтэй холбоотой гэх мэт зардлуудад 12-18 сарын хугацаагаар 1200 хүртэлх ам.доллар хүүгүй зээл олгоно.

*Тэтгэвэр авагчдад арилжааны банкаар олгогдох хэрэглээний зээлийн нөхцөл:*

Тэтгэвэр авагчдад 4-6 долоо хоногоор 2000 хүртэлх ам.доллар, зээлийн хүүг тухайн банк тодорхойлж олгоно.

Тэтгэвэр авагчдад дээрх 2 төрлийн зээлээс гадна олон нийтийн сайн дурын санхүүгийн тусламжийн хөтөлбөрүүдээр дамжуулан зайлшгүй шаардлагатай өрхийн эд зүйлс худалдан авах зориулалтаар 800-3000 хүртэлх ам.долларын зээлийг бага хүүтэй олгохоос гадна өрхийн орлогыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг зохион байгуулдаг байна.

<sup>36</sup>Loans to pensioners, <https://www.sbi.co.in/portal/web/personal-banking/loans-to-pensioners>

<sup>37</sup>Pensioner Loans, <http://www.finder.com.au/pensioner-loans>

#### 4. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС<sup>38</sup>

АНУ-д тэтгэвэр барьцаалсан зээлийн асуудал сүүлийн жилүүдэд нэлээд хурцадмал яригдаж буй асуудлын нэг болж байгаа юм. АНУ-ын нэгэн сонины сурвалжлагч, сэтгүүлч Женифер Абелийн бичсэнээр: «Бидний амьдралд гунигтай боловч зайлсхийх аргагүй, үнэн баримттай нэгэн зүйл байна. Энэ бол «санхүүгийн хувьд хэчнээн хүнд байвч, таны энэ мэт хүнд байдлыг улам бүр муутгаж байж өөртөө ашиг олдог хүмүүс байгаа явдал юм. Ийнхүү ашиг олдог хүмүүсийн ихэнх нь тэтгэврийн зээлийг (бас тэтгэврээ урьдчилж авах ч гэж нэрлэдэг) нэлээд ашигтай бизнес гэж үздэг байна»<sup>39</sup> гэжээ. Үүнээс үзэхэд АНУ-д Тэтгэвэр барьцаалсан зээлийн асуудал бизнесийн хэмжээнд хүрсэн ч тодорхой хууль эрх зүйн зохицуулалтгүй өнөөг хүрчээ. Ийм учраас, АНУ-ын Холбооны Худалдааны Комиссоос (Federal Trade Commission) тэтгэврээ урьдчилан авах төлөвлөгөөний аюул, эрсдэлийн тухайд анхааруулан сануулгыг (consumer warning) нийтлүүлсэн байдаг байна.

Мөн Форбос сэтгүүлийн 2013 оны 4-р сарын 30-ны дугаарт Жон Уасик хэмээх нийтлэлч «Тэтгэврийн зээл бол хараахан хуулиар зохицуулагдаагүй байгаа хор мөн» хэмээх нийтлэлийг гаргажээ. Түүний бичсэнээр бол энэхүү тэтгэврийн зээлд хамрагдагсдын ихэнх нь засгийн газрын эсхүл цэрэг армийн тэтгэвэртэй хүмүүс ба нэгэнт холбооны засгийн газрын албан хаагчид нь тэтгэврийн төлбөрөө гуравдагч этгээдэд шилжүүлэх нь хууль бус байдаг тул эдгээр компаниудын үйл ажиллагаа хууль ёсны гэдэг нь маш сэжигтэй бөгөөд тодорхойгүй хэрэг мөн гэжээ.<sup>40</sup> Мөн Холбооны Худалдааны Комиссын сануулгаас гадна Мэйне муж улсын Пайн Три Легал Ассистанс (Pine Tree Legal Assistance) хэмээх групп бүх АНУ-ын оршин суугчдад зориулж «Аюултай тэтгэврийн зээлийн таван шинж»<sup>41</sup> гэдэг нийтлэл гаргасан бол Нью-Йорк Таймсийн «Тэтгэврийн зээл нь тэтгэврийн насныхныг илүү их өрөнд оруулж байна»<sup>42</sup> гэх зэрэг нийтлэлүүдэд энэ талаар тодорхой бичжээ.

Улсын хэрэглэгчдийг хамгаалах агентлаг болох «Холбооны Худалдааны Комисс»-оос «Маргаашийн тэтгэврийн чекээ өнөөдөр бэлэн мөнгө болгож ав» гэсэн уриатай тэтгэврийн урьдчилгаа, тэтгэврийн худалдаа, тэтгэврийн зээл гэхчлэн янз бүрээр нэрлэгддэг тэдгээр бизнес үйлчилгээний хэрэглэгчдэд зориулан тэтгэврийн зээл нь ихэвчлэн их өндөр хүүтэй, хүү багатай байлаа ч өндөр татвар төлөхүйц нөхцөлтэй тул танд хохиролтой байдаг гэсэн сануулга, зөвлөмжийг өгсөн байдаг ажээ.

Зээл олгогчид нь ахмад дайчид эсхүл засгийн газраас тэтгэвэрт гарагсдыг гол үйлчлүүлэгчдээ болгодог нь тэднийг баталгаатай орлоготой гэж үздэг ба тэднийг банканд шинэ данс нээхийг санал болгодог. Ингэснээр тухайн дансыг зээл олгогч компани хянах боломжтой болохоор үл барам, энэ нь тэдний хувьд «Засгаас олгож буй тэтгэврийг гуравдагч этгээдэд шилжүүлж болохгүй» хэмээх хуулийн заалтаас зайлсхийн хийдүүлэх арга болдог байна.

#### 5. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Тус улсад «Тэтгэврийн зээлийн тухай» хууль үйлчилдэггүй. Өөрөөр хэлбэл, тэтгэврийг барьцаалсан зээлийн үйлчилгээ хийгдэх хуулийн зохицуулалт байхгүй.

Банкны зээлийн талаарх эрх зүйн хэм хэмжээг зохицуулдаг гол эрх зүйн акт нь Иргэний хууль ба мөн Банк, банкны үйл ажиллагааны тухай хууль, Төв банкны тухай хуулинд зээлийн харилцааны талаар зохицуулалтыг хуульчилсан.

<sup>38</sup>Alternatives-pension-loans. <http://www.ptla.org/>

<sup>39</sup>Jennifer Abel /reporter and editor for local newspapers in "Connecticut"/, May 2013- <http://www.ptla.org/alternatives-pension-loans>

<sup>40</sup>John wasik, contributor, <http://www.forbes.com/sites/johnwasik/2013/04/29/pension-loans-still-unregulated-poison/>

<sup>41</sup>Alternatives-pension-loans. <http://www.ptla.org/>

<sup>42</sup>Alternatives-pension-loans. <http://www.ptla.org/>

Зохих хууль тогтоомжуудын зэрэгцээ тодорхой банкны зээл олгох үйл явц нь тухайн банкны зээлийн журмаар зохицуулагддаг.

Иймд ОХУ-д банкууд тэтгэвэрт гарсан хүмүүст зээл олгохдоо хэрэглээний зээлийн хүрээнд бараг ижил нөхцөлөөр зээл олгодог байна. Үүнд:

- Жилийн хүү 16-25 хувь
- Зээлдэгч нь 65-70-аас дээшгүй настай байх
- Зээлдэгчийн 5 сарын тэтгэврээс илүүгүй хэмжээний зээлийг барьцаагүй олгодог.

\* \* \*

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- State Pension Credit Act 2002- <http://lawvolumes.dwp.gov.uk/docs/a12-0101.pdf>
- Гражданский Кодекс РФ. base.garant.ru»
- Alternatives to Pension Loans- <http://www.ptla.org/alternatives-pension-loans>
- Jennifer Abel /reporter and editor for local newspapers in “Connecticut”, May 2013- <http://www.ptla.org/alternatives-pension-loans>
- John wasik, contributor, [HTTP://WWW.FORBES.COM/SITES/JOHNWASIK/2013/04/29/PENSION-LOANS-STILL-UNREGULATED-POISON/](http://WWW.FORBES.COM/SITES/JOHNWASIK/2013/04/29/PENSION-LOANS-STILL-UNREGULATED-POISON/)
- Loans to pensioners, <https://www.sbi.co.in/portal/web/personal-banking/loans-to-pensioners>
- Pensioner Loans, <http://www.finder.com.au/pensioner-loans>
- Пенсионный кредит. <http://www.ypensioner.ru/vse-o-kreditah-vzyat-kredit-pogasit-kredit>

# 3

## БҮЛЭГ

---

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ, ГАДААД БОДЛОГО

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**ХОЛБООНЫ УЛСУУДЫН ПАРЛАМЕНТЫН ТАНХИМЫН ТОО**

Б.Ариунжаргал, Г.Билгээ

Судалгаанд хамрагдсан нийт 191 улсын 28 нь холбооны улс бөгөөд үүнээс хоёр танхимтай холбооны улс 2, нэг танхимтай холбооны улс 8 байна. Үүнд:

Хүснэгт 1

Холбооны улсуудын парламентын танхимын тоо	Улс орны тоо	Улс орнууд
2 танхимтай	20	Австрали, Австри, АНУ, Аргентин, Бельги, Босни Герцеговин, Бразил, Герман, Канад, Малайз, Мексик, Мьянмар, Нигерия, ОХУ, Пакистан, Сомали, Судан, Швейцарь, Энэтхэг, Этиоп
1 танхимтай	8	Арабын НЭУ, Венесуэл, Ирак, Коморын арлууд, Микронез, Непал, Сент-Китс ба Невис, Өмнөд Судан

**Холбооны улсуудын парламентын танхимын тоо, нэр болон гишүүдийн тоо<sup>43</sup>**

Хүснэгт 2

№	Улсын нэр	Танхимын тоо	Танхимын нэр	Гишүүний тоо <sup>44</sup>
1.	Австрали	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	76 150
2.	Австри	2	Холбооны Зөвлөл Үндэсний Зөвлөл	61 183
3.	АНУ	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	100 435/434
4.	Арабын НЭУ	1	Холбооны Үндэсний Ассамблей	40
5.	Аргентин	2	Сенат Депутатуудын танхим	72 257
6.	Бельги	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	60 150
7.	Босни Герцеговин	2	Ардын танхим Төлөөлөгчдийн танхим	15 42
8.	Бразил	2	Холбооны Сенат Депутатуудын танхим	81 513
9.	Венесуэл	1	Үндэсний Ассамблей	165
10.	Герман	2	Бундесрат буюу Холбооны зөвлөл Бундестаг буюу Холбооны хурал	69 598/631
11.	Ирак	1	Төлөөлөгчдийн танхим	328
12.	Канад	2	Сенат Нийтийн танхим	105/85 308/304

<sup>43</sup><http://www.ipu.org/parline-e/Modlist.asp><sup>44</sup>PARLINE database on national parliaments, <http://www.ipu.org/parline-e/Modlist.asp>



13.	Коморын арлууд	1	Холбооны Ассамблей	33
14.	Малайз	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	70/59 222
15.	Мексик	2	Сенаторын танхим Депутатуудын танхим	128 500
16.	Микронез	1	Конгресс	14/12
17.	Непал	1	Ассамблей	601/599
18.	Нигерия	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	109/108 360
19.	ОХУ	2	Холбооны Хурал Төрийн Дум	170 450
20.	Пакистан	2	Сенат Үндэсний Ассамблей	104/100 342/323
21.	Сент-Китс ба Невис	1	Үндэсний Ассамблей	15
22.	Сомали	2	Дээд танхим Ардын танхим	54 275
23.	Өмнөд Судан	2	Мужуудын зөвлөл Депутатуудын танхим	50 332
24.	Судан	2	Төрийн зөвлөл Үндэсний Ассамблей	56/54 426
25.	Танзани	1	Үндэсний Ассамблей	357
26.	Швейцарь	2	Сенат Төлөөлөгчдийн танхим	46 200
27.	Энэтхэг	2	Муж улсуудын зөвлөл Ардын танхим	245/243 545/543
28.	Этиоп	2	Ардын Төлөөлөгчдийн танхим Холбооны танхим	547 135

\* \* \*

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛТАЙ ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНЭЭР СОНГОГДОХ НАСНЫ ДООД ХЯЗГААР

Г.Билгээ

Судалгаанд парламентын засаглалтай 29 орныг хамруулсан бөгөөд эдгээр улсуудад Парламентын сонгуульд нэр дэвшигчийн насны доод хязгаар хэрхэн тогтоосныг дараах хүснэгтэд оруулсан болно.

Хүснэгт 1

Насны доод хязгаар	Улсын тоо	Улс орнууд
18 нас	9	Албани, Андорра, Багамын арлууд, Бельги, Белиз, Ботсван, Нидерланд, Словен, Хорват
21 нас	15	Австрали, Барбадос, Болгар, Доминик, Израиль, Ирланд, Латва, Сент-Винсент ба Гренадин, Сент-Люси, Сингапур, Словак, Чех, Ямайка, Канад, Эстони
25 нас	4	Бангладеш, Литва, Турк, Япон
30 нас	1	Ирак

Парламентын гишүүнээр сонгогдох насны доод хязгаарыг тогтоосон байдал

Хүснэгт 2

№	Улсын нэр	Насны доод хязгаар <sup>45</sup>
1.	Австрали	21*
2.	Албани	18*
3.	Андорра	18*
4.	Багамын арлууд	18*
5.	Бангладеш	25*
6.	Барбадос	21*
7.	Бельги	18*
8.	Белиз	18*
9.	Ботсван	18*
10.	Болгар	21*
11.	Нидерланд	18*
12.	Доминик	21*
13.	Израиль	21*
14.	Ирак	30*
15.	Ирланд	21*
16.	Канад	21**
17.	Латва	21*
18.	Литва	25*
19.	Сент-Винсент ба Гренадин	21*
20.	Сент-Люси	21*

<sup>45</sup>Хоёр танхимтай парламентай орнуудын доод танхимын гишүүнээр сонгогдох нэр дэвшигчийн насны доод хязгаарыг авсан

21.	Сингапур	21*
22.	Словак	21*
23.	Словен	18*
24.	Турк	25*
25.	Хорват	18**
26.	Чех	21*
27.	Эстони	21**
28.	Ямаик	21*
29.	Япон	25**

Эх сурвалж: \* Үндсэн хууль, \*\* Сонгуулийн тухай хууль

\* \* \*

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ ГАДААДЫН  
ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч(PhD), Б.Ариунжаргал,  
Г.Билгээ, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл,  
Ө.Мөнхтунгалаг, Р.Нургүл, Ч.Онончимэг,  
Д.Халиун, А.Пагма, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа*

Судалгаанд дэлхийн 40 орныг хамруулж, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох, Засгийн газрын гишүүдийг томилох харилцааг хэрхэн зохицуулдаг талаар судалсан болно.

*Хүснэгт 1*

<b>Засгийн газрын гишүүнийг тодорхойлох субъект</b>	<b>Улсын тоо</b>	<b>Улс орнууд</b>
Парламент	7	Албани, Канад, Латви, Македон, Сингапур, Словен, Хорват
Ерөнхийлөгч	21	АНУ, Герман, Доминикан, Индонез, Ирланд, Исланд, Итали, Кыргызстан, Литва, Молдав, ОХУ, Польш, Словак, Өмнөд Солонгос, Тайвань, Унгар, Финлянд, Франц, Чех, Чили, Эстони
Хаан	5	Бельги, Дани, Голланд, Их Британи, Норвеги,
Ерөнхий сайд	7	Бангладеш, Болгар, Босни Герцеговин, Израйл, Турк, Швед, Япон

**Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлох  
тухай зарим орны эрх зүйн зохицуулалт**

*Хүснэгт 2*

<b>№</b>	<b>Улс орнууд</b>	<b>Эрх зүйн зохицуулалт</b>
1	<b>Албани</b>	<u>Үндсэн хууль:</u> 3.96.1 Сайд нарын зөвлөлийн бүтцийг Ассамблей батална. Ерөнхийлөгч нь Засгийн газрыг бүрдүүлэх эрхийг Ассамблейд олонхын суудал авсан намд олгодог. Харин нийт гишүүдийн ердийн олонхын дэмжсэнээр Сайд нарын танхимын бүрэлдэхүүнийг батална.
2	<b>АНУ</b>	<u>Үндсэн хууль:</u> 2.2.(2) Ерөнхийлөгч нь Сенатын зөвшөөрөл, зөвлөмжөөр Сенатчдын гуравны хоёр нь сайшаан дэмжсэн нөхцөлд томилох эрхтэй.
3	<b>Бангладеш</b>	<u>Үндсэн хууль:</u> 56. Бангладешийн Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг, сайдыг, төрийн нарийн бичгийн даргыг, орлогч сайдыг томилно. Томилогдох сайд нарын нийт бүрэлдэхүүний 9/10 -с багагүй хэсэг парламентын гишүүдээс бүрдэнэ.
4	<b>Бельги</b>	<u>Үндсэн хууль:</u> 96. Хаан [өөрийнхөө] сайд нарыг томилно, хална. Төлөөлөгчдийн танхим Засгийн газарт итгэхгүй байгаагаа зохих журмаар илэрхийлсэн тохиолдолд Холбооны засгийн газар Хаанд огцрох тухай хүсэлт тавина. Төлөөлөгчдийн танхим Ерөнхий сайдаар томилуулах хүнийг хаанд санал болгоно. 101, 104. Сайд нар Төлөөлөгчдийн танхимын өмнө ажлаа хариуцна. Төрийн нарийн бичгийн дарга нарыг хаан томилно.

5	Болгар	<p><u>Үндсэн хууль:</u> 99. Улсын Ерөнхийлөгч нь Парламент дахь улс төрийн намын бүлгүүдтэй зөвлөлдсөний дараа, хамгийн олон суудал бүхий улстөрийн намаас Ерөнхий сайдад нэр дэвшигчид кабинетаа бүрдүүлэхийг даалгана.</p> <p>(2) Ерөнхий сайдад нэр дэвшигч нь 7 хоногийн дотор кабинетын бүрэлдэхүүнээ тодорхойлж чадаагүй тохиолдолд Улсын Ерөнхийлөгчөөс дараагийн хүнд дээрх үүргийг даалгана. Ерөнхий сайдад нэр дэвших хүнийг энэ удаад парламентад авсан суудлынхаа тоогоор 2 дугаарт жагсаж байгаа улстөрийн намын бүлэг санал болгоно.</p> <p>(3) Хэрэв энэ удаад мөн өмнөхийн адил нөхцөл байдал үүсч асуудал саатвал Ерөнхийлөгч дараа дараагийн намын бүлгээс санал болгосон нэр дэвшигчид дээрх асуудлыг даалгана.</p> <p>(4) Зөвшилцлийн болон өмнөтгөл шатны ажилбарууд амжилттай болсон бол Улсын Ерөнхийлөгчөөс Ерөнхий сайдад нэр дэвшигчийг томилуулахаар Ардын хуралд санал оруулна.</p> <p>(5) [Эдгээрийн дараа ...] Засгийн газар байгуулагдаж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч парламентыг тарааж Түр засгийн газрыг томилон шинэ сонгууль зарлан, сонгуулийн товыг тогтооно.</p>
6	Босни Герцеговин	<p><u>Үндсэн хууль:</u> Сайд нарын зөвлөлийн дарга нь сайд нарыг томилно. Парламентын ассамблей итгэл үзүүлээгүй тохиолдолд Сайд нарын зөвлөл огцорно.</p>
7	Герман	<p><u>Үндсэн хууль:</u> 64(1) Холбооны канцлерийн санал болгосноор Холбооны сайдыг Холбооны ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.</p>
8	Дани	<p><u>Үндсэн хууль:</u> 14. Хаан Ерөнхий сайд, сайд нарыг томилж, огцруулна. Хэдэн сайдтай байх, тэд ямар үүрэгтэй байхыг Хаан шийднэ. (ҮХ-ийн 14.)</p>
9	Голланд	<p><u>Үндсэн хууль:</u> 43. Хаан Ерөнхий сайд, сайд нарыг томилж, огцруулна.</p>
10	Доминикан	<p><u>Үндсэн хууль:</u> 128.2.а. Ерөнхийлөгч сайд нарыг томилж, огцруулна.</p>
11	Израил	<p><u>Үндсэн хууль:</u> Ерөнхийлөгчийн санал болгосноор Кнессет Ерөнхий сайдын 4 жилийн хугацаагаар томилно. Кнессетээс зөвшөөрөл авсны үндсэн дээр сайд нарыг Ерөнхий сайд томилно.</p>
12	Индонез	<p><u>Үндсэн хууль:</u> 17. Төрийн сайдыг Ерөнхийлөгч томилж чөлөөлнө.</p>
13	Ирланд	<p><u>Үндсэн хууль:</u> 28.1 Засгийн газар нь 7-15 гишүүнээс бүрдэх бөгөөд Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгч томилно.</p>
14	Исланд	<p><u>Үндсэн хууль:</u> 15 . Ерөнхийлөгч сайдуудыг томилж чөлөөлөх бөгөөд хэдэн сайдтай байхыг, мөн тэдний албан үүргийг тодорхойлно.</p>
15	Итали	<p><u>Үндсэн хууль:</u> 92. Засгийн газар нь Зөвлөлийн Ерөнхийлөгч болон сайдуудаас бүрддэг бөгөөд үүнийг Сайд нарын Зөвлөл гэж нэрлэдэг. Итали улсын Ерөнхийлөгч Сайд нарын Зөвлөлийн Ерөнхийлөгчийг томилох ба Зөвлөлийн Ерөнхийлөгчийн санал болгосноор сайдуудыг томилно.</p>
16	Их Британи	<p><u>Үндсэн хууль:</u> Ерөнхий сайдын санал болгосноор Хатан хаан Засгийн газрыг бүрдүүлж сайд нарыг томилно. Засгийн газар Хатан хааны нэрийн өмнөөс ажилдаг байна. <a href="http://www.gov.uk">www.gov.uk</a></p>

17	<b>Канад</b>	<u>Үндсэн хууль:</u> Ерөнхий сайдын сонгон авсан кабинетын гишүүдийг Парламент хэлэлцэж батална. <a href="http://www.parl.ca">www.parl.ca</a>
18	<b>Кыргызстан</b>	<u>Үндсэн хууль:</u> 84. Жогорку Кенешт талаас илүү суудал авсан бүлэг, эсвэл эвслийн бүлэг нь анхны хуралдаанаас хойш 15 хоногийн дотор Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ. Ерөнхий сайдад нэр дэвшигч Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүнийг Жогорку Кенешт санал болгоно. Жогорку Кенеш нь Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүнийг дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгч 3 хоногийн дотор Ерөнхий сайд болон бусад сайд нарыг томилно.
19	<b>Латви</b>	<u>Үндсэн хууль:</u> 55. Сайд нарын танхим нь Ерөнхий сайд ба түүний урьсан сайд нараас бүрдэнэ. 56. БНУ-ын Ерөнхийлөгчөөс үүрэг авсан этгээд Сайд нарын танхимыг бүрдүүлнэ. 59. Сейм итгэл үзүүлсэнээр Ерөнхий сайд ба сайд нар бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлнэ. Ерөнхий сайд ба сайд нар үйл ажиллагаагаа Сеймын өмнө хариуцна.
20	<b>Литва</b>	<u>Үндсэн хууль:</u> 92. Сеймийн дэмжсэн нэр дэвшигчийг БНУ-ын Ерөнхийлөгч Ерөнхий сайдаар томилно. Сайд нарыг Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө. Ерөнхий сайд томилогдосноосоо хойш 14 хоногийн дотор өөрийн бүрдүүлж, Ерөнхийлөгчийн томилсон Засгийн газраа Сеймд танилцуулж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө танилцуулна.
21	<b>Македон</b>	<u>Үндсэн хууль:</u> 90. Улсын Хурал бүрдсэнээс хойш 10 хоногийн дотор Ерөнхийлөгч Улсын Хуралд олонхыг бүрдүүлж чадсан нам, эсвэл намуудын эвслээс дэвшүүлсэн нэр дэвшигчид Засгийн газрыг бүрдүүлэх мандат олгоно. Мандат авсан этгээд авсанаасаа хойш 20 хоногийн дотор Улсын Хуралд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг өргөн барьж, бүрэлдэхүүнээ санал болгоно. Мөрийн хөтөлбөр болон саналын үндсэн дээр Улсын Хурал Засгийн газрыг нийт гишүүдийнхээ олонхын саналаар сонгоно.
22	<b>Молдав</b>	<u>Үндсэн хууль:</u> 98(2), (3), (4) Ерөнхий сайдын томилогдсоноос хойш 15 хоногийн дотор Парламент нь Засгийн газрын бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэж сонгогдсон нийт гишүүдийнхээ олонхын саналаар дэмжсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь Засгийн газрыг томилно.
23	<b>Норвеги</b>	<u>Үндсэн хууль:</u> 12. Эзэн хаан өөрөө Төрийн зөвлөлийг сонгох ба Төрийн зөвлөл нь Ерөнхий сайд болон бусад долоон гишүүнээс бүрдэнэ.
24	<b>ОХУ</b>	<u>Үндсэн хууль:</u> 111.1, Ерөнхий сайдыг Төрийн Думын зөвшөөрснөөр Ерөнхийлөгч томилно. 112.1, 112.2. Ерөнхий сайд нь томилогдсон өдрөөсөө хойш 7 хоногоос хэтрэхгүй Шадар сайд нар, холбооны сайд нарын албан тушаалд нэр дэвшигчдыг Ерөнхийлөгчид санал болгоно.

25	Польш	<p><u>Үндсэн хууль:</u> 154.1. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч Сайд нарын Зөвлөлийн даргын нэрийг дэвшүүлж, нэр дэвшигч Сайд нарын Зөвлөлийн бүрэлдэхүүнийг санал болгоно. Сеймийн анхны хуралдаан болсон өдөр, эсхүл өмнөх Сайд нарын Зөвлөл огцорсон өдрөөс хойш 14 хоногт багтан Ерөнхийлөгч Сайд нарын Зөвлөлийн дарга болон гишүүдийг томилно.</p> <p>154.2. Сайд нарын Зөвлөлийн дарга нь томилогдсоноосоо хойш 14 хоногт багтан Сайд нарын Зөвлөлийн үйл ажиллагааны хөтөлбөрөө Сеймд өргөн барьж, итгэл үзүүлэхийг хүснэ. Сейм итгэл үзүүлэх эсэх шийдвэрээ хуулиар тогтоогдсон депутатуудын тооны талаас багагүй нь ирсэн тохиолдолд абсолют олонхын саналаар гаргана.</p>
26	Сингапур	<p><u>Үндсэн хууль:</u> 25. Ерөнхийлөгч Парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээх чадвартай гэж үзсэн Парламентын гишүүнийг Ерөнхий сайдаар томилох бөгөөд Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентын гишүүд дундаас сайд нарыг томилно.</p> <p>26.2A. Ерөнхий сайдаас бусад сайд нар дараах нөхцөлд огцруулна: Ерөнхийлөгч Ерөнхий сайдын зөвлөсний дагуу сайдыг тухайн албан тушаалаас нь албан ёсоор огцруулах тухай шийдвэр гаргасан.</p>
27	Словак	<p><u>Үндсэн хууль:</u> 110. Засгийн газрын даргыг Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.</p> <p>111. Засгийн газрын даргын санал болгосноор Ерөнхийлөгч Засгийн газрын гишүүдийг томилж, чөлөөлөх ба тэдэнд яамдыг удирдах бүрэн эрх олгоно.</p>
28	Словен	<p><u>Үндсэн хууль:</u> 112. Сайд нарыг Засгийн газрын даргын санал болгосноор Үндэсний Ассамблейн шийдвэрээр томилж, чөлөөлнө. Томилгоо явагдахаас өмнө сайдад нэр дэвшигчид нь Үндэсний Ассамблейн эрх бүхий комиссоос явуулах асуулгад оролцоно.</p>
29	Солонгос (Өмнөд)	<p><u>Үндсэн хууль:</u> 66.4-т "Гүйцэтгэх эрх мэдэл нь Ерөнхийлөгчөөр удирдуулсан Засгийн газарт байна" гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, Гүйцэтгэх засаглалын удирдан зохион байгуулах хамгийн дээд эрх мэдэл нь Ерөнхийлөгчид байдаг.</p> <p>2.3.94. Сайд нарыг Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилно.</p>
30	Тайвань	<p><u>Үндсэн хууль:</u> 56. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Ерөнхийлөгч томилно.</p>
31	Турк	<p><u>Үндсэн хууль:</u> 109. Сайд нарын Зөвлөл нь Ерөнхий сайд болон сайд нараас бүрдэнэ. Ерөнхий сайд нь сайд нарыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас, эсхүл Үндэсний Их хурлын гишүүнд тавигдах шаардлагыг хангасан этгээдийн томилох бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын санал болгосны дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.</p>
32	Унгар	<p><u>Үндсэн хууль:</u> 33. Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын хурал нийт гишүүдийнхээ олонхын саналаар Ерөнхий сайдыг сонгоно. Улсын хурал ерөнхий сайдыг томилох, Засгийн газрын хөтөлбөрийг батлах шийдвэрийг нэгэн зэрэг гаргана.</p> <p>Ерөнхий сайдын санал болгосноор сайд нарыг Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.</p>

33	<b>Финлянд</b>	<p><u>Үндсэн хууль:</u> 61. Ерөнхийлөгчийн санал болгосноор Ерөнхий сайдыг Парламентаас сонгох бөгөөд бусад сайдуудыг Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилно. Ерөнхий сайдыг сонгохоос өмнө парламентад төлөөлөл бүхий бүлгүүд Засгийн газрын бүрэлдэхүүн, улс төрийн хөтөлбөрийг хэлэлцэж, Ерөнхийлөгч Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Парламентад танилцуулна.</p>
34	<b>Франц</b>	<p><u>Үндсэн хууль:</u> 8. Ерөнхийлөгч Ерөнхий сайдын санал оруулснаар Засгийн газрын бусад гишүүнийг томилох ба бүрэн эрхийг нь дуусгавар болгоно.</p>
35	<b>Хорват</b>	<p><u>Үндсэн хууль:</u> 98. Ерөнхийлөгч нь парламентад авсан суудлын тоонд үндэслэн парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээсэн этгээдийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ. 110. Ерөнхий сайдад нэр дэвшигч нь эрх олгогдсоноос хойш 30 хоногийн дотор танхимаа бүрдүүлж, мөрийн хөтөлбөрөө Парламентад танилцуулж итгэл үзүүлэх хүсэлт тавьж шийдүүлнэ. Парламентын гишүүдийн олонх Ерөнхий сайд болон Засгийн газарт итгэл үзүүлэхийг дэмжвэл Ерөнхийлөгч шийдвэр гаргаж, Ерөнхий сайдыг томилж, Ерөнхий сайд болон гишүүд нь Парламентад тангараг өргөнө. 111. Засгийн газрыг байгуулах эрх олгогдсоноос хойш 30 хоногийн дотор Засгийн газрыг бүрдүүлж чадаагүй, эсхүл Парламентаас Засгийн газарт итгэл үзүүлэх боломжгүй гэж үзвэл Ерөнхийлөгч хугацааг 30 хүртэлх хоногоор сунгаж болно. Энэ хугацаанд бүрдүүлж чадаагүй бол Засгийн газрыг байгуулах эрхийг өөр этгээдэд шилжүүлнэ. 112, 110, 111-р зүйлд зааснаар Засгийн газар байгуулагдаж чадаагүй нөхцөлд Ерөнхийлөгч нам бус түр Засгийн газрыг өөрөө байгуулж, Парламентын сонгуулийг хугацаанаас өмнө зарлана.</p>
36	<b>Чех</b>	<p><u>Үндсэн хууль:</u> 68. Ерөнхийлөгч Засгийн газрын даргыг томилох ба түүний санал болгосноор Засгийн газрын бусад гишүүдийг томилно. Засгийн газар томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор Депутатуудын танхимд өөрт нь итгэл үзүүлэх хүсэлтээ тавина.</p>
37	<b>Чили</b>	<p><u>Үндсэн хууль:</u> 32. Ерөнхийлөгч нь Төрийн сайдууд, орлогчид, захирагчид, засаг дарга нарыг томилж, чөлөөлнө.</p>
38	<b>Швед</b>	<p><u>The Instrument of Government Act:</u> 6.1-6.4. Риксдагийн гишүүдийн талаас илүү хувь дэмжвэл Ерөнхий сайдыг томилж, Ерөнхий сайд бүтэц бүрэлдэхүүнээ Риксдагт өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд бусад сайдуудаа томилно.</p>
39	<b>Эстони</b>	<p><u>Үндсэн хууль:</u> 89. Ерөнхийлөгч Ерөнхий сайдад нэр дэвшигчийг товлж, түүнд Засгийн газрыг бүрдүүлэх үүрэг өгнө. Үүрэг авсан нэр дэвшигч 14 хоногийн дотор Рийгикогууд бүрдүүлэх гэж буй Засгийн газрынхаа талаар илтгэнэ. Илтгэлийн дараа хэлэлцүүлэггүйгээр илээр санал хурааж нэр дэвшигчид Засгийн газрыг бүрдүүлэх бүрэн эрх олгоно. Бүрэн эрх авсан нэр дэвшигч 7 хоногийн дотор Ерөнхийлөгчид Засгийн газрын бүрэлдэхүүнээ өргөн барина. Ерөнхийлөгч 3 хоногийн дотор Засгийн газрыг томилно.</p>
40	<b>Япон</b>	<p><u>Үндсэн хууль:</u> 67. Парламент тогтоол гарган гишүүд дотроосоо Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ. Нэр дэвшүүлэх асуудлаар Парламентын хоёр танхим санал нэгдэж чадахгүй бол Төлөөлөгчдийн танхимын шийдвэр Парламентын шийдвэрт тооцогдоно. 68. Ерөнхий сайд Сайд нарыг томилох бөгөөд Сайд нарын олонх нь Парламентын гишүүд байх ёстой.</p>



**ТӨРИЙН ТЭРГҮҮНЭЭР СОНГОГДСОН ТОХИОЛДОЛД УЛС ТӨРИЙН  
НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛЭЭС ТАТГАЛЗДАГ БОЛОН ТҮДГЭЛЗҮҮЛДЭГ  
ЭСЭХ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Р.Хатанбаатар, И.Жаргалзаяабямба,  
Д.Жигваагүнсэл, Р.Нургүл, Ө.Мөнхтунгалаг,  
Ч.Онончимэг, А.Пагма, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа*

Дэлхийн улс орнуудад ерөнхийлөгчийн эрх мэдэл хоорондоо их ялгаатай. Тухайлбал, АНУ-д ерөнхийлөгч нь төрийн тэргүүнээс гадна засгийн газрын тэргүүн байдаг бол Германд ерөнхийлөгч нь зөвхөн төрийн тэргүүн, засгийн газраа толгойлохгүй. Иймд ерөнхийлөгчийн намын гишүүнчлэл нь зөвхөн төрийн тэргүүн үү, эсвэл засгийн газраа толгойлох уу гэдгээс хамаарна. Хэрэв ерөнхийлөгч улс төрийн намуудын бүрдүүлсэн засгийн газрыг толгойлж байгаа бол намтай холбоотой байна.

Дэлхийн нилээд олон орны Үндсэн хуулинд ерөнхийлөгчийг улс төрийн намын үйл ажиллагаанд оролцохыг хориглосон байдаг байна. Албани (1998), Беларусь (1996), Болгар (2003), Чад (1996), Эстони (1992), Казахстан (1998), Кыргызстан (2003), Литва (1992), Нигер (1999), Турк (2002), Уругвай (1996) онуудад тус тус хориглосон заалт оруулж байжээ.

(Жич: Үндсэн хуулиа баталсан, эсвэл өөрчлөлт оруулсан оныг нь хаалтанд бичив).

№	Улс орон	Эрх зүйн зохицуулалт
1	<b>Австри</b>	Холбооны канцлер нь Засгийн газрыг тэргүүлдэг ба ихэвчлэн ялсан намын дарга байна.
2	<b>Албани</b>	<ul style="list-style-type: none"> <li>Бүгд Найрамдах Улсын ерөнхийлөгч нь төрийн өөр алба давхар хашиж болохгүй, улс төрийн намын гишүүн байж болохгүй, мөн хувийн ашгийн байгууллагын үйл ажиллагаанд орж болохгүй.</li> </ul> <p align="right"><i>Үндсэн хуулийн 89-р зүйл</i></p>
3	<b>Болгар</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгч нь Үндсэний Ассемблейн гишүүн болон өөр ямар нэгэн улс, нийтийн эрх мэдэлтэн эсхүл эдийн засгийн идэвхитэй үйл ажиллагаа мөн ямар нэг намын гишүүнчлэлээс татгалзна.</li> </ul> <p align="right"><i>Үндсэн хуулийн 95-р зүйл 2-т</i></p>
4	<b>Беларусь</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ерөнхийлөгч бүрэн эрхийн хугацаандаа улс төрийн нам болон улс төрийн зорилго бүхий олон нийтийн байгууллагын гишүүнчлэлээ зогсооно.</li> </ul> <p align="right"><i>Үндсэн хуулийн 86-р зүйл</i></p>
5	<b>БНХАУ</b>	<ul style="list-style-type: none"> <li>“БНХАУ-ын дарга, түүний орлогчийг БХАТИХурлаас сонгоно”, “Улсын дарга нь БХАТИХурал ба БХАТИХ-ын Байнгын хорооны санал шийдвэрийг үндэслэн БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд, Ерөнхий сайдын орлогчийг томилно. [БНХАУ нь үндсэн хуульдаа заасанчлан “социалист төр”-тэй</li> </ul> <p align="right"><i>Үндсэн хуулийн 79-80-р зүйл</i></p>
6	<b>Ирланд</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ерөнхийлөгч нь парламентын хоёр танхимын алины ч гишүүн байж болохгүй. Хэрвээ парламентын аль нэг танхимын гишүүн Ерөнхийлөгчөөр сонгогдвоос тэрээр тухайн танхим дахь суудлаасаа чөлөөлөгдсөнд тооцно.</li> <li>Ерөнхий сайдыг /Taoiseach/ парламентын доод танхимаас нэр дэвшүүлэх ба олонхын суудал авсан намын дарга байдаг. Олон нам эсхүл эвсэлийн засгийн газар байгуулах үед Ерөнхий сайдаар тухайн эвсэлийн доторх хамгийн том намын дарга томилогдоно.</li> </ul> <p align="right"><i>Үндсэн хуулийн 12-р зүйл, 6.1, 6.2-т</i></p>

7	Итали	<ul style="list-style-type: none"> <li>Шүүгч, мэргэжлийн цэргийн албан хаагч (ажиллаж байх хугацаандаа), хууль сахиулах албан хаагч, гадаадад суугаа дипломат ажилтан, консул төлөөлөгч зэрэг албан хаагчдын намын гишүүн байх эрхийг хуулиар хязгаарлаж болно.</li> <li>Ерөнхий сайд нь намын гишүүн байна</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 98-р зүйл</i></p>
8	ИБУИНВУ	<ul style="list-style-type: none"> <li>Хаант засаглалтай. Хаан нь парламентад суудалтай улс төрийн аль ч намын гишүүн биш. 1701 (Act Of Settlement)-аар зохицуулна.</li> <li>Парламентын даргын хувьд Британы Парламент Лордын болон Төлөөлөгчийн танхимаас бүрдсэн, хаант засаглалын шинж чанарыг илэрхийлсэн өвөрмөц онцлогтой. Төлөөлөгчдийн танхимын даргыг гишүүдээс сонгоно. Төлөөлөгчдийн танхимын даргыг намын гишүүнчлэлээс татгалзах зохицуулалтгүй.</li> <li>Засгийн газрын тэргүүний хувьд 1922 оноос Хаан парламентад олонх болж байгаа намын даргыг Ерөнхий сайдаар томилно. Ерөнхий сайд намын гишүүнчлэлээс татгалзах заалтгүй.</li> </ul>
9	Канад	<ul style="list-style-type: none"> <li>Канадын Албан ёсны төрийн тэргүүн нь Хатан хаан.</li> <li>Ерөнхий сайд нь намын дарга байна.</li> </ul>
10	Казахстан	<ul style="list-style-type: none"> <li>“Улсын ерөнхийлөгч улс төрийн намын гишүүн бус байна” гэсэн утгатай заалт байсан. Энэ заалтыг 2007 онд конституцийн агуулгаас хасчээ.</li> <li>Бүгд Найрамдах улсын ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж байх хугацаандаа улс төрийн намын гишүүнчлэлээс түдгэлзүүлнэ.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 43-р зүйл, 2-т</i></p>
11	Кыргызстан	<ul style="list-style-type: none"> <li>Бүгд Найрамдах Кыргыз улсын ерөнхийлөгч нь дараагийн Ерөнхийлөгчийн сонгууль эхлэх хүртэлх бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаандаа улс төрийн нам, байгууллагын гишүүнчлэлээсээ түдгэлзэнэ.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 43-р зүйл, 5-т</i></p>
12	Латви	<ul style="list-style-type: none"> <li>Ерөнхийлөгчийн албан тушаалыг өөр албан тушаалтай хавсран хашиж үл болно.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 38-р зүйл</i></p>
13	Литва	<ul style="list-style-type: none"> <li>Бүгд Найрамдах улсын ерөнхийлөгч нь Сеймийн гишүүн болон өөр бусад албан тушаал эрхэлж болохгүй, ерөнхийлөгчийн цалингаас өөр, уран бүтээлийн шагнал гэх мэт ямарваа урамшуулал авч болохгүй. Бүгд Найрамдах улсын ерөнхийлөгчөөр сонгогдсон этгээд нь дараагийн ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажил эхлэх хүртэл улс төрийн нам болон улс төрийн байгууллагын гишүүнчлэлээсээ түдгэлзэнэ.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 83-р зүйл</i></p>
14	Нигер	<ul style="list-style-type: none"> <li>Бүгд Найрамдах улсын ерөнхийлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаандаа улс төрийн нам болон үндэсний хэмжээний байгууллагуудын гишүүн болон удирдах бүрэлдэхүүний гишүүн байж болохгүй.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 44-р зүйл</i></p>
15	ОХУ	<ul style="list-style-type: none"> <li>ОХУ-ын Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацаандаа улс төрийн намын гишүүнчлэлээсээ татгалзах эрхтэй.</li> </ul> <p><i>Улс төрийн намуудын тухай хуулийн 1-р бүлэг, 10-р зүйл.</i></p>
16	Польш	<ul style="list-style-type: none"> <li>Ерөнхийлөгч өөрийн албан тушаалаас өөр ямар нэг албан тушаал, нийтийн алба, чиг үүрэг гүйцэтгэж болохгүй.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 4-р хэсэг 132-р зүйл</i></p>

17	<b>Турк</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ерөнхийлөгчөөр сонгогдсон этгээд хэрэв намын гишүүн бол намтайгаа харилцаагаа таслана, Үндэсний Их Хурлын гишүүний статус нь цуцлагдана.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 101-р зүйл</i></p>
18	<b>Узбекистан</b>	<ul style="list-style-type: none"> <li>Узбекистаны Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Улсын ерөнхийлөгч улс төрийн намын харъяалалгүй (намаас гарсан ба түдгэлзсэн) байна” гэж заасан. Энэ хязгаарлалт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн үйлчлэх хугацаанд хамаарна.</li> </ul>
19	<b>Уругвай</b>	<ul style="list-style-type: none"> <li>Бүгд Найрамдах улсын ерөнхийлөгч болон Сонгуулийн шүүхийн гишүүн нь улс төрийн хороод, клубүүдэд харьяалагдаж болохгүй, намын байгууллагад удирдах алба хашиж болохгүй, ямар ч тохиолдолд сонгуулийн өмнөх сурталчилгааны ажилд оролцож болохгүй.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 77-р зүйл</i></p>
20	<b>Хорват</b>	<ul style="list-style-type: none"> <li>Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь сонгогдсоны дараа улс төрийн болон намын гишүүнчлэлээсээ татгалзах бөгөөд энэ тухай Парламентдаа мэдэгдэнэ.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 96-р зүйл</i></p>
21	<b>Чад</b>	<ul style="list-style-type: none"> <li>Бүгд Найрамдах улсын ерөнхийлөгчийн албан тушаалыг аливаа өөр сонгуульт ажил, төрийн алба, мэргэжлийн болон ашгийн үйл ажиллагаатай хавсарч болохгүй. Мөн улс төрийн нам, улс төрийн намуудын бүлгийн үйл ажиллагаанд оролцож болохгүй.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 71-р зүйл</i></p>
22	<b>Румын</b>	<ul style="list-style-type: none"> <li>Румыны Ерөнхийлөгч нь алба хаших хугацаандаа ямарваа намын гишүүн байж болохгүй ба, бусад улсын болон хувийн ямарч албыг хашиж болохгүй.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 84 зүйл, 1 хэсэг</i></p>
23	<b>Энэтхэг</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ерөнхийлөгч нь парламентын хоёр танхимын алинд ч эсхүл аль нэг муж улсын Хууль тогтоох танхимын гишүүн байх ёсгүй ба, хэрвээ парламентын хоёр танхимын аль нэгний эсхүл аль нэгэн муж улсын хууль тогтоох танхимын гишүүн Ерөнхийлөгчид сонгогдвоос тэрээр Ерөнхийлөгчийн албыг эхэлсэн өдрөөс тухайн танхимын суудлаас чөлөөлөгдсөнд тооцно.</li> <li>Энэтхэг нь парламентын засаглалын тогтолцоог баримталдаг тул Ерөнхий сайдаар ерөнхийдөө Энэтхэгийн парламентын Лок Сабха хэмээх доод танхимд олонхын суудал авсан намын (эсхүл эвсэлийн) дарга нь болдог.</li> <li>Энэтхэгийн парламентын Лок Сабха хэмээх доод танхимыг даргалагч бол Спикер нь байна. Спикер нь ерөнхий сонгуулийн дараах Лок Сабха-ны хамгийн анхны хуралдаанаас сонгогдоно. Түүнийг Лок Сабха-ны гишүүд дундаас сонгох ба, засаг барьж буй намын эсхүл эвсэлийн гишүүн байх нь тогтсон заншил юм.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 59-р зүйл, 1-т</i></p>
24	<b>Эстони</b>	<ul style="list-style-type: none"> <li>Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон тохиолдолд өмнө эрхэлж байсан ажил албан тушаал болон Ерөнхийлөгчөөр ажиллах хугацаандаа намын гишүүнчлэлээсээ түдгэлзэнэ.</li> </ul> <p><i>Үндсэн хуулийн 84-р зүйл</i></p>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [http://www.vks.bg/english/vksen\\_p04\\_01.htm](http://www.vks.bg/english/vksen_p04_01.htm)
- <http://www.irishstatutebook.ie/en/constitution/>
- <http://www.sabor.hr/Default.aspx?art=2405>
- <http://www.cdep.ro/pls/dic/site.page?id=371>
- <http://india.gov.in/my-government/constitution-india>
- [http://Prime\\_Minister\\_of\\_India#Constitutional\\_framework\\_and\\_position\\_of\\_prime\\_minister](http://Prime_Minister_of_India#Constitutional_framework_and_position_of_prime_minister)
- [http://en.wikipedia.org/wiki/speaker\\_of\\_India](http://en.wikipedia.org/wiki/speaker_of_India)
- <https://www.riigiteataja.ee/en/eli/530102013003/consolide>
- [https://www.ndi.org/files/1948\\_polpart\\_janda\\_110105.pdf](https://www.ndi.org/files/1948_polpart_janda_110105.pdf)
- <http://www.tourmycountry.com/austria/politics.htm>
- A.Simpson: Antonie de Anglterre R.Lafont, Paris 1963, x.57

## ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ БА ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХАРЬААЛЛЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Г. Чулуун, А. Пагма, Б. Ариунжаргал,  
Р. Нургүл, Ө.Мөнхтунгалаг, И.Жаргалзаяабямба,  
Д.Жигваагүнсэл, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа*

Прокурорын байгууллагыг харьяаллаар нь эрх зүйн шинжлэх ухаанд дараах байдлаар ангилж байна. Үүнд:

1. Прокурорын байгууллага нь хууль зүйн яамны бүрэлдэхүүнд багтана. (Бельги, Герман, Дани, Израиль, Голланд, Польш, Румын, АНУ, Франц, Япон, бусад )
2. Прокурорын байгууллага шүүх эрх мэдлийн бүрэлдэхүүнд багтана. (Азербайджан, Болгар, Гүрж, Испани, Итали, Индонез, Колумб, Латви, бусад )
3. Аттorneyн тогтолцоотой. (Attorney), (Их Британи, Энэтхэг, бусад )
4. Прокурорын байгууллага нь бие даасан тогтолцоотой бөгөөд Парламент ба Ерөнхийлөгчийн өмнө ажлаа хариуцдаг. (Египет, БНХАУ, БНАСАУ, ОХУ, ТУХН-ийн орнууд, бусад )

№	Улс	Үндсэн хуулийн шүүх	Прокурорын байгууллага
1.	<b>ОХУ</b>	Холбооны ба Бүгд Найрамдах Улсууд, ОХУ-ын субъектуудын хууль, тогтоомжууд Үндсэн хуультай нийцэж буй эсэхтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэх эрх бүхий бие даасан байгууллага болно.  -Үндсэн хууль, 1993, бүлэг 7, зүйл 125	ОХУ-ын прокурорын байгууллага нь нэгдсэн холбооны төвлөрсөн бие даасан тогтолцоо болно. Тус байгууллага нь ажлаа ОХУ-ын Холбооны Хуралд тайлагнана.  - Үндсэн хууль, 1993, бүлэг 7, зүйл 129. - ОХУ-ын прокурорын байгууллагын тухай хууль, 1992, хэсэг 1, зүйл 1.
2.	<b>Латви</b>	Үндсэн хуулийн шүүх хуулийн хүрээнд хуулиуд Үндсэн хуульд нийцсэн эсэх талаарх хэргийг авч үзэх болон хуулиар олгосон бусад эрх мэдлийг хэрэгжүүлэх бие даасан байгууллага болно.  -Үндсэн хууль, 1922, хэсэг 6, зүйл 85	Прокурорын байгууллага нь шүүх эрх мэдлийн байгууллага бөгөөд эрх мэдлийнхээ хүрээнд хууль сахих үйл ажиллагаанд бие даасан хяналт тавина.  -Прокурорын байгууллагын тухай хууль
3.	<b>Польш</b>	Үндсэн хуулийн Трибунал бусад эрх мэдлээс үл хамаарах бие даасан байгууллага болно.  -Үндсэн хууль, 1997, хэсэг 8, зүйл 173	Прокурорын байгууллага нь Сайд нарын Зөвлөлд харьяалагддаг. Хууль зүйн сайд нь улсын Ерөнхий прокурор байдаг.  -Прокурорын байгууллагын тухай хууль, зүйл 64
4.	<b>Франц</b>	Үндсэн хуулийн зөвлөл нь Ерөнхийлөгчийн сонгуулийг зөв явуулсан эсэх талаар хяналт тавьж, сонгуулийн талаарх гомдол маргааныг хэлэлцэж, дүнг зарлах, ард нийтийн санал асуулгад хяналт тавьж дүнг зарлах, Парламентын хоёр танхимаар хуулийг хэлэлцэн батлагдахаас өмнө Үндсэн хуультай нийцэж байгаа эсэх талаар санал гаргана.  -Үндсэн хууль, зүйл 56, 61	Прокурорын байгууллага нь Хууль зүйн яамны бүрэлдэхүүнд багтана.  -Эрүүгийн хууль, 2-р бүлгээр зохицуулсан.

5.	<b>Япон</b>	<p>Дээд шүүх нь хууль, тогтоол, журам болон бусад албан шийдвэрийг Үндсэн хуульд нийцсэн эсэх талаар эцсийн шийдвэрийг гаргана.</p> <p>-Үндсэн хууль, зүйл 81</p>	<p>Прокурорын байгууллага нь <b>Хууль зүйн яамны харьяа</b> Засгийн газрын агентлаг юм.</p> <p><a href="http://www.moj.go.jp/ENGLISH/index.html">http://www.moj.go.jp/ENGLISH/index.html</a> Public Prosecutors Offices Law (1947 No. 61)</p>
6.	<b>АНУ</b>	<p>Нэгдсэн Улсын Дээд шүүх ба аль ч шатны ердийн шүүх нь шүүх засаглалын хүрээнд Үндсэн хуулийн асуудлыг нийтлэг журмаар хэлэлцэнэ.</p> <p>-Үндсэн хууль, зүйл 3 зүйл, 1. 2-т</p>	<p>Прокурорын байгууллага нь Ерөнхий прокуророор тэргүүлсэн <b>Хууль зүйн яамны харьяа байгууллага</b>. АНУ-ын Ерөнхий прокурорын ажлын аппарат нь бусад орнуудад байдаг Прокурорын байгууллага, Дотоод хэргийн яам, Сөрөг тагнуулын болон Эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, Шоронгуудыг удирдах газар гэсэн бие даасан байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэн хэрэгжүүлдэгээр онцлог ялгаатай</p> <p><a href="http://home.heinonline.org/titles/US-Attorney-General--Department-of-Justice-Collection">http://home.heinonline.org/titles/US-Attorney-General--Department-of-Justice-Collection</a></p>
7.	<b>Болгар</b>	<p>Үндсэн хуулийн шүүх нь хуулийн хүрээнд хуулиуд Үндсэн хуульд нийцсэн эсэх талаарх хэргийг авч үзэх болон хуулиар олгосон бусад эрх мэдлийг хэрэгжүүлэх бие даасан байгууллага болно.</p> <p>-Үндсэн хууль, зүйл 147</p>	<p>Прокурорын байгууллага шүүх эрх мэдлийн бүрэлдэхүүнд багтана.</p> <p>Шүүхийн Дээд зөвлөл түүний байгууллагад шүүх, прокурор, мөрдөн байцаах байгууллага багтана.</p> <p>Шүүхийн Дээд зөвлөл санал оруулснаар Ерөнхийлөгч Ерөнхий прокурорыг 7 жилийн хугацаатай томилоно.</p> <p>-Үндсэн хуулийн 129, 133-р зүйл</p>
8.	<b>Хорват</b>	<p>Үндсэн хуулийг дагаж мөрдөх, хууль, тогтоол, шийдвэр нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар болон Үндсэн хуультай холбоотой маргааныг Үндсэн хуулийн шүүхээр шийдвэрлэнэ.</p> <p>-Үндсэн хууль, зүйл 126-129</p>	<p>Прокурорын байгууллага нь бие даасан, хараат бус шүүх эрх мэдлийн байгууллага юм.</p> <p>-Үндсэн хуулийн 125-р зүйл.</p>
9.	<b>Эстони</b>	<p>Дээд шүүх нь мөн Үндсэн хуулийн хяналтын шүүх юм.</p> <p>-Үндсэн хууль, зүйл 149</p>	<p>Прокурорын байгууллага нь Хууль зүйн яамны харьяа Засгийн газрын агентлаг юм.</p> <p>Улсын Ерөнхий прокурорыг 5 жилийн хугацаатай томилох бөгөөд прокурорын байгууллага нь эрх мэдлийнхээ хүрээнд хууль сахиу үйл ажиллагаанд бие даасан хяналт тавина.</p> <p><a href="http://www.prokuratuur.ee/en/prosecutors-office">http://www.prokuratuur.ee/en/prosecutors-office</a></p>

10	Казахстан		<p>“Прокурорын байгууллага нь төрийн бусад байгууллагаас хараат бусаар ажиллана ... зөвхөн улсын ерөнхийлөгчид тайлагнана” гэжээ. Казахстанд, Ерөнхий прокурорыг Улсын ерөнхийлөгч Сенаттай зөвшилцөн 5 жилийн хугацаатай томилдог.</p> <p>- Үндсэн хууль, зүйл 83.2</p>
11.	Узбекистан	<p>“Узбекистаны шүүхийн систем нь Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, Иргэний хэргийн дээд шүүх, Каракалпакстаны иргэний ба эрүүгийн хэргийн дээд шүүхүүд, Ташкентын мужийн ба “хот, районы [эрүү, иргэний] шүүх” –ээс бүрдэнэ;</p> <p>-Үндсэн хууль, зүйл 107</p>	<p>- Дээд Шүүх эрүүгийн, иргэний, захиргааны хэргийн хүрээнд дээд эрх мэдэлтэй ... цэргийн, районы, район хоорондын, хотын, мужийн, мөн түүнчлэн Каракалпакскийн дээд шүүхийн үйл ажиллагаанд хяналт тавих” эрхтэй;</p> <p>-... улсын нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгмөр хангуулах чиг үүргийг Улсын Ерөнхий прокурор хэрэгжүүлнэ;</p> <p>Үндсэн хууль, зүйл 110,</p>
12.	БНХАУ	<p>БНХАУ нь социалист улс мөн бөгөөд улс даяар социалист эрхзүй, хууль ёсыг дагаж мөрдөнө”, “... тус улсын ямар ч хууль тогтоомж Үндсэн хуульд харшлах ёсгүй”, “төр засгийн, зэвсэгт хүчний, улстөрийн, намын болон олон нийтийн байгууллагууд, үйлдвэр албан газрууд Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлнэ, үүнийг зөрчвөл хариуцлагад татна, ямар ч хувь хүн, байгууллага Үндсэн хууль, бусад хуульд захирагдана” гэжээ.</p> <p>- Үндсэн хууль, зүйл</p>	<p>Ардын дээд прокурорын байгууллага нь БХАТИХ –д болон БХАТИХ –ын Байнгын хороонд ажлаа тайлагнана. Орон нутгийн Ардын прокурорын газрууд нутгийн засаг захиргаанд болон дээд шатны удирдах (прокурорын) байгууллагад ажлаа хариуцна;</p> <p>- Үндсэн хууль, зүйл 133</p>
13.	ИБУИНВУ	<p>Үндсэн хуулийн бие даасан шүүхийн тогтолцоогүй улс. 2005 оны Үндсэн хуулийн шинэчлэлийн тухай хуулийн дагуу Их Британий парламент хараат бус үйл ажиллагаа явуулж Үндсэн хуульд тайлбар хийх эрхтэй. Лордын танхимын дарга /Лорд канцлер/ хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн бүрэн эрхт гишүүн байдаг. Лорд канцлер Британийн дээд шүүх Лордуудын танхимын хуульч лордуудын зөвлөлийн хуралдааныг тэргүүлэн, ерөнхий шүүгчийн статус эдэлнэ. ИБУИНВУ -ын хамгийн дээд шатны шүүхийн үүргийг Лордын танхим гүйцэтгэдэг.</p> <p>-Stephen Hardy, English Legal System, 1999</p>	<p>Их Британийн прокурорын байгууллага нь нэгдсэн холбооны төвлөрсөн бие даасан тогтолцоогүй болно.</p> <p>Прокурорын хяналтын чиг үүргийг Засгийн газрын харьяа Ерөнхий прокурорын алба Attorney General's Office гүйцэтгэнэ.</p> <p>Лордын танхимын дарга /Лорд канцлер/ буюу дээд шүүхийн ерөнхий шүүгч нь ерөнхий прокурор, өмгөөлөгчдийн хорооны дарга, Шотландын ерөнхий прокурорыг томилох эрхтэй.</p> <p>-Attorney General's Office, //www.gov.uk/government/organisations/attorney-generals-office/</p>

14.	<b>БНСВУ</b>	<p>Үндсэн хуулийн бие даасан шүүхийн тогтолцоогүй улс. Үндсэн хуулийн хяналтын эрхийг дээд шүүхэд олгосон байна. Үндсэн хуулийн 91 дүгээр зүйлээр дээд шүүх нь хууль, хуулийн хүчин чадалтай болон бусад зарлиг, сайдын тушаал, захиргааны байгууллагын шийдвэр ҮХ-д нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэнэ. Мөн Төрийн зөвлөл үндсэн хуулийг тайлбарлах эрхтэй.</p> <p>-<i>Үндсэн хууль, 1992, бүлэг 10, зүйл 126-138.</i></p>	<p>Прокурорын байгууллагын бие даасан тогтолцоогүй. Үндсэн хуулиар Ардын хянан шалгах хороо Прокурорын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ. Ерөнхийлөгч Ардын хянан шалгах хорооны Ерөнхий прокурорыг томилох, чөлөөлөх эрхтэй.</p> <p>- <i>Үндсэн хууль, 1992, бүлэг 10, зүйл 137,138.</i></p>
15.	<b>Энэтхэг</b>	<p>УДШ болон дээд шатны бусад бүх шүүх харилцан адилгүй хянан шийдвэрлэх ажиллагаагаар Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг.</p> <p>-<i>Үндсэн хууль 1949, зүйл 363</i></p>	<p>Атторнейн тогтолцоотой.</p> <p>Атторней нь хууль зүйн шинжтэй бүхий л асуудалд Засгийн газрыг төлөөлнө. Дээд эрх мэдэл бүхий хуулийн зөвлөх.</p> <p>-<i>Үндсэн хууль, 1949, бүлэг 5, зүйл 76</i></p>
16.	<b>Ирланд</b>	<p>Дээд шүүх нь төрийн байгууллага, хувийн хэвшлийн, иргэний хэрэг болон Ирланд Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх бүхий л асуудлыг шийдвэрлэдэг бие даасан байгууллага юм.</p> <p>-<i>Үндсэн хууль, 1934, зүйл 34.3</i></p>	<p>Атторнейн тогтолцоотой. Атторней нь хууль, эрх зүйн асуудлаар Засгийн газарт зөвлөх үүрэгтэй. Ажлын албатай.</p> <p>-<i>Үндсэн хууль, 1937, зүйл 30</i></p>
17.	<b>Румын</b>	<p>Үндсэн хуулийн шүүх нь бие даасан хараат бус байна.</p> <p>-<i>Үндсэн хууль, 1989, зүйл 145</i></p>	<p>Прокурорын байгууллага нь Хууль зүйн сайдын эрх мэдлийн хүрээнд хууль ёсны, шударга, шаталсан хяналтын зарчмын дагуу өөрийн үйл ажиллагааг явуулна.</p> <p>-<i>Үндсэн хууль, 1989, зүйл 132</i></p>
18.	<b>Австрали</b>	<p>Дээд шүүх нь Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг.</p> <p>-<i><a href="http://legal_systems.academic.ru/">http://legal_systems.academic.ru/</a></i></p>	<p>Атторнейн тогтолцоотой.</p> <p>-<i><a href="http://www.ag.gov.au/Pages/default.aspx">http://www.ag.gov.au/Pages/default.aspx</a></i></p>
19.	<b>БНСУ</b>	<p>Үндсэн хуулийн бие даасан шүүхтэй.</p> <p>-<i>Үндсэн хууль, 6-р бүлэг 111 зүйл</i></p>	<p>Прокурорын байгууллага нь Хууль зүйн яамны бүрэлдэхүүнд багтана.</p>
20.	<b>Австри</b>	<p>Үндсэн хуулийн шүүх нь бие даасан байна.</p> <p>-<i>Үндсэн хууль 1983, хэсэг В, зүйл 87, 1 хэсэг</i></p>	<p>Австрийн прокурорын байгууллага нь зохион байгуулалтын хувьд Хууль зүйн яамны бүрэлдэхүүнд багтах бөгөөд үйл ажиллагаагаа нь шүүхийн тогтолцооны хүрээнд явна.</p> <p>-<i>Прокурорын тухай хууль, 2 зүйл, 3-р хэсэг</i></p>
21.	<b>Унгар</b>	<p>Үндсэн хуулийн шүүх нь бие даасан байна.</p> <p>-<i>Үндсэн хууль, 1949, бүлэг 4, 32 зүйл/А.1</i></p>	<p>Прокурорын байгууллага нь бие даасан байна. Ерөнхий прокурор нь Парламентад үйл ажиллагааны тайлан гаргаж өгнө.</p> <p>-<i>Үндсэн хууль, 1949, бүлэг 11, зүйл 52.2</i></p>



22.	<b>Чех</b>	Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийг хамгаалах шүүхийн байгууллага юм.  -Үндсэн хууль 1992, 83 зүйл -Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, зүйл 10	Прокурорын газар Хууль зүйн яамны харьяанд байдаг.  - <a href="http://www.cz-invest.ru/novosti/1050.html">http://www.cz-invest.ru/novosti/1050.html</a>
23.	<b>Словак</b>	Үндсэн хуулийн шүүх нь шүүхийн байгууллагаас хараат бусаар бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.  -Үндсэн хууль, 1993, бүлэг 7, зүйл 124 -Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, 1992, бүлэг 1, зүйл 1	Прокурор нь шүүх, төр эрх мэдлийн бүрэлдхүүнд багтана.  -Үндсэн хууль, бүлэг 8, хэсэг 149
24.	<b>Канад</b>	Дээд шүүх нь Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлнэ.  -Дээд шүүхийн тухай хууль, 53.1.а	Прокурорын байгууллага нь Хууль зүйн яамны харьяанд байна.  <a href="http://www.ppsc-sppc.gc.ca/eng/bas/index.html#intro">http://www.ppsc-sppc.gc.ca/eng/bas/index.html#intro</a>
25.	<b>Итали</b>	Үндсэн хуулийн бие даасан шүүхтэй.  -Үндсэн хууль, 4-р бүлэг.	Прокурорын бүтэц нь Дээд шүүхийн харьяанд байдаг.  <a href="http://www.giustizia.it/giustizia/it/mg_2_1_4_2_2.wp">http://www.giustizia.it/giustizia/it/mg_2_1_4_2_2.wp</a>

\* \* \*

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <http://constitution.findlaw.com/>
- <http://japan.kantei.go.jp/>
- <http://www.moj.go.jp/>
- Public Prosecutors Offices Law (1947 No. 61)
- <http://home.heinonline.org>
- <http://www.vks.bg/>
- <http://www.prokuratuur.ee/>
- <http://www.sabor.hr/>
- <https://www.riigiteataja.ee>
- [http://legal\\_systems.academic.ru/](http://legal_systems.academic.ru/)
- <http://www.gov.uk/>
- <http://www.ag.gov.au/>
- <http://www.cz-invest.ru>
- <http://www.ppsc-sppc.gc.ca/>
- <http://www.giustizia.it/>

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

**БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС, БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС,  
БҮГД НАЙРАМДАХ КЫРГЫЗСТАН УЛСЫН ШҮҮГЧИЙН ЭРХ  
ЗҮЙН БАЙДЛЫН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа*

Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Кыргызстан Улсуудын шүүгчийн эрх зүйн байдлыг /Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч болон бусад шүүхийн шүүгчид/ дараах байдлаар авч үзлээ.

- Шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчид тавигдах болзол, шаардлага /мэргэжлээрээ ажилласан жил, нас гэх мэт/;
- Шүүгчийн сонгон шалгаруулалтын талаарх асуудал ;
- Шүүгчийг томилох тухай асуудал;
- Шүүгчээр томилохоос татгалзах тухай зэрэг болно.

## **I. БҮГД НАЙРАМДАХ КЫРГЫЗСТАН УЛС**

Кыргызстан Улсын Шүүхийн тогтолцоо нь Дээд шүүх, орон нутгийн шүүхээс бүрдэх бөгөөд Дээд шүүхийн бүтцэд Үндсэн хуулийн танхим байна. Мөн түүнчлэн хуулиар төрөлжсөн шүүхүүд байгуулж болно. /Үндсэн хуулийн 6-р хэсэг 93-97-р зүйл “Кыргызстан Улсын шүүх эрх мэдэл”/

### ***Шүүгчийн албан тушаалд тавигдах шаардлага:***

1/ Дээд шүүхийн шүүгч нь 40-өөс дээш 70-аас доош насны, хууль зүйн дээд боловсролтой, хууль зүйн мэргэжлээр 10-аас доошгүй жил, үүнээс 5 жил шүүгчээр ажилласан Кыргызстан Улсын иргэн байна.

2/ Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын шүүгч нь 40-өөс дээш 70-аас доош насны, хууль зүйн дээд боловсролтой, хууль зүйн мэргэжлээр 15-аас дээш жил ажилласан, төрийн болон албан ёсны хэл эзэмшсэн Кыргызстан Улсын иргэн байна.

3/ Орон нутгийн шүүхийн шүүгчээр 30-аас дээш 65-аас доош насны, хууль зүйн дээд боловсролтой, хууль зүйн мэргэжлээр 5-аас доошгүй жил ажилласан, Кыргызстан улсын иргэн байж болно.

Шүүгчийн албан тушаалд анх удаа нэрээ дэвшүүлсэн, шүүгчээр ажиллаж байгаагүй этгээд, мөн шүүгчээр ажиллаж байсан боловч бүрэн эрх дуусгавар болсноос хойш сонгон шалгаруулалтад оролцох хүртэл 10 жилийн хугацаа өнгөрсөн этгээдэд дараах нэмэлт шаардлага тавигдана. Үүнд: Нэр дэвшигчдийн хувьд өдөр, эчнээ мэргэшлийн сургалтанд хамрагдаж шалгалт өгч, гэрчилгээ авах бөгөөд энэхүү гэрчилгээ нь шалгалт өгсөнөөс хойш 3 жилийн хугацаанд хүчинтэй байна. Сургалтын хөтөлбөр, шалгалт авах комиссын бүрэлдэхүүн, түүнчлэн шалгалт авах журмыг Шүүгчдийн зөвлөл тогтооно.

Шүүгчийн албан тушаал хашихад шаардлагатай хууль зүйн мэргэжлээр ажилласан хугацаанд дараах ажилласан хугацааг оруулж тооцно:

1. Хууль зүйн дээд боловсролтой Жогорку Кенешийн депутат;
2. Ерөнхийлөгчийн хууль зүйн аппаратын ажилтан, Жогорку Кенеш дэх Ерөнхийлөгчийн эрх бүхий төлөөлөгч;
3. Жогорку Кенешийн аппаратын эрх зүйн журам, хүний эрх, үндсэн хуулийн хууль тогтоомж, төрийн тогтолцоо, шүүх эрх зүйн асуудал хариуцсан байнгын хороо, хууль эрх зүйн хэлтэс, нэгжийн ажилтан;
4. Засгийн газрын аппаратын батлан хамгаалах, хууль хяналтын байгууллагын асуудал хариуцсан хууль зүйн нэгж, зохион байгуулалтын нэгжийн ажилтан;

5. Дээд шүүхийн аппаратын ажилтан;
6. Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын аппаратын ажилтан;
7. Орон нутгийн шүүхийн аппаратын ажилтан;
8. Төрийн эрх бүхий байгууллагын ажилтан;
9. Прокурорын байгууллагын ажилтан;
10. Хууль зүйн системийн ажилтан;
11. Дотоод хэргийн байгууллагын хууль зүйн алба, мөрдөн байцаах нэгжийн ажилтан;
12. Үндэсний аюулгүй байдлын хууль зүйн алба, мөрдөн байцаах нэгжийн ажилтан;
13. Гаалийн байгууллага, санхүүгийн цагдаагийн байгууллагын хууль зүйн алба, мөрдөн байцаах нэгжийн ажилтан;
14. Яам, төрийн хороо, захиргааны газар, тэдгээрийн харьяа байгууллагын хууль зүйн албаны ажилтан;
15. Улсын комисс, сангийн аппаратын хууль зүйн албаны ажилтан;
16. Орон нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагын аппаратын хууль зүйн албаны ажилтан;
17. Омбудсманы аппаратын хууль зүйн дээд боловсролтой ажилтан;
18. Өмчийн хэлбэрээс үл хамаарсан хуулийн этгээдийн хууль зүйн албаны ажилтан;
19. Өмгөөлөгч;
20. Нотариатч;
21. Хууль зүйн дээд сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, багш зэрэг болно.

### ***Шүүгчийн сонгон шалгаруулалтын талаарх асуудал:***

#### ***Дээд шүүх, Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын шүүгчийн хувьд:***

Шүүгчдийг сонгох зөвлөл нь Дээд шүүх, Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын шүүгч тогтоосон нас /насны хязгаар/-нд хүрэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө, эсвэл шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, шүүгчийн албан тушаалаас хугацаанаас өмнө чөлөөлөхөөс 20-оос доошгүй хоногийн өмнө шүүгчийн сул болон чөлөөлөгдөх албан тушаалд сонгон шалгаруулалт зарлана.

Нэр дэвшигч нь сонгон шалгаруулалтад оролцох өргөдлийг зар нийтэлснээс хойш 20 хоногийн хугацаанд Шүүгчдийг сонгох зөвлөлд гаргасан байна.

Өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

1. Паспортын хуулбар;
2. Хууль зүйн дээд боловсролын дипломын баталгаажуулсан хуулбар;
3. Хөдөлмөрийн дэвтэр, хууль зүйн мэргэжлээр ажилласан жилийг тодорхойлох бусад баримт бичгийн баталгаажуулсан хуулбар;
4. Сонгон шалгаруулалтад оролцохоос өмнө нэг жилийн дотор гаргасан эрүүл мэндийн байдлын талаарх эмнэлгийн тодорхойлолт.

Өргөдөлд нэр дэвшигчийн хувийн байдлыг тодорхойлох бусад баримт бичиг /тодорхойлолт, баталгаа/-ийг хавсаргаж болно. Кыргызстан улсын шүүгч Дээд шүүх, Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын шүүгчийн сонгон шалгаруулалтад өргөдөл гаргах замаар оролцож болно.

#### ***Орон нутгийн шүүхийн шүүгчийн хувьд:***

Шүүгчдийг сонгох зөвлөл сонгон шалгаруулалтын үндсэн дээр орон нутгийн шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшигчийг сонгоно.

Шүүгчдийг сонгох зөвлөл нь орон нутгийн шүүхийн шүүгчийн сул болон чөлөөлөгдсөн орон тоонд тогтоосон нас /насны хязгаар/-нд хүрэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө,

эсвэл шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, шүүгчийн албан тушаалаас хугацаанаас өмнө чөлөөлөхөөс 20-оос доошгүй хоногийн өмнө шүүгчийн сул болон чөлөөлөгдөх албан тушаалд сонгон шалгаруулалт зарлана.

Орон нутгийн шүүхийн шүүгч бүрэн эрхийн хугацаа дуусахаас 60-80 хоногийн хугацаанд түүнийг орон нутгийн шүүхийн шүүгчээр томилох өргөдлийг Шүүгчдийг сонгох зөвлөлд гаргах эрхтэй. Энэ тохиолдолд зөвлөл өргөдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор өргөдөл “Кыргызстан улсын шүүгчийн статусын тухай” хуулийн 17-д заасан дүрэмд нийцэж байгаа эсэхийг хянана. Хэрвээ зөвлөлөөс нэр дэвшигчийг шүүгчээр томилуулахаар санал болгоогүй бол 5 хоногийн дотор сонгон шалгаруулалт зарлана. Нэр нь дэвшээгүй шүүгч үүнээс хойш 1 жил өнгөрсөн бол шүүгчийн өөр сул орон тоонд нэрээ дэвшүүлэх эрхтэй.

Шүүгчээр ажиллаж байгаа этгээд өргөдөл гаргах замаар сонгон шалгаруулалтанд оролцож болох бөгөөд өргөдөлд шүүгчийн хувийн хэрэг, хянан шийдвэрлэсэн хэргийн тоо, чанарыг илэрхийлсэн мэдээлэл, шагнал, урамшуулал, шийтгэлийн мэдээлэл, тодорхойлолт зэрэг баримт бичгийг хавсаргана.

Баримт бичиг нь шаардлага хангасан этгээд нэр дэвшигчийн жагсаалтад бүртгэгдэнэ. Нэр дэвшигчийн жагсаалт сонгон шалгаруулалт зарлагдсанаас хойш 40-өөс дээшгүй хоногийн дотор олон нийтэд мэргэжлийн болон ёс зүйн чанарын талаар шүүмж авах зорилгоор өдөр тутамын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр мэдээлнэ.

Сонгон шалгаруулалтад дараах этгээд оролцоно:

1. Шүүгч;
2. Шүүгчээр ажиллаж байсан боловч бүрэн эрх дуусгавар болсон, эсвэл албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш сонгон шалгаруулалтад оролцох хүртэл 10 жилийн хугацаа өнгөрөөгүй этгээд;
3. Мэргэшлийн шалгалт өгч, гэрчилгээ авсан этгээд байна.
  - *Сонгон шалгаруулалтын эхний үе шат*: нэр дэвшигч, түүний эхнэр, нөхөр, гэр бүлийн гишүүдийн орлогын мэдүүлэг, нэр дэвшигчийн хувийн байдлын талаарх мэдээллийг хянаж үзнэ. Орлогын мэдүүлгийг заавал гаргуулна. Зөвлөл Эхний үе шатын үр дүнгээр 2 дах үе шатанд оруулах эсэх шийдвэрийг нээлттэй санал хураалтаар олонхийн саналаар гаргана.
  - *2 дахь үе шат*: өгөгдсөн эрх зүйн сэдвээр зохион бичлэг бичих, амаар тайлбарлах, үндсэн хуулийн эрх зүй, шүүн таслах ажиллагаа, эрүү, иргэнийн эрх зүй, хянан шийдвэрлэх ажиллагааны асуултад хариулах. Шалгалтын сэдэв, асуултуудыг тухайн шүүгчийг сонгох зөвлөлөөс нийтэлнэ. Оноогоор дүгнэнэ. Босго оноо авсан этгээд 3 дахь үе шатанд оролцоно. Босго оноог зөвлөлөөс жил бүр тогтоох бөгөөд босго онооноос давсан нэр дэвшигч саналын хуудаст бичигдэнэ.
  - *Хэрвээ энэ үе шатанд 1 нэр дэвшигч байвал 3 дахь үе шатыг* явуулахгүйгээр шүүгчээр томилуулахаар санал болгоно.

### ***Шүүгчийг томилох тухай асуудал:***

#### **Дээд шүүх. Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын шүүгчийн хувьд:**

- Дээд шүүхийн шүүгчийг тогтоосон насанд хүртэл хугацаагаар сонгоно.
- Дээд шүүхийн шүүгчид өөрийн бүрэлдэхүүнээс Дээд шүүхийн дарга, түүний орлогч нарыг 3 жилийн хугацаагаар сонгоно. /Кыргызстан Улсын Үндсэн хуулийн 6-р хэсэг 93-97-р зүйл “Кыргызстан Улсын шүүх эрх мэдэл”<sup>46</sup>/

<sup>46</sup>[http://www.gov.kg/?page\\_id=263](http://www.gov.kg/?page_id=263)

Шүүгчдийг сонгох зөвлөл өргөдөл хүлээн авч дууссанаас хойш 10 хоногийн дотор сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн Дээд шүүх, Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын шүүгчид сонгох нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгоно. Ерөнхийлөгч ирүүлсэн материалыг буцаах эрхтэй. Шүүгчдийг сонгох зөвлөл нэр дэвшигчийг Дээд шүүх, Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын шүүгчийн албан тушаалд томилоход саад болж байгаа нөхцөл байдал тогтоогдоогүй тохиолдолд Ерөнхийлөгчид дахин санал болгох ба Ерөнхийлөгч ажлын 10 өдрийн дотор Жогорку Кенеш /Хууль тогтоох дээд байгууллага/-д Дээд шүүх, Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын шүүгчийн албан тушаалд сонгуулахаар өргөн мэдүүлнэ. Шүүгчдийг сонгох зөвлөлийн 2/3-аас доошгүй саналаар дээрх шийдвэрийг гаргана. Шүүгчдийг сонгох зөвлөл Ерөнхийлөгчийн гаргасан үндэслэлтэй санал нэгдвэл сонгон шалгаруулалтыг дахин зарлана.

- Жогорку Кенеш шүүгчийг сонгох талаар Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэнээс хойш 2 долоо хоногийн дотор шийдвэр гаргана.
- Жогорку Кенеш өргөн мэдүүлсэн нэр дэвшигчийг сонгоогүй тохиолдолд Ерөнхийлөгч Шүүгчдийг сонгох зөвлөлөөс шинээр зарласан сонгон шалгаруулалтаар санал болгосон өөр нэр дэвшигчийг өргөн мэдүүлнэ.

**Орон нутгийн шүүхийн шүүгчийн хувьд:**

Орон нутгийн шүүхийн шүүгчдийг Шүүгчдийг сонгох зөвлөлөөс санал болгосны дагуу Ерөнхийлөгчөөс эхний удаа 5 жилийн хугацаагаар, цаашид тогтоосон насанд хүртэл хугацаагаар томилно.

Орон нутгийн шүүхийн шүүгчдийн хурал өөрийн бүрэлдэхүүнээс шүүхийн дарга, даргын орлогчийг 3 жилийн хугацаагаар сонгоно. /Үндсэн хуулийн 6-р хэсэг 93-97-р зүйл “Кыргызстан улсын шүүх эрх мэдэл”<sup>47</sup>/

Орон нутгийн шүүхийн шүүгчдийг Шүүгчдийг сонгох зөвлөлөөс санал болгосны дагуу Ерөнхийлөгчөөс эхний удаа 5 жилийн хугацаагаар, цаашид тогтоосон насанд хүртэл хугацаагаар томилно. Орон нутгийн шүүхийн шүүгчдийн хурал өөрийн бүрэлдэхүүнээс шүүхийн дарга, даргын орлогчийг 3 жилийн хугацаагаар сонгоно.

Орон нутгийн шүүхийн шүүгчийг зөвлөлөөс санал болгосноор Ерөнхийлөгч томилно. Ерөнхийлөгч материалыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор үндэслэл зааж буцааж болно. Энэ тохиолдолд зөвлөл шинээр сонгон шалгаруулалт явуулж өөр нэр дэвшигчийг санал болгоно.

***Шүүгчээр томилохоос татгалзах, чөлөөлөх үндэслэл:***

Дараах этгээд Дээд шүүх, Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын шүүгч болон орон нутгийн шүүхийн шүүгчээр ажиллаж болохгүй;

1. Ял шийтгүүлсэн;
2. Өмнө нь шүүгчээр ажиллаж байгаад зохисгүй үйлдлийн улмаас ажлаасаа чөлөөлөгдсөн;
3. Хууль хяналтын байгууллагаас халагдсан, өмгөөлөгчийн тусгай зөвшөөрөл нь Өмгөөллийн үйл ажиллагааны тухай хуулийн 10-р зүйлд заасан үндэслэлээр хүчингүй болсон;
4. Гадаад улсын иргэний харьяалалтай.

<sup>47</sup>[http://www.gov.kg/?page\\_id=263](http://www.gov.kg/?page_id=263)

## II. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

### *Шүүгчийн албан тушаалд тавигдах ерөнхий шаардлага:*

БНСУ-ын Үндсэн хуулийн 101-3 дугаар заалтад шүүгчийн албан тушаалд тавигдах шаардлагыг хуулиар тогтооно гэж заасан байна.

Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль (Court Organization Act)-ийн 42 дугаар зүйлд шүүгчийн албан тушаалд Шүүгчийн улсын шалгалт (National Judicial Examination)-ад тэнцэж, Шүүхийн судалгаа, сургалтын хүрээлэнд 2 жилийн сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн (Judicial Research and Training Institute (JRTI)), эсхүл хуульчийн сонгон шалгаруулалт буюу bar exam-д тэнцсэн этгээд нэр дэвшиж болно гэж заасан байна.

2007 оноос хууль, эрх зүйн сургалтын тогтолцоог шинэчилж эхэлсэн бөгөөд өмнө нь шүүгчийн албан тушаалд нэр дэвших этгээд нь хууль зүйн дээд боловсролтой байхыг шаарддаггүй, хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн бол нэр дэвшиж болдог байсныг АНУ-ын сургалтын тогтолцоотой төстэй тогтолцоо нэвтрүүлж, шүүгч, прокурор зэрэг албан тушаалд заавал ч үгүй хуулийн сургууль төгссөн байх шаардлага тавьдаг болсон байна.

Ингэснээр 2018 оноос эхлэн шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчдээс шүүгчийн улсын шалгалт авахаа больж, шүүгчийн албан тушаалд зөвхөн итгэмжлэгдсэн хуулийн сургуулийг дүүргэж, хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, мэргэжлийн дадлага туршлага бүхий этгээд дундаас сонгох болсон байна.

2011 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Шүүхийн зохион байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд 2022 он хүртэл шүүгчийн албан тушаалд тавигдах шаардлагыг шат дараатайгаар өөрчлөхөөр заасан байна. Үүнд:

- 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл: Шүүгчийн албан тушаалд Шүүгчийн улсын шалгалтад тэнцэж, Шүүхийн судалгаа, сургалтын хүрээлэнд 2 жилийн сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн, эсхүл хуулийн сургуулийг дүүргэж, Хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн этгээдийг нэр дэвшүүлэхээр заасан байна. Бүх нэр дэвшигчид нь гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан байх.
- 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл: Шүүгчийн албан тушаалд хуулийн сургуулийг дүүргэсэн, таваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан байх.
- 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл: Шүүгчийн албан тушаалд хуулийн сургуулийг дүүргэсэн, долоогоос доошгүй жил мэргэжлээрээ ажилласан байх.
- 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс: Шүүгчийн албан тушаалд хуулийн сургуулийг дүүргэсэн, арваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан этгээд нэр дэвших эрхтэй байна.

Нэмэлт, өөрчлөлтөөр шүүгчийн сонгон шалгаруулалтад тавигдах шаардлагад өөрчлөлт оруулахаас гадна Дээд шүүхийн шүүгчдэд тавигдах шаардлагыг өндөрсгөж өмнө нь 40 наснаас дээш, мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг 45 наснаас дээш, мэргэжлээрээ 20-иос доошгүй жил ажилласан байхаар болгож өөрчилсөн байна. Мэргэжлийн дадлага туршлагыг тооцохдоо мэргэжлийн салбарыг нарийвчлан тогтоож, дараах салбарт 20-иос доошгүй жил ажилласан байхаар заасан байна.

Үүнд: 1) шүүгч, прокурор, эсхүл өмгөөлөгч; 2) Засгийн газрын агентлаг, орон нутгийн захиргаа, улсын эсхүл хувийн компани, төрийн өмчит компани, эсхүл бусад хуулийн этгээдэд хуулийн асуудал эрхэлсэн хуульчийн гэрчилгээ бүхий этгээд; 3) итгэмжлэгдсэн

коллеж эсхүл их сургуульд хууль зүйн туслах профессороос дээш албан тушаалд ажиллаж буй хуульчийн гэрчилгээ бүхий этгээд.<sup>48</sup>

Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон бусад шүүгчдийн хувьд ихэнхдээ тухайн албан тушаалд томилогдохоосоо өмнө шүүгчээр ажиллаж байсан байна.

### ***Шүүгчийг томилох процесс:***

Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон дээд шүүхийн шүүгчдийг Ерөнхийлөгч Үндэсний Ассамблейтай зөвшилцсөний үндсэн дээр томилно. Дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь Дээд шүүхийн шүүгчдэд нэр дэвшүүлэх саналаа Ерөнхийлөгчид урьдчилан өргөн мэдүүлнэ.

Шүүгчдийг Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Дээд шүүхийн шүүгчдийн зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр томилно. Дээд шүүхийн Ерөнхий шүүгчид хүний нөөцтэй холбоотой асуудлаар дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Хүний нөөцийн асуудал хариуцсан хороо (Personnel Committee) ажилладаг байна.<sup>49</sup>

Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг 6 жилийн хугацаатайгаар нэг удаа томилдог бол Дээд шүүхийн шүүгчийг 6 жилийн хугацаатайгаар томилдог бөгөөд улиран ажиллуулж болдог байна. Шүүгчдийг тухайн албан тушаалд нь 10 жилийн хугацаатайгаар томилох бөгөөд улиран ажиллуулж болдог.

Шүүгчид нь томилолтын хугацаа нь дуусаагүй хэдий ч тэтгэврийн нас хүрсэн тохиолдолд тэтгэвэрт гарах үүрэг хүлээнэ. Дээд шүүхийн шүүгчдийн тэтгэврийн нас нь 70, доод шатны шүүгчийн тэтгэврийн нас 65 байна.<sup>50</sup>

### ***Шүүгчийг чөлөөлөх тухай асуудал:***

Шүүгчийг эрүүгийн хариуцлагад татсан, хорих, эсхүл түүнээс хүнд ял оноосноос бусад тохиолдолд үүрэгт ажлаас нь албадан чөлөөлөхийг хориглоно.<sup>51</sup> Түүнчлэн шүүгчид сахилгын шийтгэл ногдуулахаас бусад тохиолдолд ажлаас нь түр чөлөөлөх, цалин хөлсийг бууруулахыг хориглоно.

Шүүгч нь эрүүл мэнд, сэтгэцийн эмгэг зэрэг шалтгаанаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Дээд шүүхийн шүүгчийг Ерөнхий шүүгчийн санал болгосноор Ерөнхийлөгч чөлөөлөх бөгөөд Дээд шүүхийн шүүгчээс бусад шүүгчийг Дээд шүүхийн Ерөнхий шүүгч чөлөөлнө.<sup>51</sup>

### ***Шүүгчийг томилохоос татгалзах үндэслэл:***

Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу дараах этгээдийг шүүхийн албан тушаалд томилохоос татгалзахаар заасан байна:

1. Бусад хууль болон холбогдох дүрэм, журмын дагуу төрийн албанаас халагдсан этгээд;
2. Хорих буюу түүнээс дээш ял эдэлсэн этгээд;
3. Ажлын хариуцлага алдсаны төлөө хариуцлага хүлээлгэж ажлаас нь чөлөөлснөөс хойш 5 жил хугацаа өнгөрөөгүй;

<sup>48</sup>Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 42 дугаар зүйл

<sup>49</sup>Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 41.2 дугаар зүйл

<sup>50</sup>Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 45 дугаар зүйл

<sup>51</sup>Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 46.1 дүгээр зүйл

<sup>52</sup>Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 47 дугаар зүйл



***Үндсэн хуулийн шүүхийн шүүгч:***

Үндсэн хуулийн шүүхийн даргыг Ерөнхийлөгч Үндсэн хуулийн шүүхийн шүүгч дундаас Үндэсний Ассамблейтай зөвшилцсөний үндсэн дээр томилно. Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд заасны дагуу БНСУ-ын Үндсэн хуулийн шүүх нь 9 шүүгчээс бүрдэх бөгөөд Үндэсний ассамблей, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч тус бүр 3 шүүгчийг нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч томилно.<sup>53</sup> Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг 6 жилийн хугацаатайгаар томилдог бөгөөд улиран ажиллуулж болдог.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь ажлаа гүйцэтгэхдээ Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчсөн тохиолдолд Үндэсний ассамблейн тухай, болон Үндсэн хуульд заасан үндэслэлийн дагуу Үндэсний ассамблейн тогтоолоор эрүүгийн хариуцлагад татаж болно.<sup>54</sup>

Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид сахилгын шийтгэл ногдуулахаас бусад тохиолдолд ажлаас нь түр чөлөөлөх, цалин хөлсийг бууруулахыг хориглоно.<sup>55</sup> Үндсэн хуулийн шүүхийн даргын тэтгэврийн нас нь 70, үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн тэтгэврийн нас 65 байна.<sup>56</sup>

***Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тавигдах шаардлага:***

Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр 40 нас хүрсэн, дараах салбарт 15-с доошгүй жил ажилласан этгээдийг томилж болохоор заасан байна. Үүнд: 1) шүүгч, прокурор, эсхүл өмгөөлөгч; 2) Засгийн газрын агентлаг, орон нутгийн захиргаа, улсын эсхүл хувийн компани, төрийн өмчит компани, эсхүл бусад хуулийн этгээдэд хуулийн асуудал эрхэлсэн хуульчийн гэрчилгээ бүхий этгээд; 3) итгэмжлэгдсэн коллеж эсхүл их сургуульд хууль зүйн туслах профессороос дээш албан тушаалд ажиллаж буй хуульчийн гэрчилгээ бүхий этгээд.<sup>57</sup>

**III. БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС*****Шүүгчийн албан тушаалд тавигдах шаардлага:***

Шүүгчийн болон прокурорын тухай 2802 дугаартай хуулийн 8 дугаар зүйлд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг дараах байдлаар заасан байна.

- Шүүгч болон прокуророор нэр дэвшигч нь Турк улсын иргэн байна;
- Шалгалтын жилийн нэгдүгээр сарын сүүлийн өдөр бакалавр болон магистрын боловсрол эзэмшигч нь 35 нас, докторын зэрэг хамгаалсан бол 40 нас хүрээгүй байх;
- Анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч: Тухайн улсын хууль зүйн сургуулийг төгссөн, эсхүл гадаадын аль нэг улсын хууль зүйн сургуулийг төгссөн ч Туркийн хууль зүйн сургуулийн хөтөлбөрийн дагуу дутуу үлдсэн хичээлийн шалгалтыг өгсөн гэрчилгээтэй байх;
- Захиргааны хэргийн шүүгчид нэр дэвшигч: Хууль зүйн сургууль дүүргэсэн эсхүл гадаадын хууль зүйн сургуулийг дүүргэж, Турк Улсын хууль зүйн сургалтын хөтөлбөрийн дагуу дутуу үлдсэн хичээлийн шалгалтыг амжилттай өгсөн гэрчилгээ авсан байна. Хууль зүйн сургуулийг төгсөөгүй нэр дэвшигчийн хувьд нийт шаардлагатай орон тооны 20 хувиас хэтрэхгүй байх ёстой бөгөөд эдгээр нэр дэвшигчийн хувьд хууль зүйн мэдлэгийг сургалтын хөтөлбөртөө хангалттай тусгасан улс төр, захиргааны шинжлэх ухаан, эдийн засаг, санхүүгийн салбарын

<sup>53</sup>Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйл

<sup>54</sup>Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 48 дугаар зүйл

<sup>55</sup>Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйл

<sup>56</sup>Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 7 дугаар зүйл

<sup>57</sup>Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйл



- 4-өөс доошгүй жилийн дээд боловсрол эзэмшсэн, эсхүл тэдгээртэй нийцэх, хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын их, дээд сургуулийг төгссөн байх;
- Нийтийн эрх нь хязгаарлагдаагүй байх;
  - Цэргийн алба хаасан байх;
  - Нэр дэвшигчийн хувьд шүүгч болон прокурорын албан үүргээ хаана ч /улсын аль ч газар/ биелүүлэхэд сэтгэцийн болон биеийн эрүүл мэндийн хувьд эрүүл байх, бусдад төвөгтэй байдлаар өөрийн санал бодлоо илэрхийлэхгүй байх;
  - Төрийн эсрэг гэмт хэрэг, хээл хахууль, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, залилан, хууран мэхлэх, бусдын итгэлийг буруугаар ашиглах, санаатайгаар дампуурах зэрэг, эсхүл нэр хүндэд халдсан, улсын тендер болон худалдан авах ажиллагааг будилаантуулах, төрийн нууц задруулах зэрэг гэмт хэрэгт холбогдоогүй, эдгээр гэмт хэргийн улмаас ял шийтгүүлгүй байх, эсхүл санаатайгаас бусад гэмт хэргийн хувьд 3 сараас илүү хорих, баривчлагдах зэрэг эрх чөлөөгөө хасуулсан эсхүл өршөөлд хамрагдсан, мөрдөн шалгагдаагүй байх;
  - Бичгийн шалгалт болон ярилцлагад тэнцсэн байх;
  - Шүүгч болон прокурорын мэргэжилд харшлах зан суртахууны доголдолгүй байх;
  - Өмгөөлөгч шүүгчид нэр дэвших бол мэргэжлээрээ 5 жил ажилласан байх, шалгалт болох жилийн нэгдүгээр сарын сүүлийн өдөр 45 нас хүрээгүй байх, шалгалт болон ярилцлагад тэнцсэн байх

### ***Шүүгчийн сонгон шалгаруулалтын талаарх асуудал:***

#### **Бичгийн шалгалт болон ярилцлага хийх хэлбэр**

Шүүгч болон прокурорын тухай 2802 дугаартай хуулийн 9/А дугаар зүйлд хуульчилсан. Бичгийн шалгалтыг Хууль зүйн яамнаас гаргасан протоколын дагуу Оюутан сонгох болон Байршуулах төв /Ogrenci secme ve yerlestirme merkezi/ -өөс авна.

Сул болон нөөцөд байгаа орон тоо, зэрэглэл, албан тушаал, ангилал, томилогдох албан тушаалын болзол, шалгуур болон бүртгэл, шалгалттай холбогдох зүйлсийг агуулсан зарлалыг бүртгэлийн хугацаа дуусахаас 15-аас доошгүй өдрийн өмнө Туркийн хамгийн ихээр хэвлэгддэг 5 сонинд болон нэг удаа Хууль зүйн яамны цахим хуудаст нийтэлнэ.

***Бичгийн шалгалтын хувьд:*** Турк хэл, математик, Туркийн соёл, иргэншил, Ататуркийн зарчим, хувьсгалын түүх болон иргэдийн мэдвэл зохих үндсэн мэдлэгийн асуултууд агуулсан ерөнхий мэдлэгийн болон бусад чиглэлийн сэдвийг агуулсан асуултуудаар авна.

- Анхан шатны шүүхийн шүүгчдээс: Үндсэн хууль, иргэний хууль, үүргийн эрх зүй, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль, худалдааны хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, эрүүгийн хууль, эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хууль, захиргааны хуулийг агуулсан мэдлэгийн асуултуудаар шалгалт авна.
- Захиргааны шүүхийн шүүгчдээс: Үндсэн хууль, захиргааны хууль, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хууль, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль, үүргийн эрх зүй /ерөнхий анги/, иргэний хууль, эрүүгийн хууль /ерөнхий анги/, татварын хууль, татварын процессын хууль, санхүү-эдийн засгийн сэдвийг агуулсан мэдлэгийн асуултуудаар авна.

Бичгийн шалгалтад ерөнхий мэдлэгийн асуулт 20, салбарын мэдлэгийн асуултууд 80 оноо байх хэлбэрээр үнэлнэ. Энэхүү үнэлгээг үнэлэхдээ ерөнхий мэдлэг болон салбарын мэдлэгийн сэдвийн өөр хооронд тэнцүү хэлбэрээр дүгнэнэ.

Бичгийн шалгалтын 100 онооноос 70-аас дээш оноо авсан, сул байгаа орон тооноос 3 дахин их нэр дэвшигчдийг дараагийн ярилцлагад оруулна.

*Ярилцлагын хороо:* Энэхүү хороо нь Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга эсхүл түүний орлогч, Шүүхийн хяналтын хорооны дарга, Эрүү, иргэний тэнхим, хүний нөөцийн дарга болон Туркийн хууль зүйн академийн удирдах зөвлөлөөс аливаа шалгалт бүрд өөрийн гишүүдээс томилсон 2 гишүүн нийт 7 гишүүнээс бүрдэнэ.

Туркийн Хууль зүйн академийн удирдах зөвлөлд Дээд шүүх болон Захиргааны дээд шүүхийн гишүүдээс тус бүр нэг гишүүн байх тохиолдолд тэдгээр нь Ярилцлагын хорооны үндсэн гишүүнээр томилогдоно.

Ярилцлагын хороо нь шүүгчээр нэр дэвшигчидээс дараах мэдлэг, ур чадварын шалгалтыг авна. Үүнд:

- Шүүгчийн мэргэжлийн ур чадвар;
- Тодорхой нэг сэдвийн хүрээнд ойлгон товчлох, түүнийгээ бусдад илэрхийлэх чадвар;
- Харьцааны соёл, зан суртахууны хэм хэмжээ зэрэг тухайн хувь хүний харьцааны соёл, чадвар;
- Орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн асуудлаар өөрийн үзэл бодол зэрэгт оноо өгөх хэлбэрээр үнэлнэ.

Ярилцлагын 5 асуулт нэг бүрийг 20 оноогоор үнэлэх бөгөөд ярилцлагын хорооны гишүүд тус бүрийн өгсөн 100 онооноос арифметик дундаж нь 70-аас дээш тохиолдолд тэнцсэнд тооцно.

*Нэр дэвшигчээр зарлах хугацаа болон сургалт:* Нэр дэвшигчээр зарлах хугацааг 2003 оны 4954 дугаар Туркийн Хууль зүйн академийн тухай хуульд зааснаар тогтооно. Хэрэв өмгөөлөгч нараас нэр дэвшсэн тохиолдолд 6 сарын хугацаатай мэргэжлийн өмнөх сургалтад хамрагдсан байна.

Шүүгчид нэр дэвшигчийн хугацаа нь 1 жил байх бөгөөд уг хугацааг хуульд заасан тохиолдолд сунгаж болно. Мэргэжлийн өмнөх сургалтыг тусгайлсан журмаар зохицуулах бөгөөд энэхүү сургалтыг амжилттай дүүргэсэн нэр дэвшигч нь дараагийн шатны шалгалт өгч тэнцсэн тохиолдолд шүүгчээр томилно.

Мэргэжлийн өмнөх сургалтын дараах бичгийн шалгалтанд тэнцсэн болон шүүгчээр ажиллахад хуульд заасан шаардлагыг хангасан, эрэгтэй нэр дэвшигчдийн хувьд цэргийн үүргээ биелүүлснийг нотолсон нэр дэвшигчдийг мэргэжлээрээ ажиллахыг Шүүгч болон Прокурорын дээд хороо хүлээн зөвшөөрч шийдвэрлэнэ.

1981 оны 2461 дугаар Шүүгчдийн болон Прокурорын Дээд Хорооны тухай хуулиар Шүүгчдийн болон Прокурорын дээд хорооны үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд хуулийн 4 дүгээр зүйлд Хороо нь Дээд шүүх болон Захиргааны дээд шүүхийн гишүүнийг сонгох, шүүх, шүүгч, прокурорын орон тоог хасах, шүүхийн шүүн таслах тойргийг өөрчлөх асуудлаарх Хууль зүйн яамны саналыг шийдвэрлэх, шүүгч болон прокурорын мэргэжлээр нь хүлээн зөвшөөрөх, зэрэг дэв дээшлүүлэх, нэгдүгээр зэрэг олгох, түр бүрэн эрх олгох, томилох, сэлгэн ажиллуулах, орон тоо хуваарилах, мэргэжлээрээ ажиллахад тохиромжгүй бол зохих шийдвэр гаргах, сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас нь чөлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна.

Шүүгчдийн болон Прокурорын дээд хороо ердийн болон захиргааны шүүхийн шүүгч болон прокурорыг мэргэжлээр нь хүлээн зөвшөөрч, томилох, сэлгэн ажиллуулах, түр бүрэн эрх олгох, зэрэг дэв дээшлүүлэх, нэгдүгээр зэрэг олгох, орон тоо хуваарилах, мэргэжлээрээ ажиллахад тохиромжгүй бол шийдвэр гаргах, сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас нь чөлөөлөх шийдвэр гаргана.

***Шүүгчээр томилохоос татгалзах тухай:***

Дараах нэр дэвшигчийг Турк улсын шүүхийн шүүгч болон прокуророор ажиллахыг хориглоно.

- Нэр дэвшигчийг томилох хуульд заасан тавигдах шаардлагын аль нэгийг биелүүлээгүй нь хожим нь мэдэгдсэн бол чөлөөлөх;
- Нэр дэвшигч нь шалгалтын явцад тавигдах шаардлагын аль нэгийг хангахгүй болсон нь мэдэгдсэн бол;
- Шүүгч, прокурор өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ Хууль зүйн яаманд гаргах бөгөөд 6 сарын дотор шийдвэрлэнэ. Нэр дэвших хугацаандаа тухайн хувь хүний зан суртахуун нь шүүгчээр ажиллах шаардлага хангахгүй, цаашид албан үүргээ үргэлжлүүлэх боломжгүй, хууль зүйн мэдлэг болон ажлын ур чадварын хувьд хангалттай бус гэж үзсэн нь тогтоогдсон тохиолдолд Хууль зүйн яамнаас нэр дэвшигчийг томилохоос татгалзана.

ХАВСРАЛТ

№	Асуудал		Үндсэн хуулийн шүүх	Дээд шүүх	Бусад шүүх
1	мэргэжлээр ажилласан жил	БНСУ	15-с доошгүй жил ажилласан байх	20-с доошгүй жил ажилласан байх	2018.01.01-с эхлэн 5-с доошгүй жил ажилласан байх
		Кыргыз	15-с доошгүй жил ажилласан байх	10-с доошгүй жил ажилласан байх	5-с доошгүй жил ажилласан байх
		Турк	Хуульч бол 20-оос дээш жил ажилласан байх, шүүгч прокурор бол багадаа 20 жилийн ажлын туршлагатай байх		
	Шүүгчийн албан тушаалд тавигдах болзол шаардлага	БНСУ	40 наснаас дээш	45 наснаас дээш	-
		Кыргыз	40 наснаас дээш	40 наснаас дээш	30 наснаас дээш
		Турк	Магистрын боловсрол эзэмшигч нь 35 нас, докторын зэрэг хамгаалсан бол 40 нас хүрээгүй байх;		
	бусад		Дараах албан тушаалд тогтоосон хугацаанаас доошгүй жил ажилласан байх: 1. шүүгч, прокурор, өмгөөлөгч 2. засгийн газрын агентлаг, орон нутгийн захиргаа, улсын эсхүл хувийн компани, төрийн өмчит компани, эсхүл бусад хуулийн этгээдэд хуулийн асуудал эрхэлсэн хуульчийн гэрчилгээ бүхий этгээд 3. итгэмжлэгдсэн коллеж эсхүл их сургуульд хууль зүйн туслах профессороос дээш албанд тушаалтай, хуульчийн гэрчилгээ бүхий этгээд		Шүүхийн судалгаа, сургалтын хүрээлэнд 2 жилийн сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн, эсхүл баг ехат-д тэнцсэн байх. 2018 оноос оноос эхлэн хуулийн сургуулийг дүүргэж, баг ехат-д тэнцсэн, ажилласан жил зэрэг шаардлага тавих болсон
		БНСУ			

		<p>Шүүгчийн албан тушаалд анх удаа нэрээ дэвшүүлсэн, шүүгчээр ажиллаж байгаагүй этгээд, мөн шүүгчээр ажиллаж байсан боловч бүрэн эрх дуусгавар болсноос хойш сонгон шалгаруулалтад оролцох хүртэл 10 жилийн хугацаа өнгөрсөн этгээдэд дараах нэмэлт шаардлага тавигдана. Үүнд: Нэр дэвшигчдийн хувьд өдөр, эчнээ мэргэшлийн сургалтанд хамрагдаж шалгалт өгч, гэрчилгээ авах бөгөөд энэхүү гэрчилгээ нь шалгалт өгсөнөөс хойш 3 жилийн хугацаанд хүчинтэй байна. Сургалтын хөтөлбөр, шалгалт авах комиссын бүрэлдэхүүн, түүнчлэн шалгалт авах журмыг Шүүгчдийн зөвлөл тогтооно.</p>
Кыргыз		<p>4. Анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч: Тухайн улсын хууль зүйн сургуулийг төгссөн, эсхүл гадаадын аль нэг улсын хууль зүйн сургуулийг төгссөн ч Түркийн хууль зүйн сургуулийн хөтөлбөрийн дагуу дутуу үлдсэн хичээлийн шалгалтыг өгсөн гэрчилгээтэй байх;</p> <p>5. Захиргааны хэргийн шүүгчид нэр дэвшигч: Хууль зүйн сургууль дүүргэсэн эсхүл гадаадын хууль зүйн сургуулийг дүүргэж, Турк Улсын хууль зүйн сургалтын хөтөлбөрийн дагуу дутуу үлдсэн хичээлийн шалгалтыг амжилттай өгсөн гэрчилгээ авсан байна. Хууль зүйн сургуулийг төгсөөгүй нэр дэвшигчийн хувьд нийт шаардлагатай орон тооны 20 хувиас хэтрэхгүй байх ёстой бөгөөд эдгээр нэр дэвшигчийн хувьд хууль зүйн мэдлэгийг сургалтын хөтөлбөртөө хангалттай тусгасан улс төр, захиргааны шинжлэх ухаан, эдийн засаг, санхүүгийн салбарын 4-өөс доошгүй жилийн дээд боловсрол эзэмшсэн, эсхүл тэдгээртэй нийцэх, хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын их, дээд сургуулийг төгссөн байх;</p> <p>6. Нийтийн эрх нь хязгаарлагдаагүй байх;</p> <p>7. Цэргийн алба хаасан байх;</p> <p>8. Төрийн эсрэг гэмт хэрэг, хээл хахууль, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, залилан, хууран мэхлэх, бусдын итгэлийг буруугаар ашиглах, санаатайгаар дампуурах зэрэг, эсхүл нэр хүндэд халдсан, улсын тендер болон худалдан авах ажиллагааг будилаантуулах, төрийн нууц задруулах зэрэг гэмт хэрэгт холбогдоогүй, эдгээр гэмт хэргийн улмаас ял шийтгүүлээгүй байх, эсхүл санаатайгаас бусад гэмт хэргийн хувьд 3 сараас илүү хорих, баривчлагдах зэрэг эрх чөлөөгөө хасуулсан эсхүл өршөөлд хамрагдсан, мөрдөн шалгадаагүй байх;</p> <p>9. Бичгийн шалгалт болон ярилцлагад тэнцсэн байх;</p> <p>10. Шүүгч болон прокурорын мэргэжилд харшлах зан суртахууны доголдолгүй байх;</p> <p>Өмгөөлөгч шүүгчид нэр дэвших бол мэргэжлээрээ 5 жил ажилласан байх, 45 нас хүрээгүй байх, шалгалт болон ярилцлагад тэнцсэн байх</p>
	Турк	

2	Шүүгчийн сонгон шалгаруулалтад шалгалт, сорил, асуулга авдаг эсэх	БНСУ	Шүүгчийн улсын шалгалт авдаг. 2018 оноос болиулахаар хуульд нэмэлт, өөрчлөлт орсон		
		Кыргыз	Шүүгчийн сонгон шалгаруулалтыг 3 үе шаттайгаар Шүүгчдийг сонгон зөвлөлөөс сонгоно.		
		Турк	Шүүгч болон прокурорд нэр дэвшигчээс бичгийн болон ярилцлагын хэлбэрээр шалгалт авна.		
3	томилох субъект	БНСУ	Үндэсний ассамблей, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч тусбүр 3 шүүгчийн нэр дэвшүүлж, Ерөнхийлөгч томилно	Үндэсний ассамблейтай зөвшилцсөний үндсэн дээр Ерөнхийлөгч томилно	Дээд шүүхийн Ерөнхий шүүгч
		Кыргыз	Шүүгчийг сонгох зөвлөөс Дээд шүүх, Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын шүүгчид сонгох нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал оруулан Ерөнхийлөгч нь ажлын 10 өдрийн дотор Жогорку Кенеш /Хууль тогтоох дээд байгууллага/-д		
		Турк	Шүүгч болон Прокурорын дээд хорооноос томилно.		
	чөлөөлөх субъект	БНСУ	Үндэсний Ассамблей	Ерөнхийлөгч	Дээд шүүхийн Ерөнхий шүүгч
		Кыргыз	Ерөнхийлөгч	Ерөнхийлөгч	Шүүгчдийг сонгох зөвлөл
		Турк	ҮХ-ийн шүүгчдийн олонхын саналаар чөлөөлнө.		

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Кыргыз улсын Үндсэн хууль эх сурвалж: [http://www.gov.kg/?page\\_id=263](http://www.gov.kg/?page_id=263)
- Кыргыз улсын Үндсэн хуулийн хууль “Кыргыз улсын шүүгчийн статусын тухай” <http://const-palata.kg/ru/about/pravovy-e-osnovy-deyatel-nosti-kp/o-statuse-sudej-ky-rgy-zskoj-respubliki/>
- Үндсэн хууль, *Constitution of South Korea 1948*,
- <[http://korea.assembly.go.kr/res/low\\_01\\_read.jsp?boardid=1000000035](http://korea.assembly.go.kr/res/low_01_read.jsp?boardid=1000000035)>
- Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, *Constitutional Court Act 1988*,
- <[http://ri.ccourt.go.kr/eng/ccourt/files/docs/news/The\\_Constitutional\\_Court\\_Act.pdf](http://ri.ccourt.go.kr/eng/ccourt/files/docs/news/The_Constitutional_Court_Act.pdf)>
- Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль, *Court Organization Act 1949*,
- <<http://eng.scourt.go.kr/eboard/NewsViewAction.workgubun=42&seqnum=1&currentPage=&searchWord=&pr=>>>
- БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн цахим хуудас, хандсан 2015.05.07
- <<http://english.ccourt.go.kr/cckhome/eng/introduction/organization/organization.do#none>>
- БНСУ-ын Дээд шүүхийн цахим хуудас, *Supreme Court of Korea*, хандсан 2015.05.06
- <<http://eng.scourt.go.kr/eng/judiciary/judges.jsp>> <http://www.osym.gov.tr/ana-sayfa/1-0/20150511.html>
- <http://www.osym.gov.tr/belge/1-22096/2015-sinav-takvimi.html>
- [http://www.hcjp.gov.tr/members/second\\_chamber\\_duties.html](http://www.hcjp.gov.tr/members/second_chamber_duties.html)
- <http://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.2802.pdf> (2802 sayılı Hâkimler ve Savcılar Kanunu (Feb. 24, 1983), Prime Ministry Legislative Information System website);

## ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

И.Жаргалзаяабямба,  
Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаа

### Судалгааны товч дүгнэлт:

- Судалгаанд Бүгд Найрамдах Турк Улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг, уг байгууллагын гишүүдийг хэрхэн томилдог талаарх эрх зүйн зохицуулалт, Мексик, Бүгд Найрамдах Колумб улсуудын шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн зохицуулалтын тойм, Латин Америкийн нийт 15 улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэг, гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацааны талаарх мэдээллийг хавсралтаар бэлтгэлээ. */Дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү/*
- Судалгаанд хамрагдсан орнуудад шүүгчийн хараат бус байдлыг хангах үүрэг бүхий бие даасан байгууллага шүүхийн ерөнхий зөвлөлтэй. Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн чиг үүргийг Үндсэн хуулиар, чиг үүрэг, бүрэлдэхүүн, бүрэн эрхийн талаар бие даасан хуулиар тус тус зохицуулсан байна. Бүгд Найрамдах Турк, Мексик, Бүгд Найрамдах Колумб улсуудад зөвлөлийн орон тооны гишүүдийг Ерөнхийлөгч томилдог нийтлэг зохицуулалт байна. *Тухайлбал*, Бүгд Найрамдах Турк улсад Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын Ерөнхий Прокурорыг Ерөнхийлөгч, орон тооны бус гишүүдийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс сонгосон бусад шүүхийн шүүгч нараас тус тус томилдог.
- Харин Латин Америкийн орнуудад 1980-аад оноос АНУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр шүүхийн шинэчлэлийн үйл ажиллагааг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд шүүхийн зөвлөлийг байгуулсны үр дүнд тулгамдсан асуудлуудаа тодорхойлж эрх зүйн баримт бичгүүдийг шинэчилж эхэлжээ. Эдгээр орнуудад тодорхой нэг улс төрийн эрх ашгийн төлөөлөл биш, мэргэжлийн ур чадвартай, хараат бус, бие даасан байдлыг илүүд үздэг байна.

### 1.БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС<sup>58</sup>

Бүгд Найрамдах Турк Улсын Шүүгчдийн болон Прокурорын дээд хорооны бүтэц, орон тоо, чиг үүрэг, бүрэн эрхийг Үндсэн хуулийн 159 дүгээр зүйл болон 1981 оны 2461 дугаар Шүүгчдийн болон Прокурорын Дээд Хорооны тухай **хуулиар тус тус тогтоосон байдаг.**

Тус хороо нь шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байх зарчмын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд Шүүх, шүүгч, эсхүл прокурорын орон тоог хасах, шүүхийн шүүн таслах тойргийг өөрчлөх асуудлаарх Хууль зүйн сайдын саналыг хэлэлцэн шийдвэрлэх ба түүнчлэн Үндсэн хууль болон хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Турк Улсын Үндсэн хуулийн 159-р зүйлд зааснаар Шүүгч болон прокуроруудад үүрэгт ажлаа хууль, дүрэм журмын дагуу гүйцэтгэхэд нь хууль ёсны хяналт тавьж, удирдан чиглүүлэх, үүрэгт ажлаа гүйцэтгэх үедээ хууль зөрчсөн эсэхийг нь хянан шалгах, зан авир ба үйл үйлдэл нь үүрэгт ажлын шалгууртай нийцэж буй эсэхийг хянах, мөрдөн байцаах эрхтэй ба Хууль зүйн сайд яамны аппаратад түр болон байнга ажиллах шүүгч, прокурорын зөвшөөрлийг аван, тэдгээрийг томилох **бүрэн эрхтэй.**

<sup>58</sup>The Turkish high council of judges and Prosecutors in the context of judicial Independence and accountability -<http://www.taa.gov.tr/indir/the-turkish-high-council-of-judges-and-puresecutors-in-the-context-of-judicial-independence-and-accountability->



Шүүгчдийн болон Прокурорын дээд хороог 1981 оны Шүүгчдийн болон Прокурорын Дээд Хорооны тухай /№ 2461/ хуулиар байгуулсан бөгөөд хуулийн 4 дүгээр зүйлд Хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан байна.<sup>59</sup> Үүнд:

- Дээд шүүх болон Захиргааны дээд шүүхийн гишүүнийг сонгох;
- Шүүх, шүүгч, прокурорын орон тоог хасах, шүүхийн шүүн таслах тойргийг өөрчлөх асуудлаарх Хууль зүйн яамны саналыг шийдвэрлэх;
- Шүүгч болон прокурорын;
  - а/ мэргэжлээр нь хүлээн зөвшөөрөх
  - б/ зэрэг дэв дээшлүүлэх, нэгдүгээр зэрэг олгох
  - в/ түр бүрэн эрх олгох
  - г/ томилох, сэлгэн ажиллуулах
  - д/ орон тоо хуваарилах
  - е/ мэргэжлээрээ ажиллахад тохиромжгүй бол зохих шийдвэр гаргах
  - ё/ сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас нь чөлөөлөх.
- Үндсэн хууль болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Шүүгч, прокурортой холбоотой дээр дурдсанаас бусад үйл ажиллагааг Хууль зүйн яам хэрэгжүүлнэ. Шүүгчдийн болон Прокурорын Дээд Хороо нь бие даасан байна.

Харин Турк Улсын Үндсэн хуулийн 159-р зүйлд хорооны бүтэц, орон тоог тодорхой заасан байдаг. Тухайлбал, Хороо нь орон тооны 22 ба орон тооны бус 12 гишүүнээс бүрдэх бөгөөд гурван танхимтай. Шүүгчдийн болон Прокурорын дээд хорооны дарга нь Хууль зүйн сайд байна. Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга албан тушаалаараа тус хорооны гишүүн байна. Хорооны Ерөнхийлөгч нь тус хороог төлөөлөн удирдах боловч танхимуудын үйл ажиллагаанд оролцох ёсгүй байдаг. Хороо нь танхимуудын тэргүүнийг тус тусын гишүүдээс сонгох ба, улмаар танхимуудын тэргүүнээс Дэд Ерөнхийлөгчийг сонгоно. Ерөнхийлөгч нь Дэд Ерөнхийлөгчид өөрийн зарим эрх мэдлийг шилжүүлж болно. Хорооны гишүүдийг дараах байдлаар сонгоно. Үүнд:

- Хорооны орон тооны 4 гишүүнийг Улсын Ерөнхийлөгч хуулийн салбарын багш нар ба хуульчдаас,
- Хорооны үндсэн орон тооны болон орон тооны бус гурав гурван гишүүнийг Дээд Шүүхийн нийт гишүүний хурлаас,
- орон тооны 2 болон орон тооны бус 2 гишүүнийг Захиргааны дээд шүүхийн нийт гишүүний хурлаас,
- орон тооны 1 болон орон тооны бус 1 гишүүнийг Туркийн Шүүхийн Академийн нийт гишүүдийн хурлаас,
- орон тооны 7 ба орон тооны бус 4 гишүүнийг иргэний шүүх ба улсын прокуророос нэгдүгээр зэргийн шүүгчид тавигдах шаардлагыг хангасан шүүгч нараас,
- орон тооны 3 ба орон тооны бус 2 гишүүнийг захиргааны шүүх ба улсын прокуророос нэгдүгээр зэргийн шүүгчид тавигдах шаардлагыг хангасан шүүгч нараас нууц санал хураалтаар тус тус дөрвөн жилийн хугацаатай сонгоно. Хугацаа нь дууссан гишүүн дахин сонгогдож болно.

Хорооны гишүүдийн сонгууль нь гишүүдийн албан хугацаа дуусахаас 60 хоногийн өмнө зохион байгуулагдах ёстой. Тус хороонд Улсын Ерөнхийлөгчийн томилсон гишүүдээс албан хугацаа дуусахаас өмнө чөлөөлөгдвөл, тийнхүү чөлөөлөгдсөнөөс хойш 60 хоногийн дотор шинэ гишүүнийг томилно. Бусад гишүүдээс чөлөөлөгдсөн тохиолдолд үлдэж буй албан хугацааг нь орон тооны бус гишүүд гүйцэтгэнэ.

<sup>59</sup>Улсын Их Хурлын Тамгын газар, Судалгааны эмхэтгэл IV боть, 140-145-р хуудас.

Шүүгчдийн болон Прокурорын Дээд Хороо ердийн болон Захиргааны шүүхийн шүүгч болон прокурорыг мэргэжлээр нь хүлээн зөвшөөрч, томилох, сэлгэн ажиллуулах, түр бүрэн эрх олгох, зэрэг дэв дээшлүүлэх, нэгдүгээр зэрэг олгох, орон тоо хуваарилах, мэргэжлээрээ ажиллахад тохиромжгүй бол шийдвэр гаргах, сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас нь чөлөөлөх шийдвэр гаргана.

## 2.МЕКСИК

Мексикийн шүүхийн тогтолцоог Дээд шүүх тэргүүлэх ба хамтын тойргийн шүүх, нэгдмэл тойргийн шүүх, дүүргийн шүүх болон 1995 онд хүчин төгөлдөр болсон Үндсэн хуулийн нэмэлтийн дагуу 104 дүгээр зүйлийн Е бүлэгт<sup>60</sup> Холбооны тангарагтны шүүх, Холбооны шүүхийн зөвлөлөөс бүрдэнэ.

**Холбооны шүүхийн зөвлөл** /*Council of the federal judiciary*/ - ийн үндсэн чиг үүрэг: *Холбооны шүүхийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 1 хэсэгт /Organic law of the federal judicial branch, section 1/*<sup>61</sup> Холбооны шүүхийн зөвлөл нь шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэг бүхий шүүх эрх мэдлийн дотоод гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. 1995 онд шүүхийн шинэтгэлийн хүрээнд давж заалдах болон доод шатны холбооны шүүхийн шүүгчид, шүүхийн нарийн бичгийн дарга нарын сонгон шалгаруулалтаар сонгон авсан, үйл ажиллагаагаа өөрөө зохицуулдаг холбооны дээд шүүхээс бусад холбооны шүүхийн үйл ажиллагааг зохион байгуулалт, боловсон хүчний удирдлагаар хангах зорилгоор шүүхийн хараат бус зөвлөлийг байгуулсан. Зөвлөл нь шүүгч, магистратыг сонгон шалгаруулах, томилж, чөлөөлөх, шүүгчдийн үйл ажиллагааны талаар мөрдөн шалгалт явуулах, тэдэнд сахилгын шийтгэл ногдуулах, үнэлэх, шүүгчдийн сургалт, дээд шүүхийн төсөв захиран зарцуулах, хориг тавих зэрэг асуудлаар захиргааны дүрэм журмын дагуу хяналт тавина.

**Холбооны шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүн ба бүрэн эрхийн хугацаа:** Зөвлөл нь нийт 7 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд түүний бүрэлдэхүүнд дээд шүүхийн ерөнхий шүүгч, давж заалдах шатны шүүгч 2, дүүргийн шүүгч 1, Сенатын төлөөлөгч 2, засгийн газрын гишүүн 1 тус тус ордог. 1999 оноос хойш Холбооны шүүхийн зөвлөл нь дээд шүүхээс бүх шүүгчдээ томилсон байна. Холбооны шүүхийн зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.<sup>62</sup>

Холбооны шүүхийн ерөнхий зөвлөл орон тооны гишүүдийг нэр дэвшигчдээс нууц санал хураалтаар Ерөнхийлөгч томилно. Холбооны шүүхийн зөвлөлийн ажлын алба нь 2 гүйцэтгэх нарийн бичгийн даргатай.

1. Захиргааны гүйцэтгэх нарийн бичгийн дарга
2. Сахилгын гүйцэтгэх нарийн бичгийн дарга

Гүйцэтгэх нарийн бичгийн дарга хууль зүйн мэргэжилтэй, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх шаардлагатай.

## 3.БҮГД НАЙРАМДАХ КОЛУМБ УЛС

1991 оны Үндсэн хуулиар /*Colombia's Constitution of 1991 with Amendments*<sup>63</sup> шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байгууллагатай байхаар заажээ. Үндсэн хуульд зааснаар Колумб улсад ердийн, захиргааны, үндсэн хуулийн, тусгай шүүхийн тогтолцоотой.

<sup>60</sup>Mexico and its Legal System, <http://www.llrx.com/mexicolegalsystem.htm>

<sup>61</sup>Холбооны шүүхийн тухай хууль, [http://www.trife.gob.mx/sites/default/files/LOPJF\\_ingles%2026\\_may\\_2011.pdf](http://www.trife.gob.mx/sites/default/files/LOPJF_ingles%2026_may_2011.pdf)

<sup>62</sup>Латин Америкийн шүүхийн шинэтгэл, Линн Хаммерпен, <http://law.wisc.edu/gls/lhdjc.pdf>

<sup>63</sup>Колумбын Үндсэн хууль, 1991, [https://www.constituteproject.org/constitution/Colombia\\_2005.pdf](https://www.constituteproject.org/constitution/Colombia_2005.pdf)

**Шүүхийн дээд зөвлөлийн үндсэн чиг үүрэг:** 1991 оны Үндсэн хуулийн 7 дугаар бүлгийн 254-257 дугаар зүйлд Шүүхийн дээд зөвлөлийн чиг үүргийг хуульчилсан байна. Шүүхийн дээд зөвлөл /*The superior Council of the Judicature*/ нь хараат бус байгууллага бөгөөд шүүгчдийн нийгэмлэгийг удирдана. Шүүхийн дээд зөвлөл нь шүүгчийн албан тушаалд дэвших хүмүүсийн нэрсийн жагсаалт гаргах, шүүх эрх мэдлийн байгууллагын төлөөлөгч болон өмгөөлөгч нарын сахилгын асуудлыг хэлэлцэж тэдгээрт хариуцлага ногдуулах, хуулийн товчоо, корпорацийн ажлын үр дүнг шалгах, шүүх эрх мэдлийн байгууллагын төсвийг бэлтгэж Засгийн газарт шилжүүлэх, төрөл бүрийн шүүхийн харьяаллын асуудлаар гарсан маргааныг шийдвэрлэнэ.

Захиргааны танхим нь төлөвлөлт, төсөв, шүүхийн тухай шийдвэр гаргах ба дотоод журам, шинэ хуулийн төсөлд санал гаргах эрхтэй. Сахилгын танхимд хориг тавих арга хэмжээг судална.

**Шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүн ба бүрэн эрхийн хугацаа:** Зөвлөл нь нийт 13 гишүүний бүрэлдэхүүнтэй. Тус зөвлөл нь 2 танхимаас бүрдэнэ. Үүнд:

- Захиргааны танхим
- Сахилгын танхим

Захиргааны танхим нь 8 жилийн хугацаагаар сонгогдсон 6 гишүүнтэй, Зөвлөл нь нийт 13 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд түүний бүрэлдэхүүнд дээд шүүхийн шүүгч 2, Үндсэн хуулийн шүүхийн шүүгч 1, төрийн зөвлөлөөс 3 гишүүнийг сонгоно.

Сахилгын танхим нь Засгийн газраас санал болгосноор Үндэсний конгрессоос 8 жилийн хугацаагаар сонгогдсон 6 гишүүнтэй. Тэдгээрийг дахин томилохгүй. Шүүхийн зөвлөлийн гишүүн нь Колумб улсын иргэн, 35-аас дээш насны хууль зүйн салбарт 10-аас доошгүй жил ажилласан байх нийтлэг шалгуур тавьдаг байна.

ХАВСРАЛТ

## ЛАТИН АМЕРИКИЙН ОРНУУДЫН ШҮҮХИЙН ЗӨВЛӨЛ

№	Улсын нэр	Гишүүдийн тоо	Томилгоо	Бүрэн эрхийн хугацаа	Бүрэн эрх, чиг үүрэг
1.	<b>АРГЕНТИН</b>	20 гишүүнтэй: -Ерөнхий шүүгчид- 4, -Конгрессын төлөөлөгчид- 8, -хуульч-4, -төлөөлөн гүйцэтгэх-1, -эрдэмтэн-2.	Шүүгчдийг хуулийн сонгон шалгаруулалтаар Ерөнхийлөгч тус бүрд нь томилно. Хуульчид болон эрдэмтдийг мэргэжлийн холбоогоор сонгоно. Төлөөлөн гүйцэтгэх ажилтныг сонгоно.	4 жил, улируулан сонгож болно.	-Удирдан чиглүүлэх, анхан шатны болон давж заалдах шатны шүүгчийн сургалт явуулах -Шүүхийн захиргааны болон гүйцэтгэх захиргааны ажилчдыг томилох асуудлаар байгууллагын дүрэм ба төсвийг бэлтгэх. -Дээд шүүх (SCJ) болон шүүхийн давж заалдах, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих болон шүүхийн үйл ажиллагааг хангах -Хууль зүйн яам нь шүүгчийг шилжүүлэх чадварт энэ хуулийн дагуу маргаан шийдвэрлэнэ.
2.	<b>БОЛИВИ</b>	5 гишүүнтэй : -Ерөнхий шүүгч, -Зөвлөлийн гишүүд-4.	Ассамблейн чуулганаас зөвлөлийн гишүүдийг сонгоно.	10 жил, улиран сонгогдож болно.	-Конгрессын санал болгосноор шүүгчдийг сонгоно. -Төсвийг захиран зарцуулах болон захиргааны удирдлагыг хангах -Шүүхийн сургууль, сахилгын ажиллагааг зөрчих үйлдэлд (гэмт хэрэг) арга хэмжээ авах
3.	<b>БРАЗИЛ</b>	5 гишүүнтэй : -ерөнхийлөгч, -дэд ерөнхийлөгч, -дээд шүүхийн-3 гишүүнтэй.	Дээд шүүхээс сонгогдоно.	Анхан шатны албан нөхцөлийн дагуу	-
4.	<b>КОЛУМБ</b>	13 гишүүнтэй: -захиргааны танхим- 6, -сахилгын танхим- 7	Захиргааны танхимд: -Дээд шүүхээс -2, -Үндсэн хуулийн шүүхээс -1, -Төрийн Зөвлөлөөс-3 байна. Сахилгын танхимд: Конгрессоос 7 гишүүнийг жагсаалтаар ирүүлнэ.	8 жил, албан тушаалд томилох.	-Захиргааны ажилтныг сонгон шалгаруулж, хяналт тавина. -Захиргааны танхим, төлөөлөлт, төсөв, шүүхийн тухай шийдвэр гаргах ба дотоод журам, шинэ хуулийн төсөлд санал өгч болно. -Сахилгын танхимд хориг тавих арга хэмжээг судална.

5.	<b>КОСТА РИКА</b>	5 гишүүнтэй: -Ерөнхий шүүгч -1, -Дээд зөвлөл-1, Шүүхийн гишүүн -сургалтын зөвлөл-2, -давж заалдах шатны шүүгч-1	Дээд шүүх томилно. (захиргааны сонгон шалгаруулалтын жагсаалтаас )	2 жил, Улиран сонгоно.	-Шүүхийн зөвлөл болон шүүхийн шаардлагад нийцсэн үйл ажиллагаанд шүүхийн зөвлөлийн нэр дэвшигчийг сонгон шалгаруулах -Шүүхийн зөвлөлийн сургууль болон сургалтын зөвлөмжийг тодорхойлох
6.	<b>ДОМИНИКА</b>	7 гишүүнтэй : -Ерөнхийлөгч, -Сенатын ерөнхийлөгч, -Сенатын орлогч дарга, -дээд шүүхийн шүүгч-1, -шүүгч-1, -сенатор-1, -орлогч дарга-1	Дээд шүүх, Сенат, Танхимаас сонгогдсон гишүүдээс бусад албан тушаалаас тус тус сонгоно.	Урт хугацаанд сонгоно.	Дээд шүүх тодорхойлно.
7.	<b>ЭКВАДОР</b>	8 гишүүнтэй : -Дээд шүүхийн ерөнхийлөгч, -Дээд шүүхийн гишүүд- 4, -сургуулийн хуулийн төлөөлөгч-1, -нийгэмлэгээс-1, -шүүхийн холбоо-1.	Тухайн байгууллагын сонгосон ажилтныг дээд шүүх томилно.  Дээд шүүхийн ерөнхийлөгчөөс бусад бүх хуульч байх ёстой. Идэвхтэй шүүгч, албан тушаалтан нэр дэвшүүлж болно.	6 жил, хязгааргүй, улируулан сонгож болно.	-Шүүгчдийг (дээд шүүх, доод шатны шүүхэд томилдог байх зарчмаар) сонгоно. -шүүхийн нөөцөд хяналт тавих; -дотоод захиргааны болон санхүүгийн журмыг тодорхойлж, бүх худалдан авалтын гэрээг батална.
8.	<b>САЛЬВАДОР</b>	6 гишүүнтэй : -хуульч-3, -хуулийн профессор-1 -төрийн их дээд сургууль- 1 -хувийн их дээд сургууль-1 -Олон нийтийн яамны төлөөлөгч- 1 байна.	Ассамблей чуулганаас 2/3 олонхын саналаар нэр дэвшүүлэн сонгоно.	3 жил, улируулан сонгож болно.	-
9.	<b>ГВАТЕМАЛ</b>	5 гишүүдтэй : -Дээд шүүхийн ерөнхийлөгч, -Хүний нөөцийн дарга, -Сургалт хариуцсан дарга, -Төлөөлөгч, -Шүүгчдийн төлөөлөгч,	Шууд сонгогдоно.	Үндсэн удирдлага байна.	-Конгресс болон Дээд шүүхийн давж заалдах шатны шүүх гишүүдийг сонгон шалгаруулах -зөвлөгөө өгөх, сургалтын албаны дарга нэгжийн бодлогыг тодорхойлж, шүүгчдийг шалгах

10	<b>МЕКСИК</b>	7 гишүүнтэй : -шүүхийн ерөнхийлөгч, -давж заалдах шатны шүүгч-2, -дүүргийн шүүгч-1, -Сенатын төлөөлөгч- 2, -холбооны гүйцэтгэх захирал- 1	Бүх холбогдох байгууллагаас сонгогдоно. 1999 оноос хойш Дээд шүүхийн бүх шүүгчид сонгогдох эрхтэй.	5 жил, улируулан сонгоно.	-Удирдах албан тушаалтан ба бусад шүүхийн шүүгчийг сонгон шалгаруулах, -томилгох, үнэлэх, доод шатны шүүгчдийг соёрхон батлах; -Сургалт зохион байгуулах -Дээд шүүхийн төсөв, захиран зарцуулалт, хориг тавих асуудлууд багтана. -Захиргааны дүрэм журмын дагуу шүүх хяналт тавьж зохицуулалт хийнэ.
11	<b>ПАНАМ</b>	8 гишүүнтэй: -Дээд шүүхийн ерөнхийлөгч, -шүүхийн гишүүн, -ерөнхий прокурор, -захиргааны төлөөлөгч, -үндэсний ерөнхийлөгч	Шууд сонгогдоно.	Урт хугацаанд сонгоно.	-Шүүгч ба яллах дүн шинжилгээ хийх, сонгон шалгаруулах үйл явцын талаар санал өгдөг. -Хууль, шүүхийн захиргааны үйл ажиллагааны талаар албан тушаалтанд зөвлөмж, санал өгнө.
12	<b>ПАРАГВАЙ</b>	8 гишүүнтэй : -Дээд шүүх-1, -Гүйцэтгэх төлөөлөгч -1, -Сенатор-1, -Дэд дарга-1, -Хуульн -2, -хуулийн профессор-1, -Хувийн хуулийн сургууль -1	Төлөөлж буй байгууллагаас ½ санал болгосноор томилогдоно.	3 жил, улируулан шууд сонгоно.	-
13	<b>ПЕРУ</b>	7 гишүүнтэй : -Дээд шүүхээс -1, -Ямнаас-1, -хуульн-1, -хуулийн профессор-1, -Хувийн Их сургуулиас-1, -нийгэмлэгийн төлөөлөгч- 2.	Төлөөлөн удирдах байгууллагуудаас сонгогдсон байна.	5 жил, шууд улируулан сонгоно.	-Дээд шүүх, Төрийн яамтай хамтран шүүгч, прокурорын нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, -батламж жуух бичиг баримт , үнэлгээ хийх аргыг боловсруулах.
14	<b>УРАГВАЙ</b>	7 гишүүнтэй: -шүүхийн сайд -Дээд шүүхийн ерөнхийлөгч, -Захиргааны шүүгч-1, -Хуульн-1, -Ерөнхий прокурор, -Захиргааны прокурор, -Давж заалдах шатны шүүгч	Конгресс нь хууль тогтоогч албан тушаалтныг томилно.	Урт хугацаанд сонгож болно.	-Шүүгч, шүүхийн ажилтнуудын сахилга, хяналт тавих шүүгчдийг шууд томилох,шүүхийн төсвийг боловсруулах.
15	<b>ВЕНЕСУЭЛ</b>	8 гишүүнтэй : -Дээд шүүхээс -4, -Конгрессоос- 2, -Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн-2 байна.	Дээд шүүхийн гишүүдэд төлөөллийн гишүүн байна.	6 жил, улируулан сонгож болно.	-Шүүхийн шүүгчид, төрийн хамгаалалтад хяналт тавина. -Засаг захиргаа, шүүхийн төсвийн удирдлагын зарцуулалтад хяналт тавих эрхтэй.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

- The Turkish high council of judges and Prosecutors in the context of judicial Independence and accountability -<http://www.taa.gov.tr/indir/the-turkish-high-council-of-judges-and-puresecutors-in-the-context-of-judicial-independence-and-accountability.pdf> -
- <http://www.oecd.org/corruption/acn/IstanbulJune2012ExpertSeminarProceedingsEN.pdf>
- Constitution of the Republic of Turkey- [http://en.wikisource.org/wiki/Constitution\\_of\\_the\\_Republic\\_of\\_Turkey](http://en.wikisource.org/wiki/Constitution_of_the_Republic_of_Turkey)
- УИХ-ын Тамгын газар, Судалгааны эмхэтгэл IV боть “Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудалд” харьцуулсан судалгаа Ц.Норовдондог (Ph.D), Б. Буяндэлгэр, Ш. Хишигсүрэн, Ц.Түвшинзаяа, хуудас 140-145;
- Mexico and its Legal System, <http://www.llrx.com/mexicolegalsystem.htm>
- Холбооны шүүхийн тухай хууль, [http://www.trife.gob.mx/sites/default/files/LOPJF\\_ingles%2026\\_may\\_2011.pdf](http://www.trife.gob.mx/sites/default/files/LOPJF_ingles%2026_may_2011.pdf)
- Латин Америкийн шүүхийн шинэтгэл, Линн Хаммерген,<http://law.wisc.edu/gls/lhdjc.pdf>
- Колумбын Үндсэн хууль, 1991, [https://www.constituteproject.org/constitution/Colombia\\_2005.pdf](https://www.constituteproject.org/constitution/Colombia_2005.pdf)

**БОЛГАР УЛСЫН СОНГУУЛИЙН СИСТЕМ, 2009 ОНЫ СОНГУУЛЬ БОЛОН  
ЕВРОПЫН ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ***Д.Жигваагүнсэл***БОЛГАРЫН СОНГУУЛИЙН СИСТЕМЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ:**

- Нэг танхимтай парламент
- Танхимын нэр: Ардын Хурал (Народно Собрание)
- Гишүүний тоо: 240
- Хугацаа: 4 жил
- Сонгуулийн тойрог: 1991 оноос хойш: 31 тойрогтой (суудлын тоо нь хүн амаас хамааран өөр өөр). 1990: 28.
- Санал хураалтын систем нь 1991 оноос хойш 31 гишүүн нь мажоритар системээр (first-past-the-post (FPTP) system) сонгогдож; 209 гишүүн нь намын хаалттай жагсаалтаар пропорционал төлөөллийн системээр сонгогддог болсон. Эдгээр суудлуудыг пропорционал төлөөллийн (d'Hondt) аргаар хуваарилна. Бүх нийтийн санал хураалтаар наанадаж 4 хувийн санал авсан нам болон эвслүүд парламентын төлөөллийн эрхтэй болно.
- Сонгогчид тавих шаардлага: 18 нас хүрсэн; Болгарын иргэн.
- Сонгуулийн саналыг заавал өгөх албагүй.

**БОЛГАРЫН ПАРЛАМЕНТЫН 2009.07.05-НЫ СОНГУУЛЬ:**

Болгарын парламентын сонгууль 2009 оны 7-р сарын 5 нд зохион байгуулагджээ.

Болгарын 2009 оны сонгуулийг олонхын саналын элемент багатай холимог сонгуулийн системтэй сонгууль болсон гэж үздэг. Парламентын нийт 240 суудлын 209-ийг нь пропорционал системээр хуваарилж, үлдсэн 31 (Болгарын сонгуулийн тойргийн тоо) нь мажоритар системээр сонгосон байна.

Сонгуульд ялалт байгуулсан Бойко Борисовын GERB нам 40% санал авсан байдаг. Харин сонгуулийн өмнө тэргүүлж явсан Социалист нам 18% саналаар хоёрт оржээ. Сонгуулийн ирц 60.2% байсан нь хамгийн бага хувь хэмжээ байв.

2009 оны 4-р сард BSP, DPS, Ataka, Эмх цэгц, хууль ба шударга ёсны намуудын саналаар сонгуулийн шинэчлэлийг хийжээ. Үүгээр сонгуульд эвсэл болж орж буй намуудын тухайд сонгуулийн босгыг 4% -с 8% болгон нэмж (үүнийг тухайн үед 7,3% санал авсан DCB ба SDS-ийн эвслийн эсрэг хийсэн зүйл гэж олон нийт үзсэн байдаг), нийт 240 суудлын 31-ийг нь мажоритар системээр сонгоно гэж тогтоосон байна. Үүнээс хойш 2013.05.12 болон 2014.10.05-нд Парламентын сонгууль зохион байгуулагдсан байна.

**ЕВРОПЫН ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛЬ:**

Евро парламент (**EU Parliament**- ЕХ Парламент буюу **EP-ЕП**) нь Европын Холбооны байгууллагуудаас (7 үндсэн байгууллага бий) шууд сонгогддог. Энэ нь Европын Холбооны Чуулган (7 байгууллагын гурав дахь нь), Европын Комисс (гүйцэтгэх байгууллага)-ын хамтаар Европын Холбооны хууль тогтоох үүргийг гүйцэтгэнэ. Энэхүү парламент нь 751 (өмнө нь 766 байсан) гишүүнтэй, дэлхийд хоёрт эрэмбэлэгдэх (Энэтхэгийн парламентын дараа орно) том ардчилсан сонгууль төдийгүй бас хамгийн том үндэстэн дамнасан (2009 онд 375 сая сонгогчидтой байв) ардчилсан сонгууль юм.



Энэ нь 1979 оноос хойш таван жил тутам сонгуулийн эрх бүхий олон нийтийн сонгуулиар шууд сонгогдож иржээ. Гэхдээ мөн үеэс хойш Евро парламентын сонгуулийн сонгогчдын ирц сонгууль тус бүрд буурсаар 1999 оноос хойш 50%-аас доош орсон үзүүлэлттэй болсон байна. 2014 онд гэхэд л бүх Европын сонгогчдын 42.54% нь саналаа өгсөн байдаг.

1. 2014 оны сонгуулиар Болгар улс Европын Парламентад 17 суудал авсан бол 2009 оны сонгуулиар 18 суудал авч байжээ. *Тухайлбал,*

<i>Нам</i>	<i>Санал</i>	<i>Саналын %</i>	<i>Суудал</i>
GERB - Болгарын Европын Хөгжлийн төлөөх иргэд	627,693	24.36	5
KB - Болгарын Эвсэл	476,618	18.50	4
DPS - Эрх ба эрх чөлөөний хөдөлгөөн	364,197	14.14	3
АТАКА - Давшилт	308,052	11.96	2
NDSV - Үндэсний тогтвортой байдал ба дэвшлийн Болгарын сонгуулийн систем хөдөлгөөн	5,146	7.96	2
Sinyata - Цэнхэр эвсэл	204,817	7.95	2
Lider - Лидер	146,984	5.70	-
RZS - Эмх цэгц, Хууль ёс, Шударга ёс	120,280	4.67	-
IMRO - Болгарын Үндэсний Хөдөлгөөн	57,931	2.25	-
Бусад	64,724	2.51	-
<b>Бүгд (бусдыг оролцуулаад)</b>	<b>2,576,434</b>	<b>100.00</b>	<b>18</b>

\*\*\*

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [www.nsd.uib.no/european\\_election\\_database/country/bulgaria/](http://www.nsd.uib.no/european_election_database/country/bulgaria/)
- [www.nsd.uib.no/european\\_election\\_database/country/bulgaria/](http://www.nsd.uib.no/european_election_database/country/bulgaria/)
- [http://en.wikipedia.org/wiki/Bulgarian\\_parliamentary\\_election,\\_2009](http://en.wikipedia.org/wiki/Bulgarian_parliamentary_election,_2009)

## ДЭЭД ШҮҮХИЙН ХУУЛИЙН ТАЙЛБАР ХИЙХ БҮРЭН ЭРХИЙН ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч (PhD),  
А.Пагма, Б.Ариунжаргал*

Гадаадын зарим орны, тухайлбал ХБНГУ, ОХУ, Латви улсын дээд шүүхүүдийн хууль тайлбарлах бүрэн эрхийн талаарх мэдээллийг бэлтгэхдээ тодотгох үүднээс эрхийн хэм, хэмжээний тайлбарын агуулга, төрөл, хэлбэрийн талаар товч лавлагааг оруулсан болно.

<p style="text-align: center;"><b>Монгол Улсын Үндсэн хууль</b> Тавьдугаар зүйл</p> <p>1. Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>4/Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;</p>	<p style="text-align: center;"><b>Монгол Улсын шүүхийн тухай хууль</b> Дөрөвдүгээр бүлэг Хяналтын шатны шүүх</p> <p>17 дугаар зүйл. Улсын дээд шүүхийн бүрэн эрх</p> <p>17.3.Улсын дээд шүүх энэ хуулийн 17.1-д заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>17.3.1.Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх;</p>
---	---

### **Нэг. Эрхийн хэм хэмжээний албан ёсны ба албан ёсны бус тайлбар**

Эрх зүйн актын тайлбарыг:

- а) албан ёсны;
- б) албан ёсны бус гэж хоёр ангилна.

**1.1. Албан ёсны тайлбар** -Төрийн байгууллага, албан тушаалтан өөрийн эрх мэдлийн хүрээнд эрхийн актын агуулгыг тайлбарласныг албан ёсны тайлбар гэх бөгөөд уг тайлбар нь хуулийг хэрэглэх практикт зайлшгүй дагах хэм хэмжээ болно.

Албан ёсны тайлбарыг гаргаж буй субъектаар нь:

- а) аутентик тайлбар;
- б) хуулиар эрх олгогдсон байгууллагын (legal) тайлбар гэж ангилна.

Албан ёсны тайлбар нь:

- а) хэм хэмжээний (норматив);
- б) хэргийн (casual) гэсэн хоёр хэлбэртэй.

**Аутентик тайлбар** - эрх зүйн актыг тогтоосон байгууллагын зүгээс эрхийн хэм хэмжээг албан ёсоор тайлбарлана.

**Хуулиар эрх олгогдсон байгууллагын тайлбар** - эрх зүйн актыг тогтоогоогүй байгууллагын зүгээс өөрт хуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээнд эрхийн хэм хэмжээг албан ёсоор тайлбарлана.

Аутентик ба хуулиар эрх олгогдсон байгууллагын тайлбар нь хэм хэмжээний ба хэргийн гэсэн хэлбэртэй байна.

**Хэм хэмжээний тайлбар** - эрхийн хэм хэмжээний албан ёсны тайлбар бөгөөд тухайн эрхийн актыг практикт хэрэглэхэд хуулийн адил заавал баримтлах ёстой.


Эрхийн хэм хэмжээний албан ёсны тайлбарыг тодорхой тохиолдол, хэрэгтэй холбон гаргахгүй бөгөөд тухайн эрхийн актын хамрах бүх тохиолдолд нийтлэг үйлчлэх

загвар гэж ойлгоно. Хэм хэмжээний тайлбар нь зөвхөн үйлчилж буй эрхийн актын утгыг тайлбарлах бөгөөд шинээр ямар нэгэн хэм хэмжээ тогтоохгүй. Эрхийн хэм хэмжээний албан ёсны тайлбар нь бие даасан утга байхгүй, хэрэв тайлбарлагдаж буй анхны эрхийн акт хүчингүй болох юмуу өөрчлөгдвөл тайлбар ч өөрчлөгдөнө.

**Хэргийн тайлбар** - тодорхой хэргийг шийдвэрлэх үед эрхийн хэм хэмжээг албан ёсоор тайлбарласныг хэлэх бөгөөд зөвхөн уг хэргийг шийдвэрлэхэд баримтална. Эрх бүхий байгууллагаас гаргаж буй албан ёсны тайлбар нь тусгай актаар томъёологдоно.

**1.2. Албан ёсны бус тайлбар**- Албан ёсны бус тайлбар нь хуулийн хувьд заавал мөрдөгдөх хүчинтэй биш бөгөөд илэрхийлэх хэлбэрийн хувьд аман (өмгөөлөгч, шүүгч, прокурорын зүгээс иргэдэд тайлбарлах) болон бичгийн хэлбэртэй. Дараах байдлаар ангилна:

- ахуйн (өдөр тутмын амьдрал, ахуйд иргэдийн зүгээс хийгдэнэ);
- мэргэжлийн (прокурор, өмгөөлөгч, хуулийн зөвлөх, эрх зүйн мэргэжилтний тайлбар);
- онолын (эрдэмтэд, судлаачид судалгаа, монограф, сурах бичиг, өгүүллэг, коммент хэлбэрээр нийтэлсэн).



### Хоёр. Зарим орны эрхзүйн зохицуулалт

#### 2.1 ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

ХБНГУ-д Холбооны Хэргийн шүүх (*Bundesgerichtshof, Federal Court of Justice* - эрүүгийн болон иргэний хэргийн шүүх), Холбооны захиргааны хэргийн шүүх, Холбооны санхүүгийн хэргийн шүүх, Холбооны хөдөлмөрийн хэргийн шүүх, Холбооны нийгмийн хэргийн шүүх гэсэн Холбооны 5 дээд шүүх бий. Дээд шүүхүүд бүгд нэг ижил түвшнийх бөгөөд хоорондын маргаантай асуудлаа байнгын бус ажиллагаатай Хамтарсан сенатаар шийдүүлдэг. Түүхэнд Хамтарсан сенат маш цөөхөн хуралдаж шийдвэр гаргасан байдаг.

ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүх нь (*Bundesverfassungsgericht*) Үндсэн хууль болон иргэний үндсэн эрхийг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй. Мөн Холбооны муж улс бүр

өөрийн Үндсэн хуультай, Үндсэн хуулийн шүүхтэй. Холбооны болон муж улсын Үндсэн хуулийн шүүхүүд тус бүрдээ Үндсэн хуулиа тайлбарлах эрхтэй байна.

Хуульд албан ёсны тайлбар хийх тухайд ХБНГУ-ын Холбооны үндсэн хуулийн шүүх нь ийм тайлбарыг хийдэг бөгөөд ХБНГУ-ын Үндсэн хуулийн Холбооны үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг тодорхойлсон 93 дугаар зүйлд Үндсэн хуулийн эрх зүйн харилцаанд оролцогчдын маргаан гарсан тохиолдолд Холбооны үндсэн хуулийг тайлбарлах бүрэн эрхийг хуульчилжээ<sup>64</sup>.

Холбооны үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 31(2) дахь заалтад тусгайлан зааснаар, Холбооны засгийн газар, Муж улсын засгийн газар, эсвэл Бундэстагийн дөрөвний нэгийг санал гаргаснаар Холбооны буюу Муж улсын хууль тогтоомж Үндсэн хуультай зөрчилдсөн гэсэн маргаан, эсвэл Муж улсын хууль тогтоомж Холбооны хууль тогтоомжтой зөрчилдсөн гэсэн маргаантай холбоотой абстракт<sup>65</sup> болон бодит<sup>66</sup> асуудлын талаарх ялгаатай байр суурь буюу эргэлзээ байгаа тохиолдолд тус шүүхийн шийдвэр нь хуулийн адил хүчинтэй<sup>67</sup>.

## 2.2 ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

ОХУ-ын Үндсэн хуулийн 126 дугаар зүйлд Дээд Шүүх нь иргэн, эрүү, эдийн засаг, захиргааны хэргийн болон бусад асуудлаар шүүхийн дээд байгууллага болохыг хуульчлан, шүүхийн практикийн асуудлаар тайлбар өгнө хэмээн заажээ<sup>68</sup>.

ОХУ-ын “Дээд Шүүхийн тухай” Холбооны хуулийн 1 дүгээр бүлгийн 2 дугаар зүйлийн 7.1 дэх заалтад Дээд шүүх нь “Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийг нэгдмэл маягаар хэрэглэх явдлыг хангах үүднээс шүүхийн практикийг судлан, нэгтгэн дүгнэсний үндсэн дээр энэхүү практикийн асуудлаар тайлбар өгнө” гэж заажээ<sup>69</sup>.

Дээд Шүүхийн шүүхийн практикийн асуудлаарх тайлбарыг Дээд Шүүхийн Бүгд хурлаас тогтоол хэлбэрээр гаргадаг байна. Дээд Шүүхийн Бүгд хурал нь ОХУ-ын Дээд Шүүхийн бүх шүүхчдийн (хуульд 170 шүүгчтэй гэж заасан<sup>70</sup>) хурал бөгөөд тус хурлаар шүүхийн практик, шүүхийн статистикийг судласан материал, ОХУ-ын Ерөнхий прокурор ба ОХУ-ын Хууль зүйн сайдын танилцуулгыг тус тус хэлэлцэн шүүхүүдэд шүүхийн практикийн асуудлаар тайлбар өгдөг.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>64</sup>Basic Law for the Federal Republic of Germany, <https://www.bundestag.de>

<sup>65</sup>Foermilch (англиар formal)

<sup>66</sup>Sachlich (англиар factual)

<sup>67</sup>Law on the Federal Constitutional Court (Gesetz über das Bundesverfassungsgericht), <http://www.iuscomp.org/gla/statutes/BVerfGG.htm>

<sup>68</sup>Конституция РФ, Глава 7, статья 126. <http://dogovor-urist.ru/>

<sup>69</sup>ФКЗ “О Верховном Суде Российской Федерации”, Глава 1, ст.2, 7.1. [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_170506/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_170506/)

<sup>70</sup>Мөн тэнд

## ХАВСРАЛТ 1

**Монгол Улсын Дээд шүүхээс гаргасан хуулийн албан ёсны тайлбарын тоо /1993-2010/<sup>73</sup>**

1993 оноос 2010 он хүртэл Улсын Дээд шүүхээс нийт 161 удаа хуулийн зүйл, заалтыг тайлбарласан байна.

<i>Он</i>	<i>Тайлбарын тоо</i>
1993	4
1994	5
1995	6
1996	6
1997	12
1998	6
1999	2
2000	6
2001	2
2002	7
2003	10
2004	1
2005	3
2006	26
2007	17
2008	16
2009	19
2010	9
<b>Нийт - 161</b>	

## ХАВСРАЛТ 2

**2008-2010 онуудад Монгол Улсын Дээд шүүхээс хийсэн хуулийн тайлбар<sup>74</sup>**

<i>тогтоолын дугаар</i>	<i>Батлагдсан он</i>	<i>Гарчиг</i>
<b>2008 он</b>		
09	2008-02-28	Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай
10	2008-03-07	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг шүүхийн практикт хэрэглэх тухай
11	2008-03-07	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай
12	2008-03-26	Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай

<sup>73</sup>Улсын Дээд шүүх, Шүүхээс хууль тайлбарлах хэрэглэх онол практикийн тулгамдсан асуудал. Уб., 2004 он, 203 дахь тал

<sup>74</sup><http://www.supremecourt.mn>

13	2008-03-26	Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг булаах” гэмт хэргийг 147 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх” гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар
14	2008-03-26	Эрүүгийн хуулийн 93 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах, санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдсан үед бусдыг санаатай алах гэмт хэргийг хүнийг санаатай алах гэмт хэргээс ялгаж, зөв зүйлчлэх талаар
15	2008-03-31	Газрын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай
16	2008-03-31	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
17	2008-06-19	Монгол Улсын Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
25	2008-03-31	Орон сууц болон орон сууц хувьчлах тухай хуулиудын зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
26	2008-06-19	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
29	2008-06-25	Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
30	2008-06-25	Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
45	2008-11-25	Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай
46	2008-11-25	Гэр бүлийн болон иргэний бүртгэлийн тухай хуулиудын зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай
47	2008-11-25	Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан хуулиудын зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
<b>2009 он</b>		
08	2009-03-31	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удардлагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
09	2009-03-31	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
10	2009-03-31	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
14	2009-05-22	Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийг шүүхийн практикт хэрэглэх тухай
15	2009-05-22	Гэмт хэргийн улмаас учирсан хохиролыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай
16	2009-05-22	Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

17	2009-06-15	Иргэний хуулийн 10,11 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
18	2009-06-15	Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 1,2 дугаар дэд бүлгүүдийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
19	2009-06-15	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай
20	2009-06-15	Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 3 дугаар дэд бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
21	2009-06-24	Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
22	2009-06-24	Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
23	2009-06-24	Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
25	2009-07-06	Улсын Дээд шүүхийн 2006 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай
27	2009-07-14	Өршөөл үзүүлэх тухай хуулийн зарим зүйл, хэсгийг хэрэглэх тухай
30	2009-10-28	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44,4 дэх хэсгийг тайлбарлах тухай
31	2009-10-28	Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн зарим зүйл, заалтыг шүүхийн практикт хэрэглэх тухай
32	2009-10-28	Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
33	200-10-28	Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
<b>2010 он</b>		
08	2010-04-26	Төрийн албаны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
09	2010-04-26	Ашигт малтмалын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
13	2010-05-19	Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
14	2010-05-19	Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
15	2010-05-19	Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
16	2010-06-22	Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 4 дүгээр дэд бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
17	2010-06-22	Иргэний хуулийн 5,6,7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай
18	2010-06-22	Улсын Дээд шүүхийн 2004 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 08 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай
20	2010-07-20	Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийг шүүхийн практикт хэрэглэх тухай

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Basic Law for the Federal Republic of Germany, <https://www.bundestag.de>
- Law on the Federal Constitutional Court (Gesetz ьber das Bundesverfassungsgericht), <http://www.iuscomp.org/gla/statutes/BVerfGG.htm>
- Конституция РФ. <http://dogovor-urist.ru/>
- ФКЗ “О Верховном Суде Российской Федерации”. [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_170506/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_170506/)
- On Judicial Power, Part II, Chapter 6, Section 49. [unpan1.un.org](http://unpan1.un.org)
- Монгол Улсын Дээд Шүүх, Шүүхээс хууль тайлбарлах хэрэглэх онол практикийн асуудал. УБ., 2008 он

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



**БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРАЛТАЙ ХОЛБОГДОХ ЛАВЛАГАА***А.Пагма, Д.Жигваагүнсэл***• БНМАУ-ын Ардын Их Хурлын үйл ажиллагааны үндсийг хуульчилсан эрх зүйн баримт бичгүүд**

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хуульд өөрчлөлт ба нэмэлт оруулах тухай. БНМАУ-ын 9 дүгээр Их Хурлын тогтоол. 1949 оны 2 дугаар сарын 19. БНМАУ-ын Есдүгээр Их Хурлын илтгэл, хууль, тогтоолууд. Улаанбаатар, 1949 он
2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль. 1960 он. БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987
3. БНМАУ-ын Ардын Их Хурлыг сонгох сонгуулийн тухай дүрэм. 1986 он. БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987
4. БНМАУ-ын орон нутгийн АДХ сонгох сонгуулийн тухай дүрэм. 1984 он. БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987
5. БНМАУ-ын Ардын Их Хурлын Регламент. 1981 он. БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987
6. БНМАУ-ын аймаг, хотын АДХ-ын тухай хууль. 1984 он. БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987
7. БНМАУ-ын сум, хороо, район, орон нутгийн хотын АДХ-ын хууль. УБ., 1978 он
8. БНМАУ-ын депутатын тухай хууль. 1978 он. БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987
9. БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатыг огцруулах журмын тухай хууль. 1961 он. БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987
10. БНМАУ-ын аймаг, хот, сум, хороодын АДХ-ын депутатыг огцруулах журмын тухай хууль. 1963 он. Зарим хууль тогтоолын эмхтгэл. УБ., 1970 он


**• БНМАУ-ын төрийн эрх байгууллагуудын тогтолцоо**

1949 онд хуралдсан Улсын IX Их Хурал БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар төрийн байгууллагуудын сонгуулийн системийг бүх нийтийн тэгш, шууд, саналаа нууцаар гаргаж сонгох шинэ систем болгон тогтоожээ.

Энэхүү системийн дагуу 1951 оны 6 дугаар сарын 10-ны өдөр БНМАУ-ын Улсын Их Хурлыг (1960 оны Үндсэн хууль үйлчлэх хүртэл Улсын Их Хурал гэж нэрлэж байсан) сонгох анхдугаар удаагийн сонгууль явагдсан.

Үүнээс өмнө баг<sup>75</sup>, хорины хөдөлмөрчдийн хурлаас сум, хорооны Хурлын төлөөлөгчдийг, түүнээс аймаг, хотынхныг сонгосны дараа Улсын Их Хурлыг аймаг, хотын бага хурлаас төлөөлөгчдийг сонгох журмаар шатлан байгуулж байсан бол 1951 оноос хойш шинэ системээр бүх шатны Хурлыг нийт иргэд, сонгогчдоос шууд сонгох тогтолцоонд шилжжээ.

<sup>75</sup>1959 оны 8 дугаар сард багийг татан буулгаснаар сум, хороо нь орон нутгийн анхан шатны нэгж болов.

**БНМАУ-ын сонгуулийн шинэ систем (1949-1990)**

1960 оны Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийн 18 дугаар зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн эрхийг барих дээд газар нь Ардын Их Хурал мөн. БНМАУ-ын АИХ, түүний байгууллагуудын журмыг БНМАУ-ын Үндсэн хуульд нийцүүлж гаргасан БНМАУ-ын АИХ-ын регламент болон бусад хуулиар тодорхойлно.” хэмээн хуульчилсан байна.

Ардын Их Хурлын анхдугаар сонгууль 1951 онд явагдсанаас хойш 1990 оныг дуустал Ардын Их Хурлын нийт 12 удаагийн сонгууль зохион байгуулагдсан байна.

1960 оны Үндсэн хуульд Ардын Их Хурлыг бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийн эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах замаар тус улсын 18 нас хүрсэн бүх иргэн сонгох ба 5 жилийн хугацаагаар сонгоно гэж заасан байдаг ч сонгууль ихэвчлэн 3-5 жилийн давтамжтай явагдсан байна.

1960 оны Үндсэн хуулийн 3-р бүлэгт БНМАУ-ын Ардын Их Хуралд тус аймгийн харьяалалтай хороо, аймгийн төвөөс бусад орон нутгийн хот бүрээс нэг, аймгийн төвийн болон улсын харьяалалтай хотын 10000 хүн ам тутмаас 1 депутат тус тус сонгох ба Ардын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа 5 жил байхаар хуульчилсан байна. Мөн Ардын Их Хурлын ээлжит чуулганыг жилд нэг удаа хийх бөгөөд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн санаачилгаар буюу эсхүл депутатуудын гуравны нэгээс доошгүй нь шаардвал Ардын Их Хурлын ээлжит бус чуулганыг хийдэг байжээ.

**БНМАУ-ын Ардын Их Хурлын ээлжит сонгууль явагдсан он дараалал**

<b>АИХ-ын ээлжит сонгууль</b>	<b>Сонгууль явагдсан он</b>	<b>Бүрэн эрхийн хугацаа</b>
1 дэх удаагийн	1951	3 жил
2 дахь удаагийн	1954	3 жил
3 дахь удаагийн	1957	3 жил
4 дэх удаагийн	1960	3 жил
5 дахь удаагийн	1963	3 жил
6 дахь удаагийн	1966	3 жил

7 дахь удаагийн	1969	4 жил
8 дахь удаагийн	1973	4 жил
9 дэх удаагийн	1977	4 жил
10 дахь удаагийн	1981	5 жил
11 дэх удаагийн	1986	5 жил
12 дахь удаагийн	1990	-

БНМАУ-ын ардын депутатуудын хурлууд эрх хэмжээ, үйлчлэх нутаг дэвсгэр үйл ажиллагааныхаа шинжээр бие биенээсээ ялгаатай. Үүний үндсэн дээр ардын депутатуудын хурлууд 2 хэсэгт хуваагдана. Нэгдүгээр хэсэгт дээр дурдсан төрийн эрх барих ардын төлөөлөгчдийн дээд байгууллага болох БНМАУ-ын Ардын Их Хурал, хоёр дугаар хэсэгт төрийн эрх барих ардын төлөөлөгчдийн орон нутгийн байгууллагууд болох аймаг, хот, район, сум, хороодын ардын депутатуудын хурлууд хамаарна.

Орон нутгийн АДХ-ын сонгууль анх 1952 оны 10 сарын 19-нд шинэ сонгуулийн үндсэн дээр анх удаа БНМАУ-ын аймаг, хот, сум хороо баг, хорины ардын хурлын депутатуудыг сонгох сонгууль явагдсан. Орон нутгийн ардын хурлын депутатуудыг сонгох 16 удаагийн сонгууль болсон байна.

**БНМАУ-ын сум, хороо, район, орон нутгийн хотын Ардын Депутатуудын  
Хурлын сонгууль явагдсан он дараалал**

<b>Орон нутгийн АДХ-ын ээлжит сонгууль</b>	<b>Сонгууль явагдсан он</b>	<b>Бүрэн эрхийн хугацаа</b>
1 дэх удаагийн	1952	2 жил
2 дахь удаагийн	1954	2 жил
3 дахь удаагийн	1956	3 жил
4 дэх удаагийн	1959	2 жил
5 дахь удаагийн	1961	2 жил
6 дахь удаагийн	1963	2 жил
7 дахь удаагийн	1965	2 жил
8 дахь удаагийн	1967	2 жил
9 дэх удаагийн	1969	3 жил
10 дахь удаагийн	1972	3 жил
11 дэх удаагийн	1975	3 жил
12 дахь удаагийн	1978	3 жил
13 дахь удаагийн	1981	3 жил
14 дахь удаагийн	1984	3 жил
15 дахь удаагийн	1987	3 жил
16 дахь удаагийн	1990	АИХ-ын сонгуультай хамт явагдсан.

БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн дагуу АИХ-ыг 5 жилийн хугацаагаар, орон нутгийн АДХ-ыг 3 жилийн хугацаагаар сонгохоор хуульчилсан боловч сонгууль энэ хугацаанд явагдаагүй зарим тохиолдол байна. Тухайлбал, 1952-1967 онуудад 2 жилийн давтамжтай явагджээ.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1969 оны 144 дугаар зарлигаар АИХ-ыг 4 жилийн хугацаагаар орон нутгийн АДХ-ыг 3 жилийн хугацаагаар сонгож байхаар тогтоожээ.

\* \* \*

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- БНМАУ-ын Үндсэн хууль. 1940 он
- БНМАУ-ын Үндсэн хууль. 1960 он
- БНМАУ-ын Есдүгээр Их Хурлын илтгэл, хууль, тогтоолууд. Улаанбаатар, 1949 он
- БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987
- БНМАУ-ын сум, хороо, район, орон нутгийн хотын АДХ-ын хууль. УБ., 1978 он
- Зарим хууль тогтоолын эмхтгэл. УБ., 1970 он
- Дашням И. БНМАУ-ын сонгуулийн систем. УБ., 1975 он
- Дашням И. БНМАУ-ын төрийн эрх барих байгууллагууд. УБ., 1978 он
- Готов Ц. БНМАУ-ын Ардын Их Хурал. УБ., 1981 он
- Жамбал Ч. Орон нутгийн Ардын Депутатуудын Хурлын бүрэн эрх. УБ., 1987 он
- Амарсанаа Ж. БНМАУ-ын төрийн эрх зүй. УБ., 1988 он
- БНМАУ-ын түүхийн зарим нэр томъёо, он цагийн тайлбар толь. УБ., 1991 он
- Болдбаатар Ж., Лүндээжанцан Д. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 2011 он
- Жавзансүрэн М. Монгол төрийн түүхэн дэх Ардын Их Хурал. УБ., 2013 он

## ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ ЯВУУЛАХ ХУГАЦААНЫ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

*Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч (PhD), Б.Ариунжаргал,  
И.Жаргалзаяабямба, Ө.Мөнхтунгалаг,  
Ч.Онончимэг, Д.Халиун, Ц.Элбэгзаяа*

Судалгаанд нийт 43 орныг хамруулан авч үзсэн бөгөөд орон нутгийн сонгууль явуулах хугацааны хувьд улс орон бүр харилцан адилгүй байна.

*Орон нутгийн сонгуулийг явуулах хугацаагаар нь авч үзвэл:*

- 2 жилийн хугацаатай явуулдаг - 1 улс /Литва/;
- 3 жилийн хугацаатай явуудаг - 6 улс /Азербайжан, Албани, Малайз, Мальдив, Шинэ Зеланд, Эстони/;
- 4 жилийн хугацаатай явуулдаг - 25 улс;
- 5 жилийн хугацаатай явуулдаг - 7 улс;
- 6 жилийн хугацаатай явуулдаг - 3 улс байна.

Холбооны зарим улсын хувьд хугацааны хувьд харилцан адилгүй бөгөөд Канадын хувьд мужууд нь 1-4 жилийн хугацаатайгаар орон нутгийн сонгуулийг явуулдаг байна.

Орон нутгийн захирагчийн хувьд сонгодог эсхүл томилдог хэлбэрээр авч үзвэл дийлэнх улсын хувьд томилох бөгөөд тодорхой хугацааг хуульдаа тусгаагүй байна.

№	Улс	Орон нутгийн сонгууль явагдах хугацаа	Хуулийн зохицуулалт
1	Австри	5 жил. Зөвхөн Дээд-Австрид 6 жил.	<ul style="list-style-type: none"> <li>Европын Засаг дарга нар-Mayors in Europe 5 буюу 6 жил. Шууд буюу шууд бус сонгогдоно.</li> </ul> Бүрэн эрхийн хугацаа – Legislaturperiode <a href="http://www.citymayors.com/government/europe_mayors.html">http://www.citymayors.com/government/europe_mayors.html</a>
2	Австрали	4 жил	<p>Орон нутгийн засаг захиргааны тухай хууль” 2007 оны нэмэлт өөрчлөлт, 13 бүлэг, 5.1</p> <ul style="list-style-type: none"> <li>орон нутгийн сонгуулийн хугацаа нь 4 жил байна гэжээ.</li> </ul> <p>Орон нутгийн засаг захиргааны тухай хууль” 2007 оны нэмэлт өөрчлөлт, 13 бүлгийн 2-т</p> <ul style="list-style-type: none"> <li>сайд 3 хүний бүрэлдхүүнтэй зөвлөлийн ахлах ба гишүүдийг томилох ба 4 жил үргэлжилнэ.</li> <li>Нийт Австралийн 6 мужид 695 зөвлөлийн захирагчийн хугацаа: 1 болон 4 жилийн хооронд өөр өөр байдаг.</li> </ul>
3	Азербайжан	5 жил	<p>Үндсэн хууль</p> <ul style="list-style-type: none"> <li>142-р зүйл. Орон нутаг, хот, тосгон болон сууринд нутгийн удирдлагыг сонгуулиар сонгогдсон нутгийн захиргаа /муниципалитет/-гаар дамжуулах хэрэгжүүлнэ.</li> <li>158-р зүйл. Үндсэн хуулийг батлагдсанаас хойш 2 жилийн дотор Нутгийн өөрөө удирдах ёсны тухай хуулийг баталж, орон нутгийн захиргааны сонгуулийг явуулна.</li> </ul> <p>Нутгийн захиргааны эрх зүйн байдлын тухай хууль</p> <ul style="list-style-type: none"> <li>20 зүйл. Нутгийн захиргааны гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил байна.</li> </ul>

4	<b>Албани</b>	3 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>108-р зүйл, Нутгийн удирдлагын анхан шатны нэгж нь коммун, муниципалитет, тойрог байна.</li> <li>109-р зүйл, Нутгийн удирдлагын үндсэн нэгжүүдийн төлөөллийн байгууллага нь Зөвлөл байх бөгөөд Зөвлөлийг 3 жил тутам бүх нийтийн шууд сонгуулиар нууцаар санал хурааж сонгоно.</li> <li>Муниципалитет, коммунуны гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг энэ зүйлийн 1 дүгээр параграфд заасан процедураар бүх иргэд сонгоно.</li> </ul>
5	<b>Армен</b>	4 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>107-р зүйл. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь 4 жилийн хугацаагаар бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгогдсон нутгийн захиргааны зөвлөл болон нутгийн зөвлөлийн даргаас бүрдэнэ.</li> </ul>
6	<b>Бангладеш</b>	5 жил	<p><i>Орон нутгийн Засгийн газрын тухай “хуулийн 1.1</i></p> <ul style="list-style-type: none"> <li>орон нутгийн сонгуулийн хугацаа 5 жил байна.</li> </ul> <p><i>“Орон нутгийн Засгийн газрын тухай “хуулийн 4.1</i></p> <ul style="list-style-type: none"> <li>Холбооны Паришард засаг дарга гэж нэрлэх ба Шадар комиссар томилно.</li> <li>Бангладешийн 493 дэд дүүрэг, 64 дүүргийн 6 хотын албан захирагч нь 5 жилийн хугацаатай, шууд бусаар сонгогдоно.</li> </ul>
7	<b>Беларусь</b>	4 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>118-р зүйл. Орон нутгийн депутатуудын зөвлөлийг тухайн нутаг дэвсгэрийн иргэд 4 жилийн хугацаагаар сонгоно.</li> <li>119-р зүйл. Орон нутгийн гүйцэтгэх болон зохион байгуулах байгууллагуудын удирдлагыг Бүгд Найрамдах Улсын ерөнхийлөгч томилж чөлөөлнө, эсхүл ерөнхийлөгчийн тогтоосон журмын дагуу харгалзах орон нутгийн депутатуудын зөвлөл албан тушаалд нь батална.</li> </ul>
8	<b>Бельги</b>	6 жил	<p><i>Бельгийн орон нутгийн сонгуулийн тухай хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>Засаг даргыг сонгохгүй, харин Засгийн газар нь сонгогдсон орон нутгийн Консулуудаас нэгийг нь томилно.</li> </ul>

9	<b>Болгар</b>	4 жил  4 жил тутамд парламентын болон орон нутгийн сонгууль нэг өдөр явагддаг.	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>138-р зүйл. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь орон нутгийн зөвлөл бөгөөд орон нутгийн иргэдээс 4 жилийн хугацаагаар сонгоно.</li> <li>139-р зүйл. Нутгийн гүйцэтгэх эрх мэдлийг Кмет хэрэгжүүлнэ. Кметийг орон нутгийн иргэд, эсхүл нэгдлийн зөвлөлөөс 4 жилийн хугацаагаар сонгоно. Кмет нь орон нутгийн иргэд, нэгдлийн шийдвэр, хуулийг хэрэгжүүлнэ.</li> </ul> <p><i>Үндэсний Ассемблейн гишүүдийг сонгох тухай хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>1-р зүйл. Энэхүү хууль нь Болгар улсын Үндэсний Ассемблейн гишүүд болон орон нутгийн захирагч, дарга нарыг сонгох харилцааг зохицуулна.</li> <li>4-р зүйл. Сонгогч нь нэг саналыг Үндэсний Ассемблейн гишүүнд, нэг саналыг орон нутгийн захиргааны зөвлөлийн гишүүнд, нэг саналыг орон нутгийн захирагчид, нэг саналыг дүүргийн захирагчид өгнө.</li> </ul>
10	<b>Герман</b>	5 жил.  Зөвхөн Брэмэнд 4 жил байна.	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн сонгуулийг V сарын 10-наас XI сарын 20-ны хооронд явуулахыг Дотоод Яам товлон.</li> <li>Европын Парламент дахь ХБНГУ-ын депутатыг сонгох өдөр санал хураалт явуулж болно.</li> </ul> <p><i>Бадэн-Вюртэмберг муж улсын Орон нутгийн сонгуулийн тухай хууль, зүйл 38 а</i></p> <ul style="list-style-type: none"> <li>Засаг даргын сонгуулийг Европын Парламент, Бундэстаг, Мужийн Парламент, Бүсийн хурал, Тойргийн зөвлөл, Тосгоны зөвлөл, Дүүргийн зөвлөл, эсвэл Бүх нийтийн санал асуулгын өдөр явуулна.</li> <li>Засаг даргыг зарим муж улсад иргэд (шууд), заримд нь Орон нутгийн удирдлагын зөвлөл (шууд бус)-ийг 5-9 жилийн хугацаатайгаар сонгоно.</li> </ul>
11	<b>Гүрж</b>	4 жил	<p><i>Нутгийн өөрийн удирдлагын тухай хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>Нутгийн өөрийн удирдлагын төлөөллийн байгууллага- сакребулогийн гишүүдийг тухайн нутаг дэвсгэрт оршин суудаг Гүржийн иргэд Гүрж улсын хууль тогтоомжоор тогтоогдсон журмын дагуу бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийн зарчимд үндэслэсэн нууц санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгоно.</li> <li>Нутгийн захиргааны тэргүүн - гамгебели болон өөрийн удирдлагат хотуудын мэрийг сакребуло зөвшөөрснөөр сакребулогийн дарга томилж, чөлөөлнө.</li> </ul>
12	<b>Ирланд</b>	5 жил	<ul style="list-style-type: none"> <li>Европын Засаг дарга нар - Засаг даргыг Зөвлөлийн гишүүд дундаас 1 жилийн хугацаагаар томило.</li> </ul>

13	<b>Испани</b>	4 жил	<p>Үндсэн хуулийн 140.1, 141 дүгээр зүйл; Сонгуулийн ерөнхий тогтолцоо органик хууль 5/1985;</p> <ul style="list-style-type: none"> <li>• 3 түвшний сонгуультай:</li> <li>- Үндэсний түвшний сонгууль (Конгресс),</li> <li>- Өөртөө засах орны сонгууль (17 өөртөө засах коммунийн хууль тогтоох байгууллагыг сонгох),</li> <li>- Орон нутгийн түвшний сонгууль</li> <li>• Испани улсын орон нутгийн сонгууль нь 4 жил тутамд явагддаг ба ойролцоогоор 66,000 орчим төлөөлөгчид сонгогддог байна.</li> <li>• Зөвлөлийн сонгуулийн намын жагсаалтын ахлагч нь 4 жилийн хугацаатай сонгогдоно.</li> </ul>
14	<b>Итали</b>	5 жил	<p>Үндсэн хууль</p> <ul style="list-style-type: none"> <li>• 121-р зүйл. Мужийн байгууллагууд нь мужийн зөвлөл, жунт, жунтын дарга байна. Мужийн зөвлөл нь Үндсэн хууль ба бусад хуулиар мужид оногдсон эрх мэдлийн хүрээнд хууль тогтоох мэдлийг хэрэгжүүлнэ. Жунт нь мужийн гүйцэтгэх байгууллага байна. Жунтын дарга мужийг удирдаж, хариуцлага хүлээнэ.</li> <li>• 122-р зүйл. Мужийн жунтын дарга, гишүүд болон мужийн зөвлөлийн гишүүдийг сонгох сонгуулийн систем, сонгуульт байгууллагын бүрэн эрхийн хугацааг Бүгд Найрамдах улсын хуулиар тогтоогдсон үндсэн зарчмын хүрээнд мужийн хуулиар тогтооно.</li> <li>• 5 жил. Шууд сонгогдоно.</li> </ul>
15	<b>Канад</b>	1-4 жил  Мужаас хамаарч харилцан адилгүй хугацаанд орон нутгийн сонгууль явагдана	<p>“Орон нутгийн Засгийн газрын тухай хууль”, 1996</p> <ul style="list-style-type: none"> <li>• Канадын орон нутгийн сонгууль нь аймаг, нутаг дэвсгэрийн харьяалалаас хамааран 1, 2, 3, 4 жилийн хугацаатай байна. Жишээ нь:</li> <li>• Британи Колумб- 4 жил,</li> <li>Нунавит Хамлетс- 1 жил</li> <li>Баруун хойд нутаг Хамлетс- 2 жил</li> <li>Онтарио- 4 жил,</li> <li>Нова Скотиа- 4 жил,</li> <li>Квэбэк- 4 жил байна.</li> <li>• Канад улсад Хатан хааны төлөөлөл нь Засгийн газрын Холбооны болон орон нутгийн түвшинд засаг дарга байна.</li> <li>• Ерөнхий сайдын зөвлөснөөр хатан хаан томилсон байна.</li> </ul>
16	<b>Казахстан</b>	4 жил	<p>Үндсэн хууль</p> <ul style="list-style-type: none"> <li>• 87-р зүйл. Казахстаны Maslikhats орон нутгийн сонгууль (орон нутгийн байгууллага) 4 жилд нэг удаа явагддаг. Казахстаны томоохон хот, муж, дүүргийн даргыг Аким гэх ба Ерөнхий сайд санал болгосноор Улсын ерөнхийлөгчийн томилно. Ерөнхийлөгч нутаг дэвсгэрийн нэгжийн Акимын томилогдох хугацааг тогтооно.</li> </ul>



17	Кыргызстан	4 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>90-р зүйл, 1/ Нутгийн өөрийн удирдлагыг харгалзах Кенешүүд хэрэгжүүлнэ. 2/ Нутгийн Кенешийг тухайн нутаг дэвсгэрийн нэгжид оршин суудаг БНКУ-ын иргэд бүх нийтийн, шууд сонгуулийн зарчмаар нууц санал хураалтаар, хуулиар тогтоосон журмын дагуу сонгоно.</li> <li>76-р зүйл 2/ Нутгийн төрийн захиргааны байгууллагын тэргүүнийг хуулиар тогтоосон журмаар томилж, чөлөөлнө.</li> </ul> <p><i>Нутгийн өөрийн удирдлагын тухай хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>21-р зүйл: 1/ Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллага – Нутгийн Кенешийг энэ хууль, Сонгуулийн тухай хууль болон нутгийн Кенешийн депутатуудын эрх зүйн байдлын тухай хуулиудыг үндэслэн 4 жилийн хугацаагаар сонгоно.</li> </ul> <p><i>БНКУ-д дараах нутгийн Кенеш байна:</i></p> <p>а) айылын кенеш – айылын аймаг дахь нутгийн өөрийн удирдлагын төлөөллийн байгууллага;</p> <p>б) хотын кенеш – хотын нутгийн өөрийн удирдлагын төлөөллийн байгууллага;</p> <p>3. Нутгийн кенешүүд бүх нийтийн, шууд сонгуулийн зарчмаар нууц санал хураалтаар сонгогдох депутатуудаас бүрдэнэ. Нутгийн кенешүүдийн депутатын сонгуулийг явуулах журмыг хуулиар тогтооно.</p> <ul style="list-style-type: none"> <li>49-р зүйл. Айыл окмоту-ийн даргыг айылын кенеш айылын кенешийн депутатуудаас нэр дэвшүүлж, районы төрийн захиргааны байгууллагын тэргүүн – акимд танилцуулсан нэр дэвшигчдээс тухайн кенешийн бүрэн эрхийн хугацаагаар сонгоно.</li> </ul>
18	Люксембург	6 жил	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн сонгууль 6 жилийн хугацаатай байх ба Мэр нь шууд бус сонгогдох ба орон нутгийн санал болгосноор Засгийн газар томилно.</li> </ul> <p><a href="http://www.citymayors.com/government/europe_mayors.html">http://www.citymayors.com/government/europe_mayors.html</a></p>
19	Литва	2 жил	<p><i>Нутгийн өөрийн удирдлагын тухай хууль 1994.</i></p> <ul style="list-style-type: none"> <li>5-р зүйл. Зөвлөлийн гишүүдийг тухайн хотын захиргааны оршин суугчид хоёр жилийн хугацаагаар сонгох бөгөөд Литва улсын иргэнийг бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгоно.</li> </ul>
20	Латви	4 жил	<p><i>Хот, тосгоны зөвлөл болон орон нутгийн /Pagasts/ Зөвлөлийн сонгуулийн тухай хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>1-р зүйл. Хот, тосгон, дүүрэг, орон нутгийн зөвлөлийг 4 жил тутамд ардчилсан, тэгш, шууд, нууц зарчмаар хувь тэнцүүлэх сонгуулийн хэлбэрээр сонгоно.</li> </ul>

21	<b>Нидерланд</b>	4 жил	<ul style="list-style-type: none"> <li>Засаг даргыг Хатан хаан буюу Дотоод хэргийн сайд 6 жилээр томилно.</li> </ul> <a href="https://www.vile-netzwerk.de/niederlande/articles/niederlande-staat-und-regierung.html">https://www.vile-netzwerk.de/niederlande/articles/niederlande-staat-und-regierung.html</a>
22	<b>Норвеги</b>	4 жил	<p>Орон нутгийн засаг захиргааны сонгуулийн хууль 1992.</p> <ul style="list-style-type: none"> <li>Бүрэн эрхийн хугацаа 4 жил байна. (7.1)</li> <li>Албан захирагчийг шууд бус зөвлөл томилно.</li> </ul>
23	<b>Малайз</b>	3 жил	<p>Орон нутгийн хууль 1976.</p> <ul style="list-style-type: none"> <li>10-р зүйл. Бүрэн эрхийн хугацаа 3 жил байна. Хотын захирагчийг томилдог.</li> </ul>
24	<b>Мальдив</b>	3 жил	<p>Үндсэн хууль 2008.</p> <ul style="list-style-type: none"> <li>2-р бүлэг VIII 231 (В). Зөвлөлийн хугацаанд сонгогдсон тойрог 3 жил байна. Дарга, дэд даргыг сонгогдсон зөвлөлийн гишүүд дундаас нууц санал хураалтаар сонгоно.</li> </ul>
25	<b>Молдова</b>	4 жил	<p>Сонгуулийн тухай хууль</p> <ul style="list-style-type: none"> <li>119-р зүйл. Хот, сектор, тосгоны примар (дарга) болон район, хот, сектор, тосгоны зөвлөлийн зөвлөхүүдийг бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийн зарчимд үндэслэсэн нууц, чөлөөт санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгоно.</li> </ul>
26	<b>Польш</b>	4 жил	<p>Үндсэн хууль</p> <ul style="list-style-type: none"> <li>164-р зүйл. Нутгийн өөрийн удирдлагын үндсэн нэгж нь гмина байна.</li> <li>169-р зүйл. Нутгийн өөрийн удирдлагын нэгж нь өөрийн зорилтыг шийдвэр гаргагч, гүйцэтгэгч байгууллагаараа дамжуулан хэрэгжүүлнэ.</li> <li>Шийдвэр гаргагч байгууллагын сонгуулийг бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар явуулна.</li> </ul> <p>Нутгийн өөрийн удирдлагын байгууллагын тухай хууль</p> <ul style="list-style-type: none"> <li>Зүйл 16. 5. Гминий зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа нь сонгуулиас хойш 4 жил байна.</li> <li>Зүйл 26. 1. Гминий удирдах байгууллага нь Гүйцэтгэх хороо байна. Хотын мэр Гүйцэтгэх хорооны дарга байна.</li> <li>Зүйл 28. 1. Гминий зөвлөл Гүйцэтгэх хороог 3-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр өөрийн бүрэлдэхүүнээс юмуу гаднаас сонгоно.</li> </ul>

27	<b>Румын</b>	4 жил	<p><i>Law on Local public administration 2001.</i></p> <ul style="list-style-type: none"> <li>Хэсэг 1. Орон нутгийн зөвлөлийг орон нутгийн сонгуулийн тухай хуульд заасны дагуу бүх нийтийн тэгш, шууд, нууц, чөлөөтэй сонгох эрхийн үндсэн дээр сонгоно.</li> <li>Хэсэг 2. 20.2.а. Орон нутгийн зөвлөл нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд зөвлөлийн гишүүд дундаас хотын дарга болон орлогчийг сонгоно.</li> </ul> <p><i>Орон нутгийн сонгуулийн тухай хууль</i></p> <p>Хэсэг 3.</p> <ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн зөвлөл нь 4 жилийн хугацаанд сонгогдох бөгөөд дайны болон гамшгийн үед үндсэн хуульд заасны дагуу хугацааг сунгаж болно.</li> <li>Хуулийн дагуу бүрдүүлсэн зөвлөл нь чуулганы хугацаанд энгийн олонхын саналаар зөвлөлийн даргыг сонгоно.</li> </ul>
28	<b>Серби</b>	4 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>180-р зүйл. Автономит муж болон нутгийн өөрөө удирдах байгууллагын чуулган Автономит муж болон нутгийн өөрөө удирдах байгууллагын дээд шатны байгууллага нь Чуулган байна. Чуулган нь депутатуудаас бүрдэх бөгөөд нутгийн өөрийн удирдах байгууллагын чуулган нь зөвлөлийн гишүүдээс бүрдэнэ. Депутат болон зөвлөлийн гишүүдийг 4 жилийн хугацаагаар шууд, нууц сонгуулиар сонгоно.</li> </ul>
29	<b>Сингапур</b>	-	<ul style="list-style-type: none"> <li>Сингапур улс нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд муж, аймаг зэрэг нэгжид хуваагддаггүй. 2001 оноос хойш засаг даргаар даргалуулсан 5 дүүрэгт хуваагдаж байгаа бөгөөд Нэгдлийн хөгжлийн зөвлөл буюу Community Development council нь орон нутгийн захиргааны зарим чиг үүргийг хэрэгжүүлдэг. Нэгдлийн хөгжлийн зөвлөл тусбүр 12-80 гишүүн бүхий Зөвлөлтэй байх бөгөөд засаг дарга даргална. Зөвлөлийн гишүүдийг Ардын холбооны дарга, эсхүл дэд дарга томилно.</li> </ul> <p><a href="http://app.sgdi.gov.sg/listing_others.asp?category=COM_DEV_CENTRES">http://app.sgdi.gov.sg/listing_others.asp?category=COM_DEV_CENTRES</a></p>
30	<b>Словени</b>	4 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>138-142-р зүйлээр нутгийн өөрөө удирдах асуудлыг зохицуулсан. Нутгийн удирдлага нь нутгийн захиргааны зөвлөл, мэр болон хяналтын хорооноос бүрдэнэ.</li> </ul> <p><i>Нутгийн өөрийн удирдлагын тухай хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>37-р зүйл. Нутгийн захиргааны зөвлөлийг шууд, нууц санал хураалтаар сонгоно.</li> <li>41-р зүйл. Нутгийн захиргааны зөвлөлийн гишүүдийг 4 жилийн хугацаагаар сонгоно.</li> <li>42-р зүйл. Мэрийг нутгийн оршин суугчдын шууд, нууц сонгуулиар сонгоно. Мэрийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.</li> </ul>

31	<b>Словак</b>	4 жил	<p><i>Үндсэн хууль</i> IV бүлэг. Нутгийн өөрийн удирдлага</p> <p>Зүйл 69. Обецийн байгууллагууд нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>а) Обецийн төлөөлөл</li> <li>б) обецийн ахлагч байна.</li> <li>3. Обецийн төлөөлөл нь депутатуудаас бүрдэнэ. Депутатуудыг тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугчид 4 жилийн хугацаагаар сонгоно. Депутатуудын сонгууль нь бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар явагдана.</li> <li>4. Обецийн ахлагчийг тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугчид бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар 4 жилээр сонгоно.</li> <li>Илүү дээд түвшний нутаг дэвсгэрийн нэгжийн байгууллагууд нь: <ul style="list-style-type: none"> <li>а) Илүү дээд түвшний нутаг дэвсгэрийн нэгжийн төлөөлөгчид</li> <li>б) Илүү дээд түвшний нутаг дэвсгэрийн нэгжийн дарга байна.</li> </ul> </li> <li>5. Илүү дээд түвшний нутаг дэвсгэрийн нэгжийн төлөөлөл депутатуудаас бүрдэнэ. Депутатуудыг тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугчид 4 жилийн хугацаагаар сонгоно. Депутатуудын сонгууль нь бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар явагдана.</li> <li>6. Илүү дээд түвшний нутаг дэвсгэрийн нэгжийн даргыг тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суугчид бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар 4 жилээр сонгоно.</li> </ul>
32	<b>Солонгос</b>	4 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>117-р зүйл. Нутгийн захиргааны байгууллага нь нутгийн иргэдийн эрх ашигтай холбоотой үүргийг хэрэгжүүлэх, орон нутгийн төсөв захиран зарцуулах, хууль тогтоомжийн хүрээнд орон нутагт мөрдөгдөх эрх зүйн акт гаргаж болно. Нутгийн захиргааны байгууллагын бүтцийг хуулиар тогтооно.</li> <li>Зүйл 118. Нутгийн захиргааны байгууллагад Иргэдийн төлөөлөгчдийн хурал байна. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүтэц, эрх мэдлийн хүрээ, төлөөлөгч сонгох ба Засаг дарга томилох, нутгийн захиргааны байгууллагын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.</li> </ul>
33	<b>Тайвань</b>	4 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>113-р зүйл. (1) Провинцийн өөрийн удирдлагын байгууллагууд нь: Провинцийн ассамблей; Провинцийн ассамблейн гишүүдийг тухайн провинцийн иргэд сонгоно. Провинцийн Засгийн газар ба Провинцийн губернатор; Провинцийн губернаторыг тухайн провинцийн иргэд сонгоно.</li> </ul> <p><i>Нутгийн өөрийн удирдлагын тухай хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>Провинцийн ассамблейн гишүүд болон Провинцийн губернаторыг хоёр 4 жилээр (4+4) сонгоно.</li> </ul>

34	<b>Турк</b>	5 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>127-р зүйл. Орон нутгийн захиргаа нь муж, хотын дүүрэг болон тосгоны оршин суугчдын эрх ашгийг хангаж, хамгаалах зорилго бүхий нутгийн иргэдээс сонгогдсон шийдвэр гаргах эрх бүхий байгууллага байна. Орон нутгийн захиргааны сонгуулийг 5 жил тутам бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгоно. Гэхдээ орон нутгийн захиргааны байгууллагын ерөнхий болон нөхөн сонгууль нь Үндэсний Их Хурал /Парламент/-ын ээлжит болон нөхөн сонгуулиас нэг жилийн өмнө, эсхүл хойно явагдах бол орон нутгийн сонгуулийг Үндэсний Их Хурлын сонгуультай зэрэг явуулна.</li> </ul>
35	<b>Украин</b>	4 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>141-р зүйл. Тосгон, суурин, хотын зөвлөлийн депутатуудыг тухайн тосгон, суурин, хотын оршин суугчид бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийн зарчмаар нууц санал хураалтаар 4 жилийн хугацаагаар сонгоно.</li> <li>Нутаг дэвсгэрийн громада (нийт иргэдийн хурал) бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийн зарчмын үндсэн дээр нууц санал хураалтаар харгалзах тосгон, суурин, хотын даргыг сонгоно. Дарга нь Зөвлөлийн гүйцэтгэх байгууллагыг толгойлно.</li> </ul>
36	<b>Унгар</b>	4 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>Бүлэг IX. Зүйл 44. 2) Нутгийн төлөөллийн байгууллагын гишүүд болон захирагчдын сонгуулийг өмнөх бүх нийтийн сонгууль явагдсанаас хойш 4 дэх жилийн 10 дугаар сард явуулна.</li> </ul>
37	<b>Финлянд</b>	4 жил	<p><i>Нутгийн захиргааны байгууллагын тухай хууль (1995).</i></p> <ul style="list-style-type: none"> <li>Бүлэг 2-Орон нутгийн зөвлөл, Хэсэг 9 (1) Орон нутгийн зөвлөлийн гишүүдийг орон нутгийн сонгуулиар нь тухайн нутгийн иргэд 4 жил тутам сонгоно. Орон нутгийн сонгуулиар Зөвлөлийн гишүүдийг шууд пропорциональ, нууц санал хураалтаар сонгоно.</li> <li>24.1. Мэр нь 4 жилийн хугацаатай орон нутгийн зөвлөлөөс шууд бусаар сонгогдоно. Мэр нь төрийн албан хаагч байна.</li> </ul>

38	<b>Франц</b>	6 жил	<p><i>Үндсэн хуулийн 72-р зүйл.</i>  <i>Нутгийн удирдлагын тухай хууль.</i></p> <ul style="list-style-type: none"> <li>Засаг захиргааны нэгж нь 4 шатлалтай. Засгийн газар - Бүсийн удирдлага (region) - мужийн удирдлага (department) - хот тосгоны удирдлага (commune)</li> <li>Анхан шатны нэгж хот тосгон - Коммуны зөвлөл байна. Тус зөвлөлөөс тухайн засаг захиргааны нэгжид гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх захирагч буюу мэрийг сонгоно. Зөвлөлийн гишүүдийг орон нутгийн чөлөөт сонгуулиар 6 жилийн хугацаатай явуулна. 3 жил тутамд гишүүдийн 50 хувийг шинээр сонгодог. Зөвлөлөөс сонгогдсон захирагч зөвлөлийн дарга болон гүйцэтгэх эрх мэдлийг давхар хэрэгжүүлнэ.</li> <li>Мужийн өөрийн удирдлага - Мужийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг сонгуулийн насны оршин суугчдын ердийн олонхын саналаар 6 жилийн хугацаатай сонгоно. 3 жил тутамд гишүүдийн 50 хувийг шинээр сонгодог. Мужийн гүйцэтгэх засаглалыг зөвлөлийн дарга хэрэгжүүлнэ.</li> <li>Бүсийн өөрийн удирдлага - Бүсийн зөвлөл хурлын төлөөлөгчдийг 6 жилийн хугацаатайгаар сонгоно. Бүсийн зөвлөлийн дарга тухайн засаг захиргааны нэгжид гүйцэтгэх эрх мэдлийг давхар хэрэгжүүлнэ.</li> </ul>
39	<b>Хорват</b>	4 жил	<p><i>Орон нутаг болон бүс нутгийн өөрийн удирдлагын байгууллагын төлөөлөгчдийн сонгуулийн тухай хууль 2001</i></p> <ul style="list-style-type: none"> <li>4 -р зүйл. Ээлжит сонгууль 4 жил тутам 5 дугаар сарын 3 дахь долоо хоногийн бүтэн сайн өдөр нууц санал хураалтаар сонгоно.</li> <li>Хотын мэр болон мужийн захирагчийг төлөөлөгчдийн байгууллага гишүүдийн олонхын саналаар сонгодог.</li> </ul>
40	<b>Чех</b>	4 жил	<p><i>Үндсэн хууль</i></p> <ul style="list-style-type: none"> <li>Зүйл 102. (1) Нутаг дэвсгэрийн анхан шатны болон илүү дээд шатны нэгжүүдийн төлөөллийн байгууллагын гишүүдийг бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгоно.</li> <li>(2) Төлөөллийн байгууллагын гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна.</li> </ul>
41	<b>Шинэ Зеланд</b>	3 жил	<p><i>Орон нутгийн засаг захиргааны хууль 2002.</i></p> <ul style="list-style-type: none"> <li>3-р зүйл. Бүрэн эрхийн хугацаа 3 жил байна.</li> <li>57.2-р зүйл. Ур чадвар, мэдлэг, туршлагыг харгалзан Амбан захирагчаар томилно.</li> </ul>
42	<b>Швейцарь</b>	4 жил. Зөвхөн 3 кантонд 5 жил.	<ul style="list-style-type: none"> <li>Орон нутаг өөрөө тогтооно. Гэвч Холбооны парламенттайгаа ижил 4 жил. Зөвхөн 3 Кантонд 5 жил.</li> <li>Европын Засаг дарга нар - Mayors in Europe Мөчлөг янз бүр. Шууд бусаар Зөвлөл сонгоно (Зөвлөлийн дарга нь Засаг даргын албыг хашдаг).</li> </ul> <p><a href="http://www.citymayors.com/government/europe_mayors.html">http://www.citymayors.com/government/europe_mayors.html</a></p>

43	<b>Эстони</b>	3 жил	<p><i>Үндсэн хуулийн 56-р зүйл.</i></p> <ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн захиргааны төлөөллийн байгууллага нь 3 жилийн хугацаанд чөлөөт сонгуулиар сонгогдсон консул байна. Сонгууль нь бүх нийтийн, шууд, тогтмол байна. Санал нууц байна.</li> <li>Орон нутгийн захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт байнга оршин суудаг, 18 нас хүрсэн хүн хуульд заасан нөхцөл журмаар орон нутгийн захиргааны байгууллагын консулын сонгуульд оролцоно.</li> </ul>
----	---------------	-------	---

\* \* \*

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [http://www.citymayors.com/government/europe\\_mayors.html](http://www.citymayors.com/government/europe_mayors.html)
- <http://www.municipalkg.narod.ru/interlaw/azer.htm>
- <http://ru.president.az/azerbaijan/constitution/>
- <http://www.mta.gov.am/ru/the-lsg/>
- <http://www.parliament.am/parliament.php?id=constitution&lang=rus>
- [http://www.vks.bg/english/vksen\\_p04\\_01.htm](http://www.vks.bg/english/vksen_p04_01.htm)
- <http://www.landesrecht-bw.de/jportal/?quelle=jlink&query=KomWG+BW&psml=bsbawueprod.psml&max=true&aiz=true>
- [http://www.citymayors.com/government/europe\\_mayors.html](http://www.citymayors.com/government/europe_mayors.html)
- <http://www.guichet.public.lu/citoyens/de/citoyennete/elections/elections-communales/candidat-elections-communales/>
- <http://www.litlex.lt/Litlex/eng/Frames/Laws/Documents/167.HTM>
- <http://www.legislationline.org/documents/action/popup/id/4912>
- <https://www.vile-netzwerk.de/niederlande/articles/niederlande-staat-und-regierung.html>
- [www.legislationline.org/documents/id/4405](http://www.legislationline.org/documents/id/4405)
- <http://www.cdep.ro/legislatie/eng/vol46eng.pdf>
- [http://app.sgdi.gov.sg/listing\\_others.asp?t\\_category=COM\\_DEV\\_CENTRES](http://app.sgdi.gov.sg/listing_others.asp?t_category=COM_DEV_CENTRES)
- <http://www.lenobl.ru/Document/1412700085.pdf>
- <https://www.constituteproject.org/constitution>
- <http://www.finlex.fi/en>
- <http://www.finlex.fi/fi/laki/kaannokset/1995/en19950365.pdf>
- <http://www.legislationline.org/documents/id/5847>
- <https://www.riigiteataja.ee/en/eli/530102013003/consolide>
- [www.lexadin.nl](http://www.lexadin.nl)

**ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ПАРЛАМЕНТЫН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА**

*Г.Алтан-Оч (PhD), Б.Ариунжаргал, И.Жаргалзаяабямба,  
Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, О.Нарантуяа,  
Ч.Онончимэг, А.Пагма, Д.Халиун, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа*

Нэг. Дэлхийн 187 орны Парламентын бүрэн эрхийн хугацааг<sup>76</sup> хүснэгт 1-ээр харуулав.

*Хүснэгт*

<b>Хугацаа</b>	<b>Улсын тоо</b>	<b>Улс орнууд</b>
6 жил	5	Египет,* Йемен,* Либери,* Шри-ланк, Марокко.*
5 жил	94	Азербайжан, Алжир,* Антигуа ба Барбуда, Армен, Афганистан,* Бангладеш, Барбадос, Белиз, Боливи, Бостван, Брукино-Фасо, Бурунди, Бутан, Венесуэл, Вьетнам, Габон,* Гайана, Гамби, Гренада, Доминика, Жибути, Замби, Зимбабве, Зүүн Тимор, Индонез, Ирланд, Итали, Их Британи Вант улс,* Кабо-Верде, Казакстан,* Камбож,* Камерун, Кени, Кипр, Коморын арлууд, Конго (БНАКУ), Конго,* Кот-д Ивуар, Куба, Кыргызстан, Лаос, Лесото, Люксембург, Маврикий, Мавритани*, Маливи, Малайз,* Мали, Мальдив, Мальта, Мозамбек, Монако, Мьянмар, Намиби,* Нигер, Никарагуа, Өмнөд Африкийн БНУлс, Пакистан,* Панам, Папуа-Шинэ Гвиней, Парагвай, Перу, Руанда,* Самоа, Сан-Марино, Свазиланд, Сейшеллийн арлууд, Сенегал, Сент-Винсент ба Гренадин, Сент-Китс ба Невис, Сент-Люси, Сингапур, Солонгос (БНАСАУ), Сомали, Судан, Суринам, Сьерра-Леон, Тажикистан, Танзан, Того, Төв Африкийн БНУлс, Тринидад ба Тобаго, Тувалу, Тунис,* Туркменистан, Уганда, Узбекистан, Украин, Уругвай, Фижи, Франц*, Хятад, Экваторын Гвиней, Энэтхэг,* Этиоп, Ямайка.
4 жил	76	Австри,* Албани, Ангол, Андора, АНУ,* Арабын Нэгдсэн Эмират Улс, Аргентин*, Бахрейн, Беларусь, Бельги, Бенин, Болгари, Босни Герцеговин, Бразил,* Вануату, Гаити,* Гана, Гвентемала, Гвиней-Биссау, Герман, Гондурас, Грек, Гүрж, Дани, Доминиканы БНУ, Израиль, Ирак, Иран, Исланд, Испани, Йордан, Канада,* Кирибати, Колумби, Коста-Рика, Кувейт, Латви, Ливан, Литва, Лихтенштейн, Мадагасгар, Македони, Маршаллын арлууд, Молдав, Монгол, Нигерия, Нидерланд, Норвеги Оман, ОХУ,* Палау, Польш, Португали, Румын, Сан-Томе ба Принсип, Саудын Араб, Серби, Сири, Словак, Словени,* Соломоны арал, Солонгос (БНСУ), Тайланд,* Турк, Унгар, Финланд, Хорват, Чад, Чех,* Чили,* Чрна Гора, Швед, Швейцарь, Эквадор, Эритрей, Эстони, Япон.*
3 жил	10	Австрали,* Катар, Ливи, Мексик,* Науру, Сальвадор, Тонга, Шинэ Зеланд, Филиппин.*
2 жил	2	Багамын арлууд, Микронез.

<sup>76</sup>Хоёр танхим бүхий парламенттай орны доод танхимын парламентын бүрэн эрхийн хугацааг авсан.

(\*) тэмдэглэсэн.



**ДЭЛХИЙН УЛС ОРНУУДАД 2015 ОНЫ 3-6 ДУГААР САРЫН ХООРОНД  
ЯВАГДСАН ПАРЛАМЕНТЫН БОЛОН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
СОНГУУЛИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА**

*Р.Хатанбаатар, А.Пагма, Д.Халиун*

2015 оны 3-6 дугаар сарын хооронд Парламентын сонгуулийг Их Британи, Израиль, Финлянд, Тувалу, Турк зэрэг 5 оронд явуулсан бол Ерөнхийлөгчийн сонгууль Польш, Казахстан, Того, Узбекистан, Нигери зэрэг 5 улсад явагдсан байна.

Казахстан улсын хувьд 2016 онд Ерөнхийлөгч болон Парламентын сонгууль нэг жил болох учраас хоёр сонгуулийг нэг жил явуулах нь сонгуулийн чанарт сөрөг нөлөөтэй гэж үзэж Казахстан улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг нэг жилээр урагшлуулж 2015 оны дөрөвдүгээр сарын 26-нд явуулсан байна. Польш улсад Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль 2015 оны 5 дугаар сарын 10-ны өдөр явагдсан бөгөөд аль ч нэр дэвшигч 50%-с дээш санал аваагүй тул 5 дугаар сарын 24-ны өдөр хоёр дахь шатны сонгуулийг явуулж төрийн тэргүүн Бронислав Коморовский ялагдаж, сөрөг хүчний намын нэр дэвшигч Анжей Дуда 51,55%-ийн саналаар ялалт байгуулсан.

**НЭГ. ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛЬ**

**1. Их Британийн** парламентын сонгууль 2015 оны 5 дугаар сарын 7-нд боллоо. Сонгуулийн дүнгээр Консерватив нам Төлөөлөгчдийн танхимд олонхын суудал авч, дангаараа Засгийн газар байгуулах боломжтой болжээ.

- Нийтийн танхимын суудлын тоо - 650
- Засгийн газар байгуулахад шаардагдах суудлын тоо - 326
- Сонгуулийн систем - мажоритар
- Нийт оролцсон намын тоо - 67
- Нийт нэр дэвшигчид - 3921
- Нийт сонгогчид - 46,425,386
- Сонгуулийн ирц - 66,1 %
- Нийт сонгогдсон гишүүдийн 29% буюу 191 нь эмэгтэй.

*Хүснэгт 1*

<b>№</b>	<b>Нам, намын дарга</b>	<b>Авсан саналын тоо, хувь</b>	<b>Төлөөлөгчдийн танхимд авсан суудлын тоо, хувь</b>
1	Консерватив нам Дэвид Камерон	11 334 920 (36,9%)	331 50.8%
2	Лейборист нам Эд Милибэнд	9 344 328 (30,4%)	232 35.7%
3	Шотландийн Үндэсний нам Никола Старжен	1 454 436 (4,7%)	56 8.6%
4	Либерал демократууд	2 415 888 (7,9%)	8 1.2%
5	Ардчилсан юнионист нам	184 260 (0,6%)	8 1.2%
6	Шинн Фейн	176 232 (0,6%)	4
7	Уэльсийн нам	181 694 (0,6%)	3

8	Социал демократ лейборист нам	99 809 (0,3%)	3
9	Ольстерийн юнионист нам	114 935 (0,4%)	2
10	Нэгдсэн вант улсын тусгаар тогтнолын нам	3 881 129 (12,6%)	1
11	Англи, Уэльсийн ногоон нам	1 157 613 (3,8%)	1
12	“Альянс” нам	61 556 (0,2%)	0
	Бусад		1

**2. Израильд** парламентын сонгуулийг пропорциональ системээр явуулдаг бөгөөд 3 хувийн босготой юм.

2015 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Израильд парламентын ээлжит бус сонгууль явагдаж Ерөнхий сайд Биньямин Нетаньяхугийн тэргүүлдэг эрх баригч “Ликуд” нам сонгогчдын 23,40 хувийн санал авч ялалт байгуулсан байна. “Ликуд” нам Кнессетийн 120 суудлаас 30 суудлыг авсан байна. Тус сонгуульд нийт 25 улс төрийн нам, эвсэл оролцсоноос дараах 10 нам, эвсэл Кнессетэд суудал авчээ.

Хүснэгт 2

№	Нам, эвсэл	Жагсаалтад өгсөн саналын тоо	Саналын хувь	Мандатын тоо
1	“Ликуд”	985,408	23,40	30
2	“Сионист лагерь”	786,313	18,67	24
3	“Нэгдсэн жагсаалт”	446,583	10,61	13
4	“Еш атид”	371,602	8,82	11
5	“Кулану”	315,360	7,49	10
6	“Байт Иегуди”	283,910	6,74	8
7	“ШАС”	241,613	5,74	7
8	“Бидний гэр Израйль”	214,906	5,10	6
9	“Яхадута-Тори”	210,143	4,99	6
10	“Мерец”	165,529	3,93	5

Энэ удаагийн парламентын сонгуулийн ирц 72,3 хувь байсан ба энэ нь 1999 оноос хойших хугацаанд явагдсан 6 удаагийн сонгуулийн хамгийн өндөр ирцтэй сонгууль болжээ.

Сар гаруй үргэлжилсэн яриа, хэлэлцээрийн дүнд Израйльд эвслийн засгийн газар байгуулагдсан.

**3. Финляндын** нэг танхимтай парламент (Eduskunta – Riksdagen)-ын сонгууль 2015 оны 4 дүгээр сарын 19-нд боллоо.

Парламентын 200 гишүүний 199-ийг нь олон мандаттай (6-33 суудал) 14 тойргоос пропорциональ системээр сонгоно. Аланд мужаас сонгогдох 1 гишүүнийг мажоритар системээр сонгоно.

- Нийт нэр дэвшигчдийн тоо - 2146
- Сонгуульд оролцсон нам - 16
- Парламентад суудал авсан нам - 8
- Засгийн газарт орсон намын тоо - 3, Төвийн нам (KESK), Финнийн нам ( Finns Party (PS), Үндэсний эвслийн нам (National Coalition Party (KOK))
- Нийт сонгогчид - 4221237
- Сонгуульд санал өгсөн - 2957163

Суудлын тоо:

Хүснэгт 3

№	Намын нэр	Суудлын тоо
1	Center Party (KESK)	49
2	The Finns Party (PS)	38
3	National Coalition Party (KOK)	37
4	Social Democratic Party (SDP)	34
5	Green League (Vihr)	15
6	Left Alliance (Vas)	12
7	Swedish People's Party (RKP)	9
8	Christian Democrats (KD)	5
9	Бусад	1

Сонгогдсон парламентын гишүүдээс:

- Эрэгтэй - 117
- Эмэгтэй - 83

**4. Тувалу** улсын парламентын сонгууль 2015 оны 3 дугаар сарын 31-нд болсон. Тус улсад намын систем байхгүй.

- Парламентын нийт суудлын тоо - 15
- Сонгуульд нэр дэвшигчид- 32
- Сонгуулийн систем - Мажоритар. 7 арлаас тус бүр 2, нэг арлаас 1 гишүүн сонгоно.

**5. Турк** улсын нэг танхимтай парламент Үндэсний Их Хурал (Grand National Assembly of Turkey)-ын сонгууль 2015 оны 6 дугаар сарын 7-нд явагдлаа. Өнөөдрийн байдлаар (2015.6.8) сонгуулийн эцсийн дүн гараагүй байна.

- Парламентын нийт суудлын тоо - 500
- Сонгуульд оролцсон намын тоо - 20
- Сонгуулийн систем - пропорциональ
- Парламентад суудал авах саналын босго - 10%

Сонгуулийн урьдчилсан дүн:

Хүснэгт 4

№	Намын нэр	Саналын тоо, хувь	Суудлын тоо
1	Шударга ёс, хөгжлийн нам	18,716,728(40,9%)	258
2	Бүгд найрамдах улсын ардын нам	11 467 332 (25,0%)	132
3	Үндэсний хөдөлгөөний нам	7 489 887 (16,3%)	80
4	Ард түмний ардчиллын нам	5,990,349 (13,1%)	80

Бусад намууд нь 10%-ийн босго даваагүй

## Хоёр. Ерөнхийлөгчийн сонгууль

Хүснэгт 5

№	Улс орон	Сонгууль яагадсан огноо, жил	Сонгуулийн тогтолцоо,	Нэр дэвшигчид	Нэр дэвшигчдийн авсан саналын тоо, хувь	Сонгуульд санал өгсөн сонгогчдын тоо
1	Польш /хоёр дахь шат/	2015-05-24 1990 1995 2000 2005 2010 2015	TRS  Two Round System буюу Хоёр шаттай тогтолцоо	Анжей Дуда Хууль, шударга ёс нам	8,630,627 51.55%	Сонгуульд санал өгсөн: 16,993,169 Хүчинтэй: 16,742,938 Хүчингүй: 250,231 Бүртгэгдсэн нийт сонгогчдын тоо: 30,709,281 Ирц: 54.5%
				Бронислав Коморовский Иргэний платформ нам	8,112,311 48.45%	
				Анжей Дуда Хууль, шударга ёс нам	5,179,092 34.76%	
				Бронислав Коморовский Иргэний платформ нам	5,031,060 33.77%	
				Павел Кукиз Бие даагч	3,099,079 20.80%	
				Януш Корвин Микке Европарламентын гишүүн, KORWIN	486,084 3.26%	
				Магдалена Огурек Демократ зүүн холбоо	353,883 2.38%	
				Адам Ярубас Польш ардын нам	238,761 1.60%	
				Януш Паликот Паликотын хөдөлгөөнийн тэргүүн	211,242 1.42%	
				Гжегож Браун Найруулагч	124,132 0%	
				Мариан Ковальски Иргэний хөдөлгөөн	77,630 0%	Сонгуульд санал өгсөн: 15,023,886 Хүчинтэй: 14,898,934 Хүчингүй: 124,952 Бүртгэгдсэн нийт сонгогчдын тоо: 30,688,570 Ирц: 48.5%
				Яцек Вилк Шинэ барууны конгресс	68,186 0%	
				Павел Танаино Шууд ардчилал	29,785 0%	

2	Казахстан	2015-04-26 1991 1999 2005 2011 2015	TRS Two Round System буюу Хоёр шаттай тогтолцоо	Нурсултан Назарбаев Ардын ардчилсан нам "Нур Отан"  Түргүн Сыздықов Ардын коммунист нам  Абелыгази Калиакпарович Кусаинов Нам бус	8,833,250 97.75%  145,756 1.61%  57,718 0%	Сонгуульд санал өгсөн: 9,242,936 Хүчинтэй: 9,090,920 Хүчингүй: 152,016 Бүртгэгдсэн нийт сонгогчдын тоо: 9,547,864 Ирц: 95.22%
3	Того	2015-04-25 2003 2005 2010 2015	FPTP First Past The Post буюу нэг мандаттай харьцангуй олонхийн хувилбарын тогтолцоо	Фор Эссозимна Бүгд найрамдах улсын төлөөх холбоо  Жан-Пьер Фабр Өөрчлөлтийн төлөөх үндэсний альянс  Loved Tchabotой Gogue Интеграл хөгжлийн төлөөх демократуудын альянс  Жерри Таама New Togolese Commitment  Мохамед Тхассона-Траоре Ардчилал болон хөгжлийн төлөөх иргэний хөдөлгөөн	1,221,282 58.77%  731,230 35.19%  83,768 4.03%  21,569 1.03%  20,048 0%	Сонгуульд санал өгсөн: 2,138,438 Хүчинтэй: 2,077,897 Хүчингүй: 58,813 Бүртгэгдсэн нийт сонгогчдын тоо: 3,509,258 Ирц: 60.92%
4	Узбекистан	2015-03-29 1991 2000 2007 2015	TRS Two Round System буюу Хоёр шаттай тогтолцоо	Ислам Каримов Узбекистаны либерал-демократ нам  Акмаль Саидов Демократ нам "Миллий Тикланиш"  Хотамжон Кетмонов Ардын демократ нам  Наримон Умаров Социал-демократ нам "Адолат"	17,122,597 90.39%  582,688 3.08%  552,309 2.92%  389,024 2.05%	Сонгуульд санал өгсөн: 18,942,349 Хүчинтэй: байхгүй Хүчингүй: байхгүй Бүртгэгдсэн нийт сонгогчдын тоо: 20,798,052 Ирц: 91.08%

5	Нигери	2015-03-28 2007 2011 2015	TRS Two Round System буюу Хоёр шаттай тогтолцоо	<p>Мохаммаду Бухари Бүх дэвшилтэт хүчний конгресс нам</p> <p>Гудлак Джонатан Ардын ардчилсан нам (PDP)</p> <p>Адебайо Аиени Африкийн ардын альянс (APA)</p> <p>Гания Галадима Нигерийн холбооны конгрессын нам (ACPP)</p> <p>Сэм Эке Иргэдийн олон нийтийн нам (CPR)</p> <p>Руфус Салау Ардчиллын төлөөх альянс (AD)</p> <p>Мани Ахмад Африкийн демократ конгресс (ADC)</p> <p>Аллагоа Чинеду Нигерийн ардын нам (PPN)</p> <p>Мартин Оново Үндэсний ухамсрын нам (NCP)</p> <p>Тунде Анифовосе-Келани Үйл хөдлөлийн альянс (AA)</p> <p>Чекаас Окорие Нэгдсэн прогрессив нам (UPP)</p> <p>Комфорт Сонайяа КОВА нам (KP)</p> <p>Годсон Окойе Нэгдсэн демократ нам (UDF)</p> <p>Анброз Алберт Овуру Hope Democratic Party (HOPE)</p>	<p>15,424,921 53.96%</p> <p>12,853,162 44.96%</p> <p>53,537 0.19%</p> <p>40,311 0.14%</p> <p>36,300 0.13%</p> <p>30,673 0.12%</p> <p>29,666 0.10%</p> <p>24,475 0.09%</p> <p>24,455 0.09%</p> <p>22,125 0.08%</p> <p>18,220 0.06%</p> <p>13,076 0.05%</p> <p>9,208 0.03%</p> <p>7,435 0.03%</p>	<p>Сонгуульд санал өгсөн: 29,432,083 Хүчинтэй: 28,587,564 Хүчингүй: 844,519 Бүртгэгдсэн нийт сонгогчдын тоо: 67,422,005 Ирц: 43.65%</p>
---	--------	------------------------------------	---	--	---	---

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- <http://www.electionguide.org>
- <http://www.idea.int>
- <http://aceproject.org/>
- <http://www.ipu.org/parline-e/parlinesearch.asp>

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**ДЭЛХИЙН 25 ОРНЫ 1945 ОНООС ХОЙШИХ ЗАСАГЛАЛЫН ХЭЛБЭР,  
ТӨРИЙН ТЭРГҮҮНИЙ СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО, ТӨРИЙН ТЭРГҮҮНЭЭР  
АЖИЛЛАСАН ХҮМҮҮСИЙН ЛАВЛАГАА**

*Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч (PhD), Б.Ариунжаргал,  
И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл,  
Ө.Мөнхтунгалаг, О.Нарантуяа, Ч.Онончимэг,  
А.Пагма, Д.Халиун, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа*

Судалгаанд дэлхийд Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээгээр болон нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр тэргүүлэгч нийт 25 орны төрийн тэргүүнийг сонгох сонгуулийн тогтолцоо ба 1945 оноос хойших засаглалын хэлбэр, төрийн тэргүүнээр болон ерөнхий сайдаар ажилласан хүмүүсийн талаарх мэдээлэл лавлагааг бэлтгэв.

*Хүснэгт 1*

<b>№</b>	<b>Улсын нэр</b>	<b>Засаглалын хэлбэр /1945 оноос хойш</b>	<b>Төрийн тэргүүн байсан хүмүүс /1945 оноос хойш/</b>	<b>Ерөнхий сайд байсан хүмүүс /1945 оноос хойш/</b>	<b>Төрийн тэргүүний сонгуулийн систем</b>
1	<b>АНУ</b>	Ерөнхийлөгчийн засаглалтай	Ерөнхийлөгчид: Харри Трумэн /1945-1953/ Дивайт Эйзенхавэр /1953-1961/ Ричард Никсон /1969-1970/ Жимми Картер /1970-1978/ Рональд Рейган /1981-1989/ Жорж Буш /1989-1993/ Билл Клинтон /1993-2001/ Бага Жорж Буш /2001-2009/ Барак Обама /2009 оноос/		Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгоно.
2	<b>Хятад</b>	Нэг намын тогтолцоотой.	Ерөнхийлөгчид: Mao Zedong /1949-1959/ Liu Shaoqi /1959-1968/ 1968-1983 оны хооронд БНХАУ-ын дарга гэсэн албан тушаал байхгүй <sup>77</sup> -1968-1975 оны хооронд Дун Биу /1968-1975/, Сун Цинлин 1968-1972 гэсэн хоёр орлогч дарга үүрэг гүйцэтгэж байсан. Li Xiannian /1983-1988/ Yang Shangkun /1988-1993/ Jiang Zemin /1993-2003/ Hu Jintao /2003-2013/ Xi Jinping /2013- /	Ерөнхий сайдууд: Чжоу Эньлай 1949-1976 Хуа Гофэн 1976-1980 Чжао Цзыян 1980-1987 Ли Пэн 1988-1998 Чжу Жунци 1998-2003 Вэнь Цзябао 2003-2013 Ли Кэцян 2013-одоо	Парламентаас сонгоно.

<sup>77</sup>[http://world\\_rulers.academic.ru/](http://world_rulers.academic.ru/)



3	Япон	1947 оноос Парламентын үндсэн хуульт хаант засаглал	Хаад: - Showa /1926-1989 онд/ - Akihito /1989 оноос- өнөөг хүртэл/	Ерөнхий сайд: Kijūrō Shidehara /1945- 1946/ Shigeru Yoshida /1946- 1947/ Tetsu Katayama /1947- 1948 Hitoshi Ashida /1948-1948/ Shigeru Yoshida /1948- 1954/ Ichiro Hatoyama/1954-1956/ Tanzan ishibashi /1956- 1957/ Nobusuke Kishi /1958- 1960/ Hayato Ikeda /1960-1964/ Easaku Sato/1964-1972/ Kakuei Tanaka /1972- 1974/ Takeo Miki /1974-1976/ Takeo Fukuda /1976-1978/ Masayoshi Ohira /1978- 1980/ Zenko Suzuki /1980-1982/ Yasuhiro Nakasone /1982-1987/ Noboru Takeshita /1987- 1989/ Sosuke Uno /1989-1989/ Toshiki Kaifu /1990-1991/ Kiichi Miyazawa /1991- 1993/ Morikhiro Hosokawa /1993-1994/ Tsutomu Hata/1994-1994/ Tomiichi Murayama /1994-1996/ Ryutaro Hashimoto /1996-1998/ Keizo Obuchi /1998-2000/ Yashiro Mori /2000-2001/ Junichiro Koizumi /2001- 2006/ Shinzo Abe /2006-2007/ Yasuo Fukuda /2007-2008/ Taro Aso /2008-2009/ Yukio Hatoyama /2009- 2010/ Naoto Kan /2010-2011/ Yoshihiko Noda /2011- 2012/ Shinzo Abe /2012-2014/ Shinzo Abe /2014-өнөөг хүртэл/	Төрийн тэргүүнийг угсаа залгамжлуулан тодруулдаг
---	------	--	--	--	---

4	<b>Герман</b>	1945-1949 онд Холбоотнуудын Хяналтын Зөвлөлийн Дээд Комиссарын засаглал  1949 оноос Парламентын засаглалтай Холбооны Бүгд Найрамдах Улс	<b>Ерөнхийлөгчид:</b> Theodor Heuss /1949-1959/ Heinrich Lübke /1959-1969 / Gustav Heinemann /1969-1974/ Walter Scheel /1974-1979/ Karl Carstens /1979-1984/ Weizsäcker /1984-1994/ Roman Herzog /1994-1999/ Johannes Rau /1999-2004/ Horst Köhler /2004-2010/ Christian Wulff /2010-2012/ Joachim Gauck /2012-... /	<b>Ерөнхий сайдууд:</b> -Konrad Adenauer /1949–1963/ -Ludwig Erhard /1963–1966/ -Kurt Georg Kiesinger /1966–1969/ -Willy Brandt /1969–1974/ -Helmut Schmidt /1974–1982/ -Helmut Kohl /1982–1998/ -Gerhard Schröder /1998–2005/ -Angela Merkel 2005-...	Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгоно.
5	<b>Франц</b>	Хагас ерөнхийлөгчийн засаглалтай.	<b>Ерөнхийлөгчид:</b> Philippe Fritain /1940-1944/ Vincent Auriol /1947-1954/ Renй Coty /1954-1959/ Charles de Gaulle /1959-1969/ Alain Poher /1969-1969/ Georges Pompidou /1969-1974/ Alain Poher /1974-1974/ Valйry Giscard d'Estaing /1974-1981/ Franzоis Mitterrand /1981-1995/ Jacques Chirac /1995-2007/ Nicolas Sarkozy /2007-2012/ Franzоis Hollande /2012 оноос		Бүх нийтийн сонгуулиар шууд сонгоно. (олонхын саналаар-хоёр шат бүхий сонгуулийн тогтолцоотой)
6	<b>Их Британи</b>	Парламентын Үндсэн хуульт Хаант засаглалтай.	-Хатан хаан II Элизабет /1952- одоог хүртэл/	Winston Churchill (1945.05.10-1945.07.26) Clement Attlee (1945.07.26-1951.10.26) Winston Churchill (1951.10.26-1955.04.06) Auithony Eden (1955.04.06-1957.01.10) Harold Macmillan (1957.01.10-1963.10.19) Alec Douglas-Home (1963.10.19-1964.10.16) Harold Wilson (1964.10.16-1970.06.19) Edward Health (1970.06.19-1974.03.04) Harold Wilson (1974.03.04-1976.04.05 ) James Callaghan (1976.04.05-1979.05.04) Margaret Thatcher (1979.05.04-1990.11.28 ) John Major ( 1990.11.28-1997.05.02) Tony Blair ( 1997.05.02-2007.06.27) Gordon Brown ( 2007.06.27-2010.05.11) David Cameron ( 2010.03.11- одоо хүртэл)	Төрийн тэргүүнийг угсаа залгамжлуулан тодруулдаг

7	<b>Бразил</b>	<p>1937-1967 Ерөнхийлөгчийн засаглалтай Бразилийн Нэгдсэн Улс</p> <p>1967 оноос</p> <p>Ерөнхийлөгч</p> <p>ийн засаглалтай Бразилийн Холбооны БНУ</p>	<p>Ерөнхийлөгчид: Цэргийн <b>Хунт 1945-1950</b> Josй Linhares 1945–1946 Eurico Gaspar Dutra 1946–1951 Getуlio Vargas 1951–1954 Cafй Filho 1954–1955 Carlos Luz 1955 Nereu Ramos 1955–1956 Juscelino Kubitschek 1956–1961 Jуnio Quadros 1961 Ranieri Mazzilli 1961 Joro Goulart 1961–1964 Ranieri Mazzilli 1964 Castelo Branco 1964–1967 Artur da Costa e Silva 1967–1969 Цэргийн <b>Хунтын Төр Засгийн газар 1969</b> Emнlio Garrastazu Mйdici 1969–1974 Ernesto Geisel 1974–1979 Joro Figueiredo 1979–1985 Josй Sarney 1985–1990 Fernando Collor de Mello 1990–1992 Itamar Franco 1992–1995 Fernando Henrique Cardoso 1995–2003 Luiz Inйcio Lula da Silva 2003–2011 Dilma Rouseff 2011–...</p>	<p>Бүх нийтийн сонгуулиар шууд сонгоно. (олонхын саналаар-хоёр шат бүхий сонгуулийн тогтолцоотой)</p>
---	---------------	--	---	---

8	Итали	Парламентын Бүгд Найрамдах Улс	<b>Ерөнхийлөгчид:</b> Джузеппе Сарагат /1964-1971/ Джованни Леоне /1971- 1978/ Алессандро Пертини /1978-1985/ Франческо Коссига 1985-1992/ Оскар Луиджи Скальфаро /1992-1999/ Карло Адзелио Чампи /1999-2006/ Джорджо Наполитано /2006-2015.1 сар/ Серджо Маттарелла /2015. 3 сараас/	Ерөнхий сайдууд: Альчиде де Гаспери /1945-1953/ Джузеппе Пелла /1953- 1954/ Аминторе Фанфани /1954-1954/ Марио Шельба 1954-1955 Антонио Сеньи 1955- 1957 Адоне Дзоли 1957-1958 Аминторе Фанфани 1958-1959 Антонио Сеньи 1959- 1960 Фернандо Тамброни 1960-1960 Аминторе Фанфани 1960-1963 Джованни Леоне 1963- 1963 Альдо Моро 1963-1968 Джованни Леоне 1968- 1968 Мариано Румор 1968- 1970 Эмилио Коломбо 1970- 1972 Джулио Андреотти 1972-1972 Джулио Андреотти 1972-1973 Мариано Румор 1973- 1973 Альдо Моро 1974-1976 Джулио Андреотти 1976-1979 Франческо Коссига 1979-1980 Арнальдо Форлани 1980-1981 Джованни Спадолини 1981-1983 Аминторе Фанфани 1982-1983 Беттино Кракси 1983- 1987 Аминторе Фанфани 1987-1987 Джованни Гориа 1987- 1988 Чириако де Мита 1988- 1989 Джулио Андреотти 1989-1992 Джулиано Амато 1992- 1993 Карло Адзелио Чампи 1993-1994 Сильвио Берлускони 1994-1995 Ламберто Дини 1995- 1996 Романо Проди 1996-1998 Массимо д'Алема 1998- 2000 Джулиано Амато 2000- 2001 Сильвио Берлускони 2001-2006 Романо Проди 2006-2008 Сильвио Берлускони 2008-2011 Марио Монти 2011-2013 Энрико Летта 2013-2014 Маттео Ренци 2014-одоо	Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгоно.
---	-------	--------------------------------------	--	--	---

9	Орос	<p>-Зөвлөлт засаглал /1922-1991 он/</p> <p>-Хагас ерөнхийлөгчийн засаглалтай Холбооны Бүгд Найрамдах Улс /1991 оноос /</p>	<p><b>ЗХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга нар:</b>  Н. В. Подгорный /1965-1977/  Л.И. Брежнев /1977-1982/  В. В. Кузнецов (и.о.) /1982-1983/  Ю. В. Андропов /1983-1984/  В. В. Кузнецов (и.о.) /1984.2 сар-1984. 4 сар/  К.У. Черненко /1984.11 сар-1985.10 сар/  В. В. Кузнецов (и.о.) /1985.2 сар-1985. 7 сар/  А. А. Громыко /1985.2 сар-1988.10 сар/  М. С. Горбачёв /1988.10 сар-1989.5 сар/</p> <p><b>ЗХУ-ын Дээд Зөвлөлийн дарга:</b>  М. С. Горбачёв /1989.5 сар-1990.3 сар/  <b>ЗХУ-ын Ерөнхийлөгч:</b>  М. С. Горбачёв /1990.3 сар-1991.12 сар/  <b>Б.Н. Ельцин /1991-1999/</b>  В. В. Путин /2000-2008/  Д. А. Медведев /2008-2012/  <b>В. В. Путин /2012-одоо /</b></p>	<p>ЗХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга нар:  И.В. Сталин 1941-1953  Г. М. Маленков 1953--1955  Н.А.Булганин 1955-1958  Н.С. Хрущёв 1958-1964  А.Н. Косыгин 1964-1980  Н. А. Тихонов 1980-1985  Н.И.Рыжков 1985-1991  ЗХУ-ын Ерөнхий сайд В.С.Павлов 1991-1991  ОХУ-ын Ерөнхий сайд Е.Т.Гайдар(үүрэг гүйцэтгэгч) 1992-1992  В.С.Черномырдин 1992-1998  С.В.Кириенко 1998-1998  В.С.Черномырдин (үүрэг гүйцэтгэгч)1998-1998  Е.М.Примаков 1998-1999  С.В.Степашин 1999-1999  В.В.Путин 1999-2000  М.М.Касьянов 2000-2004  В.Б.Христенко (үүрэг гүйцэтгэгч)2004-2004  М.Е.Фрадков 2004-2007  В.А.Зубков 2007-2008  В.В.Путин 2008-2012  В.А.Зубков (үүрэг гүйцэтгэгч)2012-2012  Д.А.Медведев 2012.5 сараас-одоо</p>	<p>Бүх нийтийн сонгуулиар шууд сонгоно (олонхын саналаар-хоёр шат бүхий сонгуулийн тогтолцоотой)</p>
10	Энэтхэг	<p>Парламентын Бүгд Найрамдах Холбооны Улс</p>	<p>Ражендра Прасад 1952-1957  Sarvepalli Radhakrishnan 1962.05.13-1967.05.13  Zakir Хуссейн 1967.05.13-1969.03  Varahagiri Бенката Giri / үүрэг гүйцэтгэгч/ 1969.03-07.20  Мохаммад Hidayatullah-/ үүрэг гүйцэтгэгч/ 1969.07.20-08.24  Varahagiri Бенката Giri 1969-1974  Fakhruddin Али Ахмед 1974.08.24-1977.02.11  Basappa Danappa Jatti 1977.02.11-07.25  Neelam Sanjiva Редди 1977-1982  Giani Zail Сингх 1982-1987  Ramaswamy Venkataraman 1987-1992  Шанкар Dayal Шарма 1992-1997  Kocheril Раман Narayanan 1997-2002  APJ Абдул Калам 2002-2007  Пратибха Патил 2007-2012  Pranab Мукержэ 2012-одоог хүртэл</p>	<p>Jawaharlal Nehru 1947-1964  Gulzarilal Nanda 1964  Lal Bahadur Shastri 1964-1966  Gulzarilal Nanda 1966-1966  Indira Gandhi 1966-1977  Morarji Desai 1977-1979  Charan Singh 1979-1980  Indira Gandhi - 1980-1984  Rajiv Gandhi – 1984-1989  VP Singh – 1989-1990  Chandra Shekhar 1990-1991  PV Narasimha Rao 1991-1996  AB Vajpayee – 1996  HD Deve Gowda 1996-1997  IK Gujral – 1997-1998  Atal Bihari Vajpayee 1998-2004  Manmohan Singh 2004-2014  Narendra Modi – 2014-одоог хүртэл</p>	<p>Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгоно.</p>

11	<b>Канад</b>	<p>Парламентын засаглалтай ардчилсан, Үндсэн хуульт хаант улс.</p> <p><i>/1982 онд батлагдсан Канадын актаар Британийн үндсэн хуулийн болон хууль тогтоох аливаа хамаарлыг дуусгавар болгосон/</i></p>	<p>Амбан захирагчид:</p> <p>Жорж Ванье /1959 -1967/ Робер Ташро, /1967.2 сар/ Роланд Миченер /1967-1974/ Жюль Леже /1974-1979/ Эдвард Шрейер /1979-1984/ Жанна Сове /1984-1990/ Рамон Джон Гнатышин /1990-1995/ Ромео Леблан /1995-1999/ Адриенна Кларксон /1999-2005/ Микаэль Жан /2005-2010/ Дэвид Ллойд Джонстон /2010-одоог хүртэл/</p>	<p>Ричард Беннет 1930.08.07- 1935.10.23 Луи Сен-Лоран 1948.11.15- 1957.06.21 Джон Дифенбейкер 1957.06.21-1963.04.22 Лестер Пирсон 1963.04.22-1968.04.20 Пьер Трюдо 1968.04.20-1979.06.04 1980.03.03-1984.06.30 Джо Кларк 1979.06.04-1980.03.03 Джон Тёрнер 1984.06.30-1984.09.17 Брайан Малруни 1984.09.17-1993.06.25 Ким Кэмпбелл 1993.06.25-1993.11.04 Жан Кретьен 1993.11.04-2003.12.12 Пол Мартин 2003.12.12-2006.02.06 Стивен Харпер 2006.02.06- одоог хүртэл</p>	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилно
12	<b>Австрали</b>	<p>Парламентын засаглалтай ардчилсан, Үндсэн хуульт хаант улс.</p> <p><i>/1986 онд Австралийн Акт батлагдсанаар Британийн парламентаас хууль зүйн хамаарлаа бүрэн тасалсан/</i></p>	<p>Амбан захирагчид:</p> <p>Ричард Кейзи, барон Кейзи /1965-1969/ Пол Хэзлак /1969-1974/ Джон Керр /1974-1977/ Зелман Коуэн /1977-1982/ Ниниан Стивен /1982-1989/ Уильям Хейден /1989-1996/ Уильям Дин /1996-2001/ Питер Холлингуорт /2001-2003/ Генерал-майор Майкл Джеффери /2003-2008/ Квентин Брайс /2008-2014/ Питер Косгроув /2014-одоог хүртэл/</p>	<p>Артур Фадден /1941.08.28-1941.10.07/ Джон Кёртин /1941.10.07-1945.07.05/ Форд, Фрэнк /1945.06.06-1945.06.13/ Бен Чифли /1945.07.13-1949.12.19/ Роберт Мензис /1949.12.19-1966.01.26/ Гарольд Холт /1966.01.26- 1967.12.19/ Джон Мак-Ивен /1967.12.19-1968.01.10/ Джон Гортон /1968.01.10-1971.03.10/ Уильям Макмагон /1971.03.10-1972.12.05/ Гоф Уитлэм /1972.12.05-1975.11.11/ Малколм Фрейзер /1975.11.11-1983.03.11 Роберт Хоук 1983.03.11-1991.12.20 Пол Китинг /1991.12.20-1996.03.11/ Джон Говард /1996.03.11-2007.12.03/ Кевин Радд /2007.12.03-2010.06.24 Джулия Гиллард /2010.06.24-2013.06.27 Кевин Радд /2013.06.27-2013.09.18/ Тони Эбботт 2013.09.18</p>	Амбан захирагчийг Эзэн хаан/Хатан хаан томилно

13	Испани	Парламентын Үндсэн хуульт хаант засагтай	Генерал Франкогийн Испани Улс 1936–1975 Francisco Franco 1936-1975 Alejandro Rodríguez de Valcárcel 1975-1975 Испанийн Вант улс 1975-2015 Juan Carlos I /1975- 2014/ Felipe VI /2014 – одоог хүртэл/	Генерал Франкогийн Испани Улс 1936–1975 Francisco Franco 1939.04.01-1973.06.08 Luis Carrero Blanco 1973.06.09-1973.12.20 Torcuato Fernández- Miranda 1973.12.20-1973.12.31 Carlos Arias Navarro 1973.12.31-1976.07.01 Fernando de Santiago Díaz 1976.07.01-1976.07.03 Испанийн Вант улс 1975-2015 Adolfo Suárez 1976.07.03-1981.02.25 Leopoldo Calvo-Sotelo 1981.02.25-1982.12.02 Felipe González 1982.02.02-1996.05.04 José María Aznar 1996.05.04-2004.04.16 José Luis Rodríguez Zapatero 2004.04.16-2011.12.20 Mariano Rajoy 2011.12.20-одоог хүртэл	Төрийн тэргүүнийг угсаа залгамжлуулан тодруулдаг
14	Өмнөд Солонгос	Ерөнхийлөгч ийн засаглалтай.	Ерөнхийлөгчид: -И Сын-мань /1948-1960/ Юнь Бу-сонь/1960-1962/ Паг Жон-хи /1963-1979/ Чуй Гё-ха /1979-1980/ Чонь Дү-хуань /1980-1988/ Ну Тэ-ү /1988-1993/ Ким Ён-сам /1993-1998/ Ким Дэ-жүн /1998-2003/ Ну Мү-хёнь /2003-2008/ И Мён-баг /2008-2013/ Паг Гын-хе /2013 оноос/		Бүх нийтийн сонгуулиар шууд сонгоно (энгийн олонхын саналаар)
15	Мексик	Ерөнхийлөгч ийн засаглалтай.	Manuel Ávila Camacho /1940-1946/ Miguel Alemán Valdés /1946-1952/ Adolfo Ruiz Cortines /1952-1958/ Adolfo López Mateos /1958–64/ -Gustavo Díaz Ordaz /1964–1970/ Luis Echeverría Álvarez /1970–1976/ José López Portillo /1976–1982/ Miguel de la Madrid /1982–1988/ Carlos Salinas de Gortari /1988–94/ Ernesto Zedillo /1994-2000/ Vicente Fox /2000-2006/ Felipe Calderón /2006-2012/ Enrique Peña Nieto /2012-/		Бүх нийтийн сонгуулиар шууд сонгоно (энгийн олонхын саналаар)

16	<b>Катар</b>	Хэмжээгүй эрхт эзэн хаант улс	Эмирууд: Sheikh Abdullah bin Jassim Al Thani /1913-1949/ Sheikh Ali bin Abdullah Al Thani /1949-1960/ Sheikh Ahmad bin Ali Al Thani /1960 -1972 / Sheikh Khalifa bin Hamad Al Thani /1972-1995/ Sheikh Hamad bin Khalifa Al Thani /1995-2013/ Sheikh Tamim bin Hamad Al Thani /2013-/		Төрийн тэргүүнийг угсаа залгамжлуулан тодруулдаг.
17	<b>Люксембург</b>	Парламентын Үндсэн хуульт Хаант засаглалтай.	Хаад: Grand Duke Jean /1964.11.12 -2000.10.7/ Grand Duke Анри 2000.10.7- одоо хүртэл )	Ерөнхий сайдууд: Pierre Dupong (1944.11.23-1953.12.23) Joseph Bech 2-р үе (1953.12.29-1958.03.29) Prerri Frieden (1958.03.29-1959.02.23) Prierre Werner 1-р үе (1959.02.15-1974.06.15) Gaston Thorn (1974.06.15-1979.07.16) Prierre Werner (1979.07.16-1984.07.20) Jacques Santer (1984.07.20-1995.01.26) Jan-Claude Juncker (1995.01.26-2013.12.04) Xavier Bettel (2013-12.04-одоо хүртэл)	Төрийн тэргүүнийг угсаа залгамжлуулан тодруулдаг
18	<b>Сингапур</b>	Парламентын засаглалтай.  /1965 онд Бүгд Найрамдах Сингапур Улс тусгаар тогтнолоо зарласан/	Ерөнхийлөгчид: YOSOF ishak /1965-1970 онд/ benjamin henry sheares /1971-1981/ Devan Nair /1981-1985/ Wee Kim Wee /1985-1993/ Ong Teng Cheong /1993-1999/ S. R. Nathan /1999-2005/ S. R. Nathan /2005-2011/ Tony Tan Keng Yam /2011-2017/	Lee kuan yew /1959-1990/ Goh chok tong /1991-2004/ Lee hsien loong /2004-өнөөг хүртэл/	Бүх нийтийн сонгуулиар шууд сонгоно (энгийн олонхын саналаар)
19	<b>Бруней</b>	Хэмжээгүй эрхт эзэн хаант улс /1984 оны 1 дүгээр сарын 1-нд Бруней улс бүрэн тусгаар тогтнолоо зарлан тунхагласан/	Султан: - Ahmad Tajuddin /1924-1950/ -Omar Ali Saifuddien III /1950-1967/ -Hassanal Bolkiah /1967- одоог хүртэл/		Төрийн тэргүүнийг угсаа залгамжлуулан тодруулдаг
20	<b>Кувейт</b>	Үндсэн хуульт, үе залгамжилсан эмир буюу хаант засагтай улс.	Эмирууд: -Sabah Salem Al-Mubarak -Al-Sabah /1965-1977 онд/ -Jaber Al-Ahmad Al-Jaber -Al-Sabah /1977-2006 онд/ • Saad Al-Salim Al-Sabah /2006-2006/ • Sabah Al-Ahmad Al-Jaber Al-Sabah /2006-өнөөг хүртэл/		Төрийн тэргүүнийг угсаа залгамжлуулан тодруулдаг



21	Норвеги	Парламентын Үндсэн хуульт Эзэн хаант улс	Хаад: - Haakon VII /1905.11.18-1957.09.21/ Olav V /1957.09.21- 1991.01.17 Harald V /1991.01.17 – одоог хүртэл/	Einar Gerhardsen /1945-1951/ Oscar Torp /1951-1955/ Einar Gerhardsen /1955- 1963/ John Lyng /1963.08- 1963.09/ Einar Gerhardsen /1963- 1965/ Per Borten /1965-1971/ Trygve Bratteli /1971-1972/ Lars Korvald /1972-1973/ Trygve Bratteli /1973-1976/ Odvar Nordli /1976-1981/ Gro Harlem Brundtland /1981.02-1981.10/ Kere Willoch /1981-1986/ Gro Harlem Brundtland /1986-1989/ Jan P. Syse /1989-1990/ Gro Harlem Brundtland /1990-1996/ Thorbjörn Jagland /1996-1997/ Kjell Magne Bondevik /1997-2000/ Jens Stoltenberg /2000- 2001/ Kjell Magne Bondevik /2001-2005/ Jens Stoltenberg /2005- 2013/ Erna Solberg /2013-одоо/	Төрийн тэргүүнийг угсаа залгамжлуулан тодруулдаг
22	Арабын Нэгдсэн Эмират Улс	Үндсэн хуульт Хаант засагтай.	7 улс буюу эмират нь Абу-Даби, Ажман, Дубай, Фужайра, Рас ал-Хайма, Шаржа, Умм ал-Кувейн юм. Эдгээр улс бүр нь Эмиртэй.		Бусад
23	Сан- Марино	Парламентын засаглалтай.	Жил бүр 4 захирагч капитан-регентс хууль тогтоох Дээд зөвлөлөөс сонгох бөгөөд хоёр хоёроороо ээлжлэн төрийн тэргүүн болон гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүний үүргийг гүйцэтгэнэ.		Парламентаас сонгоно.
24	Швейцарь	Парламентын засаглалтай холбооны улс	Холбооны зөвлөл нь хамтаараа төрийн тэргүүн байна. Холбооны Зөвлөл: Дорис Leuthard (гишүүн), Eveline Widmer- Schlumpf (гишүүн), Ueli Maurer (гишүүн), Дидье Burkhalter (гишүүн), Симонетта Sommaruga (ерөнхийлөгч), Johann Schneider Ammann (дэд ерөнхийлөгч), Ален Berset (Гишүүн)	Оскар Леймгрубер (1944-1951) Шарль Осер (1951-1967) Карл Хубер (1968-1981) Вальтер Бүзер (1981- 1991) Франсуа Кушпен (1991- 1999) Аннемари Хубер-Хотц (2000-2007) Корина Казанова (2008-оноос одоог хүртэл)	Парламентаас сонгоно.
25	Саудын Араб	Хэмжээгүй эрхт Эзэн хаант улс	Abdulaziz /1932.09.22- 1953.11.09/ Saud /1953.11.09-1964.11.02/ Faisal /1964.11.02-1975.03.25/ Khalid /1975.03.25-1982.06.13 Fahd /1982.06.13-2005.08.01/ Abdullah /2005.08.01-2015.01.23/ Salman /2015.01.23 - одоог хүртэл		Төрийн тэргүүнийг угсаа залгамжлуулан тодруулдаг.

**ИЗРАИЛЬ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ЗАСГИЙН ГАЗРЫГ  
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ЗААЛТУУД**  
(Албан бус орчуулга)

Р.Хатанбаатар

**1. Израиль улсын үндсэн хууль<sup>78</sup> дараах хуулиудаас бүрдэнэ:**

- Улсын эдийн засгийн тухай үндсэн хууль
- Израилийн нийслэл Иерусалим хотын тухай үндсэн хууль
- Хүний нэр төр, эрх чөлөөний тухай үндсэн хууль
- Шүүх эрх мэдлийн тухай үндсэн хууль
- Улсын ерөнхийлөгчийн тухай үндсэн хууль
- Засгийн газрын тухай үндсэн хууль
- Кнессетийн тухай үндсэн хууль
- Улсын хянан шалгагчийн тухай үндсэн хууль
- Зэвсэгт хүчний тухай үндсэн хууль
- Израилийн тусгаар тогтнолын тунхаглал
- Израилийн газрын тухай үндсэн хууль болон бусад.

**2. Улсын ерөнхийлөгчийн тухай үндсэн хууль**

Зүйл 11. Чиг үүрэг, эрх мэдэл

(а) Улсын ерөнхийлөгч:

- (1) Засгийн газрыг бүрдүүлэх арга хэмжээ авах, хуулийн дагуу засгийн газрын огцрох саналыг хүлээн авах.

**3. Засгийн газрын тухай үндсэн хууль** (2001 онд батлагдаж, 2003 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн)

Зүйл 3. Кнессетийн итгэл

Засгийн газар бүрэн эрхээ Кнессет итгэл үзүүлснээр хэрэгжүүлнэ.

Зүйл 4. Хариуцлага

Засгийн газар Кнессетийн өмнө хамтын хариуцлага хүлээнэ; сайд нь өөрийн хариуцсан асуудлаар Ерөнхий сайдын өмнө хариуцлага хүлээнэ.

Зүйл 5. Бүрэлдэхүүн

- (а) Засгийн газар Ерөнхий сайд ба бусад сайд нараас бүрдэнэ.
- (b) Ерөнхий сайд Кнессетийн гишүүн байна. Сайд Кнессетийн гишүүн байх албагүй.
- (c) Сайд яамыг толгойлно; мөн яамгүй сайд байж болно.
- (d) Кнессетийн гишүүн аль нэг сайд Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгчээр томилогдож болно.
- (e) Сайд Ерөнхий сайдын орлогчийн хувиар илтгэж болно.

Зүйл 7. Засгийн газрыг байгуулах даалгавар

- (а) Шинэ Засгийн газар байгуулах шаардлага тулгарсан үед Улсын ерөнхийлөгч Кнессет дэх намын бүлгүүдийн төлөөлөлтэй зөвлөлдсөний дараа Засгийн газар байгуулах даалгаврыг биелүүлэхэд бэлэн гэдгээ илэрхийлсэн Кнессетийн гишүүнд Засгийн газар байгуулах даалгавар өгнө; Ерөнхийлөгч энэ үйлдлийг сонгуулийн үр дүн албан ёсоор хэвлэгдснээс хойш 7 хоногийн дотор, эсвэл шинээр Засгийн газар байгуулах шаардлага гарсан тохиолдолд гүйцэтгэнэ; Ерөнхий сайд нас барсан тохиолдолд хугацаа нь 14 хоногийн дотор байна.

<sup>78</sup>Basic Law: The Government (2001), <http://knesset.gov.il/>

- (b) Хэрэв энэхүү зөвлөлдөх үйл ажиллагаа Кнессетийн чуулган нээгдэхээс өмнө хийгдэж байгаа бол Ерөнхийлөгч шинэ Кнессетийг бүрдүүлэх нэр дэвшигчдийн жагсаалтуудын төлөөлөлтэй зөвлөлдөнө.
- (c) Засгийн газарт итгэл үл үзүүлэх асуудал тавигдсаны дараа Засгийн газрыг байгуулах асуудал гарсан тохиолдолд энэ зүйлийн заалтыг хэрэглэхгүй.

**Зүйл 8. Засгийн газрыг бүрдүүлэх хугацаа**

Зүйл 7-д заасны дагуу Ерөнхийлөгчөөс Засгийн газрыг байгуулах даалгавар авсан Кнессетийн гишүүн уг даалгаврыг 28 хоногийн дотор биелүүлэх үүрэгтэй. Улсын ерөнхийлөгч дээрх хугацааг сунгаж нэмэлт хугацаануудыг тогтоож болох бөгөөд нэмэлт хугацааны нийлбэр нь 14 хоногоос хэтрэхгүй.

**Зүйл 9. Даалгаврыг шилжүүлэх**

- (a) Хэрэв зүйл 8-д заасан хугацаа хэтэрсэн бөгөөд даалгавар авсан Кнессетийн гишүүн Улсын ерөнхийлөгчид Засгийн газрыг бүрдүүлсэн тухай мэдэгдээгүй, эсвэл өмнө нь Засгийн газрыг бүрдүүлэх боломжгүй тухайгаа мэдэгдсэн, эсвэл Засгийн газрын бүрэлдэхүүнээ танилцуулсан боловч Кнессет итгэл үзүүлээгүй бол Ерөнхийлөгч Засгийн газрыг бүрдүүлэх тухай даалгавраа Засгийн газрыг бүрдүүлэхэд бэлэн гэдгээ илэрхийлсэн Кнессетийн өөр гишүүнд өгч болно, эсвэл Кнессетийн Спикерт Засгийн газрыг бүрдүүлэх боломжгүй боллоо гэдгийг мэдэгдэнэ. Ерөнхийлөгч даалгаврыг өөр гишүүнд өгөх юмуу Спикерт мэдэгдэх дээр дурдсан үйлдлийг Засгийн газрыг бүрдүүлэх хугацаа дууссан, эсвэл Кнессетийн гишүүн Засгийн газрыг бүрдүүлэх боломжгүй тухайгаа мэдэгдсэн, эсвэл Кнессет итгэл үзүүлэхээс татгалзсан өдрөөс хойш 3 хоногийн дотор гүйцэтгэнэ.
- (b) Улсын ерөнхийлөгч энэ зүйлийн заалтын дагуу Засгийн газрыг бүрдүүлэх даалгавар өгөх, эсвэл Кнессетийн Спикерт Засгийн газрыг бүрдүүлэх боломжгүй боллоо гэдгийг мэдэгдэхийн өмнө Кнессет дэх фракцуудын төлөөлөлтэй дахин зөвлөлдөх эрхтэй.
- (c) Энэ Зүйлийн дагуу Засгийн газрыг бүрдүүлэх даалгавар авсан Кнессетийн гишүүн уг даалгаврыг 28 хоногийн дотор хэрэгжүүлэх ёстой.

**Зүйл 10. Намын бүлгүүдийн хүсэлтээр даалгавар өгөх**

- (a) Хэрэв Улсын ерөнхийлөгч Зүйл 9(а) заалтын дагуу Кнессетийн Спикерт Засгийн газрыг бүрдүүлэх боломжгүй гэж мэдэгдсэн, эсвэл мөн заалтын дагуу Кнессетийн гишүүнд Засгийн газрыг бүрдүүлэх даалгавар өгсөн боловч уг гишүүн 28 хоногийн дотор Засгийн газрыг бүрдүүлсэн тухайгаа мэдэгдээгүй, эсвэл заагдсан хугацаанаас өмнө Засгийн газрыг бүрдүүлэх боломжгүй боллоо гэдгээ мэдэгдсэн, эсвэл өргөн барьсан Засгийн газрын бүрэлдэхүүнд нь Кнессет итгэл үзүүлээгүй бол Кнессетийн гишүүдийн олонх Улсын ерөнхийлөгчид бичгээр хандаж бичгийн хэлбэрээр өөрийн зөвшөөрлөө өгсөн Кнессетийн тодорхой нэг гишүүнд Засгийн газрыг бүрдүүлэх даалгаврыг өгөхийг хүсэх эрхтэй; хүсэлтийг Ерөнхийлөгч мэдээлэл хийсэн, эсвэл Зүйл 9(с) заалтанд заасан хугацаа дууссан, эсвэл Кнессетийн гишүүн Засгийн газрыг бүрдүүлэх боломжгүй болсноо мэдэгдсэн, эсвэл Кнессет итгэл үзүүлээгүй өдөр зэрэг хугацаанаас хойш 21 хоногийн дотор гаргана.
- (b) Хэрэв Ерөнхийлөгчид дээр дурдсан хүсэлтийг хүргэсэн бол Ерөнхийлөгч 2 хоногийн дотор нэр заагдсан Кнессетийн гишүүнд Засгийн газрыг бүрдүүлэх даалгавар өгнө.
- (c) Энэ заалтын дагуу Засгийн газрыг бүрдүүлэх даалгавар авсан Кнессетийн гишүүн даалгаврыг 14 хоногийн дотор гүйцэтгэх ёстой.

## Зүйл 11. Засгийн газар байгуулагдаагүй тохиолдлын ээлжит бус сонгууль

- (a) Хэрэв Зүйл 10(а) заалтын дагуу хүсэлт тавигдаагүй, эсвэл Кнессетийн гишүүн Зүйл 10(с) –д заасан хугацаанд Засгийн газрыг бүрдүүлж чадаагүй, эсвэл тухайн хугацаа дуусахаас өмнө уг гишүүн Засгийн газрыг бүрдүүлэх боломжгүй болсноо Ерөнхийлөгчид мэдэгдсэн бол Ерөнхийлөгч энэ тухай Кнессетийн Спикерт мэдэгдэнэ.
- (b) Хэрэв Ерөнхийлөгч дээр заагдсан журмын дагуу Кнессетийн Спикерт мэдэгдсэн, эсвэл Зүйл 10(а) заалтын дагуу Засгийн газар бүрдүүлэх үүрэгтэй Кнессетийн гишүүн Засгийн газрын бүрэлдэхүүнээ танилцуулсан боловч Кнессет итгэл үзүүлээгүй бол Кнессет өөрийн бүрэн эрхийн хугацаанаас өмнө өөрөө тарах шийдвэр гаргасанд тооцох бөгөөд үүний дараа Кнессетийн сонгууль явуулна, Ерөнхийлөгч мэдэгдэл хийсэн, эсвэл Кнессет итгэл үзүүлээгүй өдрөөс хойш 90 дэх хоног өнгөрөхийн өмнөх мягмар гаригт сонгуулийг явуулахаар товлон.

## Зүйл 12. Засгийн газар бүрдүүлэх процедурыг зогсоох

Кнессетийг тараах тухай хууль батлагдмагц Засгийн газрыг бүрдүүлэх процедур зогсоно.

## Зүйл 13. Засгийн газрыг бүрдүүлэх

- (a) Хэрэв Улсын ерөнхийлөгч Кнессетийн гишүүнд Засгийн газрыг бүрдүүлэх даалгавар өгсөн бол энэ тухайгаа Кнессетийн Спикерт мэдэгдэнэ, Кнессетийн Спикер Кнессетэд мэдэгдэнэ.
- (b) Хэрэв Кнессетийн гишүүн Засгийн газрыг бүрдүүлсэн бол энэ тухайгаа Улсын ерөнхийлөгч ба Кнессетийн Спикерт мэдэгдэнэ, Кнессетийн Спикер энэ тухай Кнессетэд мэдэгдэж, уг мэдэгдлээс хойш 7 хоногийн хугацаанд Засгийн газрын бүрэлдэхүүнийг Кнессетэд танилцуулах өдрийг тогтооно.
- (c) Засгийн газрыг бүрдүүлсэн Кнессетийн гишүүн Засгийн газраа толгойлно.
- (d) Засгийн газрыг бүрдүүлсний дараа Кнессетэд хандаж, бодлогын үндсэн чиглэл, бүрэлдэхүүн, сайд нарын үүргийн хуваарилалтаа танилцуулан, итгэл үзүүлэхийг хүснэ. Кнессет итгэл үзүүлснээр Засгийн газар байгуулагдсанд тооцогдож, сайд нар албан тушаалдаа орно.

**МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАНЫ УДИРДЛАГЫГ  
ХЭРХЭН СОНГОЖ, ТОМИЛЖ БАЙСАН ТАЛААРХ ЛАВЛАГАА**

А.Пагма

**Нэг. БНМАУ-ын төрийн захиргааны байгууллагын удирдлагыг сонгох,  
томилох журмын талаар (1960-1990)**

БНМАУ-ын төрийн захиргааны байгууллагын тогтолцоо нь дээд, төв, орон нутгийн байгууллага гэсэн 3 хэсгээс бүрдэж байв. БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуулийн 37 дугаар зүйл, Сайд нарын Зөвлөлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар Сайд нарын Зөвлөл бол төрийн гүйцэтгэн захирах дээд байгууллага байв. Сайд нарын Зөвлөл нь БНМАУ-ын Ардын Их Хурал, түүний Тэргүүлэгчдийн өмнө ажлаа хариуцан тайлагнаж тэдгээрийн хууль, зарлигийг биелүүлэх үндсэн дээр төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагыг нэгтгэн удирдах замаар төрийн гүйцэтгэн захирах үүргээ гүйцэтгэдэг байжээ.

Үндсэн хууль болон БНМАУ-ын Ардын Их Хурлын Регламентын дагуу БНМАУ-ын АИХ-ын чуулган нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн даргыг томилон, Сайд нарын зөвлөлийн шинэ бүрэлдэхүүний тухай Сайд нарын Зөвлөлийн даргын саналыг Ардын Их Хурлаар хэлэлцэж Сайд нарын Зөвлөлийг бүх бүрэлдэхүүнээр буюу түүнд нэр дэвшсэн хүн нэг бүр дээр депутатуудын саналыг хураах журмаар байгуулж байсан байна. Сайд нарын Зөвлөлийн бүрэлдэхүүнд Сайд нарын Зөвлөлийн даргаас гадна нэгдүгээр орлогч дарга, орлогч дарга нар, БНМАУ-ын сайд, Улсын хорооны дарга нар орж байжээ.

АИХ-ын чуулганы чөлөө цагт сайд нар болон Сайд нарын Зөвлөлийн бусад гишүүдийг томилох буюу албан тушаалаас чөлөөлөх асуудлыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн даргын өргөн мэдүүлснээр БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганд дараа оруулан батлуулахаар БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид зарлиг гарган шийдвэрлэж байсан байна.<sup>79</sup>

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 32 дугаар зүйлд “БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн аппарат нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газар, Зохион зааварлах хэлтэс болон зохион байгуулалтын бүтцийн бусад нэгжээс бүрдэнэ. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн аппаратын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл батална. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн аппаратыг толгойлох бөгөөд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн бүрэлдэхүүнд орно” гэж заажээ.

Яам, Улсын хороо, тусгай газрууд нь төрийн захиргааны төв байгууллага байсан ба яам, улсын хороог Ардын Их Хурлаас байгуулж, Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх тусгай газруудыг Сайд нарын Зөвлөлөөс байгуулдаг байв.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 19 дүгээр зүйлд “БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл нь Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх тусгай газрын дарга, яамны орлогч сайд, улсын хорооны орлогч дарга, өөртөө харьяалагдах бусад байгууллагын орлогч дарга нарыг томилж, яам, улсын хороо, өөртөө харьяалагдах бусад байгууллагын коллегийн болон улсын хорооны гишүүдийг батална” гэж хуульчилжээ.<sup>80</sup>

<sup>79</sup>БНМАУ-ын Ардын Их Хурлын Регламент. 1981 он. БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987

<sup>80</sup>БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987

Яам, улсын хороо, тусгай газруудын хэлтэс, газрын дарга нарыг МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний тогтоолыг үндэслэн зохих газруудын сайд, дарга нарын тушаалаар томилдог байсан.

### ***Төрийн захиргааны орон нутгийн байгууллага***

Төрийн захиргааны орон нутгийн байгууллагад аймаг, хот, сум, хороо, район, орон нутгийн хотын Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргаад, тэдгээрийн хэлтэс, газар, түүнчлэн яаманд шууд харьяалагдаж, орон нутагт ажилладаг захиргааны байгууллагууд орж байв.

Аймаг, хотын гүйцэтгэх захиргааг тухайн аймаг, хотын АДХ-ын чуулганаар депутатуудын дотроос дарга, нэгдүгээр орлогч дарга, орлогч дарга, хариуцлагатай нарийн бичгийн даргыг оролцуулан 7-11 гишүүний бүрэлдэхүүнтэй сонгож байсан. Хурлын гүйцэтгэх захиргаа нь үйл ажиллагаагаа түүнийг сонгосон Хурал болон БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд шууд тайлагнана.<sup>81</sup>

Сум, хороо, район, орон нутгийн хотын АДХ-ын чуулганаар депутатуудын дотроос тухайн орон нутгийн Ардын Депутатуудын Хурлын Гүйцэтгэх Захиргааны дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга (районд бол хариуцлагатай нарийн бичгийн дарга) нарыг оролцуулан 5-9 гишүүний бүрэлдэхүүнтэй ил сонгоно.<sup>82</sup>

Хэдийгээр хууль эрх зүйн хувьд төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудыг тухайн түвшны Хурлуудаас томилж, сонгох журам үйлчилж байсан боловч 1990 он хүртэл монгол төрийн албаны социалист ёсыг эрхэмлэсэн төвлөрсөн удирдлага бүхий тогтолцоонд тулгуурлаж байсан билээ.

## **2. Монгол Улсын төрийн захиргааны албаны удирдлагыг сонгон шалгаруулах, томилох журмын талаар (1990-2015)**

1990 онд Үндсэн хуулийн нэмэлтийн хууль батлагдсанаар төрийн албаны бүтэц, зохион байгуулалтад нэлээд өөрчлөлт орж, улмаар 1992 онд шинэ Үндсэн хуулийг баталснаар төрийн жинхэнэ албаны эрхзүйн үндсийг шинээр тогтоов. Үүний үндсэнд УИХ-аас 1994 онд Төрийн албаны тухай хуулийг батлан 1995 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдүүлснээр төрийн албаны бие даасан хуультай болж Монгол Улсын төрийн албаны шинэ тогтолцооны эрхзүйн үндсийг бий болгосон байна. Төрийн албаны тухай хуулийг 2002 онд шинэчлэн найруулж, 2008 оноос хойш нэлээд хэдэн удаа зарчмын шинжтэй томоохон нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Үүнд, нам төвтэй төрийн албаны тогтолцоог мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус төрийн албаны тогтолцоо болгон өөрчлөн шинэчлэхэд ихээхэн анхаарч ирсэн байна.

Ийнхүү 1990 оноос хойш Монгол Улсын төрийн албаны шинэтгэлийн үйл явц эхэлсэн бөгөөд ардчилсан нийгмийн мөн чанарт нийцүүлж төрийн байгууллын шинэ тогтолцоог бүрдүүлэх, төрийн мэргэшсэн албыг бүрдүүлж, төлөвшүүлэх, засаглалын институцийн чадавх, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, улс төрөөс ангид, мэдлэг чадварт суурилсан төрийн албыг бэхжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа юм.

<sup>81</sup>БНМАУ-ын аймаг, хотын АДХ-ын тухай хууль. 1984 он. БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987

<sup>82</sup>БНМАУ-ын сум, хороо, район, орон нутгийн хотын АДХ-ын хууль. УБ., 1978 он

Төрийн албаны тухай хуулиар төрийн албаны болон албан тушаалын ангилал, зэрэглэл, төрийн албанд баримтлах зарчим, төрийн албан хаагчийн эрх, үүрэг, хариуцлага зэрэг гол чухал асуудлууд тусгагдан төрийн албаны хэмжээнд нийтлэг мөрдөгдөж эхэлсэн юм. Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд төрийн захиргааны албан тушаал, түүний ангилалыг 17 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд авах эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан.

Түүнчлэн тус хуулийн 35<sup>1</sup> дүгээр зүйлд төрийн байгууллагын зарим удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх журмыг заасан ба үүний үндсэн дээр УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ыг баталжээ.

Тус Журмын 1 дэх хэсгийн 2 дугаарт “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд төрийн захиргааны болон төрийн тусгай албаны зорилт, чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, түүнээс дээших бусад албан тушаал хамаарна гэж заасан.

“Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-д төрийн захиргааны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сул орон тооны захиалга ирүүлэх, сонгон шалгаруулалтыг мэдээлэх, сонгон шалгаруулах комисс байгуулах, сонгон шалгаруулалтад оролцогчийг бүртгэх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах сонгон шалгаруулалтын дүн гаргах, нэр дэвшүүлэх журмыг нарийвчлан зохицуулжээ.

Төрийн албаны тухай хуулийн 35<sup>1</sup> дүгээр зүйлд төрийн байгууллагын зарим удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх журмыг дараах байдлаар хуульчилсан байна.

Төрийн албаны төв байгууллага дараах албан тушаалд нэг хүний нэрийг дэвшүүлж, түүнийг томилох эрх бүхий этгээдэд санал болгоно. Үүнд:

- Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга ;
- Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;
- төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;
- Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын төсвийн шууд захирагч;
- агентлагийн дарга \цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон зэвсэгт хүчний байгууллагаас бусад\ ;
- Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга;
- аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга.

Төрийн албаны төв байгууллага нь сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэхээс ажлын 21-ээс доошгүй өдрийн өмнө тухайн албан тушаалын талаар нийтэд мэдээлнэ.

Дээр дурдсан албан тушаалтныг сонгон шалгаруулж нэр дэвшүүлэхэд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, бусад төсвийн ерөнхийлөн захирагч, улс төрийн аливаа нам, эвслийн зүгээс төрийн албаны төв байгууллагад нөлөө үзүүлэхийг хуулиар хориглосон.

Төрийн албаны төв байгууллага нь албан тушаалд нэр дэвшигчийг төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулан, хэрхэн сонгосон тухайгаа нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтын хамт нийтэд мэдээлнэ.

Томилох эрх бүхий этгээд төрийн албаны төв байгууллагаас Төрийн албаны хуулийн 35<sup>1</sup> дүгээр зүйлд заасан албан тушаалд санал болгосон нэр дэвшигчийг холбогдох албан тушаалд томилно.

Томилох эрх бүхий этгээд төрийн албаны төв байгууллагын санал болгосон нэр дэвшигчийг томилохоос хуульд заасан үндэслэлээр 1 удаа татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд төрийн албаны төв байгууллага өөр хүнийг зохих журмын дагуу санал болгоно.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгчийг томилох, чөлөөлөхтэй холбогдсон асуудлыг тус тусын хуулиар зохицуулна.

\* \* \*

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- БНМАУ-ын Үндсэн хууль. 1960 он
- Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
- БНМАУ-ын Ардын Их Хурал, орон нутгийн АДХ-ын талаарх хууль тогтоомжийн эмхтгэл (1956-1986). УБ., 1987
- БНМАУ-ын хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл. УБ., 1960 он
- БНМАУ-ын сум, хороо, район, орон нутгийн хотын АДХ-ын хууль. УБ., 1978 он
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль. 2002 он
- УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолын хавсралт “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам.” 2003 он
- Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 2011 он

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



## ДЭЛХИЙН 25 ОРНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ /ТӨРИЙН ТЭРГҮҮН/-ИЙГ ОГЦРУУЛАХ ҮНДЭСЛЭЛИЙГ ҮНДСЭН ХУУЛИАР ЗОХИЦУУЛСАН ЭСЭХ

*Р.Хатанбаатар, Г.Алтан-Оч (PhD), Б.Ариунжаргал,  
И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг,  
О.Нарантуяа, Ч.Онончимэг, А.Пагма, Д.Халиун, Г.Чулуун, Ц.Элбэгзаяа*

№	Улсын нэр	Ерөнхийлөгчийг огцруулах үндэслэл	Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хугацаанаасаа өмнө чөлөөлөгдсөн эсэх
1	<b>АНУ</b>	Үндсэн хуулийн 2 бүлгийн 4 хэсэгт: Нэгдсэн улсын Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон иргэний бүх албан тушаалтныг төрд тэрсэлсэн, хахууль авсан болон бусад хүнд, хөнгөн гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчил гаргасны төлөө импичментээр албан тушаалаас нь огцруулж болно.	Ерөнхийлөгч • Ричард Никсон 1974.8.9 <sup>83</sup>
2	<b>Хятад</b>	БНХАУ–ын төрийн байгууллын системд “төвлөрсөн ардчилал” –ын гэх зарчим үйлчилдэг (Ст.3) тул нэгэнт сонгогдсон, жишээлбэл, Улсын дарга элдэв шалтгаанаар буруутан болох магадлал бага юм. БНХАУ–ын Үндсэн хуульд Улсын даргыг огцруулахтай холбогдсон зүйл заалт үгүй.  1982 оны Үндсэн хуулиар дахин бий болсон “Улсын дарга” –ын албан тушаалд ажилласан хүмүүсээс “эх орноосоо урвасан” хэрэгт холбогдсон тохиолдол гараагүй.	БНХАУ–ын Үндсэн хуулиа 1982 онд шинэчилсэн ба энэ хуулиар “Улсын дарга”–ын албан тушаалыг дахин бий болгож сэргээсэн.  Сүүлийн 30 гаран жилд БНХАУ –д, хугацаанаасаа өмнө чөлөөлөгдсөн Улсын дарга гараагүй;
3	<b>Япон</b>	1947 оноос Парламентын үндсэн хуульт хаант засаглалтай. Эзэн хааныг угсаа залгамжлуулан тодруулдаг. Үндсэн хуулиар эзэн хааныг огцруулах зохицуулалтгүй.	• Ерөнхий сайд: • Hitoshi Ashida /1948-1948/ • Tanzan ishibashi /1956-1957/ • Masayoshi Ohira /1978-1980/ • Sosuke Uno /1989-1989/ • Toshiki Kaifu /1990-1991/ • Morikhiro Hosokawa /1993-1994/ • Tsutomu Hata/1994-1994/ • Tomiichi Murayama /1994-1996/ • Yashiro Mori /2000-2001/ • Junichiro Koizumi /2001-2006/ • Shinzo Abe /2006-2007/ • Yasuo Fukuda /2007-2008/ • Yukio Hatoyama /2009-2010/ • Naoto Kan /2010-2011/ • Yoshihiko Noda /20011-2012/

<sup>84</sup><http://www.historyplace.com>

4	<b>Герман</b>	Үндсэн хуулийн заалт §61 (2): Холбооны Үндсэн хуулийн Шүүх нь Холбооны ерөнхийлөгчийг Үндсэн хууль буюу бусад хуулийг санаатайгаар зөрчсөн гэж үзвэл түүнийг огцруулах шийдвэр гаргана.	1968 онд Холбооны ерөнхийлөгч Heinrich Lübke, 2010 онд Холбооны ерөнхийлөгч Horst Kähler, 2012 онд Холбооны ерөнхийлөгч Christian Wulff нар тус тус хугацаанаас өмнө өөрсдөө татгалзсан. 1974 онд Холбооны канцлер Willy Brandt-г Холбооны ерөнхийлөгч огцруулсан.
5	<b>Франц</b>	Үндсэн хуульд холбогдох заалт байхгүй.	Ерөнхийлөгч • Charles de Gaulle-1969 <sup>84</sup>  Ерөнхий сайд • Мануэл Воллс – 2014
6	<b>Их Британи</b> <sup>85</sup>	Хаант засаглалтай тул байхгүй	Ерөнхий сайд • Aulthony Eden (1955-1957) эрүүл мэндийн улмаас огцорсон. • Harold Macmillan (1957-1963)  1963 оны 10 сард өвчний учир огцорсон байна . • Alec Douglas-Home (1963-1964) 1964 оны сонгуулиар хүчтэй өрсөлдөгч хөдөлмөрийн намд суудлаа алджээ. • Harold Wilson (1964-1970), (1974-1976) 1970 оны сонгуулиар суудлаа алдсан ч  1974 онд эргүүлэн авч чадсан байна. 1976 онд огцорох мэдэлдэл гэнэт гаргасан ба өндөр насны тэтгэвэрт гарсан ч эдийн засгийн хямралын үе, фунтийн ханш уналттай холбон тайлбарласан байдаг. • James Callaghan (1976-1979) 1979 оны сонгуульд ороогүй, улс төрийн алдаа гаргаснаа өөрөө хүлээн зөвшөөрчээ.

<sup>84</sup>[https://en.wikipedia.org/wiki/Charles\\_de\\_Gaulle](https://en.wikipedia.org/wiki/Charles_de_Gaulle)<sup>85</sup>[https://en.wikipedia.org/wiki/List\\_of\\_Prime\\_Ministers\\_of\\_the\\_United\\_Kingdom](https://en.wikipedia.org/wiki/List_of_Prime_Ministers_of_the_United_Kingdom)

7	<b>Бразил</b>	<p>Үндсэн хууль 1988, 86-р зүйл 2-т Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлах</p> <p>(1) Гэмт хэрэгт холбогдсон бөгөөд тэр нь шүүхээс тодорхойлогдсон тохиолдолд ерөнхийлөгчийн эрхийг түдгэлзүүлнэ.</p> <p>(2) Эрх мэдлээ хэтрүүлсэн. Энэ нь Парламентын хэлэлцүүлэгт орсон бол эрх мэдлийг нь түдгэлзүүлнэ.</p> <p>(3) Түдгэлзүүлсэн нь 180 хоногийн дотор эцэслэн шийдвэрлэгдээгүй бол буцаж ажилдаа орно.</p>	<p>Төрийн тэргүүн:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Josй Linhares 1945–1946</li> <li>• Cafй Filho 1954–1955</li> <li>• Carlos Luz 1955</li> <li>• Nereu Ramos 1955–1956</li> <li>• Jвnio Quadros 1961</li> <li>• Ranieri Mazzilli 1961</li> <li>• Ranieri Mazzilli 1964</li> <li>• Artur da Costa e Silva 1967–1969</li> </ul> <p>Цэргийн Хунтын Төр Засгийн газар 1969</p> <ul style="list-style-type: none"> <li>• Fernando Collor de Mello 1990–1992</li> </ul>
8	<b>Итали</b>	<p>Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа эх орноосоо урвасан эсвэл Үндсэн хуульд халдсанаас бусад тохиолдолд хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй.</p> <p>Ерөнхийлөгч эх орноосоо урвасан, эсвэл Үндсэн хуульд халдсан тохиолдолд Парламент танхимуудын нэгдсэн хуралдаан хийж гишүүдийн үнэмлэхүй олонхын саналаар түүнийг шүүхэд шилжүүлнэ.</p> <p>/Үндсэн хууль/ 1947 он. Зүйл 90</p>	<p>Ерөнхийлөгч Джорджо Наполитано 2006-2013 онд Ерөнхийлөгчөөр ажилласны дараа 2013 онд Италийн нийгэм-эдийн засгийн хямралыг даван туулахын тулд 2 дахь удаагаа сонгогдсон ба 2015 оны 1 сард өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн.</p> <p>Ерөнхий сайдууд хугацаанаасаа өмнө чөлөөлөгдөж байсан.</p>
9	<b>Орос</b>	<p>Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч эрүүл мэндийн шалтгааны улмаас эрх мэдлээ хэрэгжүүлэх ямар ч чадваргүй болсон эсвэл албан тушаалаасаа зайлуулагдсан тохиолдолд огцорсоноор бүрэн эрх нь хугацаанаасаа өмнө дуусгавар болно.</p> <p>Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн сонгууль Ерөнхийлөгчийн бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш 3 сарын дотор явагдах ёстой.</p> <p>Үндсэн хууль. 1993 он, зүйл 92</p>	<p>ЗХУ задран унасантай холбоотой ЗХУ-ын Ерөнхийлөгч М.С.Горбачёв 1991оны 12 сарын 25-ны өдөр албан тушаалаасаа буусан.</p> <p>ОХУ-ын Ерөнхийлөгч Б.Н. Ельцин 1991-1999, 1999 оны 12 сард өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн.</p> <p>Ерөнхий сайдууд хугацаанаасаа өмнө чөлөөлөгдөж байсан.</p>

10	<b>Энэтхэг</b>	<p>Үндсэн хууль 1950, 5 бүлэг, 56-р зүйл</p> <p>(А) Ерөнхийлөгч өөрөө өргөдлөө өгсөн тохиолдолд</p> <p>(Б) Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдвол хугацаанаас өмнө огцруулна.</p> <p>(В) Бүрэн эрхийн хугацаа нь дууссан ерөнхийлөгч дараагийн ерөнхийлөгчийг тодорхой болтол ажлаа хийнэ.</p>	<p>Ерөнхийлөгч: Zakir Хуссейн 1967.05.13-1969.03 Varahagiri Бенката Giri / үүрэг гүйцэтгэгч ерөнхийлөгч/ 1969.03-07.20 Мохаммад Hidayatullah-/ үүрэг гүйцэтгэгч ерөнхийлөгч/ 1969.07.20-08.24 Fakhruddin Али Ахмед 1974.08.24-1977.02.11 Basappa Danappa Jatti 1977.02.11-07.25</p> <p>Ерөнхий сайд: Gulzarilal Nanda – 1964 Lal Bahadur Shastri – 1964-66 Gulzarilal Nanda – 1966 Indira Gandhi – 1966-77 Morarji Desai – 1977-79 Charan Singh – 1979-80 VP Singh – 1989-90 Chandra Shekhar – 1990-91 AB Vajpayee – 1996 HD Deve Gowda – 1996-97 IK Gujral – 1997-98</p>
11	<b>Канад</b> <sup>86</sup>	Амбан захирагчийн бүрэн эрхийн хугацаа, огцруулах үндэслэлийг Үндсэн хуульд тусгаагүй.	<p>Ерөнхий сайд нар:</p> <ul style="list-style-type: none"> <li>• John George Diefenbaker (1963)</li> <li>• Pierre Elliott Trudeau (1974)</li> <li>• Joe Clark (1979)</li> <li>• Paul Martin (2005) засгийн газарт итгэл үзүүлээгүй</li> <li>• Stephen Harper (2011) засгийн газарт итгэл үзүүлээгүй, хугацаанаас нь өмнө сонгууль явуулсан</li> </ul>
12	<b>Австрали</b> <sup>87</sup>	Амбан захирагчийн бүрэн эрхийн хугацаа, огцруулах үндэслэлийг Үндсэн хуульд тусгаагүй.	<p>Ерөнхий сайд нар:<sup>88</sup></p> <ul style="list-style-type: none"> <li>• Whitlam, Edward (1975) Амбан захирагч чөлөөлсөн</li> <li>• Hawke, Robert James (1991) Намаас дэмжлэг аваагүй</li> <li>• Rudd, Kevin (2010) Намаас дэмжлэг аваагүй</li> <li>• Gillard, Julia (2013) Намаас дэмжлэг аваагүй</li> </ul>
13	<b>Испани</b> <sup>89</sup>	Үндсэн хуулийн 57-р зүйлд заасны дагуу Испанийн хаан ширээг залгамжлах залгамжлагчгүй болсон тохиолдолд Парламент Испанийн эрх ашигт нийцүүлэн угсаа залгамжлагчийг сонгоно.	-

<sup>86</sup>[https://www.constituteproject.org/constitution/Canada\\_2011.pdf?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Canada_2011.pdf?lang=en)

<sup>87</sup>[https://www.constituteproject.org/constitution/Australia\\_1985.pdf?lang=en](https://www.constituteproject.org/constitution/Australia_1985.pdf?lang=en)

<sup>88</sup><http://australianpolitics.com/lists/prime-ministers-since-1901>

<sup>89</sup><http://australianpolitics.com/lists/prime-ministers-since-1901>

14	<b>Өмнөд Солонгос</b>	Үндсэн хуульд холбогдох заалт байхгүй.	Ерөнхийлөгч <ul style="list-style-type: none"> <li>• И Сынгман-1960</li> <li>• Юүн Бусон 1961<sup>90</sup></li> </ul>
15	<b>Мексик</b>	Ноцтой үндэслэл шалтгаан байна гэж Конгресс улмаар шийдвэр гаргаж Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь чөлөөлнө (Ст.86);  Эх орноосоо урвасан асуулттай шууд холбогдох тодорхой заалт байхгүй, харин дамаар холбож болох, Ерөнхийлөгч Конгрессийн зөвшөөрөлгүйгээр улсын хилээс гадагш явах эрхгүй; гэсэн заалт Мексикийн Үндсэн хуульд бий.	Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч Засгийн газрыг тэргүүлнэ (Ст.80), Ерөнхийлөгчийн бүрэн эрх 12 дугаар сарын 1-нээс эхэлнэ, 6 жил үргэлжилнэ (Ст.83);  Сүүлийн 80 жилд, (бүрэн эрхийн хугацаанаасаа өмнө) чөлөөлөгдсөн Ерөнхийлөгч гараагүй;
16	<b>Катар</b>	Үндсэн хуулийн (2003 оны) 8-р зүйл Катарын Төрийн эрхийг Ал Тхани гэр бүл ба, Хамад Бен Халифа Бен Хамад Бен Абд-Аллах Бен Жасминий удмынханы өв залгамжлагч барьдаг.  Үндсэн хуулийн 15-р зүйл Ханхүүгийн суудал эзгүй болсныг түүнийг нас барсан, эсхүл төр барих бүрэн чадваргүй болсон тохиолдолд Төр барьж буй Гэр бүлийн зөвлөл тодорхойлно.	Эмирүүд: <ul style="list-style-type: none"> <li>• Sheikh Ahmad bin Ali Al Thani</li> <li>• /1972 онд/</li> <li>• Sheikh Khalifa bin Hamad Al Thani</li> <li>• /1995 онд/</li> </ul>
17	<b>Люксембург</b> <sup>91</sup>	Хаант заслалтай тул байхгүй	Ерөнхий сайд <ul style="list-style-type: none"> <li>• Prierre Dupong (1944-1953) Үндэсний холбооны Засгийн газрын өрөөнд нас баржээ.</li> <li>• Prierre Frieden (1958-1959) 1959 оны сонгуулиар нас барсан байна.</li> <li>• Prierre Werner (1979-1984) өндөр насны тэтгэвэрт гарчээ.</li> <li>• Jan –Claude Juncker (1995-2013) Хамгийн удаан урт, тасралтгүй ажиллаж байсан ч авилгын хэрэг гарсан байна. Хаан Grand Duke Henri өөрөө тагнуул хийж, хэвлэлийн бага хурлаар огцрох мэдэгдэл хийж Засгийн газар огцорч байсан.<sup>92</sup></li> </ul>
18	<b>Сингапур</b>	Үндсэн хуулиар Ерөнхийлөгчийг огцруулах зохицуулалтгүй.	Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдууд бүрэн эрхийн хугацаанаас өмнө огцроогүй.

<sup>90</sup>[https://en.wikipedia.org/wiki/List\\_of\\_Presidents\\_of\\_South\\_Korea](https://en.wikipedia.org/wiki/List_of_Presidents_of_South_Korea)<sup>91</sup>[https://en.wikipedia.org/wiki/List\\_of\\_Prime\\_Ministers\\_of\\_Luxembourg](https://en.wikipedia.org/wiki/List_of_Prime_Ministers_of_Luxembourg)<sup>92</sup><http://www.dailymail.co.uk/news/article-2360592/Entire-government-Luxembourg-resigns-spying-corruption-scandal-forces-prime-minister-quit.html#ixzz2Yq8lbcQs>

19	<b>Бруней</b>	Хэмжээгүй эрхт эзэн хаант улс  Үндсэн хуульдаа тусгаагүй.	Бруней улсын Султан нь тус улсын эзэн хаан, төрийн тэргүүн, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн, Бруней лалын шашны тэргүүн, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, Сангийн сайдын үүргийг гүйцэтгэдэг.
20	<b>Кувейт</b>	Үндсэн хуульт, үе залгамжилсан эмир буюу хаант засагтай улс. Үндсэн хуулиар эмирийг огцруулах зохицуулалтгүй.	Уламжлалын дагуу Хунтайж Ерөнхий сайдаар томилогдоно. Эмир ерөнхий сайдыг томилно. Ерөнхий сайд нар бүрэн эрхийн хугацаанаас өмнө огцроогүй.
21	<b>Норвеги</b>	Үндсэн Хуульд эзэн хааныг огцруулах заалт байхгүй боловч 36-р зүйлд зааснаар Норвегийн хаан ширээ залгамжлах ханхүү болон гүнж хааны зөвшөөрөлгүйгээр гэрлэхийг хориглоно. Мөн Хааны болон Парламентын зөвшөөрөлгүйгээр /гишүүдийн 2/3 санал авсан байх/ хэргэм зэрэг болон өндөр албан тушаал эрхлэхийг хориглох бөгөөд зөрчсөн тохиолдолд тэдгээр болон түүний үр удам хаан ширээ залгамжлах эрхээ алдана.	Ерөнхий сайд  <ul style="list-style-type: none"> <li>• Christopher Horsrud (1928)</li> <li>• Einar Gerhardsen (1963)</li> <li>• John Lyng (1963)</li> <li>• Kjell Magne Bondevik (2000)</li> </ul>
22	<b>Арабын Нэгдсэн Эмират Улс</b>	Үндсэн хуульд ерөнхийлөгчийг огцруулах тухай заалт байхгүй байна.	-
23	<b>Сан-Марино</b>	Жил бүр 6 сарын хугацаатай 4 захирагч капитан-регентс сонгох бөгөөд капитан-регент нь хоёр хоёроороо ээлжлэн төрийн тэргүүний үүргийг тус тус гүйцэтгэдэг. Капитан-регентс огцруулах талаар Үндсэн хуульд тусгаагүй.	-
24	<b>Швейцарь</b>	Үндсэн хуулинд тусгаадаагүй	Үгүй. <i>Тайлбар:</i> Швейцарийн Холбооны ерөнхийлөгч (7 гишүүнтэй Холбооны зөвлөлийн дотроос 1 жилийн хугацаатай сонгодог) нь Төрийн тэргүүн биш. Үндсэн хуулинд “Төрийн тэргүүн” (Улсын ерөнхийлөгч) буюу “Засгийн газрын дарга” (Ерөнхий сайд) гэсэн ойлголт байхгүй. Дээрх бүх чиг үүргийг хамтын удирдлага бүхий Холбооны зөвлөл гүйцэтгэдэг. Харин Холбооны ерөнхийлөгч нь Засгийн газрын болон Холбооны зөвлөлийн хуралдааныг даргалдаг.
25	<b>Саудын Араб</b>	Төрийн тэргүүнийг угсаа залгамжлуулан тодруулдаг эзэн хаант улс. Үндсэн хуульд хааныг огцруулах заалт байхгүй.	

**ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЗАСАГЛАЛЫН ХЭЛБЭР: АНГИЛАЛ, ШИНЖ ЧАНАР***Р.Хатанбаатар, А.Пагма*

Эрдэмтэн, судлаачид, олон улсын байгууллага, улс орнуудын үндэсний байгууллагууд дэлхийн улс орнуудыг засаглалын хэлбэрийнх нь хувьд янз бүрээр ангилан хуваасан байна<sup>93</sup>.

Өнөөдөр дэлхийн улсууд засаглалын хувьд Бүгд найрамдах ба Хаант засагт гэсэн хоёр үндсэн хэлбэртэй байна. Үүнээс Бүгд найрамдах улс нь дотроо ерөнхийлөгчийн, парламентын, холимог буюу хагас ерөнхийлөгчийн, социалист, шашинт бүгд найрамдах улс гэсэн хэлбэрүүдэд, хаант засаг нь үндсэн хуульт хаант засагтай, хоёрдмол шинж бүхий хаант засагтай, хэмжээгүй эрх хаант засагтай гэж хуваагдана.

Судалгаанд нийт 188 улс орнуудын засаглалын хэлбэрийг авч үзлээ. Үүнд:

- Ерөнхийлөгчийн засаглалтай 39 орон;
- Холимог буюу хагас Ерөнхийлөгчийн засаглалтай 49 орон;
- Парламентын засаглалтай 50 орон;
- Социалист засаглалтай 5
- Шашны (теократ)<sup>94</sup> Бүгд найрамдах улс 1;
- Үндсэн хуульт хаант засагтай парламентын улс 29;
- Хоёрдмол шинж бүхий(дуалист)<sup>95</sup> хаант засагтай 9 орон;
- Хэмжээгүй эрхт хаант засагтай 5 орон;
- Шашинт (теократ) засаглалтай 1 орон байна.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<sup>93</sup>Political system, <http://www.britannica.com/topic/political-system> Country Comparison to the World. <https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/2128.html>; Төр улсуудын засгийн газар. Дэлхийн улс төрийн тогтолцооны гарын авлага. УБ., 2012

<sup>94</sup>Теократ (грек. theos Бог)-Шашны тэргүүн нь нэгэн зэрэг төрийн тэргүүн байдаг засаглалын хэлбэр

<sup>95</sup>Дуализм (лат. dualis-хоёрдмол) гэсэн агуулгыг илэрхийлнэ.

Хүснэгт 1

№	Засаглалын хэлбэр	Засаглалын ангилал, голлох шинж чанар	Улс орнууд
1.	Ерөнхийлөгчийн засаглалтай орнууд	<ul style="list-style-type: none"> <li>Ерөнхийлөгчийн засаглалтай</li> </ul> <p>Ийм хэлбэрийн засаглалтай улсад Ерөнхийлөгч нь нэгэн зэрэг төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүн байдаг. Ихэвчлэн ерөнхий сайдын албан тушаал байдаггүй. Ерөнхийлөгчийн засаглалын нэг онцлог нь Ерөнхийлөгчийг парламентын оролцоогүйгээр сонгож, засгийн газрыг мөн парламентын оролцоогүйгээр Ерөнхийлөгч бүрдүүлдэг. Засгийн газар зөвхөн Ерөнхийлөгчийн өмнө хариуцлага хүлээнэ. Ихэнхдээ Ерөнхийлөгч парламентыг тараах эрхгүй, парламент засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг илэрхийлэх эрхгүй, харин парламент импичментын процедураар Ерөнхийлөгчийг огцруулах эрхтэй байдаг.</p> <ul style="list-style-type: none"> <li>Холимог буюу хагас ерөнхийлөгчийн засаглалтай</li> </ul> <p>Ийм хэлбэрийн засаглалтай улсад ерөнхийлөгч, ерөнхий сайдтай ба ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалыг бодитоор хэрэгжүүлдэг. Гэхдээ засгийн газрын тэргүүний зарим чиг үүргийг ерөнхий сайд гүйцэтгэдэг. Ерөнхийлөгчийн хүчтэй засаглалын зэрэгцээ парламентын зүгээс гүйцэтгэх эрх мэдлийг хянах үр дүнтэй арга механизмтай (итгэл үзүүлэх эсэх г.м), Ерөнхийлөгч засгийн газрыг заавал парламентын оролцоотой бүрдүүлдэг онцлогтой. Ийнхүү засгийн газар Ерөнхийлөгч, парламентын аль альных нь өмнө хариуцлага хүлээнэ. (Франц, ОХУ, Португал)</p>	<p>Ангол, АНУ, Аргентин, Афганистан, Боливи, Бразил, Бурунди, Венесуэл, Гамби, Гана, Гватемал, Гондарус, Доминикан, Замби, Зимбабве, Кени, Колумби, Коморын арлууд, Конго, Коста Рика, Либериа, Малави, Мальдив, Мексик, Мьянмар, Никарагуа, Нигерия, Палау, Панама, Парагвай, Сейшелийн арлууд, Сьерра-Леоне, Судан /Өмнөд/, Судан, Туркменистан, Уругвай, Филиппин, Чили, Эквадор.</p> <p>Азербайжан, Алжир, Армян, Беларусь, Бенин, Букина-Фасо, Габон, Гвиней, Йемен, Казакстан, Камерун, Кабо-Верде Кот-д'Ивуар, Мозамбек, Намиби, Нигер, Өмнөд Солонгос, Перу, Руанда, Сальвадор, Танзани, Того, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Уганда, Узбекистан, Экваторын Гвиней, Гайти, Гүрж, Гайана, Гвиней-Бисау, Жибути, Зүүн Тимор, Конго /БНАКУ/, Литва, Мадагаскар, Мали, Мавритани, Орос, Польш, Португал, Румын, Сан-Томи ба Принсипи, Сири, Сенегал, Тайвань, Тажикистан, Франц, Шри-Ланк, Индонез.</p> <p>Австри, Бангладеш, Болгар, Босни-Герцеговин, Ботсван, Вануату, Герман, Грек, Доминика, Ирак, Ирланд, Израиль, Исланд, Итали, Кирибати, Кыргызстан, Латви, Ливан, Ливи, Маврикий, Мальт, Македон, Маршаллын Арлууд, Микронези, Молдав, Монгол, Науру, Өмнөд Африк, Пакистан, Сан-Марино, Самоа, Сингапур, Серб, Словак, Словен, Сомали, Суринам, Тринидад Тобаго, Тунис, Турк, Непал, Фижи, Финланд, Хорват, Чех, Чрна Гора, Энэтхэг, Эстони, Этиопи</p>
2.	Парламентын засаглалтай улсууд	<p>Төрийн эрх барих дээд байгууллага нь парламент бөгөөд засгийн газрыг парламент бүрдүүлж, огцруулна. Засгийн газар нь парламентын өмнө хариуцлага хүлээнэ. Төрийн тэргүүнийг парламентаас эсвэл тусгайлан байгуулсан парламентын коллегияс сонгоно. Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар сонгодог ч улс орон бий (Австри, Болгар, Монгол). Парламентын засаглалтай улсын нэг онцлог нь засгийн газар нь парламентын итгэлийг хүлээсэн тохиолдолд л эрх мэдлээ хэрэгжүүлэх боломжтой.</p>	



3.	<b>Социалист засаглалтай улсууд</b>	Үндсэн хуулиндаа социалист нийгэм байгуулах зорилгыг хуульчилсан. Эдгээр улсууд хөгжлийн өөр өөрийн онцлогтой. Тухайлбал, БНХАУ нь Үндсэн хуулийнхаа удиртгал хэсэгт хятадын онцлогтой социализм байгуулах үндсэн зорилгыг тодорхойлжээ.	Хятад, Куба, Хойд Солонгос, Вьетнам, Лаос
4.	<b>Шашны Бүгд найрамдах улс</b>	Тус улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлд Исламын Бүгд Найрамдах Иран улсын удирдлагыг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагууд велаате Иمامын <sup>96</sup> үнэмлэхүй удирдлагын дор хэрэгжүүлнэ, 113 дугаар зүйлд Удирдагчийн (Leadership) дараа Ерөнхийлөгч улс орны албан ёсны дээд удирдлага мөн хэмээн заажээ.	Исламын Бүгд Найрамдах Иран улс
5.	<b>Хаант засагтай улсууд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Үндсэн хуульд хаант засагтай парламентын улсууд</li> </ul> <p>Эдгээр улс орнуудад эзэн хааны эрх зүйн байдал нь хууль эрх зүйн хувьд болон бодит амьдралд хуулиар хязгаарлагдсан байдаг тул төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох оролцоо бага, зөвхөн ёслол, уламжлалын чиг үүрэгтэй, бэлэгдлийн шинж чанартай байдаг онцлогтой. Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү парламент, гүйцэтгэх эрх мэдлийг засгийн газар хэрэгжүүлнэ. Засгийн газар парламентын өмнө хариуцлага хүлээнэ. Иймээс үндсэн хуульд хаант засагтай ихэнх улс орон парламентын ардчилалтай оронд тооцогддог.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хоёрдмол шинж бүхий хаант засагтай улсууд</li> </ul> <p>Эдгээр улсуудад эзэн хаан нь гүйцэтгэх эрх мэдлийг бүрэн хэрэгжүүлж, зарим хууль тогтоох ба шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцоно. Төлөөллийн байгууллага нь хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлнэ, гэвч хаан хуульд бүрэн хориг тавих болон өөрийн үзэмжээр төлөөллийн байгууллагыг тараах эрхтэй. (Йордани, Марокко).</p>	Андорра, Австрали, Багамын арлууд, Барбадос, Бельги, Белиз, Камбож, Канад, Дани, Гренада, Испани, Их Британи, Лесото, Люксембург, Малайз, Нидерланд, Норвеги, Папуа-Шинэ Гвиней, Сент-Кидс ба Невис, Сент Люсия, Сент-Венсент ба Гренадин, Соломоны арлууд, Тайланд, Тувалу, Шинэ Зеланд, Швед, Япон, Ямайка,
6.	<b>Хэмжээгүй эрхт шашинт засаглалтай улс</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хэмжээгүй эрх хаант засагтай улсууд</li> </ul> <p>Эдгээр улсуудад эзэн хааны эрх мэдлийг ямар нэг хууль эрх зүйн актаар хязгаарлаагүй, засгийн бүх эрх мэдэл хааны гарт байдаг.</p> <p>Шашны тэргүүн нь Төрийн тэргүүн байдаг ба төрийн бүх эрх мэдэл бүхэлдээ түүний гарт байна.</p>	Бахрейн, Бутан, Йордан, Кувейт, Лихтенштейн, Монако, Марокко, Тонга, Арабын Нэгдсэн Эмират Улс  Бруней, Оман, Катар, Саудын Араб, Свазиланд,  Ватикан

<sup>96</sup>Wilayat al-Imam- the leadership of the Ummah - Ираны шашны дээд удирдагч

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Country Comparison to the World. <https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/fields/2128.html>
- Political system, <http://www.britannica.com/topic/political-system>
- Сафонов В. Е., Миряшева Е. В. Конституционное право зарубежных стран. Особенная часть. Москва. Изд-во: Юрайт. 2013
- Сафонов В. Е., Миряшева Е. В. Конституционное право зарубежных стран. Общая часть. Москва. Изд-во: Юрайт. 2014
- Кашенов А.Т. Конституционное право зарубежных стран. Томск. 2011
- Форма правления. <http://ensiklopedia.ru>
- Төр улсуудын засгийн газар. Дэлхийн улс төрийн тогтолцооны гарын авлага. УБ., 2012
- Дэлхийн улс орны засаглалын тогтолцоо /СТ-15/412/

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## МОНГОЛ УЛСТАЙ ЗАСАГЛАЛЫН ХЭЛБЭРИЙН ХУВЬД ИЖИЛ ТӨСТЭЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МЭДЭЭЛЭЛ

*Д.Жигваагүнсэл, Ч.Онончимэг, Д.Халиун*

### **Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүнийг сонгох хэлбэр, үе шат**

“Дэлхийн улс орнуудын засаглалын хэлбэр: ангилал, шинж чанар” лавлагаа мэдээллийг үндэслэн Парламентын засаглал бүхий 50 орноос **Ерөнхийлөгч, Парламентыг / парламентын нэг танхимтай/ бүх нийтээр сонгодог сонгуулийн тогтолцоо бүхий орнуудыг нарийвчлан авч үзэхэд** дараах улс орнууд байна. Үүнд:

- Болгар, Исланд, Кыргызстан, Македон, Монгол, Сингапур, Серб, Словак, Турк, Финланд, Хорват, Чрна Гора зэрэг болно.

Эдгээр орнуудын ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх хэлбэр, бүрэн эрх, засгийн газрын тэргүүнийг сонгох, чөлөөлөх хэлбэрийг нь тус тус нарийвчлан судлан үзлээ. Тухайлбал, /*Эдгээр улсуудын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх, томилох болон чөлөөлөх талаар дэлгэрэнгүйг Хүснэгт 1-ээс, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн харьцуулалтын дэлгэрэнгүйг Хүснэгт-2-оос үзнэ үү/*

#### **1/ Болгар:**

*Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох:*

Үндсэн хуулийн 99 дүгээр зүйлд зааснаар Ерөнхийлөгч парламент дахь бүлгүүдтэй зөвшилцсөний дараа хамгийн олон гишүүнтэй парламентын бүлгээс дэвшүүлсэн ерөнхий сайдад нэр дэвшигчид засгийн газрыг бүрдүүлэх үүрэг өгнө. Хэрэв энэ нэр дэвшигч 7 хоногийн хугацаанд Сайд нарын зөвлөлийн бүрэлдэхүүнийг санал болгож чадаагүй бол парламентын хоёр дахь олон гишүүнтэй бүлгийн нэр дэвшигчид засгийн газрыг бүрдүүлэх үүрэг өгнө.

Хэрэв Сайд нарын зөвлөлийг бүрдүүлэх даалгавар хэрэгжвэл Ерөнхийлөгч Ардын Хуралд хандан ерөнхий сайдад нэр дэвшигчийг санал болгоно.

Үндсэн хуулийн 84 дүгээр зүйлд зааснаар Ардын Хурал ерөнхий сайдыг томилж чөлөөлнө. Ерөнхий сайдын санал болгосноор Сайд нарын зөвлөлийн гишүүдийг томилж чөлөөлнө. Мөн ерөнхий сайдын санал болгосноор засгийн газрын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулна.

#### **2/ Финланд**

*Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох:*

Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлд зааснаар ерөнхий сайдыг сонгохын өмнө Эдускунта /цаашид Парламент гэх/ дахь намын бүлгийн төлөөлөгчид нэр дэвшигчдийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон бүрэлдэхүүнтэй танилцсан дүнгээ Ерөнхийлөгчид мэдээлж, ерөнхий сайдад нэр дэвшигчийг Парламентад санал болгохыг хүснэ.

Хэрэв нэр дэвшигч Парламентын ил санал хураалтаар олонхын санал авч чадвал ерөнхий сайдаар сонгогдсонд тооцно. Үүний дараа Үндсэн хуулийн 58 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгч нь ерөнхий сайдыг албан үүргээ гүйцэтгэхээр томилно. /Финландын 2000 онд батлагдсан Үндсэн хуулиар энэхүү эрх орсон<sup>97</sup> /

<sup>97</sup><http://www.asgp.co/sites/default/files/documents/NJTCYJXYUTISQLTGGTUUWLCDXVEPCE.pdf>

Өмнө нь Засгийн газрыг Ерөнхийлөгч шууд томилдог байсныг 2000 оны Үндсэн хуулиар Парламентын ил санал хураалтаар сонгодог болсон.

Бусад сайд нарыг ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилно. Хэрэв засгийн газрын бүрэлдэхүүнд томоохон өөрчлөлт оруулах бол Парламентад танилцуулна.

### 3/ Серби

*Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.*

Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн эрх мэдлийн тухай 112 дугаар зүйл болон Засгийн газрыг сонгох тухай 127 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгч парламентад сонгогдсон сонгогчдын жагсаалтуудын төлөөллийн саналыг авч үзсэний үндсэн дээр ерөнхий сайдад нэр дэвшигчийг Үндэсний ассамблейд санал болгоно.

Ерөнхий сайдад нэр дэвшигч Үндэсний Ассамблейд Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө танилцуулж, засгийн газрын бүрэлдэхүүнээ санал болгоно.

Үндэсний Ассамблей Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг дэмжих эсэх, ерөнхий сайдыг сонгох, Засгийн газрын гишүүдийг сонгох гэсэн дарааллаар санал хураалт явуулж, нийт гишүүдийн олонхын саналаар засгийн газрын гишүүдийг сонгоно.

### 4/ Чрна Гора

*Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.*

Үндсэн хуулийн 95 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгч парламент сонгогдсоноос хойш 30 хоногийн дотор парламентад төлөөлөл бүхий улс төрийн намуудын төлөөлөгчид, Үндсэн хуулийн шүүхийн дарга болон шүүгчид, Хүний эрх, эрх чөлөөний хамгаалагчтай зөвлөлдсэний үндсэн дээр парламентад ерөнхий сайдад нэр дэвшигчийг танилцуулна.

Үндсэн хуулийн 103 дугаар зүйлд зааснаар Ерөнхий сайдад нэр дэвшигч нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон бүрэлдэхүүнээ танилцуулж, парламент мөрийн хөтөлбөр болон засгийн газрын бүтцийг нэгэн зэрэг шийднэ.

Үндсэн хуулийн 82 болон 91 дүгээр зүйлүүдэд зааснаар парламент нийт гишүүдийнхээ талаас илүүгийн саналаар ерөнхий сайд ба засгийн газрын гишүүдийг сонгоно.

### 5/ Хорват

*Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох.*

Үндсэн хуулийн 98 дугаар зүйлд Ерөнхийлөгч нь намуудын Парламентад авсан суудлын тоог харгалзан парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээсэн Ерөнхий сайдад нэр дэвшигчид Засгийн газар байгуулах эрх олгоно.

Мөн хуулийн 110-р зүйлд Засгийн газрыг бүрдүүлэх эрх олгогдсоноос хойш 30 хоногийн дотор Ерөнхий сайд танхимаа бүрдүүлж, мөрийн хөтөлбөрөө Парламентад танилцуулна. Парламентын нийт гишүүдийн олонхын саналаар Ерөнхий сайд болон Засгийн газарт итгэл үзүүлэхийг дэмжвэл Засгийн газрын бүрэн эрх хэрэгжиж эхлэх бөгөөд Ерөнхийлөгч Парламентын гаргасан шийдвэрийг үндэслэн Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг томилж, Парламентын дарга давхар гарын үсэг зурна. Засгийн газрын бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд томилох шийдвэрийг гаргах бөгөөд Парламентын дарга давхар гарын үсэг зурж баталгаажуулна.

**6/ Исланд**

*Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох:*

Исландын Үндсэн хуулийн 15-р зүйлд Ерөнхийлөгч нь сайд нарыг томилж, чөлөөлнө. Ерөнхийлөгч нь засгийн газрыг бүрдүүлэх сайд нарыг болон эрх үүргийг тогтоож, хариуцлага хүлээлгэнэ.

**7/ Сингапур**

*Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох:*

Үндсэн хуулийн 25-р зүйлд Сингапурын Ерөнхийлөгч Парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээх чадвартай гэж үзсэн Парламентын гишүүнийг Ерөнхий сайдаар томилох бөгөөд Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентын гишүүд дундаас Засгийн газрыг бүрдүүлэх сайд нарыг томилно.

Мөн хуулийн 26-р зүйлд Ерөнхий сайд нь Ерөнхийлөгчид огцрох тухай өргөдлөө бичгээр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий сайдыг Парламентын олонхын итгэлийг хүлээхгүй байна гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг огцруулна. Харин бусад сайд нарын хувьд Ерөнхийлөгч Ерөнхий сайдын зөвлөсний дагуу сайдыг тухайн албан тушаалаас нь албан ёсоор огцруулах тухай шийдвэр гаргана.

**8/ Словак**

*Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох:*

Үндсэн хуулийн 110-р зүйлд Словак улсын Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг томилж, чөлөөлнө. 111-р зүйлд Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч томилж, чөлөөлөх эрхтэй болно. Хэрвээ Словак улсын Үндэсний зөвлөлөөс Ерөнхий сайдад итгэл үл үзүүлэх санал гарган баталсан тохиолдолд Словак улсын Ерөнхийлөгч Ерөнхий сайдыг эргүүлэн татна. Ерөнхий сайдыг эргүүлэн татах нь Засгийн газрыг татан буулгаж буй хэрэг мөн.

**9/ Турк**

*Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох:*

Үндсэн хуулийн 109 дүгээр зүйлд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас томилно. Ерөнхий сайд нь Засгийн газрын сайд нарыг томилохдоо Үндэсний Их хурлын гишүүд дундаас, эсхүл Үндэсний Их хурлын гишүүнд тавигдах шаардлагыг хангасан этгээдийг томилох бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын санал болгосны дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.

**10/ Македон**

*Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох:*

Үндсэн хуулийн 90 дугаар зүйлд Македон улсын Ассамблей нь Ерөнхий сайдыг томилохоос өмнө хурлаараа Засгийн бүтэц зохион байгуулалтынхаа асуудлыг шийдвэрлэж дууссаны дараа 10 хоногт багтааж Ерөнхийлөгч нь Засгийн газрыг байгуулах эрхийг сонгуульд ялж хуралд олонх болсон нам эвсэлд, эсхүл нам эвслийн санал болгосон Ерөнхий сайдад нэр дэвшигчид олгоно.

**11/ Кыргызстан**

*Ерөнхий сайд, Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилох:*

Үндсэн хуулийн 84 дүгээр зүйлд Жогорку Кенешт талаас илүү суудал авсан бүлэг, эсвэл эвслийн бүлэг нь анхны хуралдаанаас хойш 15 хоногийн дотор Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ. Ерөнхий сайдад нэр дэвшигч Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүнийг Жогорку Кенешт санал болгоно. Хэрэв Жогорку Кенеш нь Засгийн газрыг хугацаандаа баталж чадаагүй бол, эсвэл сонгуулийн дүнд аль ч улс төрийн нам талаас илүү тооны суудал аваагүй бол Ерөнхийлөгч намын бүлгүүдийн аль нэгэнд 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлэхийг санал болгоно. Хугацаандаа баталж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дараагийн намын бүлэгт санал болгоно. Хэрэв хуульд хугацаандаа баталж чадаагүй бол намын бүлгүүд өөрсдийн санаачилгаар 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ.

Ерөнхийлөгч Ерөнхий сайд болон Засгийн газрын бусад гишүүдийг томилох шийдвэрийг 3 хоногт гаргана. Хэрэв хугацаандаа томилж чадаагүй бол нэр дэвшигчдийг томилогдсон гэж үзнэ.

Ерөнхийлөгч, Ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх, томилох болон чөлөөлөх үндсэн хуулийн зохицуулалт

Хүснэгт 1.

1. Монгол Улс

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцируулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	31.1. Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна.	31.2. Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ.	25.1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:	35.2. Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхын саналаар огцруулна.
	31.3. Анхан шатны сонгуульд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаар саналаа нууцаар гаргана.		5/ Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах;	
	34.4 Ерөнхийлөгч анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогч		31.4.Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.	
	31.5.Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхын санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулна. Дахин санал хураалтаар сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.			
	6. Хэрэв хоёр дахь санал хураалтаар Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн хэн нь ч ийнхүү сонгогчдын олонхын санал аваагүй бол дахин сонгууль явуулна.			

Ерөнхий сайд	33.1.2/ Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг, хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;	25.1. Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: б/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;
--------------	--	---

2. Болгар Улс

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгч тэй байна	93.3. Ерөнхийлөгчийн сонгууль нь нийт сонгогчдын талаас илүү хувь нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд талаас илүү хүчинтэй саналыг авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно. 93.4.Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн аль нь ч олонхын санал аваагүй бол саналаараа тэргүүлсэн хоёр нэр дэвшигчийг долоо хоногийн дотор дахин санал хураахаар шийдвэрлэнэ.	Сонгуулийн тухай хуулийн 6-р зүйл 1/ Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгчид улс төрийн нам, эвслээс болон бие даагчдын үндэсний нэрсийн жагсаалтаас нэр дэвшүүлнэ.	96. Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгч нь энэхүү Үндсэн хуулийн 76.2-т заасан тангаргийг Ардын Хурлын өмнө өргөснөөр эрх мэдлээ хэрэгжүүлж эхэлнэ.	103.1 Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгч нь Үндсэн хууль зөрчих, эх орноосоо урваснаас бусад тохиолдолд өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор хийсэн үйлдэлдээ хуулийн хариуцлага хүлээхгүй. 103.2. Ардын Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй саналаар Ерөнхийлөгчийг буруутгах асуудлыг хэлэлцэх бөгөөд нийт гишүүдийн гуравны хоёр нь дэмжсэн бол түүний буруутай хэмээн үзнэ. 103.3. Үндсэн хуулийн шүүх Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийн эсрэг мэдүүлгийг гарснаас хойш сарын дотор шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн шүүхээр Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийг эх орноосоо урвасан, эсхүл Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдвол Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийн бүрэн эрх дуусгавар болно.



<p><b>Ерөнхий сайд</b></p>		<p>99-р зүйл 1/Ардын Хурлын бүлгүүдтэй зөвшилцөн, хамгийн олон санал авсан бүлгээс Ерөнхий сайдад санал авсан нэр дэвшигчид Засгийн газрын бүрдүүлэхийг үүрэг болгоно. 2/ Нэр дэвшигч сайд нарын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 7 өдрийн дотор бүрдүүлж чадаагүй бол Ерөнхийлөгч хоёр дахь бүлгээс нэр дэвшсэн хүнд үүрэг өгнө. 3/ Хоёр дахь нэр дэвшигч өмнөх хэсэгт заасан тогтоосон хугацаанд Засгийн газрыг бүрдүүлж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дараагийн бүлэгт Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх үүрэг өгнө. 4/ Хэрэв сайд нарын зөвлөлийг амжилттай бүрдүүлбэл нэр дэвшигчийг Ерөнхий сайд болгох саналыг Ардын Хуралд оруулна. 5/ Хэрэв Засгийн газрыг бүрдүүлэх талаар зөвшилцөлд хүрч чадаагүй бол Ерөнхийлөгч Ардын Хурлыг тараах сонгуулийг товлон, түр засгийн газар томилно. Ардын Хурлыг тараасан Ерөнхийлөгчийн актаар шинэ сонгуулийн хугацаа тодорхойлогдоно.</p>	<p>84-р зүйл Ардын Хурал нь : 6/ Ерөнхий сайдыг сонгож, огцруулах; Ерөнхий сайдын саналаар Сайд нарын зөвлөлийн гишүүдийг томилж, чөлөөлөх; Ерөнхий сайдын саналаар Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;</p>	<p>89-р зүйл 1.Ардын Хурлын гишүүдийн тавны нэгээс доошгүй гишүүд Засгийн газарт итгэл үл үзүүлэх тухай саналаа гаргавал Ардын Хурал санал хураалт явуулна. Ардын Хурлын нийт гишүүдийн дийлэнх олонх нь дэмжсэн тохиолдолд тэдний саналыг хүчинтэйд тооцно. 2. Ардын Хурал Ерөнхий сайд, Засгийн газарт үл итгэх шийдвэр гаргавал Ерөнхий сайд Засгийн газрыг огцруулах тухай өргөдлөө гаргана. 3. Ардын Хурал Засгийн газарт итгэл үзүүлэхээр шийдвэрлэсэн бол үгчдэслэлээр Засгийн газарт итгэл үл үзүүлэх асуудлыг дараагийн 6 сард дахин тавихгүй.</p>
----------------------------	--	---	---	---

3. Финланд

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	54-р зүйл Бүгд найрамдах улсын ерөнхийлөгчийн бүх нийтийн шууд сонгуулиар 6 жилийн хугацаагаар сонгоно. Сонгуульд талаас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгоно. Аль нь нэр дэвшигч олонхын саналыг авч чадаагүй бол хамгийн их санал авсан 2 нэр дэвшигчийн хооронд шинэ сонгууль явуулна. Шинэ шатны сонгуулиар хамгийн их санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгоно. Зөвхөн нэг нэр дэвшигчийг нэр дэвшүүлсэн бол түүнийг сонгууль явуулахгүйгээр Ерөнхийлөгчөөр томилно.	54-р зүйл Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эрхийг Парламентад доод тал нь нэг суудал авсан улс төрийн нам дэвшүүлэх ба үүнээс гадна санал өгөх эрх бүхий 20000 иргэний бүлэг нэр дэвшүүлэх эрх эдэлнэ.	55-р зүйл Бүгд найрамдах улсын ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа албан тушаалаа сонгогдсон эрхийн хугацаа албан тушаалд сонгогдсон дараах сарын эхний өдөр эхэлнэ.	55-р зүйл Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа шинээр сонгогдсон ерөнхийлөгч албан тушаалаа сонгогдсоноор дуусааар болно. <b>Газар нь</b> Ерөнхийлөгч нас барсан, эсхүл <b>Засгийн газар нь</b> Ерөнхийлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадамжгүй гэж үзсэн тохиолдолд шинэ Ерөнхийлөгчийг аль болох түргэн сонгоно.
Ерөнхий сайд		61-р зүйл. Засгийн газрыг бүрдүүлэх Ерөнхий сайдыг сонгохоос өмнө бүхий бүлгүүд засгийн газрын мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг хэлэлцэнэ. Хэлэлцээг үндэслэн, Парламентын спикер болон парламентын бүлгүүдийн саналыг Ерөнхий сайдад нэр дэвшигчийг танилцуулна. Нэр дэвшигч нь хангалттай санал аваагүй тохиолдолд, мөн адил журмын дагуу өөр нэр дэвшигчийг дэвшүүлнэ. Хоёр дахь нэр дэвшигч талаас дээш хувийн санал авч чадаагүй тохиолдолд, Ерөнхий сайдын сонгуулийг Парламентын нээлттэй санал хураалтаар явуулна. Ингэсэн тохиолдолд хамгийн их санал авсан этгээдийг Ерөнхий сайдаар сонгоно.	61-р зүйл. Парламент сайдыг сонгох бөгөөд Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч тухайн албан тушаалд томилно. Нэр дэвшигчийг Парламентын нийт гишүүдийн талаас дээш хувь нээлттэй санал хураалтаар дэмжсэнээр Ерөнхий сайдаар сонгоно. /Финляндын 2000 онд батлагдсан Үндсэн хуулиар энэхүү эрх орсон <sup>99</sup> /	64-р зүйл Засгийн газар, эсхүл сайдыг огцруулах Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, болон сайд нараас үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтийг хүлээж авч шийдвэрлэнэ. Мөн Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын хүсэлтээр сайд нарыг үүрэгт ажлаас нь чөлөөлнө. Хэрвээ Засгийн газар эсхүл сайд нь Парламентын итгэлийг хүлээгээгүй тохиолдолд хүсэлт гаргаагүй үл харгалзан Ерөнхийлөгч Засгийн газар эсхүл сайдыг огцруулна. Сайд нь Бүгд найрамдах улсын ерөнхийлөгч, эсхүл Парламентын спикерээр сонгогдсон бол түүнийг сонгууль явагдсан өдөр сайдын албан үүргээсээ огцорсонд тооцно.

<sup>99</sup><http://www.asgp.co/sites/default/files/documents/INTCYJXYUTISQLTGGTUUWLCDXVERPCE.pdf>  
Өмнө нь Засгийн газрыг Ерөнхийлөгч шууд томилдог байсныг 2000 оны Үндсэн хуулиар Парламентын ил санал хураалтаар сонгодог болсон.

## 4.Сербия

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
<b>Ерөнхийлөгч</b>	114-р зүйл. Сонгууль бүгд найрамдах улсын ерөнхийлөгчийг хуульд заасны дагуу шууд, нууц санал хураалтаар сонгоно.	9-р зүйл. Ерөнхийлөгчид улс төрийн нам, эвсэл, эсхүл иргэний бүлгээс нэр дэвшүүлэх эрхтэй байна. 10-р зүйл. Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг дэмжиж доод тал нь 10000 гарын үсэг зурж шүүхээр баталгаажуулснаар дэвшүүлнэ.		117-р зүйл Ерөнхийлөгч нь өөрийн хүсэлтээр огцрох хүсэлтээ ард нийтэд болон Парламентын даргад мэдэгдэнэ. 116-р зүйл Бүгд найрамдах улсын ерөнхийлөгч нь огцрох өргөдлөө Парламентын даргад гаргана. 118-р зүйл Парламентын гишүүдийн 2/3-аас доошгүй саналаар Ерөнхийлөгчийг Үндсэн хуулийг зөрчсөн тухай үндэслэлээр огцруулна. Ерөнхийлөгчийг огцруулах тухай асуудлыг Парламентын гишүүдийн 2/3-аас доошгүй саналаар гаргаж болно.
<b>Ерөнхий сайд</b>		127-р зүйл Ерөнхийлөгч нь нэр дэвшигчдийн жагсаалтад төлөөлөгчдийн өгсөн саналыг харгалзан үзсэний үндсэн дээр Үндэсний Ассамблейд Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ.	127-р зүйл Ерөнхий сайдад нэр дэвшигч нь Үндэсний Ассамблейд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон засгийн газрын бүтцийг танилцуулна. Үндэсний Ассамблей нь Ерөнхий сайд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг хамтад нь сонгоно. Засгийн газрыг Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн олонхын саналаар томилно.	133-р зүйл Засгийн газрын гишүүн нь огцрох тухай өргөдлөө Ерөнхий сайдад өргөн барьж болно. Ерөнхий сайд нь сайдын огцрох тухай хүсэлтийг Үндэсний Ассамблейн даргад өргөн барих ба хамгийн ойрын дараагийн хуралдах Үндэсний Ассамблейн хуралдаанаар хэлэлцэнэ. Ерөнхий сайд нь сайдыг албан тушаалаас нь огцруулах тухай хүсэлтийг Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлэх ба огцруулах тухай асуудлыг дараагийн хуралдаанаар хэлэлцэж, нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

## 5. Чрна Гора

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшиүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
<b>Ерөнхийлөгч</b>	96-р зүйл. Сонгууль Чрна Горын улсын Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар шууд, нууц санал хураалтаар сонгоно. Сүүлийн 15 жилийн дотор доод тал нь 10 жил Чрна Гора улсад оршиж сууж буй Чрна Горын улсын иргэнийг Ерөнхийлөгчөөр сонгож болно. Парламентын спикер нь Ерөнхийлөгчийн сонгуулийг зарлана.	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль 2007 4-р зүйл. Ерөнхийлөгчид улс төрийн нам, эсхүл нийт сонгогчдын 1.5%-тай тэнцэх иргэний гарын үсэг зурсныг үндэслэн бүлэг хүмүүс нэр дэвшүүлж болно. Нэг нам, эсхүл иргэний бүлэг нь нэг л нэр дэвшигчийг дэвшүүлэх эрх эдэлнэ. Хоёр буюу түүнээс дээш улс төрийн нам нь хамтран нэр дэвшүүлж болно.	Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль 2007 4-р зүйл Чрна Горын улсын Ерөнхийлөгчийг талаас дээш хувийн саналаар сонгоно. Аль ч нэр дэвшигч хангалттай санал авч чадаагүй нөхцөлд, 14 хоногийн дараа хоёр дахь шатны сонгуулийг хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн хооронд явуулна. Хоёр дахь шатны сонгуулиар хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгоно.	98-р зүйл. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусааар болох Ерөнхийлөгчийг бүрэн эрхийн хугацаа нь дуусааар болсон, эсхүл бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсны улмаас огцрох өргөдлөө өгсөн, эсхүл импичментээр огцруулна. Ерөнхийлөгч нь Үндсэн хуулийг зөрчсөний төлөө хариуцлага хүлээнэ. Парламент нь Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг тогтооход 25-аас доошгүй Парламентын гишүүдийн саналаар хэлэлцэнэ. Үндсэн хуулийн шүүх нь Ерөнхийлөгчийг Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг тогтоож, шийдвэрээ Парламент болон Ерөнхийлөгчид нэн даруй танилцуулна. Үндсэн хуулийг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд Парламент Ерөнхийлөгчийн огцруулна.
<b>Ерөнхий сайд</b>		103-р зүйл. Сонгууль Чрна Горын улсын Ерөнхийлөгч нь Парламентыг сонгогдсоноос хойш 30 хоногийн дотор нэр дэвшигчийг санал болгоно. Ерөнхий сайдад нэр дэвшигч нь Парламентад мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг танилцуулна. Парламент нь нэгэн зэрэг нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг шийдвэрлэнэ.		105-р зүйл. Засгийн газрыг огцруулах болон импичмент Засгийн газар болон засгийн газрын гишүүн нь үүрэгт ажлаасаа огцорч болно. Ерөнхий сайд огцорсноор Засгийн газрыг огцорсонд тооцно. Ерөнхий сайд Парламентад Засгийн газрын гишүүнийг огцруулах хүсэлт тавьж болно. 107-р зүйл. Итгэл үл үзүүлэх. Парламент нь засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалт явуулж болно. Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг доод тал нь 27 парламентын гишүүний саналаар гаргана. Хэрэв Парламент нь Засгийн газарт итгэл хүлээсэн тохиолдолд, санал гаргасан гишүүд 90 хоногийн дотор дахин итгэл үзүүлэх эсэх талаар санал оруулах эрхгүй байна.

## 6.Хорват

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъёкт	Огцруулах /чөлөөлөх субъёкт
<b>Ерөнхийлөгч</b>	95. Ерөнхийлөгч нь 5 жилийн хугацаагаар бүх нийтийн шууд сонгуулийн үндсэн дээр нууц санал хураалтаар сонгогдоно. Сонгогчдын олонхын санал авсан нэр дэвшигч ерөнхийлөгчөөр сонгогдоно. Хэн ч олонхын санал аваагүй тохиолдолд сонгуулийг 14 хоногийн дараа дахин явуулна. Эхний сонгуулиар хамгийн их санал авсан 2 нэр дэвшигч дараагийн сонгуульд оролцох эрхтэй.	Хорват улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. 7 зүйл Бүгд Найрамдах Хорват Улсын ерөнхийлөгчид нэр дэвшигч нь Хорват улсад бүртгэлтэй улс төрийн нам болон бие даагч нэр дэвшигч байна. 2 болон түүнээс дээш улс төрийн нам 1 нэр дэвшигчдийг дэвшүүлж болно. 8 зүйл. Бүгд Найрамдах Хорват Улсын ерөнхийлөгчид нэр дэвшигч нь сонгогчдоос наад зах нь 10000 гарын үсэг цуглуулж байж нэр дэвших эрхтэй болно.	Хорват улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. 49. Бүгд Найрамдах Хорват Улсын ерөнхийлөгч нь ажил үүргээ хүлээн авсан өдрөө Хорватын үндсэн хуулийн шүүхийн өмнө тангараг өргөснөөр бүрэн эрх нь хэрэгжиж эхэлнэ.	105 зүйл. Бүгд Найрамдах Хорват улсын ерөнхийлөгчийг үүргээ гүйцэтгэж байхдаа үндсэн хуулийг зөрчсөн гэж үзвэл Парламентын гишүүдийн 2/3 -ийн саналаар огцруулах саналыг үндсэн хуулийн шүүхэд оруулна. Үндсэн хуулийн шүүх нийт шүүгчдийн 2/3-ийн саналаар Бүгд Найрамдах Хорват улсын ерөнхийлөгчийг огцруулах асуудлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. Хэрвээ үндсэн хуулийн шүүх ерөнхийлөгчийг үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл ерөнхийлөгч албан үүргээсээ чөлөөлөгдөнө.

Ерөнхий сайд	<p>98 зүйл.</p> <p>3/ Ерөнхийлөгч нь намуудын Парламентад авсан суудлын тоог харгалзан парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээсэн Ерөнхий сайдад нэр дэвшигчид Засгийн газар байгуулах эрх олгоно.</p>	<p>110-р зүйл</p> <p>Ерөнхийлөгчөөс Засгийн газрыг бүрдүүлэх эрх олгосон нэр дэвшигч нь Засгийн газрын гишүүдийн нэрийг дэвшүүлнэ.</p> <p>Засгийн газрыг бүрдүүлэх эрх олгогдсоноос хойш газрыг бүрдүүлэх эрх олгогдсоноос хойш 30 хоногийн дотор ерөнхий сайд танхимаа бүрдүүлж, мөрийн хөтөлбөрөө Парламентад танилцуулж, итгэл үзүүлэх эсэх асуудлыг Парламентад оруулна. Парламентын нийт гишүүдийн олонхын саналаар Ерөнхий сайд болон Засгийн газарт итгэл үзүүлэхийг дэмжвэл Засгийн газрын бүрэн эрх хэрэгжиж эхэлнэ.</p> <p>Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаарх Парламентын гаргасан шийдвэрийг үндэслэн Ерөнхийлөгч ерөнхий сайдыг томилж, Парламентын дарга давхар гарын үсэг зурна. Ерөнхий сайд Засгийн газрын гишүүдийг томилж шийдвэрийг гаргаж, парламентын дарга давхар гарын үсэг зурж баталгаажуулна. Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүд Парламентад тангараг өргөнө.</p> <p>111-р зүйл</p> <p>Засгийн газрыг байгуулах эрх олгогдсоноос хойш 30 хоногийн дотор Засгийн газрыг бүрдүүлж чадаагүй, эсхүл Парламентаас Засгийн газарт итгэл үзүүлэх боломжгүй гэж үзвэл Ерөнхийлөгч хугацааг 30 хүртэлх хоногоор сунгаж болно. Энэ хугацаанд бүрдүүлж чадаагүй бол Ерөнхийлөгч Засгийн газрыг байгуулах эрх бүхий этгээдэд өөр нэр дэвшигчийг нэр дэвшүүлнэ.</p>	<p>116 зүйл.</p> <p>Ерөнхий сайд, Засгийн газар, Засгийн газрын гишүүдийг огцруулах асуудлыг парламентын гишүүдийн 1/5 саналаар оруулж парламент дэмжвэл Засгийн газар огцорно. Парламент дээрх асуудлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. Засгийн газрыг огцруулах асуудлыг парламентын гишүүдийн олонх дэмжээгүй бол дээрх асуудлаар 6 сарын дотор дахин авч хэлэлцэхгүй.</p>
--------------	---	--	--



7. Исланд

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцируулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	2-р зүйл Ерөнхийлөгч нь бүх ард түмнээс сонгогдоно.  5-р зүйл. Ерөнхийлөгч болон Улсын Их Хурал нь бүх нийтийн, шууд санал хураалтаар сонгогдоно. Хэрэв олон нэр дэвшигч өрсөлдөж байгаа тохиолдолд олонхын санал авсан нэр дэвшигч, нэг нэр дэвшигч өрсөлдөж байгаа тохиолдолд түүнийг санал хураалтгүйгээр сонгогдсонд тооцно.	5-р зүйл.  Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь 1500-с багагүй, 3000-с ихгүй сонгогчдын дэмжлэг авснаар нэр дэвшинэ. Хэрэв олон нэр дэвшигч өрсөлдөж байгаа тохиолдолд олонхын санал авсан нэр дэвшигч, нэг нэр дэвшигч нэр дэвшсэн тохиолдолд түүнийг санал хураалтгүйгээр сонгогдсонд тооцно.		
Ерөнхий сайд			15-р зүйл. Ерөнхийлөгч нь сайд нарыг томилж, чөлөөлнө. Сайдын тоо болон эрх үүргийг тогтоож, хариуцлага хүлээлгэнэ.	

8. Сингапур

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцуулах /чөлөөлөх субъект
<b>Ерөнхийлөгч</b>	<p>20.1 Бүх нийтийн шууд сонгуулиар 6 жилээр сонгодог. Ерөнхий сайд нь Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх товыг зарлана, Нэр дэвшүүлэх өдөр зөвхөн нэг нэр дэвшигч материалаа ирүүлсэн бол, түүнийг Ерөнхийлөгчөөр сонгогдсоноор зарлана. Нэгээс дээш нэр дэвшигч байгаа тохиолдолд сонгууль зарлаж сонгуулиар хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгоно.</p>	<p>19-р зүйл. Ерөнхийлөгчид нэр дэвшигч нь дараах болзлыг хангасан байна: Сингапурын иргэн байх; 45-с дээш насны сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгүүлсэн байх; Сингапур улсад нийтдээ 10-с доошгүй жил оршин суусан байх 45-р зүйлд заасан нөхцөлийг хангаагүй байх /Ерөнхийлөгчийн албан тушаалд харшлах нөхцөлүүд/ Ерөнхийлөгчийн сонгуулийн хорооноос тавигдах ёс зүйн болзлыг хангасан байх Нэр дэвших үедээ аль нэг намыг гишүүн бус байна; 3 жилээс дээш хугацаагаар дараах албан тушаалыг хашсан байх; Сайд, Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Спикер, Ерөнхий прокурор, Нийтийн албаны комиссын дарга, Ерөнхий аудитор, Ерөнхий нягтлан бодогч эсхүл ТБНД, 22А-д заасан төрийн зөвлөлийн дарга, эсхүл ерөнхий захирал, 100 сая ам.доллараас дээш хөрөнгө бүхий компанийн ТУЗ-ын дарга, эсхүл ерөнхий захирал, эсхүл дээрхтэй төстэй төрийн эсхүл хувийн байгууллагад, дээрхтэй төстэй албан тушаал эрхэлж байсан, Ерөнхийлөгчийн үүргийг гүйцэтгэхэд шаардагдах санхүүтэй холбоотой асуудлыг удирдаж, зохион байгуулах туршлагатай байх.</p>	<p>20-р зүйл Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь албан үүргээ хүлээн авснаас хойш 6 жил байна. Шинээр сонгогдсон Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан, эсхүл Ерөнхийлөгчийн албан тушаал эзгүй байгаа тохиолдолд сонгууль явагдсаны дараачийн өдөр эхэлнэ. Ерөнхийлөгч нь албан үүргээ хүлээж авахдаа Дээд шүүхийн ерөнхий шүүгч, эсхүл Дээд шүүхийн бусад шүүгчийг байлцуулж, тангараг өргөнө.</p>	



<b>Ерөнхий сайд</b>	25-р зүйл. Ерөнхий сайдыг томилох Ерөнхийлөгч Парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээх чадвартай гэж үзсэн Парламентын гишүүнийг Ерөнхий сайдаар томилох бөгөөд Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентын гишүүд дундаас сайд нарыг томилно. Ингэхдээ Парламент тасран үед томилоо хийхдээ өмнөх Парламентын гишүүнийг томилж болох ба тэрээр шинэ Парламентын анхны хуралдаан явагдсанаас хойш, тухайн Парламентын гишүүн бус нөхцөлд албан үүргээ үргэлжлүүлэх эрхгүй байна. Энэхүү зүйлд заасан томилгоог Ерөнхийлөгч хийх бөгөөд төрийн тамгаар баталгаажуулна.	26-р зүйл. А.Ерөнхий сайд огцрох тухай өргөдлөө Ерөнхийлөгчид бичгээр гаргасан, эсхүл Б. Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий сайдыг Парламентын олонхын итгэлийг хүлээхгүй байна гэж үзсэн тохиолдолд, 2А. Ерөнхий сайдаас бусад сайд нарыг дараах нөхцөлд огцруулна: Ерөнхийлөгч Ерөнхий сайдын зөвлөсний дагуу сайдыг тухайн албан тушаалаас нь албан ёсоор огцруулах тухай шийдвэр гаргасан.
---------------------	--	---

9. Словак

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъе́кт	Огцруулах /чөлөөлөх субъе́кт
<b>Ерөнхийлөгч</b>	101.2/Ерөнхийлөгчийг Словакийн иргэд шууд сонгуулиар нууц санал хураалтаар таван жилийн хугацаатай сонгоно. 4/ Нийт сонгогчдын талаас илүү хувийн санал авсан нэр дэвшигч Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Хэрвээ аль ч нэр дэвшигч сонгогчдын тухайлан заасан хэмжээний олонхын саналыг авч чадахгүй бол хоёр дахь санал хураалтыг 14 өдрийн дотор зохион байгуулна.	(3)Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг Парламентын 15-аас цөөнгүй гишүүд эсхүл Словак улсын Үндэсний зөвлөлийн сонгуулийн эрх бүхий иргэд наанадаж 15000 санал өргөх үндсэн дээр дэвшүүлнэ. Сонгуулийн тов гаргасан өдрөөс хойш 21 өдрийн дотор нэр дэвшигчийн нэрийг Словак улсын Үндэсний зөвлөлийн даргад өргөн барина.	(7) Сонгогдсон нэр дэвшигч тангараг Ерөнхийлөгчийн албаны эрх үүрэг нь эхэлнэ. Тэрээр Ерөнхийлөгчийн өмнөх албан хугацаа дуусгавар болох өдрийн үдээс өмнө Словак улсын Үндэсний зөвлөлийн өмнө Үндсэн хуулийн шүүхийн тэргүүний хөтөлбөрөөр тангараг өргөнө.	106.1/ Ерөнхийлөгчийг хугацаанаас нь өмнө бүх нийтийн санал хураалтаар эргүүлэн татаж болно. Ерөнхийлөгчийг эргүүлэн татах тухай бүх нийтийн санал асуултыг Словак улсын Үндэсний зөвлөлийн дарга Словак улсын Үндэсний зөвлөлийн бүх гишүүдийн тавны гурваас багагүй хувь эзлэх олонхын санал бүхий шийдвэрт үндэслэн зарлана. 2/ Хэрвээ эрх бүхий сонгогчдын талаас илүү хувь нь түүнийг эргүүлэн татах санал өгвөл Ерөнхийлөгчийг эргүүлэн татна.

Ерөнхий сайд	<p>110. Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.</p> <p>111. Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч Засгийн газрын гишүүдийг томилж, чөлөөлөх ба тэдэнд яамдыг удирдах бүрэн эрх олгоно.</p>	<p>115-р зүйл.</p> <p>1/ Хэрвээ Словак улсын Үндэсний зөвлөл итгэл үл үзүүлэх санал хурааж баталвал, эсхүл Засгийн газрын итгэл үзүүлэх саналын хүсэлтийг хүлээн аваагүй бол Словак улсын Ерөнхийлөгч Засгийн газрыг эргүүлэн татна.</p> <p>116-р зүйл.</p> <p>2/ Засгийн газрын гишүүн нь огцрох хүсэлтээ Словак улсын Ерөнхийлөгчид өргөн барина.</p> <p>4/ Засгийн газрын хэн нэгэн гишүүнийг эргүүлэн татах тухай саналыг Ерөнхий сайд Ерөнхийлөгчид өргөн барьж болно.</p> <p>6/ Хэрвээ Словак улсын Үндэсний зөвлөлөөс Ерөнхий сайдад итгэл үл үзүүлэх санал гарган баталбаас Словак улсын ерөнхийлөгч түүнийг эргүүлэн татна. Ерөнхий сайдыг эргүүлэн татах нь Засгийн газрыг татан буулгаж буй хэрэг мөн.</p>
--------------	---	---



10. Турк

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	102-р зүйл 1/ Ерөнхийлөгчид бүх нийтийн сонгуулиар нийт сонгогчдын үнэмлэхүй олонхын санал авсан нэр дэвшигч сонгогдоно. 2/ Хэрвээ анхны санал хураалтаар үнэмлэхүй олны санал аваагүй бол үүнээс хойш 2 дахь ням гаригт нь 2 дахь санал хураалтыг зохион байгуулна. 2 дахь санал хураалтад эхний санал хураалтаар хамгийн их санал нэр дэвшигч нь Ерөнхийлөгчөөр сонгогдоно.	101-р зүйл. Улсын Ерөнхийлөгчөөр Үндэсний Их Чуулган гишүүд дотроосоо 40 нас хүрсэн, дээд боловсролтой гишүүнийг, эсхүл Туркийн иргэд дундаас эдгээр шаардлагуудыг хангасан, депутатаар сонгогдох шаардлагыг хангасан иргэнийг сонгоно. Ингэхдээ дээрх шаардлага хангасан иргэнийг чуулганы доод тал нь 20 гишүүний бичгээр илэрхийлсэн саналыг үндэслэн нэр дэвшүүлнэ.	103-р зүйл Ерөнхийлөгч нь Үндэсний зөвлөлийн өмнө тангараг өргөнө.	105-р зүйл. Ерөнхийлөгчийг Туркийн Үндэсний Их Чуулганы бүх гишүүдийн гуравны нэгээс доошгүй саналаар, эсхүл бүх гишүүдийн дөрөвний гуравас доошгүйн шийдвэрээр эх орноосоо урвасан хэмээн үзвэл огцруулж болно.
Ерөнхий сайд		109-р зүйл. Сайд нарын зөвлөл нь Ерөнхий сайд болон сайд нараас бүрдэнэ. Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас томилно. Сайд нарын Зөвлөлийн Зөвлөл нь Ерөнхий сайд болон сайд нараас бүрдэнэ. Ерөнхий сайд нь сайд нарыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас, эсхүл Үндэсний Их хурлын гишүүнд тавигдах шаардлагыг хангасан этгээдийг томилж бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын санал болгосны дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.		

11. Македон

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	80-р зүйл Ерөнхийлөгчийг ард нийтийн шууд сонгуулиар, нууц санал хураалтаар 5 жилийн хугацаатай сонгоно.			87-р зүйл. Ерөнхийлөгч үйл ажиллагааныхаа явцад Үндсэн хууль, бусад хуулийг зөрчөөл хариуцлага хүлээнэ. Ерөнхийлөгчид хариуцлага тооцох санаачилгыг Хурал нийт бүрэлдэхүүнийхээ 2/3-ын саналаар, хариуцлага тооцох шийдвэрийг Үндсэн хуулийн цэц гаргана.

Ерөнхий сайд		84-р зүйл. Засгийн газрын бүрэлдэхүүнийг тодорхойлох эрхийг Ерөнхийлөгч олгоно. 90-р зүйл Хурал бүтэц зохион байгуулалтынхаа асуудлыг шийдэж дууссаны дараа 10 хоногт багтааж Ерөнхийлөгч нь Засгийн газрыг байгуулах эрхийг сонгуульд ялж хуралд олонх болсон нам эвсэлд, эсхүл нам эвслийн санал болгосон нэр дэвшигч [Ерөнхий сайд болох] –д олгоно.	
--------------	--	---	--

12. Кыргызстан

	Сонгуулийн хэлбэр	Нэр дэвшүүлэх	Томилдог /Баталдаг субъект	Огцруулах /чөлөөлөх субъект
Ерөнхийлөгч	61-р зүйл. Ерөнхийлөгч нь ард нийтийн сонгуулиар, 6 жилийн хугацаатай сонгогдоно. (Кыргызийн үндсэн хуульд зааснаар, нэг хүн 2 удаа Ерөнхийлөгч болох боломжгүй.	62-р зүйл. Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн тоог хязгаарлахгүй. 30000 дэмжигчийн гарын үсэг цуглуулсан хүн Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгэгдэх боломжтой.		66-69-р зүйл 1/ өөрийн хүсэлтээр 2/ эрүүл мэндийн шалтгаанаар 3/ Гэм буруутай нь тогтоодсон бол Ерөнхийлөгчийг буруутгах үндэслэлийг Жогорку Кенеш гаргахдаа "тусгай комиссын дүгнэлтэд үндэслэх" ба огцруулах саналыг түүний нийт бүрэлдэхүүний 2/3 -с багагүй хэсэг нь "дэмжсэн" байх шаардлагатай;

Ерөнхий сайд	<p>84.1 Жогорку Кенешт талаас илүү судал авсан бүлэг, эсвэл эвслийн бүлэг нь анхны хуралдаанаас хойш 15 хоногийн дотор Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ. Ерөнхий сайдад нэр дэвшигч Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүнийг Жогорку Кенешт санал болгоно.</p> <p>84.2 Хэрэв Жогорку Кенеш нь Засгийн газрыг хугацаандаа баталж чадаагүй бол, эсвэл сонгуулийн дүнд аль ч улс төрийн нам талаас илүү тооны суудал аваагүй бол Ерөнхийлөгч намын бүлгүүдийн аль нэгэнд 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлэхийг санал болгоно.</p> <p>84.3 Хугацаандаа баталж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дараагийн намын бүлэгт санал болгоно.</p> <p>84.4 Мөн хугацаандаа баталж чадаагүй бол намын бүлгүүд өөрсдийн санаачилгаар 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ.</p>
	<p>84.5 Ерөнхийлөгч Ерөнхий сайд болон Засгийн газрын бусад гишүүдийг томилох шийдвэрийг 3 хоногт гаргана. Хэрэв хугацаандаа томилж чадаагүй бол нэр дэвшигчдийг томилогдсон гэж үзнэ.</p> <p>84.6 Хэрэв парламент Үндсэн хуульд заасны дагуу Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүнийг баталж чадаагүй бол Ерөнхийлөгч хугацаанаас өмнө Жогорку Кенеш (парламент)-ийн сонгуулийг зарлана.</p>

**Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зарим орны  
Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй харьцуулсан байдал**

Судалгааны энэхүү хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулиар тогтоосон бүрэн эрхийг Болгар, Исланд, Кыргызстан, Македон, Сингапур, Серби, Словак, Турк, Финлянд, Хорват, Чрна Гора зэрэг 11 орны Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар хэрхэн зохицуулсан талаар харьцуулсан хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 2-т Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн холбогдох зүйл, заалт нь дээр дурдсан 11 орны Ерөнхийлөгчид Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон тохиолдолд (+), хэрэв уг бүрэн эрх олгогдоогүй бол (-), Үндсэн хууль болон бусад хуулиар ижил төстэй хуулийн зохицуулалт байхгүй бол (Н), бусад байгууллага, субъектүүдтэй хамтран хэрэгжүүлж байгаа бол (+3) гэсэн тэмдэглэгээгээр тус тус орууллаа. Мөн Хавсралт 1-ээр тухайн орны хувьд Хүснэгт 2-т харьцуулсан бүрэн эрхийг хэрхэн зохицуулдаг талаар хуулийн зохицуулалтыг тусгасан болно.

Хүснэгт 2.

**Монгол Улсын болон зарим орны Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн харьцуулалт:**

№	Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх	Болгар	Финлянд	Серби	Чрна Гора	Хорват	Исланд	Сингапур	Словак	Турк	Македон	Кыргызстан
1	26. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ.	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	27. 3. Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшихийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно.	+	-	-	+	+	+	*	-	+	Н	+
3	27. 4. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана.	+	-	-	-	+	+	*	+	-	+	-
4	31. 7. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.	+	+	+	+	+	Н	Н	-	+	+	-
5	33.1. 6/ Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах;	+	+	+	+	+	-	-	+	+	+	+
6	33.1. 7/ улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах;	+	+	+	+	+	Н	Н	+	+	+	+
7	33.1. 8/ уучлал үзүүлэх;	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
8	33.1. 9/ Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх;	+	-	-	-	-	-	-	-	-	-	+
9	33.1. 10/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх;	+	-	+	+	+	Н	Н	Н	+	+	+
10	33.1. 11/ бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах;	+	+	Н	Н	Н	Н	-	+	Н	Н	+

№	Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх	Болгар	Финланд	Серби	Чрна Гора	Хорват	Исланд	Сингапур	Словак	Турк	Македон	Кыргызстан
11	33.2. Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.	+	+	+	+	+	Н	Н	+	+	+	+
12	65. 1. Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.	+	-	+	-	-	-	+3	+	+	-	+
13	33.4. Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно.	Н	+	-	+	-	-	-	+	+	-	-

**Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бусад субъектуудтай хамтран хэрэгжүүлэх эрхийг зарим орны Ерөнхийлөгчийн эрхтэй харьцуулсан байдал**

№	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх	Болгар	Финланд	Серби	Чрна Гора	Хорват	Исланд	Сингапур	Словак	Турк	Македон	Кыргызстан
1	33.1. 1/ Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ;	-	-	-	-	Н	-	+3	-	+	-	-
2	33.1. 2/ Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхоороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;	+	+	+	-	+	+	+Д	+	+	+	+
3	33.1. 3/ өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно;	Н	Н	Н	Н	Н	Н	Н	Н	Н	Н	Н

№	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх	Болгар	Финланд	Серби	Чрна Гора	Хорват	Исланд	Сингапур	Словак	Турк	Македон	Кыргызстан
4	33.1. 4/ гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах;	+	+	+	+	+3	+	Н	+3	+	+	+3
5	33.1. 5/ Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах;	+	+	+	+	+	Н	Н	-	+	+	+3
6	33.1. 12/ Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.	+	+3	+	-	-	Н	Н	-	-	+3	+
7	51. 2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.	+	+	-	-	+	Н	+3	+	-	-	+
8	56. 2. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.	+	+	-	-	-	Н	+3	+	+	-	+

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН



**ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙГ ХУУЛИАР ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ**

**26-р зүйл. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ.**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	87 дугаар зүйл Үндэсний Ассамблейн гишүүн бүр, эсхүл Сайд нарын зөвлөл хууль санаачлах эрхтэй байна.
2	<b>Финлянд</b>	70 дугаар зүйл. Хууль батлах хүсэлтийг Засгийн газраас санал болгосноор Парламент, эсхүл Парламентын гишүүн гаргаж болно. Парламентын гишүүн нь Парламентын чуулгантай үед хүсэлт гаргана.
3	<b>Серби</b>	107 дугаар зүйл. Хууль болон бусад шийдвэрийн төсөл санаачлах эрхийг: Парламентын гишүүн тус бүр, автономит мужуудын Ассамблей, эсхүл доод тал нь 30000 сонгогчийн санаачилгаар хууль санаачилна. Иргэний хамгаалагч болон Сербийн Үндэсний Банк нь өөрийн эрх мэдэлд хамаарах асуудлаар хууль өргөн мэдүүлэх эрхтэй байна.
4	<b>Чрна Гора</b>	93 дугаар зүйл. Хууль санаачлах эрхийг Засгийн газар болон Парламентын гишүүн эдэлнэ. Мөн хууль санаачлах эрхийг 6000 сонгогч өөрсдийн итгэмжилсэн Парламентын гишүүнээр дамжуулан хэрэгжүүлнэ.
5	<b>Хорват</b>	85 дугаар зүйл Хорватын Парламентын гишүүн, төлөөлөгчдийн парламентын бүлгүүд болон Парламентын байнгын хороод болон Засгийн газар нь хууль санаачлах эрхтэй байна.
6	<b>Исланд</b>	25 дугаар зүйл Ерөнхийлөгч нь хуулийн төсөл болон бусад шийдвэрийн төслийг Парламентад өргөн барих эрхтэй байна. 38 дугаар зүйл Парламентын гишүүд болон сайд нар хууль болон бусад шийдвэрийн төсөл санаачлах гаргах эрхтэй байна.
7	<b>Сингапур</b>	59 дүгээр зүйл Энэхүү Үндсэн хууль болон Парламентын тогтоолд заасны дагуу аль ч гишүүн хууль санаачлах эрхтэй байна.
8	<b>Словак</b>	87 дугаар зүйл Үндэсний зөвлөлийн байнгын хороод, Парламентын гишүүд болон Засгийн газар хууль санаачлах эрхтэй байна.
9	<b>Турк</b>	88 дугаар зүйл Сайд нарын зөвлөл болон Парламентын гишүүд хууль санаачлах эрхтэй байна.
10	<b>Македон</b>	71 дүгээр зүйл Хууль санаачлах эрхийг Парламентын гишүүн, Засгийн газар болон 10000 сонгогч эдэлнэ.
11	<b>Кыргызстан</b>	79 дүгээр зүйл Хууль санаачлах эрхийг: 10000 сонгогч, Парламентын гишүүн, Засгийн газар эдэлнэ.

**27.3. Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшихийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно.**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	78 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн дарга Ассамблейг дараах тохиолдолд зарлан хуралдуулна. 1. Өөрийн санаачилгаар, 2. Гишүүдийн 1/5-ийн шаардлагаар 3. Ерөнхийлөгчийн хүсэлтээр 4. Сайд нарын зөвлөлийн хүсэлтээр
2	<b>Финлянд</b>	33 дугаар зүйл. Шаардлагатай үед Парламентын спикер шинэ сонгууль явагдахаас өмнө Парламентын чуулганыг зарлана.
3	<b>Серби</b>	106 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг гишүүдийн гуравны нэгээс дээшихийн шаардсанаар, эсхүл чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг баталсан тохиолдолд Засгийн газрын саналаар зарлаж болно.
4	<b>Чрна Гора</b>	90 дугаар зүйл. Ерөнхийлөгч, засгийн газар, эсхүл Парламентын гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар Парламентын ээлжит бус чуулганыг зарлана.
5	<b>Хорват</b>	79 дүгээр зүйл. Хорват Улсын Парламентын онцгой чуулганыг Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл гишүүдийн олонхын саналаар зарлан хуралдуулна. Ерөнхийлөгч парламентын намын бүлгүүд урьдчилан зөвлөлдсөний үндсэн дээр онцгой чуулганыг зарлах эрхтэй байна.
6	<b>Исланд</b>	23 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Парламентыг жилд нэг удаа хоёр долоо хоногоос ихгүй хугацаанд завсарлуулах эрхтэй байна. Ерөнхийлөгч өөрийн хүсэлтээр мөн Парламентын гишүүдийн олонхын шаардсанаар ээлжит бус чуулганыг зарлана.
7	<b>Сингапур</b>	-
8	<b>Словак</b>	83.2 дугаар зүйл. Үндэсний зөвлөлийн дарга нь хүсэлтээрээ, эсхүл гишүүдийн тавны нэгээс дээшихийн саналаар ээлжит бус чуулган зарлана. Энэ тохиолдолд 7 хоногийн дотор ээлжит бус чуулганыг хуралдуулна.
9	<b>Турк</b>	93 дугаар зүйл. Ерөнхийлөгч өөрийн санаачилгаар, эсхүл Сайд нарын зөвлөлийн хүсэлтээр ээлжит бус чуулган зарлана. Мөн Парламентын спикер өөрийн хүсэлтээр, эсхүл гишүүдийн тавны нэгийн бичгээр гаргасан хүсэлтээр ээлжит бус чуулганыг зарлана.
10	<b>Македон</b>	-
11	<b>Кыргызстан</b>	64.2 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Парламентын ээлжит бус чуулган зарлах эрхтэй байна. Парламентын спикер нь Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл Парламентын гишүүдийн гуравны нэгээс доошгүйн хүсэлтээр ээлжит бус чуулганыг зарлана.

**27. 4. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана.**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	75 дугаар зүйл. Үндэсний Ассамблейн анхдугаар чуулганыг сонгууль явагдсанаас хойш нэг сарын дотор Ерөнхийлөгч товлон зарлана. Ерөнхийлөгч товлон зарлаагүй тохиолдолд Үндэсний Ассамблейн 1/5 гишүүдийн саналаар товлон зарлана.
2	<b>Финлянд</b>	Парламентын дэгийн тухай журам 2 дугаар зүйл <sup>99</sup> . Парламентын анхдугаар чуулганыг хууль зүйн канцлер гишүүдийн нэрсийн жагсаалтаар гишүүдийг дуудаж эхлүүлнэ.
3	<b>Серби</b>	101 дүгээр зүйл. Парламентын анхдугаар чуулганыг сонгуулийн дүн зарлагдсанаас хойш 30 хоногийн дотор өмнөх Парламентын спикер товлон зарлана.
4	<b>Чрна Гора</b>	88 дугаар зүйл. Шинээр сонгогдсон Парламентын анхдугаар чуулганыг сонгуулийн дүн зарлагдсанаас хойш 15 хоногийн дотор өмнөх Парламентын спикер товлон зарлана.
5	<b>Хорват</b>	98 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Хорватын Парламентын сонгуулийг зарлаж, Парламентын анхдугаар чуулганыг зарлана.
6	<b>Исланд</b>	22 дугаар зүйл. Ерөнхийлөгч Парламентын сонгууль явагдсанаас хойш 10 долоо хоногоос хэтрэлгүй Парламентын анхдугаар чуулганыг товлон зарлана.
7	<b>Сингапур</b>	-
8	<b>Словак</b>	82.2 дугаар зүйл. Үндэсний зөвлөлийн нээлтийн чуулганыг Словак улсын Ерөнхийлөгч сонгуулийн дүн зарласнаас хойш 30 хоногийн дотор зарлана. Эсвэл Үндэсний зөвлөл нь сонгуулийн дүн зарлагдсанаас хойш 13 дахь өдөр хуралдана.
9	<b>Турк</b>	Парламентын дэгийн тухай журам 3 дугаар зүйл <sup>100</sup> . Парламентын анхдугаар чуулганыг зарлахгүй бөгөөд сонгуулийн дүн зарлагдсаны 5 дахь өдрийн 15 цагт хуралдана.
10	<b>Македон</b>	Парламентын дэгийн тухай хууль 9 дүгээр зүйл <sup>101</sup> . Анхны чуулганыг бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж буй Ерөнхийлөгч зарлаагүй тохиолдолд чуулганыг сонгууль явагдсанаас хойш 21 дахь хоног дээр хамгийн ахмад гишүүд зарлан хуралдуулна.
11	<b>Кыргызстан</b>	71 дүгээр зүйл. Парламентын хамгийн ахмад гишүүн анхны чуулганыг хуралдуулна.

<sup>99</sup>Parliament's Rules Of Procedure 17 december 1999 (40/2000, amendments up to 895/2012 included)  
[https://www.eduskunta.fi/FI/tietoaeduskunnasta/julkaisut/Documents/ekj\\_3+2013.pdf](https://www.eduskunta.fi/FI/tietoaeduskunnasta/julkaisut/Documents/ekj_3+2013.pdf)

<sup>100</sup>[https://global.tbmm.gov.tr/docs/rules\\_of\\_procedure\\_en.pdf](https://global.tbmm.gov.tr/docs/rules_of_procedure_en.pdf)

<sup>101</sup><http://parliament.am/library/kanonakarger/MACEDONIA.pdf>

**31. 7. Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	93 дугаар зүйл. Ерөнхийлөгч болон Дэд ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаад улируулан сонгож болно.
2	<b>Финлянд</b>	54 дүгээр зүйл. Ерөнхийлөгч тухайн албан тушаалдаа дараалан хоёроос дээшгүй удаа сонгогдоно
3	<b>Серби</b>	116 дугаар зүйл. Нэг хүнийг Ерөнхийлөгчөөр хоёроос дээш удаа сонгохгүй.
4	<b>Чрна Гора</b>	97 дугаар зүйл. Нэг хүнийг Ерөнхийлөгчид дээд тал нь 2 удаа сонгож болно.
5	<b>Хорват</b>	95 дугаар зүйл. Нэг хүнийг Ерөнхийлөгчөөр хоёроос дээш удаа сонгохгүй.
6	<b>Исланд</b>	-
7	<b>Сингапур</b>	-
8	<b>Словак</b>	103 дугаар зүйл. Нэг хүнийг Ерөнхийлөгчөөр дараалан хоёроос дээш удаа сонгохгүй.
9	<b>Турк</b>	101 дүгээр зүйл. Нэг хүнийг Ерөнхийлөгчид дээд тал нь 2 удаа сонгож болно.
10	<b>Македон</b>	80 дугаар зүйл. Нэг хүнийг Ерөнхийлөгчид дээд тал нь 2 удаа сонгож болно.
11	<b>Кыргызстан</b>	61 дүгээр зүйл. Нэг хүнийг Ерөнхийлөгчөөр дахин сонгохгүй.

**33.1. 6/ Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах;**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	98 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь: 6. Болгар улсад суух гадаад улсын дипломат төлөөлөгчийн итгэмжит болон эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авч, гадаад улс, олон улсын байгууллага дахь өөрийн орны төлөөлөгчийг сайд нарын зөвлөлийн санал болгосноор томилж, чөлөөлнө.
2	<b>Финлянд</b>	99 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Финлянд улсад суух гадаад улсын дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авна;
3	<b>Серби</b>	112 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Серби Улсад суух гадаад улсын дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авна;
4	<b>Чрна Гора</b>	95 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь гадаад орны дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авна.
5	<b>Хорват</b>	99 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Хорват улсад суух гадаад улсын төлөөлөгчийн итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах
6	<b>Исланд</b>	-
7	<b>Сингапур</b>	-

8	<b>Словак</b>	102 дугаар зүйл Ерөнхийлөгч бүрэн эрхт дипломат төлөөлөгчдийн тэргүүний хүлээн авах, итгэмжлэх, эргүүлэн татах эрхтэй байна.
9	<b>Турк</b>	104 дүгээр зүйл Турк улсаас гадаад улсад суух төлөөлөгчдийг итгэмжлэх бөгөөд Турк улсад томилогдсон гадаад орны төлөөлөгчдийг хүлээн авах.
10	<b>Македон</b>	84 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Македон Улсад суух гадаад орны дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх, эргүүлэн татах жуух бичиг хүлээн авна.
11	<b>Кыргызстан</b>	64.6.4 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Кыргызстан улсад суух гадаад орны дипломат төлөөлөгчдийн итгэмжлэх, эргүүлэн татах жуух бичиг хүлээн авна.

### 33.1. 7/ улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах;

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	98 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Одон, медалиар шагнана.
2	<b>Финлянд</b>	Улсын зөвшөөрлийг илэрхийлэх тухай хуулийн 1 дүгээр зүйл <sup>102</sup> . Ерөнхийлөгч нь улсын цол хүртээх, одон, медалиар шагнах эрхтэй байна.
3	<b>Серби</b>	112 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Өршөөл үзүүлэх болон цол хүртээнэ.
4	<b>Чрна Гора</b>	95 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь 8. Чрна Гора Улсын медалиар болон цол хүртээх эрхтэй байна.
5	<b>Хорват</b>	98 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Хуульд заасан улсын цол, бусад шагналыг гардуулна.
6	<b>Исланд</b>	-
7	<b>Сингапур</b>	-
8	<b>Словак</b>	102 дугаар зүйл Ерөнхийлөгч нь i. бусдад энэ эрхээ шилжүүлээгүй бол улсын цол хүртээнэ.
9	<b>Турк</b>	-
10	<b>Македон</b>	84 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь хуульд заасны дагуу улсын цол хүртээнэ.
11	<b>Кыргызстан</b>	64.10 дугаар зүйл Ерөнхийлөгч нь 1. Кыргызстан Улсын төрийн шагнал гардуулах, 2. Кыргызстан Улсын цол хүртээх, 3. Цэргийн дээд цол, дипломат цол болон бусад тусгай цол хүртээнэ.

<sup>102</sup>Act on the displays of public recognition (1215/1999) <https://www.finlex.fi/fi/laki/ajantasa/1999/19991215>

**33.1. 8/ уучлал үзүүлэх;**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	98 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь: 11.Уучлал үзүүлэх. /104-р зүйл Дэд Ерөнхийлөгч/
2	<b>Финланд</b>	58 дугаар зүйл, 105 дугаар зүйл. Ерөнхийлөгчийн шийдвэр: Дараах асуудлаар Ерөнхийлөгч Засгийн газрын саналыг үндэслэхгүй шийдвэр гаргана. Хуульд заасны дагуу, хувь хүний асуудлаар, эсхүл Засгийн газрын хуралдаанаар оруулах шаардлагагүй асуудлаар Ерөнхийлөгчийн уучлал үзүүлэх.
3	<b>Серби</b>	97 дугаар зүйл. 2. эрүүгийн гэмт хэрэгт өршөөл болон уучлал үзүүлэх.
4	<b>Чрна Гора</b>	95 дугаар зүйл. Чрна Гора Улсын Ерөнхийлөгч нь: 9. Өршөөл үзүүлнэ.
5	<b>Хорват</b>	98 дугаар зүйл Ерөнхийлөгч нь уучлал үзүүлнэ.
6	<b>Исланд</b>	29 дүгээр зүйл Ерөнхийлөгч өршөөл болон уучлал үзүүлнэ.
7	<b>Сингапур</b>	22Р дугаар зүйл. (1) Ерөнхийлөгч нь тухай нөхцөлд бүрдсэн бол, Кабинетын зөвлөсний үндсэн дээр: (а) гол/ аль нэг гол гэмт хэрэгтнийг/хэрэгтнүүдийг яллахад шаардагдах мэдээллийг олгосон хамсаатанд уучлал үзүүлнэ; (b) Сингапурын аль ч шүүхэд, аль ч гэмт хэрэг үйлдсэн гэмт хэрэгтэнд, үнэгүй, эсхүл хуулиар тогтоосон нөхцөлийн дагуу, эсхүл таслан шийдвэрлэх тогтоол хойшлуулахыг бүр мөсөн, эсхүл тохиромжтой гэсэн хугацаагаар хойшлуулах эрхтэй байна; (с) ял, торгууль эсхүл эд хөрөнгө хураахыг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь чөлөөлөх; (2) ямарваа нэгэн гэмт хэрэгтэн нь цаазын ялаар шийтгүүлж, тус ял нь давж заалдах шатны шүүхэд хэрэгсэхгүй болсон нөхцөлд Ерөнхийлөгч нь (1)-р хэсэгт заасан эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах материалыг шаардах эрхтэй байна
8	<b>Словак</b>	102 дугаар зүйл. Ерөнхийлөгч Уучлал, эсхүл өршөөл хэлбэрээр эрүүгийн хэргийн шүүхээр ногдуулсан шийтгэлийг бууруулах, хэргийг хэрэгсэхгүй болгоно.
9	<b>Турк</b>	104 дүгээр зүйл. Ерөнхийлөгч Тодорхой этгээдүүдэд, хүнд өвчин, хөгжлийн бэрхшээл, эсхүл өндөр насыг харгалзан шүүхээр ногдуулсан шийтгэлийг бууруулах, хэрэгсэхгүй болгох.
10	<b>Македон</b>	84 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь хуульд заасны дагуу уучлал үзүүлнэ.
11	<b>Кыргызстан</b>	64.10 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь уучлал үзүүлнэ.

### 33.1. 9/ Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх;

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	<i>Болгарын харьяатын тухай хууль 36 дугаар зүйл<sup>103</sup></i> Болгар улсын харьяат болох, харьяатаас гарах, харьяатыг сэргээх асуудлыг Болгар Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган шийдвэрлэнэ.
2	Финлянд	<i>Финляндийн харьяатын тухай хуулийн 3 дугаар зүйл<sup>104</sup></i> Финляндийн Цагаачлалын алба нь Финлянд Улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг шийдвэрлэнэ.
3	Серби	<i>Сербийн харьяатын тухай хууль 43 дугаар зүйл<sup>105</sup></i> Серб улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг дотоод асуудал хариуцсан яам шийдвэрлэнэ.
4	Чрна Гора	<i>Чрна Гора улсын харьяатын тухай хуулийн 12 дугаар зүйл</i> Чрна Гора улсын харьяат болох асуудлыг дотоод асуудал хариуцсан яам шийдвэрлэнэ. Тусгай нөхцөлийн /шинжлэх ухаан, эдийн засаг, соёл урлаг, спорт болон бусад үндэслэлээр/ дагуу харьяат болгох асуудлыг Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон Парламентын спикерийн санал болгосны дагуу дотоод асуудал хариуцсан яам, шийдвэрлэнэ.
5	Хорват	<i>Хорватын харьяатын тухай хуулийн 25 дугаар зүйл<sup>106</sup></i> Хорват улсын дотоод асуудал хариуцсан яам нь Хорват улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг шийднэ.
6	Исланд	<i>Исландын харьяатын тухай хуулийн 6 дугаар зүйл<sup>107</sup></i> Парламент нь хууль гарган Исланд улсын харьяат болох асуудлыг шийдвэрлэнэ.
7	Сингапур	127 дугаар зүйл. Засгийн газар нь 21 нас хүрсэн, өргөдөл гаргасан этгээдийг Сингапур улсын харьяат болгож болно.
8	Словак	<i>Словакийн харьяатын тухай хуулийн 8 дугаар зүйл<sup>108</sup></i> Словак улсын харьяат болох асуудлыг Словак улсын дотоод явдлын яаманд ирсэн өргөдлийн дагуу Дотоод явдлын сайд шийдвэрлэнэ.
9	Турк	<i>Туркийн харьяатын тухай хууль<sup>109</sup></i> Турк улсын дотоод асуудал хариуцсан яам болон сайд нарын зөвлөл нь Турк улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг шийднэ.
10	Македон	<i>Македон Улсын харьяатын тухай хуулийн 21 дүгээр зүйл<sup>110</sup></i> Македон Улсын харьяат болох, харьяатаас гарах, дахин сэргээх асуудлыг Дотоод явдлын сайд шийдвэрлэнэ.
11	Кыргызстан	64.7 дугаар зүйл. Ерөнхийлөгч Кыргызстан улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг шийдвэрлэнэ.

<sup>103</sup>[http://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=1&ved=0CB4QFJAA&url=http%3A%2F%2Fwww2.ohchr.org%2Fenglish%2Fissues%2Fwomen%2Fdocs%2FGovernments%2FBulgariaLawBulgarianCitizenship.doc&ei=QmWXVdihLdHKogTFhYDoCA&usg=AFQjCNER6KReRCvtZQOIIsuhfoqAnRgpw&sig2=OnZE-29hIPQagDf\\_lAinRQ&bvm=bv.96952980,d.cGU&cad=rja](http://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=1&ved=0CB4QFJAA&url=http%3A%2F%2Fwww2.ohchr.org%2Fenglish%2Fissues%2Fwomen%2Fdocs%2FGovernments%2FBulgariaLawBulgarianCitizenship.doc&ei=QmWXVdihLdHKogTFhYDoCA&usg=AFQjCNER6KReRCvtZQOIIsuhfoqAnRgpw&sig2=OnZE-29hIPQagDf_lAinRQ&bvm=bv.96952980,d.cGU&cad=rja)

<sup>104</sup><http://www.finlex.fi/en/laki/kaannokset/2003/en20030359.pdf>

<sup>105</sup><http://www.mup.gov.rs/domino/zakoni.nsf/Law%20on%20Citizenship.pdf>

<sup>106</sup>[http://eudocitizenship.eu/NationalDB/docs/CRO%20Law%20on%20Croatian%20Citizenship\\_consolidated%2028\\_10\\_2011\\_ENGLISH.pdf](http://eudocitizenship.eu/NationalDB/docs/CRO%20Law%20on%20Croatian%20Citizenship_consolidated%2028_10_2011_ENGLISH.pdf)

<sup>107</sup>[http://www.stosunki.pl/sites/default/files/images/020icelandic\\_nationality\\_act.pdf](http://www.stosunki.pl/sites/default/files/images/020icelandic_nationality_act.pdf)

<sup>108</sup><http://eudo-citizenship.eu/docs/CountryReports/recentChanges/Montenegro.pdf> <http://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=2&ved=0CCCEQFJAB&url=http%3A%2F%2Fwww.minv.sk%2F%3Fstatne-obciansstvo-1%26subor%3D21104&ei=3LycVav6B4zdoATh85moBg&usg=AFQjCNGP0dSX7Kfq5Tu8MtU-2s320KcSzg&sig2=yOcc9nO-UypLLKFNNQNWfXA&bvm=bv.96952980,d.cGU>

<sup>109</sup><http://eudo-citizenship.eu/NationalDB/docs/TUR%20Turkish%20citizenship%20law%202009%20%28English%29.pdf>

<sup>110</sup><http://www.uniset.ca/nold/zmake.txt>

**33.1. 10/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх;**

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	100 дугаар зүйл. 2. Ерөнхийлөгч нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөгөөнийг удирдан явуулах хуулиар тогтоосон статустай.
2	Финлянд	-
3	Серби	Серб улсын аюулгүй байдлыг хамгаалах байгууллагуудын тухай хуулийн 9 дүгээр зүйл <sup>111</sup> . Серб Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг Ерөнхийлөгч тэргүүлэх бөгөөд түүний эзгүйд Ерөнхий сайд тэргүүлнэ.
4	Чрна Гора	131 дугаар зүйл. Батлан хамгаалах болон аюулгүй байдлын зөвлөл нь Ерөнхийлөгч, Парламентын Спикер болон Ерөнхий сайдаас бүрдэнэ. Ерөнхийлөгч нь Батлан хамгаалах болон аюулгүй байдлын зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэнэ.
5	Хорват	Аюулгүй байдал болон тагнуулын тогтолцооны тухай хуулийн 4 дүгээр зүйл <sup>112</sup> . Аюулгүй байдлын зөвлөлийн хурлыг Ерөнхийлөгч тэргүүлэх бөгөөд аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг Ерөнхийлөгч, Ерөнхий сайдтай хамтран гарын үсэг зурж баталгаажуулна.
6	Исланд	-
7	Сингапур	-
8	Словак	-
9	Турк	104 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийг зарлан хуралдуулах, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийг даргална.
10	Македони	86 дугаар зүйл. Бүгд найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Бүгд найрамдах улсын аюулгүй байдлын зөвлөлийн дарга мөн байна.
11	Кыргызстан	64.9 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь хуульд заасны дагуу байгуулагдсан Батлан хамгаалах зөвлөлийг даргалах эрхтэй байна.

**33.1. 11/ бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах;**

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	100 дугаар зүйл. 4. Ерөнхийлөгч нь хуульд заасны дагуу Сайд нарын зөвлөлийн саналаар бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлана.
2	Финлянд	129 дүгээр зүйл. Засгийн газрын санал болгосноор Ерөнхийлөгч цэргийн дайчилгаа зарлана. Тухайн үед чуулган хуралдаагүй байгаа бол нэн даруй хуралдуулна.
3	Серби	-
4	Чрна Гора	-
5	Хорват	-
6	Исланд	-
7	Сингапур	-



8	<b>Словак</b>	102 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь т. Словак улсын Засгийн газрын саналын дагуу цэргийн дайчилгаа зарлах, дайны байдал зарлах, эсхүл онц байдал зарлах болон цуцлах эрхтэй байна.
9	<b>Турк</b>	-
10	<b>Македон</b>	-
11	<b>Кыргызстан</b>	64 дүгээр зүйл. 9. Ерөнхийлөгч нь: 3. бүх нийтийн болон хэсэгчилсэн дайны байдал зарлах, Кыргызстан Улсын бүрэн эрхт байдалд бусад улсаас занал учруулж, зэвсэглэн халдвал дайны байдал зарлах бөгөөд энэхүү асуудлыг Парламентад нэн даруй тавина.

### 33.2. Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	100 дугаар зүйл. 1. Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Болгар улсын цэрэг, армийн хүчний Үндсэн командлагч байна.
2	<b>Финлянд</b>	128 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна. Онц байдлын үед Засгийн газрын санал болгосноор, Ерөнхийлөгч энэхүү үүргээ шилжүүлж болох бөгөөд уг үүргийг хүлээн авсан этгээд нь заавал Финлянд улсын иргэн байна.
3	<b>Серби</b>	112 дугаар зүйл. Хуульд заасны дагуу Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний командлагч байх бөгөөд Сербийн армийн албан хаагчдыг томилох, дэвшүүлэх болон чөлөөлөх эрхтэй байна.
4	<b>Чрна Гора</b>	95 дугаар зүйл. 2. Ерөнхийлөгч нь Батлан хамгаалах болон аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу зэвсэгт хүчнийг командална.
5	<b>Хорват</b>	81 дүгээр зүйл. Хорватын Парламент нь Үндэсний аюулгүй байдлын болон батлан хамгаалах стратегийг батална. Хорват улсын зэвсэгт хүчин болон аюулгүй байдлын албадын иргэний хяналтыг хэрэгжүүлнэ.
6	<b>Исланд</b>	-
7	<b>Сингапур</b>	-
8	<b>Словак</b>	102 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний командлагч байна.
9	<b>Турк</b>	104 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь Үндэсний Их Хурлын нэрийн өмнөөс Туркийн зэвсэгт хүчний командлагчийн үүргийг гүйцэтгэнэ.
10	<b>Македон</b>	79 дүгээр зүйл Ерөнхийлөгч нь Македони улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.
11	<b>Кыргызстан</b>	64.8 дугаар зүйл. Кыргызстан улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний цэргийн командлагч байх бөгөөд Кыргызстан улсын Зэвсэгт хүчний дээд командлагчдыг томилох болон чөлөөлнө.

**65. 1. Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	147 дугаар зүйл Үндсэн хуулийн шүүх нь 12 шүүгчтэй байна. Шүүгчдийн 1/3-г Үндэсний Ассамблей, 1/3-г Ерөнхийлөгч, 1/3-г Кассацийн дээд шүүх болон Захиргааны хэргийн дээд шүүхийн шүүгчдийн хамтарсан уулзалтаар тус тус томилно.
2	<b>Финлянд</b>	-
3	<b>Серби</b>	172 дугаар зүйл. Үндсэн хуулийн шүүх нь 15 шүүгчтэй байх бөгөөд 9 жилийн хугацаагаар томилох болон сонгоно. Үндсэн хуулийн шүүхийн 5 шүүгчийг Үндэсний Ассамблей, 5 шүүгчийг Ерөнхийлөгч, мөн 5 шүүгчийг Кассацийн дээд шүүхийн хуралдаанаар, Үндэсний Ассамблей нь Үндсэн хуулийн дээд шүүхийн 5 шүүгчийг Ерөнхийлөгчийн нэр дэвшүүлсэн 10 нэр дэвшигч дундаас, Ерөнхийлөгч нь Үндэсний Ассамблейгаас нэр дэвшүүлсэн 10 нэр дэвшигч дундаас, Кассацийн дээд шүүхийн хуралдаан нь Дээд шүүх болон Улсын прокурорын зөвлөлөөс нэр дэвшүүлсэн 10 шүүгч дундаас тус тус томилно.
4	<b>Чрна Гора</b>	82 дугаар зүйл. Парламент нь нийт гишүүдийн олонхын саналаар Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүгчдийг томилж, чөлөөлнө.
5	<b>Хорват</b>	126 дугаар зүйл. Үндсэн хуулийн шүүх Парламентын нийт гишүүдийн 2/3-ийн саналаар нэр хүндтэй хуульч, шүүгч, прокурор, өмгөөлөгч болон их сургуулийн профессор нараас сонгогдсон 13 шүүгчээс бүрдэнэ. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нэр дэвшүүлэх асуудлыг Парламентын үндсэн хуулийн асуудал хариуцсан хороо шийдвэрлэнэ.
6	<b>Исланд</b>	Парламент Үндсэн хуулийн зөвлөлийн гишүүдийг томилно.
7	<b>Сингапур</b>	100 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь доод тал нь Дээд шүүхийн 3 шүүгчээс бүрдэх шүүхэд Үндсэн хуулийн зүйл, заалттай холбоотой асуудлаар, эсхүл гарч магадгүй гэсэн асуудлаар саналыг нь асуух эрхтэй байна. 22 дугаар зүйл. Үндсэн хуульд заасан бусад заалтыг үл харгалзан, Үндсэн хууль болон бусад хуульд заасны дагуу зөвшилцөж, эсхүл зөвлөлдөн гаргана гэсэн заалтад санал нь нийлээгүй тохиолдолд Ерөнхийлөгч нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд дараах албан тушаалд томилохоос татгалзах, эсхүл эгүүлэн татахаас татгалзах эрхтэй байна: (а) Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Дээд шүүхийн шүүгчид, Шүүхийн комиссарууд
8	<b>Словак</b>	102 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Словак улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг, Үндсэн хуулийн шүүхийн дарга, дэд даргыг томилж, чөлөөлнө, Словак улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн болон Ерөнхий прокурорын тангаргийн өргүүлнэ.

9	<b>Турк</b>	<p>104 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь с. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг, Төрийн зөвлөлийн гишүүдийн ¼-ийг томилох, Ерөнхий прокурор болон Давж заалдах шатны шүүхийн Дэд прокурор, Цэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг, Цэргийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийг болон Шүүх, прокурорын дээд зөвлөлийн гишүүдийг тус тус томилно. 146 дугаар зүйл. Үндсэн хуулийн шүүх нь 17 гишүүнтэй байна. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь нэг сул орон тоо бүрт дараах шүүхийн дарга болон гишүүд дундаас гурван шүүгчийг Давж заалдах шатны шүүхээс, хоёр шүүгчийг Төрийн зөвлөл, нэг шүүгчийг Цэргийн дээд шүүхээс, нэг шүүгчийг Цэргийн захиргааны дээд шүүхээс тус бүр 3 нэр дэвшигч дундаас холбогдох нэгдсэн хуралдаанаар томилно. Мөн Боловсролын дээд хорооноос 3 шүүгчийг Хорооны гишүүн бус хууль, эдийн засаг болон улс төрийн салбарын багш нар дундаас, үүнээс доод тал нь хоёр нь хуульч 4 шүүгчийн төрийн дээд албан тушаалтан, хувиараа өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэгч, нэгдүгээр зэргийн шүүгч, прокурор эсхүл Үндсэн хуулийн илтгэгч дундаас тус тус томилно.</p>
10	<b>Македон</b>	<p>68 дугаар зүйл. Македон улсын Парламент нь: Македон улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг сонгоно. 109 дүгээр зүйл. Македон улсын Үндсэн хуулийн шүүх нь 9 шүүгчээс бүрдэнэ. Парламент нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно. XV нэмэлт өөрчлөлт. 1. Парламент нь нийт гишүүдийн олонхын саналаар Үндсэн хуулийн шүүхийн 6 шүүгчийг сонгох бөгөөд 3 шүүгчийг нийт гишүүдийн олонхын саналаар сонгох ба үүнд Македон улсын хүн амын цөөнхийн төлөөллийн санал багтсан байх ёстой.</p>
11	<b>Кыргызстан</b>	<p>64 дүгээр зүйл. 3. Ерөнхийлөгч нь Шүүхийн томилгооны хорооны саналыг үндэслэн Парламентад Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчдийг өргөн мэдүүлнэ 74 дүгээр зүйл. 4. Парламент нь: Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Дээд шүүхийн шүүгчдийг томилох, Үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр чөлөөлөх. 93 дугаар зүйл. 3. Үндсэн хуулийн танхим нь Дээд шүүхийн нэг хэсэг байна. 97 дугаар зүйл. 1. Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхим нь Үндсэн хуулийг чандлан сахиулах үүргийг гүйцэтгэх байгууллага мөн.</p>

**33.4. Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно.**

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	-
2	Финлянд	57 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Үндсэн хууль болон бусад хуульд тусгайлан заасан эрх үүргийг хэрэгжүүлнэ.
3	Серби	112 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь 8. Үндсэн хуульд заасан бусад асуудлыг шийдвэрлэнэ.
4	Чрна Гора	95 дугаар зүйл. Чрна Гора Улсын ерөнхийлөгч нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
5	Хорват	98 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Үндсэн хуульд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
6	Исланд	30 дугаар зүйл. -
7	Сингапур	21 дүгээр зүйл 2. Ерөнхийлөгч нь бүрэн эрхийнхээ хүрээнд: 10. Үндсэн хуульд заасны дагуу бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
8	Словак	102 дугаар зүйл. 4.Ерөнхийлөгчийн 1-р хэсэгт заасан бүрэн эрхийг хуулиар нарийвчлан тогтоож болно.
9	Турк	104 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан сонгох, томилох болон бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
10	Македон	84 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь Үндсэн хуульд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
11	Кыргызстан	64 дүгээр зүйл. 11. Ерөнхийлөгч нь энэхүү Үндсэн хуульд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.

**33.1. 1/ Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ;**

№	Улс	Холбогдох заалт
1	Болгар	101 дүгээр зүйл. 1/Үндэсний Ассамблейгаас баталсан шийдвэрийг баталснаас хойш 15 хоногийн дотор нийтэд зарласнаас хойш хуулийг дахин хэлэлцүүлэхээр Ерөнхийлөгч Үндэсний Ассамблейд буцаах эрхтэй. Ийнхүү буцаагдсан хууль Үндэсний Ассамблейн нийт гишүүдийн дийлэнх олонхын саналаар батлагдана. 2/ Үндэсний Ассамблейн баталсан шинэ хуулийг Ерөнхийлөгч хүлээн авч гарын үсэг зурж зарлан тунхаглана.
2	Финлянд	77 дугаар зүйл. Ерөнхийлөгч хуулийг батламжлаагүй бол, хууль Парламентад дахин хэлэлцүүлэхээр буцаагдана. Парламент нь хуульд агуулгын хувьд өөрчлөлт оруулаагүй тохиолдолд батламжлагдах шаардлагагүйгээр хүчин төгөлдөр болно. Парламент хуулийг батлаагүй бол тус хуулийг батлаагүйд тооцно.

3	<b>Серби</b>	113 дугаар зүйл. Ерөнхийлөгч хуулийг тунхаглан зарлиг гаргах, эсхүл хуулийн Парламентад дахин хэлэлцүүлэхээр бичсэн тайлбарын хамт хуулийг баталснаас 15 хоног хэтрэлгүй, хуулийг онцгой журмаар баталсан бол 7 хоногоос тус тус хэтрэлгүй буцаах эрхтэй байна. Буцаагдсан хуулиар дахин санал хураалт явуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд нийт гишүүдийн олонхын саналаар батална. Ийнхүү батлагдсан хуулийг Ерөнхийлөгч тунхаглан зарлах үүрэгтэй байна. Үндсэн хуульд заасан хугацаанд Ерөнхийлөгч тус хуулийг тунхаглан зарлаж зарлиг гаргаагүй бол Парламентын спикер зарлиг гаргана.
4	<b>Чрна Гора</b>	94 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь хуулийг баталснаас хойш 7 хоногийн дотор, яаралтай журмаар батлагдсан хуулийг 3 хоногийн дотор зарлах, эсхүл Парламентад дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй байна. Ерөнхийлөгч нь дахин батлагдсан хуулийг тунхаглан зарлах үүрэг хүлээнэ.
5	<b>Хорват</b>	-
6	<b>Исланд</b>	26 дугаар зүйл. Парламентаар батлагдсан хуулийг 2 долоо хоногоос хэтрэлгүй Ерөнхийлөгчид зарлан тунхаглуулахаар өргөн барих бөгөөд, Ерөнхийлөгч зарлан тунхагласнаар хууль хүчин төгөлдөр болно. Хуулийг буцаасан тохиолдолд гишүүд нууц санал хураалтаар батална. Батлагдаагүй бол хуулийг хүчингүйд тооцно.
7	<b>Сингапур</b>	148D дугаар зүйл. Ерөнхийлөгч нь төсвийн төслийг батлахад Ерөнхийлөгчийн зөвлөхүүдийн зөвлөгөөг үл харгалзан зөвшөөрлөө өгөөгүй тохиолдолд, Парламентын дийлэнх олонхын саналаар төсвийн төслийг тогтоол гарган батална. Тогтоол гарснаар Ерөнхийлөгчийн зөвшөөрөл олгогдсонд тооцно.
8	<b>Словак</b>	87 дугаар зүйл. Ерөнхийлөгч хуулийг Парламентад тайлбарын хамт буцаасан тохиолдолд, Парламент дахин хэлэлцэж баталсан бол зарлан тунхагласан тооцно. Хуулийг Ерөнхийлөгч, Парламентын дарга болон Ерөнхий сайд хамтран гарын үсэг зурж батламжлах бөгөөд буцаагдсан хуулийг Парламент баталж, Ерөнхийлөгч гарын үсэг зураагүй бол Ерөнхийлөгч гарын үсэг зураагүйг үл харгалзан хүчинтэйд тооцно.
9	<b>Турк</b>	89 дүгээр зүйл. Ерөнхийлөгч Парламентаар батлагдсан хуулийг 15 хоногийн дотор зарлан тунхаглана. Ерөнхийлөгч хуулийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь зарлан тунхаглах боломжгүй гэж үзсэн бол тайлбарын хамт Парламентад заасан хугацаанд дахин хэлэлцүүлэхээр буцаана. Хэсэгчлэн буцаасан тохиолдолд Ерөнхийлөгч болон Парламент тухайн асуудлаараа хэлэлцэж болно. Төсвийн тухай хуулиуд дээрхэд хамаарахгүй. Ерөнхийлөгчийн буцаасан хуулийг Парламент ямарваа нэгэн өөрчлөлтгүй баталбал хуулийг Ерөнхийлөгч тунхаглан зарлана. Өөрчлөлт оруулж баталсан тохиолдолд, Ерөнхийлөгч буцаах эрхтэй байна.

10	<b>Македон</b>	75 дугаар зүйл. Хуулийг Ерөнхийлөгч болон Парламентын дарга нар хамтран гарын үсэг зурж, тунхаглана. Ерөнхийлөгч хуульд гарын үсэг зурахгүй байх шийдвэр гаргаж болно. Парламент хуулийг дахин хэлэлцэж нийт гишүүдийн олонхын саналаар баталсан тохиолдолд Ерөнхийлөгч гарын үсэг зурж зарлан тунхаглана. Хуулийг нийт гишүүдийн гуравны хоёр баталсан тохиолдолд Ерөнхийлөгч гарын үсэг зурж зарлан тунхаглах үүрэгтэй.
11	<b>Кыргызстан</b>	81.3 дугаар зүйл. Парламент хуулийг дахин хэлэлцэж нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар хуулийг хэвээр нь баталсан тохиолдолд Ерөнхийлөгч 14 хоногийн дотор гарын үсэг зурж зарлан тунхаглана. Ерөнхийлөгч заасан хугацаанд хуулийг хэвээр нь газрын үсэг зурж тунхаглаагүй тохиолдолд Парламентын дарга гарын үсэг зурж, 10 хоногийн дотор нийтэлнэ.

**33.1. 2/ Улсын Их Хуралд олонх суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	99 дүгээр зүйл. 1/Ардын Хурлын бүлгүүдтэй зөвшилцөн, хамгийн олон санал авсан бүлгээс Ерөнхий сайдад санал авсан нэр дэвшигчид Засгийн газрыг бүрдүүлэхийг үүрэг болгоно. 2/ Нэр дэвшигч сайд нарын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 7 өдрийн дотор бүрдүүлж чадаагүй бол Ерөнхийлөгч хоёр дахь бүлгээс нэр дэвшсэн хүнд үүрэг өгнө. 3/ Хоёр дахь нэр дэвшигч өмнөх хэсэгт заасан тогтоосон хугацаанд Засгийн газрыг бүрдүүлж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дараагийн бүлэгт Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх үүрэг өгнө. 4/ Хэрэв сайд нарын зөвлөлийг амжилттай бүрдүүлбэл нэр дэвшигчийг Ерөнхий сайд болгох саналыг Ардын Хуралд оруулна. 5/ Хэрэв Засгийн газрыг бүрдүүлэх талаар зөвшилцөлд хүрч чадаагүй бол Ерөнхийлөгч Ардын Хурлыг тараах сонгуулийг товлож, түр засгийн газар томилно. Ардын Хурлыг тараасан Ерөнхийлөгчийн актаар шинэ сонгуулийн хугацаа тодорхойлогдоно.
2	<b>Финлянд</b>	61 дүгээр зүйл. Засгийн газрыг бүрдүүлэх Ерөнхий сайдыг сонгохоос өмнө Парламентад төлөөлөл бүхий бүлгүүд засгийн газрын мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг хэлэлцэнэ. Хэлэлцээг үндэслэн, Парламентын спикер болон парламентын бүлгүүдийн саналыг сонссоны үндсэн дээр Ерөнхийлөгч Парламентад Ерөнхий сайдад нэр дэвшигчийг танилцуулна. Нэр дэвшигч нь хангалттай санал аваагүй тохиолдолд, мөн адил журмын дагуу өөр нэр дэвшигчийг дэвшүүлнэ. Хоёр дахь нэр дэвшигч талаас дээш хувийн санал авч чадаагүй тохиолдолд, Ерөнхий сайдын сонгуулийг Парламентын нээлттэй санал хураалтаар явуулна. Ингэсэн тохиолдолд хамгийн их санал авсан этгээдийг Ерөнхий сайдаар сонгоно.
3	<b>Серби</b>	127 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь нэр дэвшигчдийн жагсаалтад төлөөлөгчдийн өгсөн саналыг харгалзан үзсэний үндсэн дээр Үндэсний Ассамблейд Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ.

4	<b>Чрна Гора</b>	103 дугаар зүйл. Сонгууль Чрна Гора улсын Ерөнхийлөгч нь Парламентыг сонгогдсоноос хойш 30 хоногийн дотор нэр дэвшигчийг санал болгоно. Ерөнхий сайдад нэр дэвшигч нь Парламентад мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг танилцуулна. Парламент нь нэгэн зэрэг нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр болон Засгийн газрын бүтцийг шийдвэрлэнэ.
5	<b>Хорват</b>	98 дугаар зүйл. З/ Ерөнхийлөгч нь намуудын Парламентад авсан суудлын тоог харгалзан парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээсэн Ерөнхий сайдад нэр дэвшигчид Засгийн газар байгуулах эрх олгоно.
6	<b>Исланд</b>	15 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь сайд нарыг томилж, чөлөөлнө. Сайдын тоо болон эрх үүргийг тогтоож, хариуцлага хүлээлгэнэ.
7	<b>Сингапур</b>	25 дугаар зүйл. Ерөнхийлөгч Парламентын гишүүдийн олонхын итгэлийг хүлээх чадвартай гэж үзсэн Парламентын гишүүнийг Ерөнхий сайдаар томилох бөгөөд Ерөнхий сайдын зөвлөснөөр Парламентын гишүүд дундаас сайд нарыг томилно. Ингэхдээ Парламент тарсан үед томилгоо хийхдээ өмнөх Парламентын гишүүнийг томилж болох ба тэрээр шинэ Парламентын анхны хуралдаан явагдсанаас хойш, тухайн Парламентын гишүүн бус нөхцөлд албан үүргээ үргэлжлүүлэх эрхгүй байна. Энэхүү зүйлд заасан томилгоог Ерөнхийлөгч хийх бөгөөд төрийн тамгаар баталгаажуулна.
8	<b>Словак</b>	110 дугаар зүйл. Ерөнхий сайдыг Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө. 111 дүгээр зүйл. Ерөнхий сайдын санал болгосноор Ерөнхийлөгч Засгийн газрын гишүүдийг томилж, чөлөөлөх ба тэдэнд яамдыг удирдах бүрэн эрх олгоно.
9	<b>Турк</b>	109 дүгээр зүйл. Сайд нарын зөвлөл нь Ерөнхий сайд болон сайд нараас бүрдэнэ. Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас томилно. Сайд нарын Зөвлөл нь Ерөнхий сайд болон сайд нараас бүрдэнэ. Ерөнхий сайд нь сайд нарыг Үндэсний Их хурлын гишүүд дундаас, эсхүл Үндэсний Их хурлын гишүүнд тавигдах шаардлагыг хангасан этгээдийг томилох бөгөөд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдын санал болгосны дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.
10	<b>Македон</b>	84 дугаар зүйл. Засгийн газрын бүрэлдэхүүнийг тодорхойлох эрхийг Ерөнхийлөгч олгоно. 90-р зүйл. Хурал бүтэц зохион байгуулалтынхаа асуудлыг шийдэж дууссаны дараа 10 хоногт багтааж Ерөнхийлөгч нь Засгийн газрыг байгуулах эрхийг сонгуульд ялж хуралд олонх болсон нам эвсэлд, эсхүл нам эвслийн санал болгосон нэр дэвшигч [Ерөнхий сайд болох]–д олгоно.

11	<b>Кыргызстан</b>	<p>84.1 дүгээр зүйл.</p> <p>Жогорку Кенешт талаас илүү суудал авсан бүлэг, эсвэл эвслийн бүлэг нь анхны хуралдаанаас хойш 15 хоногийн дотор Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ. Ерөнхий сайдад нэр дэвшигч Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүнийг Жогорку Кенешт санал болгоно.</p> <p>84.2 Хэрэв Жогорку Кенеш нь Засгийн газрыг хугацаандаа баталж чадаагүй бол, эсвэл сонгуулийн дүнд аль ч улс төрийн нам талаас илүү тооны суудал аваагүй бол Ерөнхийлөгч намын бүлгүүдийн аль нэгэнд 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлэхийг санал болгоно.</p> <p>84.3 Хугацаандаа баталж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгч дараагийн намын бүлэгт санал болгоно.</p> <p>84.4 Мөн хугацаандаа баталж чадаагүй бол намын бүлгүүд өөрсдийн санаачилгаар 15 хоногийн дотор олонхоо бүрдүүлж, Ерөнхий сайдад нэр дэвшүүлнэ.</p>
----	-------------------	--

**33.1. 3/ өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно;**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	-
2	<b>Финлянд</b>	-
3	<b>Серби</b>	-
4	<b>Чрна Гора</b>	-
5	<b>Хорват</b>	-
6	<b>Исланд</b>	-
7	<b>Сингапур</b>	-
8	<b>Словак</b>	-
9	<b>Турк</b>	-
10	<b>Македон</b>	-
11	<b>Кыргызстан</b>	-

**33.1. 4/ гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах;**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	<p>92 дугаар зүйл.</p> <p>1. Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн мөн. Тэрээр Олон улсын харилцаанд улс орноо төлөөлөх ба үндэсний нэгдмэл байдлыг хангана.</p> <p>98 дугаар зүйл</p> <p>3. Ерөнхийлөгч нь Хуулиар тогтоосон нөхцөл байдлыг харгалзан Олон улсын гэрээ байгуулна.</p>
2	<b>Финлянд</b>	<p>93 дугаар зүйл.</p> <p>Финлянд улсын гадаад бодлогыг Ерөнхийлөгч Засгийн газартай хамтран чиглүүлнэ. Гэхдээ Финландын олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй холбоотой асуудлаар, түүнийг хэрэгжүүлэх болон цуцлах асуудлыг Үндсэн хуульд заасны дагуу Парламент хэрэгжүүлнэ.</p>
3	<b>Серби</b>	<p>112 дугаар зүйл.</p> <p>Ерөнхийлөгч нь Серби улсыг гадаад болон дотооддоо төлөөлнө.</p> <p>105 дугаар зүйл Парламент нийт гишүүдийн олонхын саналаар олон улсын гэрээ хэлэлцээр байгуулна.</p>



4	<b>Чрна Гора</b>	95 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Чрна Гора улсыг гадаадад болон дотоодод төлөөлнө. 82 дугаар зүйл. Парламент олон улсын гэрээ хэлэлцээр байгуулна
5	<b>Хорват</b>	94 дүгээр зүйл Хорват улсын Ерөнхийлөгч нь Хорват улсыг гадаадад болон дотоодод төлөөлнө. 139 дүгээр зүйл. Олон улсын гэрээг Үндсэн хууль, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн, олон улсын гэрээ хэлэлцээрийн агуулгаас хамааран Парламент, Ерөнхийлөгч болон Засгийн газар байгуулна.
6	<b>Исланд</b>	21 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь бусад улс оронтой гэрээ байгуулна. Ерөнхийлөгч нь улс орны хараат байдал, газар нутаг болон эзэмшлийн далай, эсхүл улс орны тогтолцоонд өөрчлөлт оруулах утга агуулсан гэрээг Парламентаас өөрөөр заагаагүй бол байгуулах эрхгүй байна.
7	<b>Сингапур</b>	-
8	<b>Словак</b>	84 дүгээр зүйл. Олон улсын гэрээг 7.3, 7.4-р заалтад заасны дагуу болон Ерөнхийлөгчөөс буцаагдсан хуулийг Парламентын нийт гишүүдийн олонхын саналаар тус тус батална.
9	<b>Турк</b>	104 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь олон улсын гэрээ байгуулна.
10	<b>Македон</b>	119 дүгээр зүйл. Македон улсын Ерөнхийлөгч нь Македон улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулна. Хуулиар заасны дагуу олон улсыг гэрээг Засгийн газар байгуулж болно.
11	<b>Кыргызстан</b>	64.6 дугаар зүйл. Ерөнхийлөгч 1/Кыргызстан улсыг гадаадад болон дотооддоо төлөөлнө. 2/ хэлцэл явуулж, Ерөнхий сайдын зөвшөөрөлтэйгөөр олон улсын гэрээ байгуулна, мөн дээрх үүргээ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн болон бусад албан хаагчдад шилжүүлж болно.

**33.1. 5/ Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах;**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	98 дугаар зүйл. 6. Болгар улсад суух гадаад улсын дипломат төлөөлөгчийн итгэмжит болон эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авч, гадаад улс, олон улсын байгууллага дахь өөрийн орны төлөөлөгчийг сайд нарын зөвлөлийн санал болгосноор томилж чөлөөлнө.
2	<b>Финлянд</b>	126 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь Ерөнхийлөгчийн тамгын газрын байнгын нарийн бичгийн даргыг болон Финлянд Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилно.
3	<b>Серби</b>	112 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь 6. Засгийн газрын саналыг үндэслэж Серби улсаас гадаад улсад суух элчин сайдуудыг зарлиг гарган томилох болон эгүүлэн татах.

4	<b>Чрна Гора</b>	95 дугаар зүйл. Ерөнхийлөгч 6.Чрна Гора улсаас гадаад улсад суух дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнийг Парламентын гадаад харилцааны асуудал хариуцсан хорооны саналыг үндэслэн Засгийн газартай зөвшилцөж томилох, эгүүлэн татах эрхтэй байна.
5	<b>Хорват</b>	99 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь Хорватын Парламентын холбогдох хорооны саналыг харгалзан, Засгийн газрын саналыг үндэслэн Ерөнхий сайдтай хамтран гарын үсэг зурж Хорват Улсаас гадаад улсад суух дипломат төлөөлөгчдийг томилж, эгүүлэн татна.
6	<b>Исланд</b>	-
7	<b>Сингапур</b>	-
8	<b>Словак</b>	102 дугаар зүйл. Ерөнхийлөгч бүрэн эрхт дипломат төлөөлөгчдийн тэргүүнийг хүлээн авах, итгэмжлэх, эгүүлэн татах эрхтэй байна.
9	<b>Турк</b>	104 дүгээр зүйл. Ерөнхийлөгч нь Турк улсаас гадаад улсад суух төлөөлөгчдийг итгэмжлэх, мөн Турк улсад гадаад улс орноос томилогдсон төлөөлөгчдийг хүлээн авна.
10	<b>Македон</b>	84 дүгээр зүйл. Македон Улсын Ерөнхийлөгч нь Македон улсаас гадаад улсад суух элчин сайд болон төлөөлөгчдийг зарлиг гарган итгэмжилж, эгүүлэн татна.
11	<b>Кыргызстан</b>	64.6 дугаар зүйл Ерөнхийлөгч нь 4 Ерөнхий сайдтай зөвшилцөж Кыргызстан улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчид болон олон улсын байнгын төлөөлөгчдийн газарт төлөөлөгчдийг томилох, эгүүлэн татах эрхтэй байна.

**33.1. 12/ Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	84 дүгээр зүйл. Парламент нь 10.Дайн зарлах болон энхийн гэрээ байгуулна.
2	<b>Финлянд</b>	93 дугаар зүйл. Ерөнхийлөгч Парламенттай зөвшилцөн дайн зарлах болон энхийн гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.
3	<b>Серби</b>	99 дугаар зүйл. Парламент нь 5. дайн зарлах, энхийн гэрээ байгуулах болон онц байдал зарлана.
4	<b>Чрна Гора</b>	82 дугаар зүйл. Парламент нь Дайны байдал болон онц байдал зарлана. Энхийн гэрээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.

5	<b>Хорват</b>	81 дүгээр зүйл. Хорватын парламент нь Дайн зарлах болон энхий гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.
6	<b>Исланд</b>	-
7	<b>Сингапур</b>	-
8	<b>Словак</b>	84 дүгээр зүйл. 4. бусад улсад дайн зарлах асуудлыг Парламентын нийт гишүүдийн 3/5-ны саналаар шийдвэрлэнэ.
9	<b>Турк</b>	92 дугаар зүйл. Парламент нь дайны байдал зарлах эрхтэй байна. Парламент завсарласан үед улс орны бүрэн эрхт байдалд бусад улсаас занал учруулж, зэвсэглэн халдаж нэн даруй шийдвэр гаргах шаардлагатай бол Ерөнхийлөгч нь Туркийн зэвсэгт хүчнийг хөдөлгөх шийдвэр гаргаж болно.
10	<b>Македон</b>	124 дүгээр зүйл. Дайны байдлыг Ерөнхийлөгч, Засгийн газар, эсхүл доод тал нь 30 гишүүний саналаар Парламентын нийт гишүүдийн 2/3-ны саналаар зарлана. Парламент хуралдах боломжгүй бол дайны байдлыг Ерөнхийлөгч зарлаж, Парламентыг хуралдмагц батлуулна.
11	<b>Кыргызстан</b>	64 дүгээр зүйл. 9. Ерөнхийлөгч нь: 3. бүх нийтийн болон хэсэгчилсэн дайны байдал зарлах, Кыргызстан Улсын бүрэн эрхт байдалд бусад улсаас занал учруулж, зэвсэглэн халдвал дайны байдал зарлах бөгөөд энэхүү асуудлыг Парламентад нэн даруй тавина.

**51. 2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	129 дүгээр зүйл. 2. Кассацийн дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Захиргааны хэргийн дээд шүүхийн дарга болон Ерөнхий прокурорыг Шүүхийн дээд зөвлөлийн санал болгосноор Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө. Дахин санал оруулсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгч томилохоос, чөлөөлөхөөс татгалзах эрхгүй байна.
2	<b>Финлянд</b>	102 дугаар зүйл. Шүүгчдийг Ерөнхийлөгч хуульд заасан журмын дагуу томилно.
3	<b>Серби</b>	105 дугаар зүйл. Парламент хүрэлцэн ирсэн гишүүдийн олонхын саналаар Дээд шүүхийн даргыг, шүүхийн дарга нарыг, Улсын ерөнхий прокурор болон улсын прокуроруудыг сонгоно. 144 дүгээр зүйл. Кассацийн дээд шүүхийн даргыг Парламент, Шүүхийн дээд зөвлөлийн санал болгосны дагуу Кассацийн дээд шүүхийн хуралдааны санал болон Парламентын холбогдох хорооны саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

4	<b>Чрна Гора</b>	82 дугаар зүйл. Парламент нь Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн шүүхийн дарга болон шүүгчдийг томилж, чөлөөлнө. 124 дүгээр зүйл. Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Чрна Гора Улсын Ерөнхийлөгч, Парламентын спикер болон Ерөнхий сайдын хамтарсан саналын дагуу Парламент томилж, чөлөөлнө. Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг 30 хоногийн дотор томилж чадаагүй бол Парламентын холбогдох хорооны саналыг үндэслэн томилно.
5	<b>Хорват</b>	119 дүгээр зүйл. Хорват Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчийг холбогдох Парламентын хорооны санал, Дээд шүүхийн хуралдааны санал зэргийг үндэслэн Ерөнхийлөгчийн санал болгосноор Парламент 4 жилийн хугацаагаар томилно.
6	<b>Исланд</b>	-
7	<b>Сингапур</b>	95 дугаар зүйл. 1. Дээд шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгчдийг Ерөнхийлөгч, Ерөнхий сайдтай зөвшилцөн томилно. 2. Ерөнхий шүүгчээс бусад шүүгчдийг томилох саналыг Ерөнхий сайд Дээд шүүхийн ерөнхий шүүгчтэй зөвшилцөн гаргана.
8	<b>Словак</b>	102 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь т. шүүгч, Словак улсын Ерөнхий шүүгч Ерөнхий шүүгчийн орлогчийг, Ерөнхий прокурор болон Шүүхийн зөвлөлийн гурван гишүүнийг томилж, чөлөөлнө, шүүгчийн тангаргийг өргүүлнэ.
9	<b>Турк</b>	Турк Улсын Дээд шүүгчдийг Шүүгч, прокурорын дээд зөвлөлөөс томилно.
10	<b>Македон</b>	105 дугаар зүйл. Македон улсын Шүүхийн зөвлөл нь шүүхийн дарга болон шүүгчдийг томилж, чөлөөлнө. Шүүгчдийг томилж, чөлөөлөх асуудлаар хүн амын цөөнхийн бүхий л төлөөллүүдийг багтаасан байна. Хуульд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл нь жил бүр Парламентад тайлангаа хүргүүлнэ.
11	<b>Кыргызстан</b>	64 дүгээр зүйл. 3/ Ерөнхийлөгч нь Шүүхийн томилгооны хорооны саналыг үндэслэн Парламентад Дээд шүүхийн шүүгчдийг нэр дэвшигчдийг өргөн мэдүүлнэ 74 дүгээр зүйл. 4/ Парламент нь: Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр Дээд шүүхийн шүүгчдийг томилох, үндсэн хуульд заасны дагуу Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр чөлөөлөх.

**56. 2. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.**

№	Улс	Холбогдох заалт
1	<b>Болгар</b>	129 дүгээр зүйл. 2. Кассацийн дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Захиргааны хэргийн дээд шүүхийн дарга болон Ерөнхий прокурорыг Шүүхийн дээд зөвлөлийн санал болгосноор Ерөнхийлөгч томилж, чөлөөлнө. Дахин санал оруулсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгч томилох, чөлөөлөхөөс татгалзах эрхгүй байна.
2	<b>Финлянд</b>	104 дүгээр зүйл. Ерөнхий прокурорыг Ерөнхийлөгч томилох бөгөөд прокурорын ажиллагааг нарийвчлан тусгай хуулиар зохицуулна.
3	<b>Серби</b>	158 дугаар зүйл. Улсын Ерөнхий Прокурорыг Парламентын холбогдох хорооны саналыг үндэслэн Засгийн газар Парламентад санал оруулж, Парламент сонгоно. Улсын Ерөнхий прокурорыг хуульд заасны дагуу Парламент, Засгийн газрын саналыг үндэслэн шийдвэрлэнэ. Улсын Ерөнхий прокурорыг чөлөөлөх асуудлыг Парламент хуульд заасны дагуу Засгийн газрын саналыг үндэслэн шийдвэрлэнэ.
4	<b>Чрна Гора</b>	82 дугаар зүйл. Парламент нь 14. Дараах албан хаагчдыг үүрэгт ажлаас нь томилж, чөлөөлнө: Ерөнхий прокурор болон улсын прокурор, Омбудсмен, Төв банкны Ерөнхийлөгч болон Төв Банкны зөвлөлийн гишүүд, Улсын Аудитын байгууллагын удирдлага болон Сенатын гишүүдийг болон хуульд бусад албан хаагчдыг.
5	<b>Хорват</b>	125 дугаар зүйл. Хорватын парламент нь Парламентын холбогдох хорооны саналыг үндэслэн, Засгийн газартай зөвшилцөн 4 жилийн хугацаатай томилно. Ерөнхий прокурорын орлогчийг Үндэсний прокурорын зөвлөл томилж, чөлөөлж, сахилгын шийтгэл ногдуулна.
6	<b>Исланд</b>	-
7	<b>Сингапур</b>	35 дугаар зүйл. 1 Ерөнхий прокурорын албаны бүтэц болон томилгоог Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын зөвлөгөөг зөвшөөрснөөр Дээд шүүхийн шүүгчээр томилогдох болзлыг хангасан этгээд дундаас томилно.
8	<b>Словак</b>	102 дугаар зүйл. Ерөнхийлөгч нь t. шүүгч, Словак улсын Ерөнхий шүүгч Ерөнхий шүүгчийн орлогчийг, Ерөнхий прокурор болон Шүүхийн зөвлөлийн гурван гишүүнийг томилж, чөлөөлнө, шүүгчийн тангаргийг өргүүлнэ.
9	<b>Турк</b>	154 дүгээр зүйл. Улсын Ерөнхий прокурор болон түүний орлогчийг Ерөнхийлөгч 4 жилийн хугацаагаар Дээд шүүхийн нэгдсэн хуралдаанаар өөрийн гишүүд дундаас нэг орон тоонд тус бүр 5 нэр дэвшигч дундаас нууц санал хураалтаар сонгоно.
10	<b>Македон</b>	91 дүгээр зүйл. Македон Улсын Засгийн газар нь Ерөнхий прокурорыг Улсын прокурорын зөвлөлийн саналыг үндэслэн нэр дэвшүүлнэ.  106 дугаар зүйл. Ерөнхий Прокурорыг Парламент 6 жилийн хугацаагаар томилно.

11	<b>Кыргызстан</b>	64 дүгээр зүйл. 4. Ерөнхийлөгч нь Хуульд заасны дагуу Парламенттай зөвшилцөн Ерөнхий прокурорыг томилно. Парламентын нийт гишүүдийн 1/3-с доошгүй гишүүдийн саналаар Ерөнхий прокурорыг чөлөөлөх, эсхүл Парламентын гишүүдийн 1/3-с доошгүй гишүүдийн саналыг Парламентын нийт гишүүдийн 2/3 зөвшөөрснөөр чөлөөлнө. Ерөнхий прокурорын саналаар дэд прокуроруудыг томилж, чөлөөлнө.
----	-------------------	---

ХАВСРАЛТ 2.

## Парламентын чуулганы хугацааг хуулиар зохицуулсан байдал

№	Улсын нэр	Парламентын чуулганы хугацаа
1	<b>Монгол</b> <i>/Байнгын ажиллагаатай/</i>	Үндсэн хуулийн 27.2-т Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна.
2	<b>Болгар</b> <i>/Байнгын ажиллагаатай/</i>	Үндсэн хуулийн 74-зүйл. Ардын Хурлын үйл ажиллагаа нь байнга тасралтгүй явагдана. Завсарлах хугацааг Ардын Хурал өөрөө тогтооно.
3	<b>Исланд</b> <i>/Байнгын ажиллагаатай/</i>	Үндсэн хуулийн 35-р зүйл. Парламентын ээлжит чуулганыг жил бүрийн 10 сарын 01-нд зарлан хуралдуулах ба дараа жилийн мөн өдөр хүртэл үргэлжилнэ.
4	<b>Кыргызстан</b> <i>/Байнгын ажиллагаатай/</i>	Үндсэн хуулийн 77.1-р зүйл. Жогорку Кенешийн чуулган нь хуралдаан хэлбэрээр зохион байгуулагдах бөгөөд 9 дүгээр сарын эхний ажлын өдөр эхэлж дараа оны 6 дугаар сарын сүүлчийн өдөр хүртэл үргэлжилнэ.
5	<b>Македон</b> <i>/Байнгын ажиллагаатай/</i>	Ассамблейн чуулганы дэгийн тухай хуулийн 5-р зүйл. Ассамблейн чуулган тасралтгүй чуулна. Чуулганы завсарлага 1 сарын хугацаатай байх ба 8-р сарын 1-нээс 31-ны өдрийг дуустал хүчинтэй байна. Ассамблейн ерөнхийлөгч завсарлагааны хугацаанд чуулганы цагийн хуваарийг батална.
6	<b>Серби</b> <i>/Байнгын ажиллагаатай/</i>	Үндсэн хуулийн 106-р зүйл. Үндэсний Ассамблейн ээлжит чуулган жилд хоёр удаа чуулна. Нэг дахь ээлжит чуулган нь 3-р сарын эхний ажлын өдөр, хоёр дахь ээлжит чуулган нь 10-р сарын эхний ажлын өдөр тус тус эхэлнэ. Ээлжит чуулганы үргэлжлэх хугацаа 90 хоногоос хэтрэхгүй байна. Үндэсний Ассамблейн ээлжит бус чуулганыг нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй саналаар, эсхүл Засгийн газрын өмнө нь хэлэлцэн тохиролцсон асуудлаар хүсэлт гаргасны дагуу зарлана.
7	<b>Сингапур</b> <i>/Байнгын бус ажиллагаатай/</i>	Үндсэн хуулийн 64-р зүйл. 1/ Парламент нь жилд нэгээс доошгүй удаа чуулах бөгөөд Парламентын дараагийн чуулган 6 сараас доошгүй хугацаа өнгөрсний дараа чуулна. 2/ Парламентын чуулганыг зохион явуулах газар болон хугацааг Ерөнхийлөгчийн албан ёсны сонинд нийтлүүлсний дагуу зарлана.
8	<b>Словак</b> <i>/Байнгын ажиллагаатай/</i>	Үндсэн хуулийн 82-р зүйл. Словак Улсын Үндэсний Зөвлөлийн чуулган тогтмол байнгын байна. Үндэсний Зөвлөл өөрөө тогтоол гарган чуулганыг завсарлуулж болно. Чуулган завсарлах хугацаа жилд 4 сараас илүү байж болохгүй.

9	<b>Турк</b> <i>/Байнгын ажиллагаатай/</i>	Үндсэн хуулийн 93-р зүйл. Үндэсний Их хурлын чуулган жил бүрийн 10-р сарын эхний өдөр чуулна. Үндэсний Их хурлын чуулган нь жил бүр дээд тал нь 3-р сарын хугацаатай завсарлаж болно.
10	<b>Финлянд</b>	Үндсэн хуулийн 4.33-р зүйл. Чуулганы үргэлжлэх хугацааг Парламент баталж, Ерөнхийлөгч зарлана.  Дэгийн тухай хууль: 1.Парламентын чуулган жил бүрийн 2 сарын эхний өдөр эхэлнэ.
11	<b>Хорват</b> <i>/Байнгын ажиллагаатай/</i>	Үндсэн хуулийн 79-р зүйл. Парламентын ээлжит чуулган жил бүрийн 1-р сарын 15-аас 7-р сарын 15, 9-р сарын 15-аас 12-р сарын 15-ны хүртэл явагдах бөгөөд ээлжит бус чуулганыг Ерөнхийлөгч, Засгийн газар эсхүл парламентын гишүүдийн олонхын хүсэлтээр хуралдуулж болно.
12	<b>Чрна Гора</b> <i>/Байнгын ажиллагаатай/</i>	Парламентын ээлжит чуулган жилд 2 удаа хуралдах бөгөөд 3 дугаар сарын эхний ажлын өдрөөс 7 дугаар сарыг дуустал, 10 дугаар сарын эхний ажлын өдрөөс 12 дугаар сарыг дуустал тус тус үргэлжилнэ. Ээлжит бус чуулганыг нийт гишүүдийн гуравны хоёрын шаардсанаар, эсвэл Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын санаачилгаар зарлан хуралдуулна.

ХАВСРАЛТ 3

Дэлхийн улс орнуудын төрийн тэргүүн, засгийн газар, хууль тогтоох байгууллагын сонгуулийн үе шат, бүтэц

Улс орон	Төрийн тэргүүнийг хэрхэн сонгодог	Засгийн газрын тэргүүнийг хэрхэн сонгодог	Ерөнхийлөгчтэй эсэх	Хууль тогтоох байгууллагын танхимын тоо	Хууль тогтоох байгууллагын танхимыг хэрхэн сонгодог	Хууль тогтоох байгууллагын танхимыг хэрхэн бүрдүүлдэг
Ерөнхийлөгчийн засаглалтай орнууд						
1 Афганистан	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилдог
2 Алжир	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилдог
3 Ангол	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бусад	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
4 Аргентин	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
5 Армян	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	



6	Азербайжан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
7	Беларусь	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
8	Бенин	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	1	Шууд сонгуулиар	
9	Болив	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
10	Бразил	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
11	Буркина Фасо	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	
12	Бирм-Мьянмар	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бусад	Бусад	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог

13	Бурунди	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
14	Камерун	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Бусад
15	Кабо Верде	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
16	Төв Африкийн БН Улс	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
17	Чили	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
18	Колумби	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
19	Коморын Арлууд	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	тийм	1	Шууд сонгуулиар	

20	Конго	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	Тийм	2	Шууд сонгуулиар	
21	Конго (БНАКУ)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Томилогддог	Тийм	2	Шууд сонгуулиар	
22	Коста Рика	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	Тийм	1	Шууд сонгуулиар	
23	Кот д-Ивуар	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	Тийм	1	Шууд сонгуулиар	
24	Жибути	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	Тийм	1	Шууд сонгуулиар	
25	Доминика	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	Тийм	1	Шууд сонгуулиар болон томилогддог	
26	Эквадор	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	Тийм	1	Шууд сонгуулиар	

27	Эль Сальвадор	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	Тийм	1	Шууд сонгуулиар	
28	Экваторын Гвиней	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Томилогддог	Тийм	2	Шууд сонгуулиар	
29	Франц	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	Тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
30	Габон	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Томилогддог	Тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
31	Гамби	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	Тийм	1	Шууд сонгуулиар	
32	Гүрж	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	Тийм	1	Шууд сонгуулиар	
33	Гана	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	Тийм	1	Шууд сонгуулиар	

34	Гватемал	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	1	Шууд сонгуулиар	
35	Гондурас	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
36	Гвиней Бисау	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
37	Гвиана	Бусад	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
38	Гаити	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
39	Индонез	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	
40	Казахстан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
41	Кени	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	

42	Өмнөд Солонгос	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	тийм	1	Шууд сонгуулиар	
43	Либер	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	
44	Мадагаскар	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	
45	Малави	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	тийм	1	Шууд сонгуулиар	
46	Мальдив	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	1	Шууд сонгуулиар	
47	Мали	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
48	Мавритани	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар

49	Мексик	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
50	Мозамбик	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	1	Шууд сонгуулиар	
51	Намиби	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
52	Никарагуа	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	тийм	1	Шууд сонгуулиар	
53	Нигер	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилгогдог	тийм	1	Шууд сонгуулиар	
54	Нигери	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар

55	Палау	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
56	Панам	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	тийм	1	Шууд сонгуулиар	
57	Парагвай	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	байхгүй	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
58	Перу	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	1	Шууд сонгуулиар	
59	Филиппин	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	тийм	2	Шууд сонгуулиар	
60	Польш	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
61	Португал	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	



62	Румын	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
63	Орос	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
64	Руанда	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
65	Сан томе ба Принсип	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
66	Сенегал	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	Бусад
67	Сейшеллын Арлууд	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	
68	Сьерра-Леон	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	1	Шууд сонгуулиар	
69	Өмнөд Судан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	

70	Шри Ланка	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна	Бусад	тийм	1	Шууд сонгуулиар	
71	Судан	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шилжилтийн - томилдог	Шууд бус сонгуулиар
72	Сири	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томиллогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
73	Тайвань	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Томиллогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
74	Тажикистан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томиллогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилдог
75	Танзани	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	тийм	1	Шууд сонгуулиар	
76	Зүүн Тимор	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томиллогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
77	Того	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Томиллогддог	тийм	1	Шууд сонгуулиар	

78	Туркменистан	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	Тийм	1	Шууд сонгуулиар	
79	Уганда	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	Тийм	1	Шууд сонгуулиар	
80	Украин	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	Тийм	1	Шууд сонгуулиар	
81	Америкийн Нэгдсэн Улс	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Сонгуулийн коллети, эсхүл хорооноос сонгогдоно	Бусад	Тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
82	Уругвай	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	Тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
83	Узбекистан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	Тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилдог
84	Венесуэл	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Тийм	1	Шууд сонгуулиар	

85	Иемен	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	
86	Замби	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	тийм	1	Шууд сонгуулиар	
87	Зимбабве	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	
Парламентын засаглалтай орнууд							
88	Австри	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
89	Бангладеш	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
90	Босни Герцеговин	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
91	Ботсван	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус/ Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	Залгамжлах болон томилдог

92	Болгар	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Шууд бүс/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
93	Хорват	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
94	Чех	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
95	Бүгд Найрамдах Доминикан Улс	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
96	Эстони	Шууд бүс/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бүс/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
97	Этиоп	Шууд бүс/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бүс/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
98	Фижи	Шууд бүс/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	Бусад

99	Финлянд	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
100	Герман	Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгогдоно	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Төлөөллүүд
101	Грек	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
102	Унгар	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
103	Исланд	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Томилгогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
104	Энэтхэг	Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгогдоно	Томилгогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
105	Ирак	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
106	Ирланд	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Намаас нэрийн жагсаалтаар томилдог

107	Израиль	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
108	Итали	Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгогдоно	Томилгогдог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
109	Кирибати	Төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна (Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно, 2 шатлал сонгуулийн тогтолцоотой)	Бүх нийтийн, шууд сонгуулиар олонхын саналаар сонгогдоно (2 шатлалтай байж болно)	тийм	1	Шууд сонгуулиар	
110	Кыргызстан	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Бусад	тийм	1	Шууд сонгуулиар	
111	Латви	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилгогдог	тийм	1	Шууд сонгуулиар	
112	Ливан	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилгогдог	тийм	1	Шууд сонгуулиар	
113	Ливи	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог - Бусад	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/парламентаас сонгогдоно	тийм	1	Шилжилтийн	
114	Литва	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилгогдог	тийм	1	Шууд сонгуулиар	

115	Македон	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
116	Малыт	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
117	Маршаллын Арлууд	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
118	Маврикий	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
119	Микронез	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
120	Молдав	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
121	Монгол	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
122	Монтенегро	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	



123	Науру	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
124	Непал	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	Бусад
125	Пакистан	Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгогдоно	Томилогддог	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
126	Самоа	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилогддог	байхгүй	1	Plurality (FPTP)	
127	Сан Марино	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/парламентаас сонгогдоно	үгүй	1	Шууд сонгуулиар	
128	Серби	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
129	Сингапур	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (энгийн олонхын саналаар)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
130	Словак	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилогддог	тийм	1	Шууд сонгуулиар	

131	Словени	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Сонирхлын бүлгүүдийн төлөөлөл
132	Сомали	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилгогдог	тийм	2	Шилжилтийн	Бусад
133	Өмнөд Африк	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус/ Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
134	Суринам	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус/ Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
135	Швейцарь	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус/ Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
136	Тринидад Тобаго	Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгогдоно	Томилгогдог	тийм	2	Шууд сонгуулиар	Томилдог
137	Тунис	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	тийм	1	Шууд сонгуулиар	
138	Турк	Бүх нийтийн, шууд сонгуулиар сонгогдоно (олонхын саналаар, 2 шатлалтай байж болох)	Томилгогдог	тийм	1	Шууд сонгуулиар	

139	Вануату	Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгогдоно	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
Үндсэн хуульг хаант засаглалтай орнууд							
140	Андорра	Бусад	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	үгүй	1	Шууд сонгуулиар	
141	Австрали	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томиллогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
142	Багамын Арлууд	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томиллогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилдог
143	Бахрейн	Угсаа залгамжилдаг	Томиллогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилдог
144	Барбадос	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томиллогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилдог
145	Бельги	Угсаа залгамжилдаг	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар
146	Белиз	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томиллогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилдог
147	Бутан	Угсаа залгамжилдаг	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилдог

148	Бруней	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Угсаа залгамжилдаг	Бусад	үгүй	байхгүй	байхгүй	
149	Камбодж	Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгогдоно	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	
150	Канад	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилдог	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
151	Дани	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
152	Гренада	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
153	Ватикан	Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгогдоно	Томилогддог	тийм	1	байхгүй	
154	Ямаик	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
155	Япон	Угсаа залгамжилдаг	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар
156	Иордан	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
157	Кувейт	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
158	Лесото	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог

159	Лихтенштейн	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
160	Люксембург	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
161	Малайз	Сонгуулийн коллеги, эсхүл хорооноос сонгогдоно	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
162	Монако	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
163	Морокко	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд бус сонгуулиар болон томилогддог
164	Нидерланд	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Бусад
165	Нидерландын Антилья	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилогддог	Засгийн газраа бүрдүүлж буй намын дарга нь Засгийн газрын тэргүүн болно	үгүй	1	Шууд сонгуулиар	
166	Шинэ Зеланд	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилогддог	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
167	Норвеги	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
168	Оман	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог
169	Папуа Шинэ Гвиней	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилогддог	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар	
170	Катар	Угсаа залгамжилдаг	Томилогддог	үгүй	1	Томилогддог	
171	Сент Кидс ба Невис	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилогддог	Томилогддог	үгүй	1	Шууд сонгуулиар болон томилогддог	
172	Сент Лусиа	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилогддог	Томилогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилогддог

173	Сент Винсент ба Гренадин	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилдог	Томилгогдог	үгүй	1	Шууд сонгуулиар болон томилдог	
174	Саудын Араб	Угсаа залгамжилдаг	Бусад	үгүй	1	Томилдог	
175	Соломонын Арлууд	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилдог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	үгүй	1	Шууд сонгуулиар	Бусад
176	Испани	Угсаа залгамжилдаг	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд болон шууд бус сонгуулиар
177	Свазиланд	Угсаа залгамжилдаг	Томилгогдог	үгүй	2	Орон нутгийн зөвлөлөөс сонгогдох болон томилдог	Доод танхимаасаа сонгогдох болон томилдог
178	Швед	Угсаа залгамжилдаг	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	үгүй	1	Шууд сонгуулиар	
179	Тайланд	Угсаа залгамжилдаг	Томилгогдог	үгүй	2	Шууд сонгуулиар	Шууд сонгуулиар болон томилдог
180	Тонга	Угсаа залгамжилдаг	Томилгогдог	үгүй	1	Шууд сонгуулиар, албан тушаалын дагуу	Бусад
181	Тувалу	Амбан захирагчийн Эзэн хаан/Хатан хаан томилдог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	үгүй	1	Шууд сонгуулиар	
182	АН Эмират	Бусад	Томилгогдог	тийм	1	Шууд сонгуулиар болон томилдог	

183	Их Британи	Угсаа залгамжилдаг	Томилгогддог	үгүй	2	Шууд сонгуулиар	Томилдог, залгамжилдаг/ шууд бус сонгуулиар
Нэг намын засаглалтай орнууд							
184	Хятад	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Бусад	
185	Куба	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус/ Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
186	Эритрей	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Шууд бус/ Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Томилдог	
187	Хойд Солонгос	Төрийн Тэргүүн нь Засгийн газрын тэргүүн байна - Угсаа залгамжилдаг	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	
188	Лаос	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Томилгогддог	тийм	1	Шууд сонгуулиар	
189	Вьетнам	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог	Шууд бус/Хууль тогтоох дээд байгууллагаас сонгогддог/ парламентаас сонгогдоно	тийм	1	Шууд сонгуулиар	Бусад
190	Баруун Сахар	Мэдээлэл олдоогүй	Мэдээлэл олдоогүй	Мэдээлэл олдоогүй	Мэдээлэл олдоогүй	Мэдээлэл олдоогүй	

\* \* \*

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Дэлхийн улс орнуудын Парламент, УБ 2010  
<https://www.cia.gov/Library/publications/the-world-factbook/fields/2128.html>  
<http://www.idea.int/esd/world.cfm>



УИХ-ын Тамгын газар ©  
“СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ – ХХІ БОТЬ”

УИХ-ын Тамгын газрын хэвлэх цех  
Хэвлэлтэнд шилжүүлсэн: 2015.09.22  
Хэвлэлийн хуудас: 20, Хэвлэсэн тоо: 350  
Цаасны хэмжээ: B5

УБ., 2015